

ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ (ХЭНБҮ)

ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Шведийн Байгаль Хамгаалах Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй "Байгаль орчны засаглал хөтөлбөр"-ийн хүрээнд боловсруулж хэвлэв.

Энэхүү гарын авлагыг үнэ төлбөргүй тараах ба худалдан борлуулахыг хориглоно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага болно.

Дэлгэрэнгүйг www.nhrctm.gov.mn цахим хуудсаар авах, эсвэл 7000-0222 дугаарын утсаар холбогдоно уу.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн тухай
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид, мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Дэлгэрэнгүйг mn.undp.org эсвэл @UNDP хаягаар авна уу.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

АЛХАМ 1: НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Суурь мэдээллийн дүн шинжилгээ

Асуудал ба хүний эрхийн хамаарал

Оролцогч талуудын дүн шинжилгээ

АЛХАМ 2: ХҮНИЙ ЭРХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Хүний эрхийн хэм хэмжээ

Төр ба бизнесийн үүрэг

Анхаарч үзэх эрхүүдийн дүн шинжилгээ

АЛХАМ 3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ

Арга зүйг тодорхойлох

Мэдээлэл цуглуулах

АЛХАМ 4. НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЭЛИЙГ ШИНЖЛЭХ

Асуудлын дүн шинжилгээ

Хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл

АЛХАМ 5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

Оролцоог хангах нь

Үр дүнтэй хэлэлцүүлэг

АЛХАМ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ТАНИЛЦУУЛАХ

Дүгнэлт хийх

Зөвлөмж боловсруулах

ХАВСРАЛТ

Хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээ

Бүлгийн ярилцлагын удирдамж

Асуулгын судалгааны хуудас

ӨМНӨХ ҮГ

Уул уурхайгаас олох үр өгөөж нь нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах өндөр боломжтой орнуудын нэг нь Монгол Улс болохыг Дэлхийн эдийн засгийн форумын судалгаанд тэмдэглэсэн байдаг. Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг бөгөөд 2019 оны гүйцэтгэлээр тус салбар ДНБ-ний 25 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72 хувь, экспортын 90 хувийг тус тус бүрдүүлжээ. Гэвч уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлээс нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг зохицуулах асуудал нь Монгол Улсын хувьд томоохон сорилт болдог. Тиймээс уул уурхайн болон бизнесийн төслүүдэд хүний эрхийг хүндэтгэх, хангах чиглэлээр бусад улсын хуримтлуулсан туршлага, сургамжаас суралцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ын хүрээнд бизнесийн байгууллагуудын нийгмийн хариуцлагыг чухалчлан үзэх болсноор хөрөнгө оруулалт, хөгжлийн төслүүдээс байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөлөлд үнэлгээ хийж, тулгарч болзошгүй асуудлыг төр, иргэд, хувийн хэвшлийн оролцоотой зөвшилцлийн замаар шийдвэрлэх олон санаачилга гарч байна. Үүний нэг нь бизнесийн төсөл, хөтөлбөрүүдийн хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэх, дүн шинжилгээ хийх зорилго бүхий Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) юм. Уг үнэлгээ нь хүний эрхийн хэм хэмжээ болон бодит хэрэгжилтийн хооронд гарч буй зөрүүтэй байдлыг илрүүлж, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн нийгмийн зөвшилцлийг бий болгох шинэлэг арга, үнэлгээний хэрэгсэл юм.

Тиймээс Хүний эрхийн Үндэсний Комисс нь уул уурхайн төслийн хэрэгжилтэд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө хэрхэн хөндөгдөж байгаад дүн шинжилгээ хийж, төрийн болон бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх, хангаж хамгаалах хандлагыг төлөвшүүлэх зорилгоор мэргэшсэн судалгааны байгууллагуудтай хамтран энэхүү Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Энэхүү ном нь

- 1) Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх Гарын авлага;
- 2) Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан;
- 3) Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт;

гэсэн гурван хэсгээс бүтэх бөгөөд эдгээр нь Хүний эрхийн Үндэсний Комисс болон Бодлогын Инновацийн Хүрээлэнгийн хамтын ажиллагааны үр дүнд Та бүхний гарт очиж байна.

Нөгөө талаас уул уурхайн болон бизнесийн бусад төслүүдээс үүдэлтэй хүний эрхийн зөрчил гарч буй талаар олон шүүмжлэл өрнөдөг ч үндэслэл бүхий баримт, дүн шинжилгээ, авч хэрэгжүүлэх шийдэл тодорхойгүй байдаг. Энэ нь

бизнесийн төслийг эхлүүлэх, тусгай зөвшөөрөл авах, олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлт зэрэг хэрэгжилтийн шатанд нийгмийн зөвшөөрөл авч чадахгүй байх, үл ойлголцол гарах, улмаар төсөл хэрэгжүүлэгчдэд нэмэлт ажиллагаа нэмэгдэх, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Иймд Хүний эрхийн Үндэсний Комисс нь томоохон төслүүдийн хэрэгжилтийн явцад Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг тогтмол хийх замаар төсөл хэрэгжүүлэгчид, хөрөнгө оруулагчид, төслийн үр шимийг хүртэгчдийн хооронд нийгмийн зөвшилцөл бий болгох чиглэлээр бүхий л талуудтай эрх тэгш, хамтран ажиллахад бэлэн байна.

Энэ дашрамд Тавантолгойн бүлэг ордын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэх, дүн шинжилгээ хийхэд хамтран ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Шведийн Байгаль Хамгаалах Агентлагийн хамтран хэрэгжүүлж буй "Байгаль орчны засаглал хөтөлбөр"-ийн Төслийн баг болон энэхүү үнэлгээний тайлан, гарын авлагыг боловсруулахад оролцсон, санал шүүмж өгч хувь нэмрээ оруулсан оролцогч талууд, судлаачид болон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, ажилтнуудад талархаж байгаагаа дахин илэрхийлье.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын
Тамгын газрын дарга Ч.Алтангэрэл

ГАРЫН АВЛАГА

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Тодорхой төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх бодит болон болзошгүй үр нөлөөг таамаглах, илрүүлэх, үнэлэх, түүнийг арилгах, бууруулах арга замыг тодорхойлох үйл явцыг нөлөөллийн үнэлгээ гэдэг. Өнөөдөр нөлөөллийн үнэлгээ нь дан ганц байгаль орчны нөлөөлөл гэдэг уламжлалт ойлголтоос гадна физик-хими, биологи, үзэгдэх орчин, эдийн засаг, хүний эрх, нийгэм, соёлын гэх мэт олон тооны нөлөөллийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт болон өөрчлөгдөж байна.

Энэхүү гарын авлагаар Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) хийх 6 алхам бүхий аргачлалыг танилцуулж байна. ХЭНБҮ нь хүний эрхийн асуудалд хэт ерөнхий, хийсвэр хандахаас сэргийлэн, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан тодорхойлж, баримтад үндэслэн шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Ялангуяа бизнесийн байгууллагуудад хүний эрхийн тухай ойлголтыг бодит туршлагад тулгуурлан хөрсөнд буулгаж таниулах, хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд үр дүнтэй арга хэрэгсэл болдог. ХЭНБҮ-ний нэг чухал давуу тал нь байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдаагүй олон асуудлыг нарийвчлан авч үзэх бололцоог олгодог.

2018 онд Бодлогын Инновацийн Хүрээлэн, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хамтран хэрэгжүүлсэн Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ нь энэ гарын авлагыг боловсруулах гол эх сурвалж болов. Түүний зэрэгцээ Бодлогын Инновацийн Хүрээлэнгийн судлаачдын багийн ХЭНБҮ-ний талаар сүүлийн жилүүдэд ажилласан туршлага, мэдлэг, олон улсын ба үндэсний холбогдох олон бүтээлүүд, эх сурвалжуудыг ашиглав.

Бид энэхүү гарын авлагыг нөлөөллийн үнэлгээ, хүний эрхийн чиглэлээр дагнан ажилладаг мэргэжилтнүүд, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хөндлөнгийн болон бие даасан ХЭНБҮ хийхэд ашиглах арга зүйн зөвлөмж байдлаар боловсрууллаа. Түүнчлэн бусад сонирхогч талууд, ялангуяа хүний эрхийн болон бизнесийн төсөл, хөтөлбөрийн мэргэжилтнүүдэд хэрэгцээтэй мэдээлэл, аргачлалууд оруулахыг зорьсон болно.


ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) нь тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, бизнесийн үйл ажиллагааны улмаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арилгах буюу бууруулах арга хэмжээ авах үйл явц юм.¹

ХЭНБҮ нь хэт ерөнхий, хийсвэр хандлагаар хандаж үр дүн багатай байсан хүний эрхийн асуудлыг нарийвчлан тодорхойлох, баримтаар үндэслэх, шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Ялангуяа бизнесийн байгууллагуудад хүний эрхийн ойлголтыг бодит туршлагаар, хөрсөнд буулгаж ойлгуулах, хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд үр дүнтэй байдаг.

ХЭНБҮ-ний нэг чухал давуу тал нь байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдаагүй асуудлыг нарийвчлан авч үзэх бололцоог олгодгоороо чухал ач холбогдолтой юм. Сайтар төлөвлөж, зохион байгуулсан ХЭНБҮ нь тухайн бодлого, хөтөлбөр, төслийн оролцогч талуудын байр суурь, дуу хоолойг тусгах өргөн бололцоог бий болгоно.

ХЭНБҮ хийх 6 үндсэн алхам



ХЭНБҮ нь хүний эрхэд нөлөөлж болохуйц олон хүчин зүйлсийн талаар баримтад тулгуурласан, нарийвчилсан дүн шинжилгээг боловсруулж, оролцогч талуудад танилцуулах, эерэг өөрчлөлтийг бий болгохыг зорьдог.

ХЭНБҮ-нээс тухайн бодлого, хөтөлбөр, төслийн холбогдох талуудад чиглэсэн дүгнэлт зөвлөмж гаргадаг. Зөвлөмж нь үйл ажиллагааг шууд цуцлах, зогсоох гэдэг хандлагаас илүүтэй гарч байгаа болон болзошгүй хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангахад чиглэсэн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд шууд чиглэдэг. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн зөрчлийг зөвхөн нэг удаа анхааруулах эсвэл зөрчилд арга хэмжээ аваад өнгөрөх бус тухайн төслийн иж бүрэн мөчлөгийн хүрээнд хүний эрхийн хэрэгжилтийг урт хугацаанд тогтвортой хангах арга замуудыг тодорхойлох, хэлэлцэх, хэрэгжилтийг хангах нь илүү үр дүнтэй билээ. Иймд аливаа тулгамдсан асуудлаар ХЭНБҮ хийгээд орхих бус тухайн асуудал,

түүний шийдлийг олон нийтэд таниулах, шийдвэр гаргагчдад нөлөөлөх ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай байдаг.²

ХЭНБҮ хийхийн ач холбогдол

• Хүний эрхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх
• Бодлого, үйл ажиллагаа хэрэгжихээс өмнө хүний эрхэд үзүүлж болох сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлж, үр дүнтэй арга хэмжээ авах
• Хууль эрх зүй, бодлогын орчны хүний эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй үр дагаврыг тодорхойлох
• Оролцогч талуудын хооронд үр дүнтэй яриа хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн ойлголтыг бий болгох
• Оролцогч талуудын оролцоо, чадавхийг нэмэгдүүлэх
• Нөлөөллийг тодорхойлох, авах арга хэмжээг санал болгох замаар төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын эгэх хариуцлагыг сайжруулах
• Оролцогч талуудын хооронд түншлэл, хамтын ажиллагааг өрнүүлж, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх эхлэлийг тавих

Аливаа ХЭНБҮ нь дараах суурь зарчимд үндэслэвэл зохино.³ Үүнд:

- ХЭНБҮ нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээг мөрдлөг болгоно.
- Үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах, зөвлөлдөх нь ХЭНБҮ-ний салшгүй бүрэлдэхүүн, үйл явцын нэг хэсэг байна.
- ХЭНБҮ-ний хувьд аливаа бодлого, төслийн улмаас нийгмийн бүлгүүдэд (жендер, нас, гарал угсаа гэх мэт) ялгавартайгаар нөлөөлөл үзүүлэх эсэхэд анхаарах ёстой. Зарим тохиолдолд ялгавартай байдал шууд ажиглагдахгүй хэдий ч шууд бус байдлаар тэгш бус нөлөөллийг бий болгох үр дагавартай байдаг.
- ХЭНБҮ хийх явцад ил тод байдлыг хангах ёстой. Нэгдүгээрт, үнэлгээ хийгдэж буй бодлого, төслийн тухай мэдээлэл ил тод, нийтэд хүртээмжтэй байх хэрэгтэй. Хоёрдугаарт, ХЭНБҮ хийх үйл явц нь өөрөө ил тод байх ёстой. Яагаад энэ бодлого, төслийг сонгож үнэлж байгаа, хэн оролцож, ямар шалгуураар хэдэн үе шаттай үнэлсэн гэх мэт бүхий л мэдээлэл ил тод байх ёстой.

² Götzmann, N. (2013). Handbook on Human Rights Impact Assessment Research Handbooks on Impact Assessment series. <https://www.elgaronline.com/view/edcol/9781788119993/9781788119993.00031.xml>; Бямбажав, Д. (2020). Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх арга зүй: Тавантолгойн бүлэг ордын үнэлгээний туршлага, сургамж. Хүний эрх сэтгүүл. Дугаар 1. 18-36 хуудас.

³ Harrison, J., & Stephenson, M. A. (2010). Human rights impact assessment: Review of practice and guidance for future assessments. Edinburgh: Scottish Human Rights Commission; Abrahams, D., & Wyss, Y. (2010). Guide to human rights impact assessment and management (HRIAM). Washington, DC: The International Business Leaders Forum, International Finance Corporation, & UN Global Compact; Иргэний Шийдэл. (2015). Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх удирдамж. УБ.



ХЭНБҮ хийхдээ оролцогч талуудтай уулзаж буй нь

ХЭНБҮ нь хүний эрхийг хамгаалахад чиглэсэн баримт, нотолгоо үндэслэлтэй дүгнэлтүүд гаргаж чадвал хүний эрхийн хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ ХЭНБҮ хийхэд цаг хугацаа, хүн хүч шаардлагатай болохыг анхаарах хэрэгтэй. Зөвхөн хоёрдогч мэдээлэлд үндэслэсэн үнэлгээ нь бодитой бус, асуудлын голыг илрүүлж чадахгүй эрсдэлтэй байдаг.

Олон улсын туршлагаас үзэхэд ХЭНБҮ-г дараах байгууллагууд хэрэгжүүлэх нь харьцангуй нийтлэг байна. Үүнд:

- Иргэний нийгмийн байгууллага: Олон улсын болон үндэсний ТББ-ууд ХЭНБҮ-г бие даан хэрэгжүүлсэн тохиолдол олон бий.
- Төрийн байгууллагууд, ялангуяа Хүний эрхийн үндэсний байгууллагууд, парламентын хороо, бие даасан ажлын хэсэг ХЭНБҮ хийсэн туршлагауд байдаг.
- Бизнесийн байгууллагууд: Компаниудын хувьд өөрсдийн үйл ажиллагааны ХЭНБҮ-г бие даан хийхээс гадна хөндлөнгийн мэргэжлийн зөвлөх байгууллагаар үнэлгээ хийлгэх явдал ихэсч байна.

Аливаа аж ахуйн нэгж хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлэхээс гадна ХЭНБҮ-г дотоод зохион байгуулалт, менежментийн системийнхээ нэг бүрдэл хэсэг болговол хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, түүнийг арилгахад маш чухал юм. Тухайн компанийн алсын хараа, стратеги, үйл ажиллагааны зарчимд ХЭНБҮ-г нэгтгэж, уялдуулах чиглэлд дэлхийн зарим томоохон компаниуд манлайлах алхам хийж байна. Тухайлбал, Данийн Хүний Эрхийн Хүрээлэнд Хьюлет-Паккард, Нестли зэрэг компани санал тавьж компанийнхаа хүний эрхийн бодлого, менежментийн байдалд үнэлгээ хийж зохих өөрчлөлтүүдийг оруулсан байдаг.⁴

ХЭНБҮ-г аж ахуйн нэгжийн дотоод бүтэц, менежментийн системд суулгах нь аливаа төсөл, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны эрсдлийг тооцох, оролцогч талуудтай харилцах стратегиа зөв боловсруулахад чухал ач холбогдолтой.

⁴ Эндээс дэлгэрүүлж үзнэ үү. <https://www.business-humanrights.org/en/latest-news/nestl%C3%A9-publishes-report-on-outcomes-challenges-of-human-rights-impact-assessments-in-7-countries/>

Бизнесийн салбарт ХЭНБҮ хийх шаардлага ихсэж буй шалтгаан

- Хөрөнгө оруулагчид, хэрэглэгчид, түншүүд тухайн компанийн нэр хүнд, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хүсч байдаг бөгөөд үүнд хүний эрхийн аливаа зөрчил сөрөг үр дагавартай байдаг.
- Орчин үед иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт ихсэж байгаа учраас компаниудын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн зөрчлийг арилгах, бууруулах шаардлага улам өндөрсөж байна.
- Харилцагч түншүүдийн шаардлагад хүний эрхийн хэм хэмжээ тусгагдах явдал ихсэж байна.
- Салбарын онцлогоос хамаарч тухайн бизнесийн үйл ажиллагаа байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд ихээхэн нөлөөлөл үзүүлэх магадлалтай тохиолдолд ХЭНБҮ-г хийх шаардлага үүсч байна.
- Тухайн үйл ажиллагаа, төслийн зорилго, агуулгаас шууд хамаарч хүний эрхийн асуудлыг анхааран үзэх шаардлага үүсдэг. Тухайлбал, дахин төлөвлөлт, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой олон тооны эрхүүдийн нөлөөлөл үүсдэг.

1 АЛХАМ

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ



Суурь
мэдээллийн дүн
шинжилгээ

Асуудал ба
хүний эрхийн
хамаарал

Оролцогч
талуудын дүн
шинжилгээ

Энэ хэсэгт үнэлгээ хийхээр сонгосон бодлого, төсөл, бизнесийн үйл ажиллагааны талаар аль болох бүрэн гүйцэд ойлгож, анхаарч судлах, тулгамдаж буй асуудлуудын хүрээг тодорхойлдог. Ингэхийн тулд суурь мэдээллийн дүн шинжилгээ хийх, анхаарч буй асуудал ба хүний эрхийн уялдаа холбоог ойлгох, оролцогч талуудын дүн шинжилгээ хийх шаардлагатай байдаг. Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзье.

СУУРЬ МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Юуны өмнө тухайн үнэлгээг хийх бодлого, төсөл, бизнесийн үйл ажиллагааны талаарх бүрэн дүүрэн ойлголттой болох хэрэгтэй. Тийм учраас олон эх сурвалжаас аль болох дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийдэг. Ямар эх сурвалжууд байж болохыг дараах хүснэгтэд жишээ болгон оруулав.

Дүн шинжилгээнд ашиглах мэдээллийн эх сурвалжууд

Бодлогын баримт бичгүүд: холбогдох хууль, тогтоол, дүрэм, журам, шийдвэрүүд
Байгууллага, төсөлд холбогдох баримт бичгүүд: танилцуулга, тайлан, татвар, бүртгэлийн мэдээлэл, менежментийн төлөвлөгөө, ТЭЗҮ, БОНУ, аудитын дүгнэлт
Судалгааны тайлан: өмнөх судалгааны тайлан, илтгэл, судлаач шинжээчдийн ярилцлага
Мониторинг, хяналтын мэдээлэл: Иргэний нийгмийн байгууллагын тайлан, судалгаа, шүүхийн шийдвэр, хэвлэлийн мэдээ
Холбогдох орон нутгийн баримт бичгүүд: төрийн байгууллагын шийдвэрүүд, статистик мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, орон нутгийн гэрээ
Газарзүйн мэдээллийн систем: холбогдох газрын зураг, газарзүйн мэдээллийн өгөгдөл, сансрын болон дроны зургууд
Сошиал медиа: Нийгмийн сүлжээн дэх форумууд, байгууллагын танилцуулга

Эдгээр эх сурвалжуудтай танилцаж, дүн шинжилгээ хийхдээ дараах жишээ хүснэгтийг ашиглаж болно.

Баримт бичгийн шинжилгээ, өмнөх судалгааны тойм хийх жишээ

Баримт бичиг, судалгааны мэдээллийн нэр	Зохиогч	Огноо	Холбогдох чухал мэдээлэл	Дүгнэлт, ишлэл	Нэмэлт тэмдэглэл
Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ.	УУХҮЯ, АМГТГ	2017 оны 9 сар.	Монгол улсын нүүрсний экспорт	2017 онд Монгол улсын нүүрсний экспорт улам бүр өссөөр 33 сая тоннд хүрсэн байна.	
Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.	“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төсөл	2015 он.	Байгаль орчин, нийгмийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан	Тавантолгойн бүлэг ордоос нүүрс экспортлох дэд бүтцийн бүс нь уурхайгаас зүүн урагш чиглэсэн Гашуунсухайт хилийн боомт хүртэлх 240 орчим км зурвас газар бөгөөд нөлөөллийн хүрээ нь зарим хэсэгтээ 41 км хүртэл өргөнтэй. 86-р хуудас.	Тоосжилт, усны хүрэлцээ, чанарын мэдээлэл

Асуудал ба хүний эрхийн хамаарал

Тухайн үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагааны улмаас үүсч буй байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн нөлөөлөл, тулгамдаж буй асуудлууд нь хүний эрхийн хэрэгжилттэй ямар уялдаа холбоо, хамааралтай болохыг ойлгох нь чухал юм. Дараах хүснэгтэд байгаль орчны асуудлууд ба хүний эрхийн хамаарлыг товч авч үзсэн байна.⁵

Байгаль орчин ба хүний эрхийн хамаарал

Хүний эрхүүдийн хэрэгжилтийг хангаж чадвал байгаль орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой. Харин байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хүний маш олон эрхийг зөрчих ноцтой үр дагавартай.	↔	Экосистем, түүний хоол хүнс, ус, өвчний менежмент, уур амьсгалын зохицуулалт зэрэг үйлчилгээг хамгаалах нь эрүүл мэнд, ус, хоол хүнсэй холбоотой эрхийн хэрэгжилтийг хангахад чухал юм.
--	---	---

⁵ НҮБХХ. 2018. Сайн туршлагыг авах нь: Уул уурхайн салбарын засаглалд хүрээлэн буй орчин ба хүний эрхийг нэгтгэх тухай Засгийн газар болон хамтрагч талуудад зориулсан гарын авлага. <https://www.undp.org/content/undp/en/home/librarypage/poverty-reduction/environmental-governance/extracting-good-practices--a-guide-for-governments-and-partners-.html>

Хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар байгаль орчны тогтвортой байдлыг хангах нь илүү үр дүнтэй	↔	Хууль эрх зүйн орчныг сайжруулахад мэдээлэл авах эрх, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо, шударга шүүхээр шүүлгэх эрх, үг хэлэх, оролцох эрх чөлөө зэрэг хүний эрхүүдийн хэрэгжилтийг хангах нь чухал.
Зөрчилдөөн нь байгаль орчны доройтлыг даамжруулж, улмаар хүний эрхэд сөргөөр нөлөөлдөг.	↔	Байгаль орчны доройтол болон хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь зөрчилдөөнийг даамжруулдаг.

Баримт, судалгааны эх сурвалжуудтай ажиллахдаа бодлого, төслийн онцлогоос хамаарч ажилчид, орон нутгийн иргэд, байгаль орчин зэрэг тодорхой асуудлыг анхнаасаа анхаарч үзэх хэрэгтэй. Жишээ нь: аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх бизнесийн төсөлд ХЭНБҮ хийх тохиолдолд ажилчдын ажлын нөхцөл, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлуудад эхнээсээ анхаарч эх сурвалжуудыг шинжилж болох юм.

Түүнчлэн, тухайн бодлого, төсөл, бизнесийн онцлогоос хамаарч дээрх хүний эрхүүдийн алинд ямар нөлөөлөл үзүүлэх нь ялгаатай байна. Жишээ нь бизнесийн байгууллагын хувьд байгууллагын хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо, үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт зэрэг нь хүний эрхийн хэрэгжилтэд шууд ба шууд бусаар нөлөөлдөг.⁶

Бизнесийн үйл ажиллагаа ба хүний эрхийн хамаарлын жишээ

Компанийн бүтэц чиг үүрэг	Гол анхаарах асуудлын жишээ	Нөлөөлөлд өртөх хүний эрхийн жишээ
Хүний нөөц	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг зөвхөн ажилд тавигдах шаардлагад үндэслэн ажилд авч, цалин хөлс олгож, албан тушаал дэвшүүлдэг үү? Эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан ажил хийснийхээ төлөө адилхан цалин хөлс авдаг уу? Ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх бодлого байдаг уу? 	<ul style="list-style-type: none"> Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх Эрх нь зөрчигдвөл эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрх
Хөдөлмөрийн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> Ажлын орчин ажилчдын бие махбодь болон сэтгэл санаанд аюулгүй юу? 	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
Худалдан авалт	<ul style="list-style-type: none"> Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч компаниуд хөдөлмөрийн суурь стандарт, хууль журмыг мөрдөж ажилладаг уу? 	<ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх Үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрх Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрлөхөөс ангид байх эрх

⁶ Shift, Oxfam and Global Compact Network Netherlands. (2016). Doing business with respect for human rights: A guidance tool for companies.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгч, харилцагчдад сөрөг үр дагавартай юу /жишээ нь эрүүл мэнд, амь насанд, хувийн нууцад, өмчид/? 	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндээ хамгаалуулах эрх Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууцад халдахаас ангид байх эрх
Үйл ажиллагаа явуулах орон нутаг	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн иргэдэд нөлөөлөл үзүүлсэн үү (жишээ нь дуу чимээ, тоос, усны хангамж)? Орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн эсэх? 	<ul style="list-style-type: none"> Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх Эрүүл мэндээ хамгаалуулах эрх Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх

Зарим тохиолдолд үүрэг хүлээгч нь хоёрдогч этгээдээр дамжуулан сөрөг нөлөөлөл үүсэхэд дам оролцдог гэдгийг анхаарах хэрэгтэй. Жишээ нь зарим уул уурхайн компаниуд туслан гүйцэтгэгч компаниудад хангалттай шаардлага тавьж, хяналт мониторинг хийлгүй орхих, зориудаар бүхий л хариуцлагыг гэрээт компаниудад үлдээх байдлаар хүний эрхэд сөрөг нөлөөлөл үүсэхэд оролцдог.

Сөрөг нөлөөлөл үүсэхэд компанийн шууд ба шууд бус оролцоо



Тухайн бодлого, төсөл, бизнесийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, нийгэм, хүний эрхийн олон асуудалд үзүүлэх нөлөөлөл олон янз, харилцан шүтэлцсэн, ээдрээтэй байдаг учраас анхаарч үзэх эрх тус бүрийг сайтар

шинжлэн дүгнэх хэрэгтэй. Доорх хүснэгтэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд үзүүлж болох нөлөөлөл, түүний шалтгааныг хэрхэн тодорхойлж болох жишээг танилцуулав.

Хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл, түүний шалтгааны жишээ

Хүний эрхүүд	Эрхийн тайлбар	Сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлсийн жишээ	Шалтгааны жишээ
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх гэдэг нь хүн бүр өөрийн амьдарч, ажиллаж буй орчиндоо эрүүл, аюулгүй байдлын зохистой түвшингээр хангагдсан байхыг хэлдэг. Эрүүл, аюулгүй орчин нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм.	Хүрээлэн буй орчны бохирдол Гэмт хэргийн өсөлт Замын тээврийн осол Дуу чимээ Усны хомсдол	<ul style="list-style-type: none"> ∅ Эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлсэн эсэх ∅ Үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан эсэх ∅ Нүүлгэн шилжүүлэлт, уул уурхайн нөлөөлөлд өртсөн өрхүүдэд тогтвортой амьжиргааг нь дэмжих нөхөн олговрын хөтөлбөртэй эсэх

Оролцогч талуудын дүн шинжилгээ

Үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагаанд оролцоо, хамааралтай талуудыг тодорхойлж, тэдгээрийн эрх ашиг, үүрэг, хариуцлагын тухай мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь ХЭНБҮ-ний үр дүнд маш чухал. Заримдаа суурь мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн оролцогч талуудыг бүрэн дүүрэн тодорхойлох боломжгүй байдаг учраас үнэлгээний багаараа сайтар хэлэлцэх, судалгааны явцад шинэ оролцогч талуудыг тодорхойлох, холбогдох мэргэжилтнүүд, иргэд, байгууллагаас тодруулга мэдээлэл авах хэрэгтэй.

Оролцогч талууд нь эерэг эсвэл сөрөг байдлаар, шууд ба шууд бусаар тухайн үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагаанд оролцоо, хамаарал бүхий хувь хүмүүс болон байгууллагууд юм.

Оролцогч талуудын дүн шинжилгээ нь тухайн үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагаанд холбоотой оролцогч талуудын оролцоо, эрх, үүрэг, ашиг сонирхол, байр суурь, харилцааны талаарх мэдээллийг харьцуулж, дүгнэлт гаргахад чиглэнэ. Дүн шинжилгээнээс аль болох дараах асуултуудад хариулсан дүгнэлт хийх хэрэгтэй. Үүнд:

- Хамгийн чухал оролцогч тал хэн бэ (эрх, үүргийн харилцаа, асуудлын шалтгаан ба шийдэхэд үзүүлэх нөлөөлөл)?
- Оролцогч талуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байна уу?

- Оролцогч талуудыг энэ үнэлгээнд хэрхэн оролцуулах вэ?

ХЭНБҮ хийхэд оролцогч талуудыг эрх эдлэгч тал, үүрэг хүлээгч тал, бусад гэсэн 3 бүлэгт хуваан үздэг.

Оролцогч талуудыг тодорхойлох жишээ



Оролцогч талуудын ангилал	Оролцогч талууд	Оролцогч талын тухай мэдээллийн тойм
Эрх эдлэгч тал	Нөлөөлөлд өртөгч орон нутгийн иргэд	
	Ажилчид	
	Хэрэглэгч, харилцагчид	
	Хүний эрхийг хамгаалагчид	
Үүрэг хүлээгч тал	Төрийн байгууллага ба орон нутгийн удирдлага	
	Компанийн удирдлага, төлөөлөл	
	Компанийн түншүүд, гэрээт, туслан гүйцэтгэгчид	
Бусад талууд	Хөрөнгө оруулагчид	
	Иргэний нийгмийн байгууллагууд	
	Олон улсын байгууллагууд	
	ХҮЭК	
	Судлаачид, сэтгүүлчид	

ХЭНБҮ-нд эрх эдлэгч талуудын мэдээллийг тусгайлан шинжилж үзэх нь нөлөөллийн цар хүрээ, ноцтой байдал зэргийг таамаглах, судалгааны хүрээгээ тогтооход чухал юм.


Эрх эдлэгч талуудыг тодорхойлсон жишээ

Талууд	Мэдээлэл
Малчид	Тавантолгойн бүлэг ордоос нүүрс экспортлох дэд бүтцийн бүс нь уурхайгаас зүүн урагш чиглэсэн Гашуунсухайт хилийн боомт хүртэлх 240 орчим км зурвас газар бөгөөд нөлөөллийн хүрээ нь зарим хэсэгтээ 41 км хүртэл өргөнтэй. Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээврийн автозам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгийг дайран өнгөрдөг. Цогтцэций суманд нийт 289 малчин өрх байна.
Сумын иргэд	2017 оны 12 дугаар сарын байдлаар Цогтцэций сумын хүн ам 7422, нийт 2441 өрх албан ёсны бүртгэлтэй байна. Өнөөгийн байдлаар сумын хүн амын 88 хувь буюу 6506 нь сумын төвд, 12 хувь буюу 916 нь хөдөө амьдарч байна. Нийт хүн амын дунд сумын төвд амьдардаг хүмүүсийн хувь аймгийн хэмжээнд хамгийн өндөр нь Цогтцэций сум байна. Уул уурхайн эрчимжилттэй холбоотой тус сумын хүн ам сүүлийн 5 жилд огцом нэмэгджээ. Үүнээс гадна уул уурхайн олборлолт, тээвэр, бусад холбогдох үйл ажиллагаанд оролцогч 8000-10000 орчим хөдөлгөөнт хүн ам Цогтцэций сумын нутаг дэвсгэрт ажиллаж, амьдардаг гэж үздэг.
Нүүрс тээврийн үйл ажиллагаанд оролцогчид	Тус бүс нутагт Нүүрс тээврийн үйл ажиллагаанд шууд ба шууд бусаар нийт 10000 орчим иргэн оролцож байна.
Эмэгтэйчүүд, хүүхдүүд ба бусад	Хүн амын хөдөлгөөн шилжин суурьшил, хүний аюулгүй байдал

Үүрэг хүлээгч болон бусад талуудын тухай аль болох дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, талуудын зураглал хийвэл урьдчилсан баримжаа, төсөөллийг бий болгох, үнэлгээг төлөвлөхөд ач холбогдолтой. Ингэхдээ тухай үеийн мэдээлэлд тулгуурлаж хийж болохоос гадна боломжтой бол эрх эдлэгч талуудын оролцоотойгоор хийвэл илүү үр дүнтэй.

Зураглалыг хийхдээ оролцоо гэсэн хэвтээ тэнхлэгтэй, нөлөө гэсэн босоо тэнхлэгтэй график үүсгэнэ. Хэвтээ, босоо тэнхлэг нь 1-10 онооны шатлалтай, тус бүртээ их, бага гэсэн 2 хэсэгтэй байна.

Оролцоо гэдэг нь тухайн хувь хүн, байгууллага үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой шийдвэр, үйл явцад шууд ба шууд бусаар оролцдог эсэхийг харуулна. Оролцоог 1-10 хүртэлх онооны шатлалаар үнэлж талуудыг графикт тэмдэглэнэ.



Нөлөө нь үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагааны улмаас үүссэн эсвэл үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад талууд нөлөө үзүүлэх боломжтой эсэхийг харуулна. Нөлөөг 1-10 хүртэлх онооны шатлалаар үнэлж талуудыг графикт тэмдэглэнэ.

Үнэлгээний багийнхан зураглалыг хийхдээ багаараа бөөндөө ярилцаж хийх эсвэл тус бүртээ зураглал хийснээ харьцуулан нэгтгээрэй. 2 тэнхлэгийн дагуу талуудыг графикт байршуулж дуусахад дараах 4 бүлэгт талууд хуваагдсан байна. Үүнд:

А бүлэг: Оролцоо бага, нөлөө их.

ХЭНБҮ-нд зайлшгүй оролцуулах шаардлагатай. Үнэлгээ хийх явцад хамтран ажиллах, үнэлгээний үр дүнгийн тухай мэдээллийг танилцуулах, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй.

Б бүлэг: Оролцоо их, нөлөө их.

ХЭНБҮ-нд зайлшгүй оролцуулах шаардлагатай. Тэдгээрийн талаар аль болох дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах, үнэлгээ хийх явцад хамтран ажиллах, үнэлгээний үр дүнгийн тухай мэдээллийг өгч, цаашид хүний эрхийн зөрчлийг засаж сайжруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй.

В бүлэг: Оролцоо их, нөлөө бага



ХЭНБҮ-нд зайлшгүй оролцуулах шаардлагатай. Үнэлгээ хийх явцад хамтран ажиллах, зөвлөлдөх, үнэлгээний үр дүнгийн тухай мэдээллийг өгч, үнэлгээний зөвлөмжүүдийг холбогдох талууд хэрэгжүүлэхэд хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй.

Г бүлэг: Оролцоо бага, нөлөө бага

Шаардлагатай бол ХЭНБҮ-нд оролцуулж болно. Үнэлгээний үр дүнгийн тухай мэдээллийг өгөх, цаашид дүгнэлт, үнэлгээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй.

2 АЛХАМ

ХҮНИЙ ЭРХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ



Энэ хэсэгт ХЭНБҮ хийхэд анхаарч авч үзэх буюу хэрэгжилтийг нь үнэлэх хүний эрхүүдийн хүрээг тодорхойлж, эрх тус бүрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай эрх зүйн болон бодлогын эх сурвалжууд, холбогдох стандарт, сайн туршлагаудыг судлан үзэх хэрэгтэй. Юуны өмнө ХЭНБҮ хийх багийн нийт гишүүд хүний эрхийн талаарх мэдлэгээ нягтлах, нэгдсэн ойлголттой болох нь чухал. Улмаар хүний эрхийн хэрэгжилтийг хангахад төр ба бизнесийн байгууллагуудын хүлээх үүргийн талаар багаар хэлэлцэж, нэгдсэн ойлголтоо тодорхойлох үнэлгээг үр дүнтэй хийх маш чухал юм. Эцэст нь тухайн үнэлгээнд анхаарч авч үзэх эрхүүдийг урьдчилсан байдлаар сонгож, тус бүрийн тодорхойлолт, холбогдох дүн шинжилгээг хийх хэрэгтэй байдаг. Ингэхдээ өмнөх алхам буюу нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд тулгуурладаг.

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Хүний эрх гэдэг ойлголт нь товчхондоо хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлвэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг байна. Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм.⁷

7 ХЭҮК. Хүний эрхэд суурилсан хандлага. Сургалтын гарын авлага. 2016 он

Хүний эрхийн суурь зарчмууд

Тэгш байх	<ul style="list-style-type: none"> Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.
Түгээмэл байх	<ul style="list-style-type: none"> Хүн бүр өөрийн оршин суугаа газар, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, соёл, үндэстний байдлаас үл хамааран ижил тэгш эрхтэй төрж, эрхээ эдлэх ёстой. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 1-р зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэж заасан буй.
Салшгүй байх	<ul style="list-style-type: none"> Тусгайлан заасан нөхцөлд албан ёсны, шүүхийн шийдвэрээр хязгаарласнаас бусад тохиолдолд хүний эрхийг хязгаарлах, салгах ёсгүй. Жишээ нь тухайн хүн шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрх чөлөөтэй байх эрхээ хязгаарлуулах явдал бий.
Ялгаварлан гадуурхахгүй байх	<ul style="list-style-type: none"> Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдлаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.
Хуваагдашгүй байх	<ul style="list-style-type: none"> Улс төрийн, иргэний, нийгмийн, соёлын болон эдийн засгийн бүхий л эрхүүд нь ач холбогдлоороо бүгд адил бөгөөд харилцан уялдаатай. Аль нэггүйгээр бусдыг нь бүрэн дүүрэн эдлэх боломжгүй юм.
Хүн үнэ цэнэ, нэр төртэй байх	<ul style="list-style-type: none"> Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, хүйсийн чиг баримжаа, хэл, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.
Харилцан хамааралтай байх	<ul style="list-style-type: none"> Хүний эрх нь орон гэр, зах, сургууль, ажлын байр зэрэг газар бүрт амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө, нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.
Хариуцлага тооцох	<ul style="list-style-type: none"> Төртэй хариуцлага тооцох: Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй. Хувь хүнтэй хариуцлага тооцох: Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй. Бусад этгээдтэй хариуцлага тооцох: Корпорациуд, төрийн бус байгууллагууд, сангууд, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээнэ.

Хүний эрх нь гол төлөв олон улсын гэрээ, тунхаг, үндэсний хуулиар баталгаажиж, хэрэгждэг. Монгол Улс 1961 онд Нэгдсэн үндэстний байгууллагын 101 дэх гишүүнээр элссэн бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ, 1948)-д заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн. Тус улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП, 1966), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭТОУП, 1966)-ыг 1974 онд соёрхон баталсан юм. Одоогийн байдлаар Монгол улс нэгдэн орсон хүний эрхийг хамгаалах олон улсын гэрээний талаар Хавсралт хэсгээс үзнэ үү.

Ардчилсан улсуудын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн дийлэнх нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн гарчигтай Хоёрдугаар бүлэгт тусгагдсан. Гэхдээ Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийг зөвхөн Хоёрдугаар бүлэгт заагдсан эрхээр хязгаарлан ойлгож болохгүй. Учир нь Үндсэн хуулийн бусад бүлэг, зүйл, тухайлбал, 21 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3-т нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, 53 дугаар зүйлийн 2 дахь

хэсэгт шүүх хуралдаанд эх хэлээрээ үг хэлэх, 54 дүгээр зүйлд хэргээ ил таслан шийдвэрлүүлэх, 55 дугаар зүйлд өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг тус тус заажээ. Үндсэн эрхийн жагсаалтыг гаргахдаа энэ мэт эрхийг орхигдуулж болохгүй.⁸

Түүнчлэн, “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан. Иймд Үндсэн хуульд томъёологдоогүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг (хэрэв Үндсэн хуульд зааснаар хязгаарлаагүй бол) манай оронд байгаа бүх хүн нэгэн адил эдлэх, хамгаалуулах боломжтой.⁹

Олон улсын гэрээ болон Монгол улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхийн хэмжээ

Хүний эрх	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
Амьд явах эрх	3-р зүйл	6-р зүйл		16.1-р зүйл
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх				16.2-р зүйл
Эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх	3-р зүйл	9-р зүйл		16.13-р зүйл
Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрлөхөөс ангид байх эрх	4-р зүйл	8-р зүйл		16.4-р зүйл
Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгүүлэхээс ангид байх эрх	5-р зүйл	7-р зүйл		16.13-р зүйл
Эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрх	6-р зүйл	16-р зүйл		14-р зүйл
Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх	7-р зүйл	14, 26-р зүйл		14-р зүйл
Дайныг аливаа хэлбэрээр сурталчилсан, алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгаанаас ангид байх эрх		20-р зүйл		
Эрх нь зөрчигдвөл эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрх	8-р зүйл	9-р зүйл		16.12-р зүйл
Хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх эрхтэй	10-р зүйл	9, 14-р зүйл		16.14-р зүйл

Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхээс ангид байх эрх	11-р зүйл	15-р зүйл		
Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууцад халдахаас ангид байх эрх	12-р зүйл	17-р зүйл		16.13-р зүйл
Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх	13-р зүйл	12-р зүйл		16.18-р зүйл
Хэн боловч мөрдөлт мөшгилтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрх	14-р зүйл			
Иргэний харьяалалтай байх эрх	15-р зүйл			15-р зүйл
Хүүхэд асрамж, туслалцаа авах эрх	25-р зүйл	10, 24-р зүйл	10-р зүйл	16.11-р зүйл
Гэрлэх, өрх тусгаарлах эрх	16-р зүйл	23-р зүйл	10-р зүйл	16.11-р зүйл
Эд хөрөнгө өмчлөх эрх	17-р зүйл			16.3-р зүйл
Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх	18-р зүйл	18-р зүйл		16.15-р зүйл
Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх	19-р зүйл	19-р зүйл		16.16-р зүйл
Тайван хуран цуглах эрхтэй	20-р зүйл	21-р зүйл		16.16-р зүйл
Эвлэлдэн нэгдэх эрхтэй	20-р зүйл	22-р зүйл		16.10-р зүйл
Улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрх	21-р зүйл	25-р зүйл		16.9-р зүйл
Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх	22-р зүйл		9-р зүйл	16.5-р зүйл
Хөдөлмөрлөх эрх	23-р зүйл		6-р зүйл	16.4-р зүйл
Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх	23-р зүйл		6-р зүйл 7-р зүйл	
Үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрх	23-р зүйл	22-р зүйл	8-р зүйл	
Эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх	25-р зүйл		11-р зүйл	
Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	25-р зүйл			16.2, 16.6-р зүйл
Сурч боловсрох эрх	26-р зүйл		13-р зүйл	16.7-р зүйл
Нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй, өөрийн туурвисан бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрх	27-р зүйл		15-р зүйл	16.8-р зүйл

Өөрөө засан тохинох эрхтэй			1-р зүйл	
Эрх чөлөөгөө хасуулсан хүний хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх		10-р зүйл		
Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйг үндэслэл болгон эрх чөлөөг хасуулахгүй байх эрх		11-р зүйл		
Гадаадын иргэний албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин хянуулах эрх		13-зүйл		
Угсаатан, шашны болон хэлний цөөнхөд багтдаг хүмүүсийн соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрх		27-р зүйл		
Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	8-р зүйл	9-р зүйл		16.12-р зүйл
Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 сарын 28-ны 64/292-р тогтоол			

ТӨР БА БИЗНЕСИЙН ҮҮРЭГ

Олон улсын хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээгээр төр бол хүний эрхийг хамгаалах, хангах үүрэг хүлээдэг. Төр нь нэн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй.¹⁰

Хүний эрх ба төрийн үүрэг¹¹

Хүний эрхийг хүндэтгэх

Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байх үүрэгтэй. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй (жишээлбэл, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хүчээр нүүлгэн шилжүүлэх, төлбөрийн чадваргүй хүмүүст төлбөртэй эмнэлгийн үйлчилгээ санал болгох гэх мэт).

Хүний эрхийг хамгаалах

Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлах үүрэгтэй.

Хүний эрхийг хангах

Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох эерэг алхамуудыг ахиц дэвшил гаргасан байдлаар авах ёстой. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээлэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авна.

¹⁰ Хүний эрхийн Үндэсний Комисс. Хүний эрх ба төрийн үүрэг. www.nhrctm.gov.mn

¹¹ Хүний эрхийн Үндэсний Комисс. Хүний эрх ба төрийн үүрэг. www.nhrctm.gov.mn

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг. Төр нь хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулахаас эхлээд зөрчигдсөн тохиолдолд хамгаалах, хүний эрхийг хангах талаар хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын төр иргэнийхээ өмнө төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрхийг хангах, зөрчигдсөн тохиолдолд хамгаалах үүргийг хүлээдэг.

Бизнесийн байгууллагын хүлээх үүргийг 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс баталсан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” хэмээх бодлогын баримт бичигт тодорхойлсон байдаг.¹² Энэ нь үндсэн 3 тулгуур зарчмаас бүрдэх ба уг баримт бичигт зарчим тус бүрийг хэрэгжүүлэх ерөнхий арга замуудыг тодорхойлсон юм.

Хүний эрх ба бизнесийн үүрэг

Хүний эрхийг хүндэтгэх

Бизнесийн байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчим юм. Бизнесийн байгууллага нь эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой юм. Энэ зарчим нь бизнесийн байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох тухай асуудалд ч хамааралтай бөгөөд урьдчилсан үнэлгээ судалгаа чухал болохыг онцолдог. Бизнесийн байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх, эрх зөрчсөн үйл ажиллагааг дэмжих, хамтран оролцохоос татгалзах үүрэгтэй.

Зөрчигдсөн эрхийг сэргээх

Иргэдийн гомдлыг хэлэлцэх, хохирлыг барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохыг шаардаж, хяналт тавих хэрэгтэй. Компаниуд иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, яриа хэлэлцээрийн зарчмаар шийдвэрлэх механизмтай байх шаардлагатай.

Бизнесийн үйл ажиллагаа нь янз бүрийн оролцогч талуудын хүний эрхийг давхар хөндөж, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл байдаг гэдгийг ухамсарлаж ойлгох нь чухал болж байна.¹³

Бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийн жишээ

Ажилчид	Орон нутгийн иргэд	Хэрэглэгч, харилцагчид
Шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын хэрэгсэл олгоогүйн улмаас эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөрчих	Агаар ба ус бохирдуулах нь иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд нөлөөлөх	Компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн чанарын шаардлага хангаагүйн улмаас амьд явах эрх зөрчигдөх


¹² Д.Бямбажав. “Хүний эрх ба нийгмийн хариуцлага”. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. 2013.02

¹³ Shift, Oxfam and Global Compact Network Netherlands. (2016). Doing business with respect for human rights: A guidance tool for companies.

Аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй ажилчдын байр сууцанд амьдрах нь Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчих	Усны хомсдол үүсгэж иргэдийн цэвэр усаар хангагдах эрхэд нөлөөлөх	Компани нь харилцагч нарынхаа мэдээллийг алдсанаас болж хувийн нууцад халдахаас ангид байх эрх зөрчигдөх
Олон цаг илүү цагаар ажиллуулах, илүү цагийн хөлс олгохгүй байх, ажлын хөлс ба албан тушаалын зэрэг дэвд ялгавартай хандах нь Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрхийг зөрчих	Компанийн машин, техник хэрэгслүүдийн улмаас дуучимээ, тоос шороо ихсэж эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх	Дэлгүүр, үйлчилгээний газрын аюулгүй байдлын доголдлын нь улмаас эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд нөлөөлөх

АНХААРЧ ҮЗЭХ ЭРХҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1-р алхам болон хүний эрхийн мэдлэгтээ тулгуурлан тухайн үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагаатай холбоотойгоор нөлөөлөлд өртөх магадлалтай хүний эрхүүдийг тодорхойлно. Ингэхдээ дараах аргачлалыг ашиглаарай.



Нэг. Олон улсын гэрээ болон Монгол улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхүүдээс тухайн бодлого, төсөл, үйл ажиллагаатай холбоотойгоор нөлөөлөлд орох магадлалтай хүний эрхүүдийн жагсаалтыг гаргана. Дараах хүснэгтэд Тавантолгойн ХЭНБҮ-г хийхэд гаргасан хүний эрхийн жагсаалтыг танилцуулав.

Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой анхаарч үзэх эрхүүдийн жагсаалт

Хүний эрх
Амьд явах эрх
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх
Эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх
Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгүүлэхээс ангид байх эрх
Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх
Эрх нь зөрчигдвөл эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрх
Хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх эрхтэй
Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх
Эд хөрөнгө өмчлөх эрх
Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх
Тайван хуран цуглах эрхтэй
Эвлэлдэн нэгдэх эрхтэй
Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх
Хөдөлмөрлөх эрх
Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх
Үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрх
Эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх

Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
Сурч боловсрох эрх
Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх
Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх

Энэ урьдчилсан жагсаалтыг үнэлгээ хийх явцад буюу судалгааны мэдээлэл, оролцогч талуудын саналд үндэслэн өөрчилж, шинэчлэх боломжтой гэдгийг анхаараарай.



Хоёр. Жагсаалтад оруулсан эрхүүдэд холбогдох баримт бичгүүдийг уншиж судална. Эрх тус бүрийн талаар аль болох системтэй, бүрэн дүүрэн тодорхойлолт хийхийн тулд баримт бичиг, эх сурвалжуудыг судлахдаа агуулгын энгийнээс хүнд рүү шилжих, жишээ тохиолдлыг харьцуулах, үндэсний ба орон нутгийн соёлын онцлогийг анхаарах зэргээр олон янзын аргыг ашиглаарай.

Албадан нүүлгэн шилжүүлэх тухай хуулийн нөлөөлөлд орох эрхүүдэд холбогдох баримт бичгүүдийн жишээ

Олон улсын гэрээ, холбогдох баримт бичгүүд

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим
- Хүүхдийн эрхийн тухай конвенц

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжууд

- Монгол улсын Үндсэн хууль
- Газрын тухай багц хууль
- Иргэний хууль

Олон улсын ба үндэсний стандартууд

- Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Зээлдэгчид Тавих Стандартууд
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Стандартууд

Бусад

- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний удирдамж
- Хүний эрхийн тайлбар толь, гарын авлагууд
- Судалгааны бүтээлүүд



Гурав. Холбогдох баримт бичгүүд, эх сурвалжуудыг судалсны үндсэн дээр эрх тус бүрийн дэлгэрэнгүй тайлбарыг боловсруулна. Тайлбарыг үнэлгээний багийн гишүүдэд ойлгомжтой байдлаар боловсруулахын зэрэгцээ тухайн эрхийн утга агуулга, холбогдох байгаль орчин, нийгмийн асуудлуудын хамаарал, үнэлгээ хийж буй бодлого, үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөл зэрэг чухал мэдээллийг оруулах нь практик ач холбогдолтой байдаг. Хүний эрхийн дэлгэрэнгүй тайлбар боловсруулах 2 төрлийн жишээг доор танилцуулав.

Хүний эрхийн дэлгэрэнгүй тайлбар хийх А жишээ

Эрхийн хүрээ	Эрх	Түлхүүр үг	Шууд хөндөгдөх	Шууд бус хөндөгдөх	Нөлөөлөл тодорхой бус	Тэмдэглэл
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх						
Тайлбар:						
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх гэдэг нь хүн бүр өөрийн амьдарч, ажиллаж буй орчиндоо эрүүл, аюулгүй байдлын зохистой түвшингээр хангагдсан байхыг хэлдэг.						
Эрүүл, аюулгүй орчин нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм.						
Эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр яригддаг бөгөөд агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний хүчин зүйлсийг авч үздэг.						
Хүрээлэн буй орчин	Ус, ариун цэврийн хангамжийн эрх	Ундны ус, усны чанар, хүртээмж	✓			
	Цэвэр агаар/ хүрээлэн буй орчны эрх	Хүрээлэн буй орчин, Орчны бохирдол	✓			
Эрүүл мэнд	Эрүүл байх эрх	Эрүүл мэнд	✓			
	Эрүүл мэндийн дээд нөхцөл байдлын эрх	Дээд нөхцөл	✓			
Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх						
Тайлбар:						
Энэ эрхийн хүрээнд амьжиргаагаа хангахуйц цалин хөлс авах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхойлох, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамруулсан бодлого, зохицуулалтыг ойлгоно.						
Цалин хөлс нь ажиллагчийн аж байдал, нийгмийн баталгааны наад захын хэм хэмжээг хангах үндсэн хэрэгсэл тул улс орнуудын хөдөлмөрийн бодлогын гол хэрэгсэл болдог. Цалин хөлсийг тогтооходоо эрх ашиг нь хөндөгдөж буй ажил олгогч болон ажиллагчдын төлөөллийн байгууллагын аль аль нь зөвшилцөлд эрх тэгш оролцож, тогтоосон хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байдаг.						
Орон гэртэй байх эрх	Зохистой орон байртай байх,	Орон гэр, Амьжиргаа		✓		
	Орон байраар хангагдах	Орон гэр		✓		
Амьжиргаа	Амьдралын зохистой түвшинд амьдрах эрх	Хангалттай байх		✓		
	Орлогын зохих эх үүсвэртэй байх эрх	Өмч		✓		

Хөдөлмөрлөх эрх						
Тайлбар: Хөдөлмөрлөх эрх: хөдөлмөрийн харилцаанд оролцож буй хүн бүрийн зайлшгүй эдлэх ёстой үндсэн эрхүүд байна. Хөдөлмөрлөх эрх нь хүний суурь эрхийн нэг бөгөөд өргөн утгатай ойлголт. Хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хөдөлмөрийн харилцаа, түүн дэх ялгаварлан гадуурхалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, ажлын цаг, цалин хөлс, нийгмийн яриа хэлэлцээ, хууль бус хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр зэргээс гадна албадан хөдөлмөр зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хамруулж үздэг.						
2	Хөдөлмөрийн нөхцөл	Таатай нөхцөлд ажиллах эрх	Ажлын нөхцөл	✓		
		Ажиллах эрх	Ажил		✓	Чухал
4	Ялгаварлан гадуурхах	Үл ялгаварлах	Үл ялгаварлах	✓		
5		Ижил ажилд адил цалин	Адил тэгш хандах			
6		Жендэрийн тэгш байдал	Жендэр		✓	
7	Эвлэлдэн нэгдэх эрх	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө			✓	ҮЭ-д хамааруулав
8		Үйлдвэрчний эвлэлд харьяалагдах эрх	Үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх	✓		
9		Ажил хаях эрх	Ажил хаялт	✓		
10	Шударга цалин хөлс	Шударга цалин хөлс хүртэх эрх	Цалин хөлс	✓		
11		Баярын өдрүүдэд цалин авах эрх	Илүү цагийн цалин хөлс	✓		
12		Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх	Хангалттай байх		✓	Анхаарах

Хүний эрхийн дэлгэрэнгүй тайлбар хийх Б жишээ

Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх

Тайлбар:

Энэ эрхийн хүрээнд амьжиргаагаа хангахуйц цалин хөлс авах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхойлох, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамруулсан бодлого, зохицуулалтыг ойлгоно.

Цалин хөлс нь ажиллагчийн аж байдал, нийгмийн баталгааны наад захын хэм хэмжээг хангах үндсэн хэрэгсэл тул улс орнуудын хөдөлмөрийн бодлогын гол хэрэгсэл болдог. Цалин хөлсийг тогтооходоо эрх ашиг нь хөндөгдөж буй ажил олгогч болон ажиллагчдын төлөөллийн байгууллагын аль аль нь зөвшилцөлд эрх тэгш оролцож, тогтоосон хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байдаг.

Баталгаа:

“Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дүгээр зүйлийн 3 дахь заалт)

“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:


- (с) гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох;

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн ii(c) заалт)

Монгол Улсын Үндсэн хууль

“...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)



Дөрөв. Гол анхаарах эрхүүдийг дэлгэрэнгүй тодорхойлсоны дараа тухайн эрх бүрт холбогдох оролцогч талуудын, ялангуяа нөлөөлөгч талын үүргийг дэлгэрэнгүй тодорхойлно. Ингэхдээ өмнө дурдсан эрхүүдэд холбогдох баримт бичгүүдийг уншиж судлаарай.

Бизнесийн байгууллагын үүргийг тодорхойлсон жишээ

Үүрэг	Хүний эрхийн бодлого	Эх сурвалж
Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх		Хүний эрхийн түгээмэл тунхаглал
		Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай олон улсын пакт
	Байгууллагын дүрэм, стандартууд	Монгол Улсын Үндсэн хууль
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах	Гомдол маргаан шийдвэрлэх журам	Хөдөлмөрийн тухай хууль
	Сургалтын хөтөлбөр	Жендэрийн тэгш байдлын тухай хууль
	Мэдээлийн сан	Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль
		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох		
Хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх		
Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохгүй байх		
Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардахгүй байх, үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахгүй байх		
Ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг ажилтанд тулган шаардаж болохгүй.		
Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг нь хуульд заасны дагуу нэмэгдүүлж олгоно.		
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;		
Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан байна.		
Эзэмшигч, ашиглагч нь үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах талаар журам тогтоон мөрдөж ажиллах;		
Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх, тэдгээрийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх		
Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулж, эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг хариуцна.		
Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах		
Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилгаа аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;		
Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх		

3 АЛХАМ

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ



Арга зүйг
тодорхойлох

Мэдээлэл
цуглуулах

Арга зүйг тодорхойлох

Өмнөх алхамуудын үр дүнд үнэлгээ хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагааны талаарх үндсэн мэдээлэл, тулгамдаж буй гол асуудлууд, тэдгээрийн хүний эрхэд үзүүлэх боломжит нөлөөлөл, оролцогч талуудын эрх, үүргийн тухай суурь ойлголт, таамаглалууд бий болсон байна. Түүний дагуу эрх, үүргийн хэрэгжилтийн үнэлгээг хийхэд ашиглах судалгааны мэдээллийг цуглуулж, боловсруулах хэрэгтэй.

Үнэлгээний судалгааг хийх багийн бүрэлдэхүүн болон судалгааны мэдээлэл цуглуулах, оролцогч талуудтай зөвлөлдөх ажлыг төлөвлөхдөө жендэрийн мэдрэмжтэй байх чухал ач холбогдолтой.

Арга зүйг тодорхойлоход анхаарах жендэрийн асуудлууд

Үнэлгээ хийхээр сонгосон бодлого, төсөл, үйл ажиллагааны талаар ямар нэгэн жендэрийн үнэлгээ, жендэрийн нөлөөллийн судалгаа хийгдсэн үү?

Үнэлгээний багт эмэгтэй хүн орсон уу?

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс судалгаанд оролцож мэдээлэл өгөхөд хязгаарлаж байгаа хүчин зүйлс бий юу?

Ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх тэгш, идэвхтэй оролцоог хэрхэн хангах вэ?

Мэдээллийг цуглуулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн санаа бодлыг бүрэн тусгах, тэмдэглэхдээ юуг анхаарах вэ?

Үнэлгээний баг хэнээс, хэрхэн, хэзээ, хэн (XXXX) цуглуулах вэ гэдгийг төлөвлөж, мэдээлэл цуглуулах удирдамж боловсруулах шаардлагатай. Үүнд өмнөх дүн шинжилгээнүүд маш чухал. Жишээ нь оролцогч талуудын дүн шинжилгээ нь хэнээс мэдээлэл цуглуулах хэрэгтэйг тодорхойлох чухал эх сурвалж болно.

Мэдээлэл цуглуулах арга зүй

Хэнээс	Уулзалт хийх, судалгаа авах, хоёрдогч мэдээлэл авах байгууллага, хүмүүс хэн бэ?
Хэрхэн	Ярилцлага хийх, ажиглах гэх мэт аргуудаас алийг ашиглах нь үр дүнтэй вэ?
Хэзээ	Мэдээлэл цуглуулах ажлыг хэзээ хийх нь үр дүнтэй вэ?
Хэн	Мэдээллийг цуглуулахдаа багаар хэрхэн ажиллах вэ, гишүүд ямар үүрэгтэй вэ?

Хэнээс мэдээлэл авах вэ гэдэг нь ХЭНБҮ-г хийж буй бодлого, төсөл, үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарна. Жишээ нь Тавантолгойн ХЭНБҮ-г хийхэд нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд оролцож буй 10 мянга орчим тээвэрчид, Цогтцэций сумын төвийн 6000 орчим иргэд, уурхай болон тээврийн зам дагуух малчид зэрэг маш олон хүний эрхийн асуудал хөндөгдөж байсан учраас маш олон байгууллага, иргэдээс мэдээлэл цуглуулах хэрэгтэй байсан. Ингэхдээ эрх эдлэгч, үүрэг хүлээгч талуудын төлөөллийг хангах, нийгмийн эмзэг, оролцоо хязгаарлагдмал бүлгээс мэдээлэл авах, жендерийн тэгш оролцоо зэргийг харгалзаж үзсэн.

Хэнээс мэдээлэл цуглуулах тухай жишээ

Орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөл, малчид, нүүрс тээврийн жолооч нар, төрийн байгууллагын ажилтнууд, аж ахуйн нэгжүүдийн удирдлага, ажилтнуудын төлөөлөл
Цогтцэций сумын төв болон Цагаан-Овоо багийн иргэдийн төлөөлөл (350 хүн) Нүүрс тээврийн жолооч нар (150 хүн)
Эмэгтэйчүүд, Цагаан-Овоо багийн иргэд, ахлах сургуулийн сурагчид, төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жолооч нар
Цогтцэций сумын төв ба Цагаан-Овоо баг, Тавантолгойн уурхай, нүүрс тээврийн зам, түүний дагуух зогсоолууд, Ханбогд сумын төв ба Жавхлантаг баг, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Гашуунсухайт боомт, Ганц мод боомтын иргэд, байгууллагуудын төлөөлөл

Судалгаанд оролцох хүмүүсийн талаарх мэдээллийг урьдчилан бэлтгэж, уулзалт ярилцлага хийхийн өмнө холбогдож уулзалтын цаг өдрүүдийг тохирч төлөвлөх нь үр дүнтэй байдаг.

Уулзалт, ярилцлага хийх хүмүүсийн нэрсийн жагсаалтын жишээ

№	Овог нэр	Эрхэлж буй ажил	Холбогдох утасны дугаар	Тайлбар
1		...сумын Засаг дарга		
2		Орлогч засаг дарга		
3		... ХХК-ний захирал		2005 онд сумын хуучин засаг даргаар ажиллаж байсан
4		ИТХ-ын дарга		
5		ЗДТГ дарга		

6		ИТХ-ын тэргүүлэгч гишүүн		Байгаль орчныг хамгаалах чиглэлээр олон жил ажилласан ИНБ-ын идэвхитэн
7		ИТХ-ын тэргүүлэгч		/...тосгоноос сонгогдсон/
8		Сав газрын захиргаа дарга		Өөр аймгаас ажлаа хийдэг
9		Сав газрын захиргаа мэргэжилтэн		Өмнө сав газрын даргаар ажиллаж байсан
11		... хөдөлгөөний тэргүүн		
14		Малчдын төлөөлөл		
15		ХХК-ийн ерөнхий инженер	дарга эзгүй тул Уурхай хариуцан ажиллаж байгаа

Мэдээллийг хэрхэн цуглуулах вэ гэдэг нь судалгааны ямар аргуудыг ашиглах вэ гэсэн үг юм. Энэ нь хэнээс мэдээлэл авах вэ гэдгээс ихээхэн хамаарна. Жишээ нь Тавантолгойн нүүрс тээвэрт оролцож буй жолооч, ажилтнуудаас мэдээлэл авахдаа асуулга судалгаа авах нь хангалттай юу, эсвэл бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага нэмж хийх хэрэгтэй юу гэдгийг тодорхойлох хэрэгтэй байсан.

Мэдээлэл цуглуулах аргууд нь өөрийн онцлогтой, давуу ба сул талуудтай байдаг учраас аль нь илүү үр дүнтэй вэ гэдгийг сайтар тооцож ашиглах хэрэгтэй. Олон аргуудыг хослуулан аль болох бүрэн дүүрэн, нарийвчилсан мэдээлэл цуглуулах нь үр дүнтэй байдаг.

Мэдээлэл цуглуулах зарим аргууд, тэдгээрийн онцлог, давуу ба сул талууд

Арга	Онцлог	Давуу тал	Сул тал
Ганцаарчилсан ярилцлага	Судалгаанд оролцогчтой ганцаарчлан уулзаж, урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу асууж, ярилцана. Ярилцлагыг нүүр тулсан байдлаар хийх нь давуу талтай боловч боломж, нөхцлөөс хамаарч интернет болон утсаар хийж болно.	<ul style="list-style-type: none"> Нээлттэй ярилцах Гол оролцогч талуудын дуу хоолойг сонсох Нарийн төвөгтэй, эмзэг асуудлыг тодруулах Дэлгэрэнгүй, өргөн цар хүрээтэй мэдээлэл авах 	<ul style="list-style-type: none"> Хувь хүний хэрэгцээнд хэт анхаарах Ярилцлага өгсөн талд хүлээлт үүсгэх Хугацаа их авах Төлөөллийг бүрэн хангахгүй байх
Бүлгийн ярилцага	Судлаач 5 болон түүнээс дээш тооны оролцогчидтой урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу ярилцлага өрнүүлнэ. Оролцогчдын төлөөллийг тэнцвэртэй хангаж, аль болох чөлөөтэй ярилцах нөхцлөөр хангах нь чухал байдаг.	<ul style="list-style-type: none"> Талуудын оролцоог хангах Хэлэлцүүлэг өрнүүлэх Хугацаа хэмнэх Зардал хэмнэх 	<ul style="list-style-type: none"> Зарим оролцогчид голлож ярих Зарим оролцогчид бусдаас эмээх Сэдвээс хазайх Талуудын төлөөлөл хангагдахгүй байх

Асуулга буюу анкетын судалгаа	Судлаач урьдчилан бэлтгэсэн анкетын дагуу судалгаанд оролцогчдоос мэдээлэл авна. Анкетын судалгаанд оролцогч өөрөө уншаад хариулж бичих эсхүл судлаач асуулт бүрийг асууж хариултыг тэмдэглэх хэлбэрээр хийж болно. Асуулгыг хэвлэсэн анкетаар болон цахим хувилбараар явуулж болно.	<ul style="list-style-type: none"> • Олон хүмүүсийг буюу төлөөллийг сайн хамруулах • Хугацаа хэмнэх • Өртөг багатай • Үр дүнг тоогоор илэрхийлэх 	<ul style="list-style-type: none"> • Түүвэр хийхэд алдаа гарах • Зарим оролцогчид дутуу хариулах • Нарийвчилсан, дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж бага
-------------------------------	--	--	---

Мэдээлэл цуглуулах аргуудаас үл хамааран судалгаанд оролцогчоос мэдээлэл авахдаа ямар дарааллаар, юуны тухай асуувал илүү үр дүнтэй гэдгийг сайтар төлөвлөөрэй. Ерөнхий үнэлгээний асуултуудыг тодорхойлоход нөлөөлөл, бодлого арга хэмжээ, үр дүн гэсэн шалгуурыг ашиглаж болдог. Нөлөөлөл нь тулгамдаж буй гол асуудлуудыг тодруулах зорилготой. Бодлого, тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор үүрэг хүлээгч, эрх эдлэгч, бусад талуудаас авсан арга хэмжээний тухай мэдээлэл авахад чиглэнэ. Үр дүнгийн хэсэг нь тэдгээр бодлого, арга хэмжээ хэрэгжсэн эсэх, асуудлыг шийдвэрлэхэд ямар ач холбогдолтой байсныг тодруулахад туслах ёстой. Доорх хүснэгтэд энэ 3 шалгуурын дагуу асуултаа хэрхэн тодорхойлохыг цэвэр усаар хангагдах эрхийн жишээн дээр танилцууллаа.

Мэдээлэл авах асуулт тодорхойлох жишээ

Шалгуур	Үнэлгээний асуултууд
<p><u>Нөлөөлөл:</u> Төсөл хэрэгжсэнээр хүний эрхийн хэрэгжилтэд нөлөөлөл байдал Эерэг нөлөөллийн хэлбэрүүд Сөрөг нөлөөллийн хэлбэрүүд</p>	<p>Төслийн улмаас цэвэр усаар хангагдах эрхэд ямар нэгэн байдлаар нөлөөлж болох уу? Цэвэр усаар хангагдах эрхийн хэрэгжилтэд ямар эерэг нөлөөлөл гарсан бэ? Цэвэр усаар хангагдах эрхийн хэрэгжилтэд ямар сөрөг нөлөөлөл гарсан бэ?</p>
<p><u>Бодлого, арга хэмжээ:</u> Төслийн баримт бичигт хүний эрхийн хэрэгжилтийг хангах зорилго бүхий бодлого, үйл ажиллагаа тусгагдсан эсэх Уг бодлогын хэрэгжилтэд хяналт дүн шинжилгээ хийгддэг эсэх Хүний эрхийг хангахад чиглэсэн тодорхой бүтэц, зохион байгуулалт байгаа эсэх Төслийн зүгээс хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн санаачилга, үйл ажиллагаа</p>	<p>Цэвэр усаар хангагдах эрхийг хангах талаар Төслийн баримт бичиг, бүтэц, удирдлагын системд ямар бодлого, үйл ажиллагаа тусгагдсан бэ? Хүний цэвэр усаар хангагдах эрхтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх механизм байнга ажилладаг уу? Төслийн улмаас цэвэр усаар хангагдах эрх зөрчигдсөн гэх гомдол сүүлийн 1 жил гарсан эсэх, эдгээр гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ? Иргэд тухайн бүс нутгийн цэвэр усны эх үүсвэрийн талаар мэдээлэл авах боломжоор хангагдсан уу? Ундны цэвэр усны хүрэлцээ хангамж сайжирсан уу? Хүний цэвэр усаар хангагдах эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааг журамлан тогтоосон уу? Хүний цэвэр усаар хангагдах эрхийн зөрчлөөс сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг Төслийн оролцогчдод явуулдаг уу?</p>

<p><u>Үр дүн:</u> Хүний эрхийн талаарх санаачлага, үйл ажиллагаа үр дүнд хүрсэн эсэх Үр дүнд хүрсэн эсэхийг бодитой тодорхойлох боломжтой эсэх</p>	<p>Төслийн үр дүнд хүний цэвэр усаар хангагдах эрхийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн бодлого, бүтцэд өөрчлөлт гарсан уу? Төслийн үр дүнд хүний цэвэр усаар хангагдах эрхийн асуудлаар гарсан гол ахиц дэвшил юу вэ? Хүний цэвэр усаар хангагдах эрхийн талаар хүрсэн үр дүнг төслийн бүх оролцогчид хүлээн зөвшөөрсөн эсэх Усны чанар, хүртээмжид ямар нэгэн өөрчлөлт гарсан уу?</p>
--	--

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

ХЭНБҮ-нд ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлага, асуулгын аргыг нилээд түлхүү ашигладаг. Эдгээрээс гадна хөндлөнгийн ба дотоод ажиглалт хийх, баримт бичгийн дүн шинжилгээ, цахим орчны мэдээллийн дүн шинжилгээ, газарзүйн мэдээллийн шинжилгээ зэрэг олон төрлийн аргууд байдаг. Эдгээрийн жишээг Тавантолгойн ХЭНБҮ-ний тайлангийн арга зүйн хэсгээс тодруулж үзээрэй.

Мэдээлэл цуглуулах ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлага, асуулгын аргуудын онцлог, эдгээрийг ашиглахдаа анхаарах зүйлсийг авч үзье.



Ганцаарчилсан ярилцлага

ХЭНБҮ хийхэд түгээмэл хэрэглэгддэг арга бол ярилцлага юм. Бидний өдөр тутмын амьдралд байдаг ярилцлагаас ялгаатай нь урьдчилан бэлтгэсэн асуудал болон асуултын хүрээнд зорилтот бүлгийн төлөөлөл болж чадахуйц хүмүүстэй хийдэг.

Ганцаарчилсан ярилцлагыг стандартчилсан, хагас стандартчилсан, стандартчилаагүй гэж 3 ангилдаг.

Ганцаарчилсан ярилцлагын төрлүүд

<p>Стандартчилсан ярилцлага</p>	<p>Ярилцлаганд оролцогчдоос ижил асуултуудыг, ижил дарааллаар асуудаг. Өөрөөр хэлбэл өмнө бэлтгэсэн стандарт бүтэц, агуулгаас хазайхгүй гэсэн үг.</p>
<p>Хагас стандартчилсан ярилцлага</p>	<p>Урьдчилж бэлтгэсэн стандарт асуултын дагуу оролцогч бүртэй ярилцаад хэрэв шаардлагатай бол шинэ, нэмэлт асуулт асуух, стандарт асуултаа хувиргаж асуух зэрэг уян хатан нөхцөлтэй.</p>
<p>Стандартчилаагүй ярилцлага</p>	<p>Урьдчилж бэлтгэсэн ерөнхий асуултуудыг судалгаанд оролцогчдын онцлогоос хамаарч янз бүрийн дарааллаар асуух, зарим асуултыг алгасах, ярилцлагын явцаас цоо шинэ асуулт тавих зэрэг чөлөөт ярилцлагын хэлбэртэй.</p>

Судлаач судалгаанд оролцогч бүрээс заавал асуух цөм асуултуудыг бэлтгэж, тухайн оролцогчийн онцлог, ярилцлагын явцаас хамаарч асууж болох асуултуудыг боловсруулдаг. Түүнчлэн, урьдчилж бэлтгээгүй асуултаас гадна шинээр асуулт асуух нь нээлттэй байна. Энэ арга нь судалгааны үр дүнд дүн

шинжилгээ хийхэд оролцогчдын хариултыг харьцуулах, тоон болон чанарын талаас нь нэгтгэн дүгнэхэд ач холбогдолтойгоос гадна оролцогчдын өгсөн чухал, онцлох мэдээллийг тодруулан авч үзэхэд хэрэгтэй байдаг.

Ганцаарчилсан ярилцлага хийхэд анхаарах зүйлс

Төлөвлөх	Ярилцлагыг хэнээс, хэзээ, хэдий хугацаанд авах талаар аль болох эртнээс төлөвлөж, тухайн оролцогчидтой холбогдож, амаар эсхүл бичгээр зөвшөөрөл авах хэрэгтэй.
Ярилцлага хийх удирдамж боловсруулах	Удирдамжид судалгааны зорилго, судлаачийн албан тушаал, ярилцлагын үргэлжлэх дундаж хугацаа, мэдээллийн нууцлал, ярилцлагын стандарт ба нэмэлт асуултуудыг тусгадаг.
Амьд яриа өрнүүлэх	Зарим туршлага багатай судлаачид зөвхөн асуулт асууж хариулт авах буюу “байцаах” байдлаар ярилцлага хийх тохиолдол байдаг. Энэ нь оролцогчдод тун уйтгартай бөгөөд бүрэн гүйцэд хариулт өгөх сэдэл, сонирхол төрүүлдэггүй. Тиймээс харилцан танилцах, энгийн ажил хэргийн яриа өрнүүлэх, хошигнох зэргээр оролцогчдыг идэвхжүүлж, судалгаанд “хамрагдагч” биш “оролцогч” болгож идэвхжүүлэх хэрэгтэй.
Төлөөллийг хангах	Ярилцлагад оролцогчдыг сонгохдоо ажлын байрны байршил, зэрэг дэв, нас, хүйс, ажлын туршлага зэргийг аль болох тэнцвэртэй хангахыг хичээх хэрэгтэй.
Ярилцлагын мэдээллийг бүрэн тэмдэглэх	Ярилцлагын үед бичлэг хийх бол оролцогчоос зөвшөөрөл авах хэрэгтэй. Бичлэг хийсний дараа мэдээллийг компьютерт шивж оруулан дуун болон текст хэлбэрээр тодорхой нэр, огноотой кодолж, архивлах хэрэгтэй. Заримдаа судалгаанд оролцогчид бичлэг хийхээс татгалзах, цааргалах тохиолдол байдаг. Энэ тохиолдолд ярилцлагын тэмдэглэлийг аль болох дэлгэрэнгүй бичиж тэмдэглээд, компьютерт шивж оруулан архивлах хэрэгтэй.



Бүлгийн ярилцлага

Бүлгийн ярилцлагыг заримдаа “Фокус бүлгийн ярилцлага” гэж нэрлэдэг. Энэ нь тодорхой нэгэн сэдэвт төвлөрч оролцогчдын байр суурь, туршлага, санаа бодлыг сонсоход ашигладаг. Бүлгийн ярилцлагыг судлаач чиглүүлэн явуулахаас гадна бусад судлаачид ажиглалт хийх, дуу хураах, тэмдэглэл хөтлөх зэргээр оролцож болдог.

Бүлгийн ярилцлагыг дараах зорилгоор ашигладаг. Үүнд:

- Судалгааны үндсэн арга болгож анхдагч мэдээлэл цуглуулах
- Нэмэлт мэдээлэл цуглуулах
- Ганцаарчилсан ярилцлага, асуулга зэрэг бусад аргуудтай хослуулан мэдээлэл цуглуулах

Бүлгийн ярилцлагын асуулт нь нээлттэй, төгсгөлтэй буюу “Тийм”, “Үгүй” гэж хариулахуйц биш байр сууриа чөлөөтэй илэрхийлэх зорилгод нийцэх ёстой. Судлаач оролцогч бүрийн оролцоог тэгш хангах, асуудлыг олон талаас авч хэлэлцэх нөхцөл бүрдүүлэх ур чадвартай байх хэрэгтэй. Бүлгийн ярилцлагыг зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Бүлгийн ярилцлага хийхэд анхаарах зүйлс

Төлөвлөх	Чиглүүлэгчийн үүргийг ухамсарлах
Бүлгийн ярилцлагыг хэнээс, хэзээ, хэдий хугацаанд авах талаар аль болох эртнээс төлөвлөж, тухайн оролцогчидтой холбогдож, амаар эсхүл бичгээр зөвшөөрөл авах хэрэгтэй. Оролцогчдын нэрсийн жагсаалт, ярилцлагын удирдамж зэргийг бэлтгэсэн байна. Удирдамж нь үндсэн зарчмын хувьд ганцаарчилсан ярилцлагын удирдамжтай ижил байх бөгөөд чиглүүлэгч болон түүний туслахын чиг үүргийг тодорхойлсон байдаг.	Бүлгийн ярилцлагыг чиглүүлэн явуулах хүн маш чухал үүрэгтэй. Чиглүүлэгч нь оролцогчдын байр суурь, хариултыг шүүмжлэх, сөргөхөөс зайлсхийж, оролцогчдод хүндэтгэлтэй хандах ёстой. Түүнчлэн чиглүүлэгч нь бусдыг сайтар сонсож, оролцогчдын үйл байдал, хэрэгцээг ажиглаж, уян хатан байх нь ярилцлагыг амжилттай явуулахад маш чухал.
Оролцогчдыг сонгох	Ярилцлагын мэдээллийг бүрэн тэмдэглэх
Дунджаар 6-12 хүнтэй бүлгийн ярилцлага зохион байгуулдаг. 6-аас цөөн бол олон янзын байр суурь, санаа бодлыг сонсоход хязгаарлагдмал байдаг. 12-оос дээш бол ярилцлагыг чиглүүлж явуулахад бэрхшээлтэй байна. Судлаач өөрөө судалгааны зорилгоос хамаарч оролцогчдыг хэрхэн сонгохоо шийднэ.	Бүлгийн ярилцлагын үед бичлэг хийх бол оролцогчдоос зөвшөөрөл авах хэрэгтэй. Бичлэг хийсний дараа мэдээллийг компьютерт шивж оруулан дуун болон текст хэлбэрээр тодорхой нэр, огноотой кодолж, хадгална. Заримдаа судалгаанд оролцогчид бичлэг хийхээс татгалзах, цааргалах тохиолдол байдаг. Энэ тохиолдолд бүлгийн ярилцлагын тэмдэглэлийг аль болох дэлгэрэнгүй бичиж тэмдэглээд, аль болох хурдан компьютерт шивж оруулах хэрэгтэй.



Асуулга

Хүн амын дундаас тодорхой шалгуур бүхий түүврээр сонгогдсон хүмүүсээс стандарт маягт ашиглан асуулга буюу анкетын судалгаа хийдэг. Асуулга судалгааны хуудас нь уншихад маш ойлгомжтой, асуулт нь аль болох богино хугацаанд ямар нэгэн эргэлзээ, үл ойлголцол үүсгэхгүйгээр хариулах боломжтой байх хэрэгтэй.

Анкетын асуултын хэлбэрүүд

Хаалттай: хариулт нь тогтсон сонголт бүхий

Нээлттэй: хариултыг урдаас тогтоогүй, хариулагч нөхөж бичих асуултууд

Нээлттэй төгсгөлтэй: хариултын хувилбарыг санал болгосон ч орхигдсон байж болзошгүй хувилбар нь нээлттэй үлдсэн асуулт

Олон сонголттой: хариултын хэд хэдэн хувилбарыг сонгох боломжтой асуулт

Анкетын асуултууд дараах зарчмын дагуу байх нь үр дүнтэй байдаг. Үүнд:

- Ойлгомжтой, салаа утгагүй, мэргэжлийн нэр томъёо хэрэглэхгүй байх
- Товчилсон болон гадаад үг хэллэг хэрэглээгүй байх
- Тулгасан шинжтэй, хэт нарийвчилсан асуултаас зайлсхийх
- Хариулахад цаг их зарцуулахгүй байх
- Нэг асуултаар нэг л агуулгыг илэрхийлэх
- Асуултыг бүтэн өгүүлбэрээр тавих

Асуулга судалгаанд оролцох хүмүүсийн түүврийг магадлалд тулгуурласан ба тулгуурлаагүй гэсэн 2 аргаар тодорхойлдог. Магадлалд тулгуурласан түүвэр нь хариулагч бүрийн сонгогдох магадлал мэдэгдэж байгааг хэлдэг. Тухайлбал: Нийт албан хаагчдын жагсаалтаас сугалаа, санамсаргүй тоон хүснэгт зэргийг ашиглан сонголт хийж болно. Эсвэл албан хаагчдыг нас, хүйс, ажилласан жил зэрэг бүлгүүдэд ангилж, бүлэг тус бүрээс сугалаа, тоон хүснэгтийн аргаар сонгож болно. Жишээ нь: Нийт хорооны хэсгийн ахлагч нарыг хүйс, ажилласан жилээр 8 бүлэгт ангилж, бүлэг тус бүрт орсон нэрсийн жагсаалтаас 4 хүн алгасан 5 дахь хүн бүрийг сонгож болно {1....1....1....1}.

Ажилласан жил	Эрэгтэй	Эмэгтэй
1 жил хүртэл		
2-3 жил		
4-5 жил		
5 жилээс дээш		

Магадлалд тулгуурлаагүй түүвэр нь хариулагчийн сонгогдох магадлал нь мэдэгдээгүй түүвэр байдаг. Тухайлбал судлаач өөрийн төсөөллөөр албан хаагчдаас санамсаргүй байдлаар сонгож болно. Ийм аргаар асуулга судалгаа хийхэд алдаа гарах магадлал өндөр. Жишээ нь: Ажлын байрны байршил, судлаачийн нас, хүйс, хувийн үзэл бодол зэргээс хамаарч нийт хүн ам буюу зорилтот бүлгийг төлөөлж чадахааргүй хүмүүс сонгогдох эрсдэлтэй.

Магадлалд тулгуурлаагүй түүврийн нэг хэлбэр нь судлаач хэд хэдэн хүнийг эхлэн сонгож, тэднээс судалгаа авсны дараа ийм судалгааг хэнээс нэмж авч болохыг тодруулж, нэмж судалгаа авах замаар түүвэр хийж болно. Үүнийг “Цасан бөмбөлгийн арга” гэдэг.

Асуулгын аргыг ашиглахад хийхэд анхаарах зүйлс

Мэдээлэл цуглуулах явцад гарч болох алдаанаас сэргийлэх

Мэдээлэл цуглуулах үйл явц нь системтэй, дэс дараалалтай, тогтсон удирдамж зааврын дагуу шударга болж байж үнэн зөв судалгаа гардаг

Анкетыг боловсруулахдаа цаг хугацаа, өртгийг харгалзах

Судалгаанд оролцогч 30 минутаас хэтрэхгүй хугацаанд хариулж дуусахуйц байхаар анкетын агуулгыг боловсруулах хэрэгтэй. Нэг удаагийн судалгаагаар маш олон сэдвээр олон асуулт асуух гэж зорих нь эрсдэлтэй. Зарим оролцогчид ажлын ачааллаасаа болж дутуу хариулах, дундажлан хариулах тохиолдол гардаг.

Анкетын асуултын хариултаас дүгнэлт хийх боломжтой байх

Зарим судлаачид санаанд орсон, чухал гэж бодсон бүх асуултаа анкетын судалгаанд оруулдаг ч төгсгөлд нь нэгтгэн дүгнэхэд бэрхшээлтэй байдаг. Асуулт бүрийг урьдчилан таамаглаж, хариултааас ямар дүгнэлт хийж болох тухай сайтар бодох хэрэгтэй.

4 АЛХАМ

НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЭЛИЙГ ШИНЖЛЭХ



Асуудлын дүн
шинжилгээ

Эрхэд үзүүлэх
нөлөөлөл

Урьдчилсан
дүгнэлт,
зөвлөмж

АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цуглуулсан олон төрлийн мэдээлэлдээ дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй асуудлуудыг судлан үзэж тодорхой баримт, нотолгоо бүхий дүгнэлт хийх хэрэгтэй.



Мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд судалгааны ямар арга ашигласнаас хамаарч тоон болон чанарын арга зүйг ашиглах, эсвэл хослуулах замаар дүн шинжилгээ хийж болно.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар цуглуулсан мэдээлэл нь тайлбар, хүүрнэл, түүх, сэтгэл хөдлөл зэрэг тоогоор илэрхийлэхэд бэрхшээлтэй бөгөөд сайтар сонсож, уншиж, эргэцүүлэн тунгаах, харьцуулах замаар утга агуулгыг тодорхойлох шаардлагатай мэдээлэл байдаг. Ийм мэдээлэлд боловсруулалт хийхдээ дараах аргачлалыг ашиглаж болно.

Ярилцлагын мэдээллийг боловсруулах арга

Ярилцлагын бичлэгийг сонсох, түүний тэмдэглэлийг сайтар унших

Ярилцлагын дэлгэрэнгүй тэмдэглэлийг уншиж гол хөндөгдөж буй ойлголтууд, асуудлуудыг ялгаж тэмдэглэх буюу кодлох

Кодолж тэмдэглэсэн ойлголт, асуудлуудын хоорондын уялдаа холбоо, адил төстэй талуудыг илэрхийлсэн сэдвүүдийг тодорхойлох

Ярилцлагын тэмдэглэлийг дахин уншиж өмнө тодорхойлсон сэдвүүд уялдаж буй эсэхийг нягтлах

Сэдвүүдийг нягтлан, шаардлагатай бол өөрчлөх, тодруулах

Сэдвүүдийн дагуу ярилцлагын дүнг тоймлон бичих, холбогдох ойлголт, сэдвүүдийг тэмдэглэсэн хэсгүүдээс жишээ татах

Ярилцлагын мэдээллийг боловсруулах аргын жишээ

Тулгамдсан асуудлууд	Орон нутгийн иргэд, малчид, жолооч нарын төлөөлөл				
	Онцлох ишлэл	Асуудлын шалтгаан	Асуудлын үр дагавар	Өнөөг хүртэлх арга хэмжээ	Цаашдын шийдэл
Сумын төв					
Тоосжилтоос үүдсэн агаарын бохирдол					
Цагаан-Овоо багийн иргэдийн эрх ашиг					
Хүн амын өсөлттэй холбоотой үүсч буй асуудлууд					
Сумын төвийн эрүүл, аюулгүй амьдрах орчин					
Унд ахуйн усны чанар, хүртээмж					
Нийгмийн асуудлууд					
Ажил эрхлэлтийг дэмжих бодлого					

Ярилцлагын мэдээллээс гол анхаарах асуудлыг тоймлосон жишээ

Тоосжилттой холбоотой тулгамдаж буй нийтлэг асуудлууд	Зарим онцлох жишээ
---	--------------------

<p>Өвчлөл</p> <ul style="list-style-type: none"> • Амьсгалын тогтолцооны өвчлөл, харшил маш их болсон. Ялангуяа, хүүхдүүдийн дунд өвчлөл ихэссэн. • Цогтцэцийд ирснээс хойш тоос шорооны харшилтай гэж оношлогдсон хүн олон. • Хавар болоход том хүн, хүүхэд гэлтгүй нийтээрээ тоосны харшил эхэлдэг. • Уул уурхайд ажилладаг хүмүүсийн хувьд архаг бронхит, ларингет зонхилдог. • Жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний үеийн хүндрэл гарах нь ихэссэн. • Их тоостой үед хоолой хорсох, хэлний уг, чихний уг загатнах зэргээр мэдрэгддэг. • Боллоцгоогүй айлын хүүхдүүд сургууль руугаа өглөө үүрээр алхахад утаа, машины тоос ихтэйгээс өвчлөл их гардаг. 	<p>“Салхи тогтуухан оройд бид агаар амьсгалж болохгүй, битүү тоос буудаг, үүнээсээ болоод амьсгалын замын өвчлөл тасрахгүй байна. 11 сараас ханиад тасардаггүй, эм тан уугаад л, гайгүй болно, дахиад л ханиалгаад байдаг”</p> <p>“Би өмнө нь харшилгүй байсан. Энд ирээд харшилтай болсон. Саяхан хот яваад 10 хоног харшлаа үзүүлээд ирсэн. Эмч нар тоосны харшил гэж оношилсон. Энэ мэтчилэн эрүүл мэндийн зардал нэмэгдсэн”</p>
<p>Санхүү, эд материалын хохирол</p> <ul style="list-style-type: none"> • Хувь хүн, өрхийн эрүүл мэндийн зардал нэмэгдсэн. • Ноос, ноолуур, махны чанар зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг бууруулдаг. • Гэрийн эд хогшил, өмч хөрөнгө тоос, шороонд дарагддаг. <p>Сэтгэл санааны дарамт</p> <ul style="list-style-type: none"> • Төрөх хүүхдийн эрүүл мэндэд маш их санаа зовж стресс үүсдэг. • Нялх хүүхдээ гадаа салхилуулахад эрсдэлтэй. • Сүрьеэ өвчин огцом нэмэгдэж байна гэж болгоомжилж байна. 	<p>“Тонус өгдөггүй эмэгтэй гэж бараг байхгүй болсон гэж эмэгтэйчүүдийн эмч ярьж байсан. Одоогоор урагт нөлөөлсөн зүйл байхгүй, яваандаа гарна”</p> <p>“Миний ойр дотны охид хүүхнүүдийн ярьж байгаагаар 2017, 2018 онд лав л 4, 5 ураг нь амьгүй болсон тохиолдол бий”</p> <p>“Өглөө эрт хичээлдээ явахад өвөл харанхуй байдаг. Нохой их дайрдаг, утаанд юу ч үзэгдэхгүй, дээрээс нь унаатай айлууд хүүхдээ хүргэх гээд олон машинууд явдаг болохоор битүү манарсан юманд л хүүхэд алхаж байдаг”</p> <p>“Манай нэг цагдаа эмнэлэгт үзүүлэл хамранд нь тоос ихээр орсноос идээт үрэвсэл үүссэн гэсэн онош гарсан”</p> <p>“Сүүлийн 5 жилд сүрьеэгийн 18 тохиолдол илэрчихээд байна. Энэ бол яах аргагүй тоосжилттой холбоотой. Ерөөсөө л амьсгалын замаар халдварладаг өвчин. Өвчин авчихаад тодорхой хугацаанд тээгээд бусдад халдаагаад яваад байдаг юм байна”</p>

Асуулгын судалгааны мэдээллийн ихэнх нь давтамж, хувь, дундаж зэрэг тоон утгаар илэрхийлэгдэх боломжтой. Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх эхний алхам бол асуулгын бүх асуултыг жагсааж, хариултын давтамж, хувийг тооцож бичих хүснэгт бэлтгэх юм. Үүнийг гараар бичих болон өөрийн хэрэглэдэг компьютерийн програм ашиглан хийж болно.

Тоон мэдээллийг нэгтгэх жишээ

Асуултууд	Хариултын сонголтууд	Хариултын давтамж (Тухайн хариултыг сонгосон хүний тоо)	Хариултын хувь (Нийт 83 хариултад эзлэх хувь)
Асуулт 1. Компанийн иргэдэд байгаль орчны нөлөөллийн талаарх мэдээлэл түгээх аргыг үнэлнэ үү.	Маш сайн 5	5	6
	Хангалттай 4	11	13
	Сайжруулах 3	33	40
	Хангалтгүй 2	7	8
	Маш тааруу 1	22	27
	Хариулаагүй 0	5	6
НИЙТ		Нийт 83 хүн	Нийт 100 хувь
Асуулт 2.			
Асуулт 3.			

Нээлттэй хариулттай асуултын мэдээллийг уншиж танилцаад утгын давхцал, ижил төстэй байдлаар нь 4-5 түлхүүр хариулт үүсгэж, түлхүүр хариулт тус бүрт дугаар оноож, тэр дугаарын дагуу хариултын давтамжийг тодорхойлдог.

Түүнчлэн, дундаж утга болон түгээмэл утга (хамгийн олон давтагдсан хариулт) тоон мэдээлэлд шинжилгээ хийх нийтлэг арга юм.

Дараах хүснэгтээр дундаж утга ба түгээмэл утгыг олох аргыг компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх бодлогыг 1-5 хүртэлх оноогоор үнэлэх асуултын жишээгээр харуулав. Дундаж утга нь харьцуулалт хийхэд үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, байгууллагын хэд хэдэн дотоод бодлогын хэрэгжилтийн талаар үнэлгээний дундаж утгыг харьцуулаад хамгийн бага дундаж утга бүхий асуудалд анхаарч болно гэсэн үг. Түгээмэл утга нь дундаж утгыг нягтлах, хариултуудын ерөнхий тархалтыг тодорхойлоход чухал.


Тоон мэдээллийн дундаж утга, түгээмэл утгыг тооцоолох жишээ

Асуултууд	Хариултын сонголтууд буюу харгалзах оноо	Хариултын давтамж	Нийлбэр утга	Дундаж утга	Түгээмэл утга
Асуулт 1. Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх бодлогыг 1-5 оноогоор үнэлнэ үү.	Маш сайн 5 Хангалттай 4 Сайжруулах 3 Хангалтгүй 2 Маш тааруу 1	5 11 33 7 22 (Нийт 83)	$5 \times 5=25$ $4 \times 11=44$ $3 \times 33=99$ $2 \times 7=14$ $1 \times 22=22$	Алхам 1. $25+44+99+14+22=204$ Алхам 2. $204 / 83 = 2.45$ Энэ асуултын хариултын дундаж утга нь 2.45	Хамгийн олон давтагдаж буй хариулт буюу 3 нь түгээмэл утга болж байна.

Асуулгын судалгааны мэдээллийг ихэнхдээ Майкрософт Эксел (Excel) болон статистик шинжилгээний программ хангамж ашиглан боловсруулж, дүн шинжилгээ хийдэг.

Тоон мэдээллийг нэгтгэн харуулсан жишээ

Нүүрс тээврийн жолооч нарын хувьд тулгамдаж буй гол асуудлууд (Асуулгын судалгааны нэгтгэсэн дүн, 2018 оны 3 сар)



Мэдээллийг олон эх сурвалжаас авсан бол хооронд нь харьцуулан нягталж үзээрэй. Үүнийг судлаачид “Гурвалжлах” арга гэдэг. Гурвалжингийн нэг тал болон 2 өнцгийн хэмжээг мэдэж байвал бусад талуудын урт болон өнцгийн хэмжээг олж чаддаг. Түүнтэй адилхан аль болох олон эх сурвалжаас мэдээлэл авна тэр хэмжээгээр асуудлыг бүрэн гүйцэд танин мэдэх боломж нэмэгдэнэ. Жишээ нь: Хэрэв бүлгийн ярилцлагаас мэдээлэл авсан бол түүнийгээ асуулгын судалгааны мэдээлэлтэй

харьцуулж үзэн дүгнэлт хийх нь үнэнд илүү ойртуулдаг.

Мэдээллийн олон эх сурвалжаас цуглуулсан мэдээллийн дүн шинжилгээ тус бүрийн тухайд зонхилох хандлагыг тодорхойлж, хооронд нь харьцуулан үзэж болно.

Мэдээллийн олон төрлийг харьцуулан авч үзсэн жишээ


Хүн амын тоо ойролцоо Ханбогд, Гурвантэс сумдын эмнэлгүүд 2017 онд 6900 болон 3111 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн бол энэ үзүүлэлт Цогтцэций сумын эмнэлгийн хувьд 2523 байна.¹⁴ Цогтцэций сумын эмнэлэг 2016, 2017 онуудад жилд дунджаар 15000 орчим үзлэг хийсэн байна. 2010 оноос өмнө хүн амын өсөлт хэвийн байх үед бусад сумдын адилаар жилд дунджаар 5000 орчим үзлэг хийдэг гэсэн тооцоолол байна.

Ажлын ачаалал маш их, нэг хүн гэхэд 2 хүний ажлыг хийж байна. Шөнийн цагаар их ажилладаг. Компаний ажиллагсад оройн цагаар ихэвчлэн ирдэг. 23.00 цаг хүртэл амбулаторын үзлэг шиг л байдаг. Илүү цаг гарахаар төсөв хөрөнгө хүрэхгүйгээс мөнгийг нь олгож чаддаггүй.

Цогтцэций сумын эмчтэй хийсэн ярилцлагаас

Асуудлын гинжин хэлхээ, шалтгааныг сайтар ойлгохын тулд янз бүрийн аргачлал ашиглаж болно. Эдгээр нь хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийн шалтгаан, түүний эсрэг хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Жишээ нь Тавантолгойн бүлэг уурхайн ойр орчимд болон Гашуунсухайтын зам дагуу нутаглаж буй малчин өрхүүдтэй уулзаж ярилцан, орчны ажиглалт хийсний үндсэн дараах 5 гол асуудал нэн тэргүүнд тулгамдаж байгааг тодорхойлж үзсэн болно. Үүнд тоосжилт, усны чанар, хүртээмж, бэлчээрийн доройтол хомсдол, малчдын аюулгүй амьдрах орчин, нөлөөллийн менежмент орсон. Асуудал тус бүрийн тухайд оролцогч талуудын бодлого, үйл ажиллагаа, холбогдох хууль эрх зүйн орчин, бусад хүчин зүйлсийг авч үзсэн.

Асуудлын шалтгааныг авч үзэх арга зүйн жишээ



Түүнчлэн, цуглуулсан мэдээллийн хүрээнд тодорхой тулгамдсан асуудлын эх сурвалж, нөлөөллийг тоймлон үзэх загваруудыг ашиглаж болно. Цогтцэций сумын төвийн орчмын тоосжилттой холбоотой мэдээллийг нэгтгэж дүгнэсэн жишээг доор танилцуулав.

Асуудлыг хүрээг тодорхойлох жишээ

Цогтцэций сумын төвийн орчим дахь тоосжилт

- Хүний эрүүл мэнд, ажиллах, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна.
 - Өвчлөлт - амьсгалын замын өвчин, жирэмсэн эхчүүдийн эрүүл мэнд, сүрьеэ,
 - Байгаль орчны нөлөөлөл (бэлчээр, ургамлын бүтэц)
 - Малын өвчлөл (нүд, уушги), ноос, ноолуурын чанар өөрчлөгдөх
- Тоосжилтын эх үүсвэр
 - Нүүрс тээвэрлэлт (хүнд даацын техник хэрэгсэл)
 - Уурхай үйл ажиллагаа (хөрс хуулалт, ачилт, буулгалт)
 - Орон нутгийн болон бусад тээврийн хөдөлгөөн
- Тоосжилтын нөлөөллийн бүс
- Уурхайн болон тээвэрлэлтийн ажилд оролцож буй иргэд
 - Уурхайн болон тээвэрлэлтийн бүс, замын дагуу ажиллаж, амьдарч байгаа иргэд (үүнд, нийтийн хоол, засвар, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлж буй иргэд багтана)
 - Уурхайн болон тээвэрлэлтийн бүс, замын ойролцоо амьдарч буй малчид
- Тоосжилтод нөлөөлж буй байгалийн хүчин зүйлс
 - Салхи (салхины чиглэл)
 - Бороо (ховор, гандуу)
- Одоогоор авч байгаа арга хэмжээ
 - Зам услах - үр дүн багатай
 - Сумын төвд хүнд даацын машины замын хаалт тавих
 - Засмалжуулах (ЭТТ-оос Цогтцэций хүртэлх 10.2 км зам)

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээний үр дүнд тодорхойлсон асуудлуудын хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг хөндөгдөж буй эрх тус бүрээр тодорхойлдог. Жишээ нь Тавантолгойн үйл ажиллагааны улмаас орон нутгийн малчдын хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг хөндөж буй дараах эрх тус бүрээр авч үзсэн. Үүнд: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, мэдээлэл авах эрх, ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх, өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх, эд хөрөнгө өмчлөх эрхийг авч үзсэн болно.

Хөндөж буй эрхийн талаарх дүгнэлтийн жишээ

Хөндөгдөж буй эрх: Эд хөрөнгө өмчлөх эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	17-р зүйл			16.3-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Хүн бүр хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх ёстой.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

2010 онд Цанхийн уурхайн нөлөөлөлд өртсөн 15 айл бүгд уурхайн тоос, дуу чимээ, хөрсний эвдрэлийн нөлөөллөөс холдон, өвөлжөө, хаваржаагаа орхин нүүсэн байдалтай байна. Нүүрс тээврийн жолооч нар зам дагуух малчдын худгаас ундны болон ахуйн зориулалтаар ус авдаг, ингэхдээ малчдын худгийг эвддэг, худгийн хажууд машинаа угаадаг байна.

Хөндөгдөж буй эрх: Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	19-р зүйл	19-р зүйл		16.16-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт хамгийн их ус ашиглаж буй Энержи Ресурс компанийн Нүүрс угаах үйлдвэрийн газрын доорх ус ашиглалт, түүнээс орчмын усны хүртээмжид үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл дутмаг байна. Эрдэнэс Тавантолгой компани нөлөөллийн бүс дэх малчдын худгийн усны түвшин, усны чанарын хяналт шинжилгээ хийдэг боловч хэмжилт хийх тогтсон цаг байдаггүй, иргэдийн оролцоо байхгүй, иргэдэд эргэж мэдээлэл өгдөггүй байна.

Улмаар нөлөөлөлд өртөж байгаа олон эрхүүдээс нэн түрүүнд арга хэмжээ авах шаардлагатай эсэхээр нь эрэмбэлж авч үзэх хэрэгтэй болдог. Энэ нь хамгийн ноцтой эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй түүнийг арилгах, эрх нь зөрчигдсэн иргэдийг хамгаалах, эрхийг нь сэргээхэд маш чухал.

Хүний эрхийн сөрөг нөлөөллийг түүний ноцтой байдал, хамрах хүрээ, эрхийг сэргээх боломж гэсэн 3 шалгуураар хэмжиж үздэг.

Хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг хэмжих шалгуураар үнэлэх жишээ

Шалгуур	Шалгуурын дагуу үнэлэх жишээ
Ноцтой байдал	Их: 15 настай барилгын ажилчин хамгаалалтын хэрэгсэлгүй ажил хийсэн. Бага: 15 настай рестораны үйлчлэгч насанд хүрэгчдээс 10 хувийн бага цалин авсан.
Хамрах хүрээ	Их: Сумын төвийн иргэдийн амьсгалын замын өвчлөл өнгөрсөн жилээс 30 хувиар нэмэгдсэн. Бага: Замын ажлын улмаас 2 айлыг нүүлгэн шилжүүлсэн.
Эрхийг сэргээх боломж	Их: Ажлаасаа үндэслэлгүй халагдсан иргэний эрхийг шүүхээс сэргээж эргүүлэн томилсон.

Бага: Барилгын ажилчин том оврын техникт дарагдаж хүнд бэртсэн.

Эдгээр 3 шалгуурын зэрэгцээ илрүүлж тодорхойлсон эрхийн зөрчил, сөрөг нөлөөллийн дахин давтагдах магадлалыг тооцох нь чухал юм. Ялангуяа хуулийн хэрэгжилт, хяналт төдийлэн хангалттай биш нөхцөлд энэ магадлалыг авч үзэх хэрэгтэй.

Хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг хэмжих шалгуурын нарийвчилсан үзүүлэлт

Шалгуур	Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, анхаарч үзэх эрэмбийг тодорхойлох, ингэхдээ дараах шалгуурын дагуу 1-3 хүртэлх оноогоор үнэлнэ.
Ноцтой байдал /Н/	(3) Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц (2) Хүний амьдралын суурь нөхцөл, хэрэгцээг хязгаарласан, өмч хөрөнгөд хохирол учруулсан (1) Бусад нөлөөлөл
Хамрах хүрээ /Х/	(3) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 50-иас дээш хувь (2) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10-50 хувь (1) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10 хүртэлх хувь
Эрхийг сэргээх боломж /Э/	(3) Бэрхшээлтэй: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгоход олон хүчин зүйлээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөхгүй байх магадлал их, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж муу (2) Харьцангуй бололцоотой: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь харьцангуй цөөн хүчин зүйлсээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж бий (1) Хялбар: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь олон хүчин зүйлсээс хамаарахгүй, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх өндөр магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж ихтэй

Дээрх шалгуур тус бүрийн дагуу нөлөөллийг үнэлсэний үндсэн дээр хөндөгдөж буй эрхүүдийг эрэмбэлж үзэх боломжтой. Өөрөөр хэлбэл нөлөөллийн хүч, зөрчлийн хүнд, хөнгөнийг тогтоож, холбогдох арга хэмжээг тодорхойлно.



Нөлөөлөлд өртөгч эрхүүдийн эрэмбийг тогтоох жишээ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I	Амьд явах эрх	3	1	3	3
	Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх	2	3	2	3
	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	2	3	2	3
	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	2	3	3	3
II	Халдашгүй дархан байх эрх	2	1	2	2

III	Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх	2	2	1	2
	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	1	3	2	2

5 АЛХАМ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ



Энэ хэсэгт үнэлгээ хийхээр сонгосон бодлого, төсөл, бизнесийн үйл ажиллагааны талаар аль болох бүрэн гүйцэд ойлгож, анхаарч судлах, тулгамдаж буй асуудлуудын хүрээг тодорхойлдог. Ингэхийн тулд суурь мэдээллийн дүн шинжилгээ хийх, анхаарч буй асуудал ба хүний эрхийн уялдаа холбоог ойлгох, оролцогч талуудын дүн шинжилгээ хийх шаардлагатай байдаг. Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзье.


ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

ХЭНБҮ-г хийх явцад оролцогч талуудын оролцоог хангах, зөвлөлдөх нь түүний салшгүй бүрдэл байх ёстой. Ялангуяа эрх эдлэгч талууд буюу нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдтэй үнэлгээний төлөвлөлтөөс эхлэн зөвлөлдөж, санаа бодлыг нь харгалзаж үзэх хэрэгтэй.

Мэдээлэл цуглуулсан аргын тухай нээлттэй, оролцооны зарчмаар зөвлөлдөх нь дүн шинжилгээ хийж, үр дүнтэй зөвлөмж гаргахад маш чухал. Энэ нь үнэлгээний үр дүн, зөвлөмжийг талууд хэлэлцэх, цаашид үйл ажиллагаандаа тусгахад чухал ач холбогдолтой. Мөн өмнө нь тооцоолоогүй байсан мэдээллийн эх сурвалж, оролцогч талуудыг илрүүлэх, зарим мэдээллийг дахин нягтлах боломж олгодог. Үнэлгээ нь талуудыг маргаан, зөрчилдөөнд түлхэх, буруу ойлголцол төрүүлэхээс сэргийлэх хэрэгтэй.

Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах олон арга хэлбэр байдаг бөгөөд хэнийг хамруулж буй, хэр зэрэг албан ёсны арга хэмжээ болох, ямар мэдээлэл харилцааны хэрэгсэл ашиглаж буй зэргээс хамаарна.¹⁵

Хэлэлцүүлгийн арга, хэрэгслүүд



Үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоог хангах нь зөвхөн ХЭНБҮ-ний тухайд тавигддаг шаардлага биш юм. Тухайлбал 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журамд олон нийтийн оролцоог хангахад баримтлах зарчмыг тодорхойлсон байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах зарчим

- Мэдээллийг түгээж, ил тод хүртээмжтэй байлгах;
- Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, түүнийг санаачлан боловсруулагч салбарын яам, төсөл хэрэгжүүлэгч болон нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд хоорондын мэдээлэл солилцох, зөвлөлдөх, зөвшилцөх боломжийг хангах;
- Төслийн учирч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, хянах тогтолцоог бүрдүүлэхэд шинжлэх ухааны загвар, тоон мэдээллийг оролцогч талуудын санал бодолтой хослуулах;
- Оролцогч талууд үнэлгээний үйл явцад хариуцлагатай хандах;

Уг журамд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний төрлөөс хамаарч үнэлгээний багаас олон нийт, оролцогч талуудын оролцоог хэрхэн хангах талаар заасан байна.

Үнэлгээний багаас талуудын оролцоог хангах арга замууд

- Нөлөөллийг тогтоох, таамаглах, үнэлэх үе шат бүрт олон нийтийн оролцоог хангах
- Нөлөөллийг таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах
- Нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах
- Нөлөөллийн үнэлгээний тайланг олон нийтэд нээлттэй байлгах
- Олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан арга хэлбэр, гарсан санал, шүүмжийг хэрхэн тусгасан талаар тайланд тусгах

ХЭНБҮ-г хэрэгжүүлэхэд олон нийт, оролцогч талуудын оролцоог хангах нь олон талын ач холбогдолтой байдаг. Талуудын оролцоог хангахад өмнө танилцуулсан оролцогч талуудын дүн шинжилгээ чухал ач холбогдолтой.

Хэлэлцүүлэгт өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, ажилгүй иргэд зэрэг нийгмийн эмзэг хэсгийнхний оролцоог хангах, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн, ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж болно.

ХЭНБҮ-г хийх бүхий л үе шатанд оролцогч талуудын оролцоог хангахдаа жендерийн мэдрэмжтэй байх нь чухал бөгөөд дараах асуудлуудыг харгалзаж үзээрэй.

Оролцоог хангахад харгалзах жендерийн асуудлууд

- Үнэлгээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүст учруулж буй харилцан ялгаатай нөлөөллийн талаар авч үзсэн үү?
- Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулах багт эмэгтэй хүн орсон уу?
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс судалгаанд оролцож санаа бодлоо илэрхийлэхэд хязгаарлаж байгаа хүчин зүйлс бий юу?
- Эмэгтэйчүүдийн оролцоог хангахад анхаарч хэлэлцүүлэг зохион байгуулах газар, цагийг уялдуулсан уу?
- Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх тэгш, идэвхтэй оролцоог хангасан уу?
- Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн санаа бодлыг бүрэн тэмдэглэж, тайланд тусгаж чадсан уу?

ҮР ДҮНТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХЭНБҮ-ний урьдчилсан дүнг оролцогч талуудад танилцуулах ажлыг дараах үе шатуудын дагуу зохион байгуулж болно.

Хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөнд тусгах асуудлууд

<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний урьдчилсан дүгнэлт, зөвлөмжүүд бүхий товч баримт бичиг, мэдээллийн хуудас, танилцуулга бэлтгэх
<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлгийг зохион байгуулах хөтөлбөр, газар, цагийг эрх эдлэгч болон оролцогч талуудын саналыг тусгаж тогтоох
<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшил, төрийн байгууллагууд буюу үүрэг хүлээгч талын зүгээс байгууллагаа бүрэн төлөөлж оролцох албан тушаалтантай холбогдож оролцоог баталгаажуулах
<ul style="list-style-type: none"> • Эрх эдлэгч, оролцогч талуудад зар мэдээ, урилга хүргүүлэх, хөтөлбөр болон холбогдох баримт бичиг, мэдээллийн хуудсыг хавсаргах
<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлэгт оролцохоор урьдчилан мэдэгдсэн хүмүүсийг оролцогчдын бүртгэлийн хуудсанд бүртгэх
<ul style="list-style-type: none"> • Оролцогчдын бүртгэлийн хуудас бэлтгэн хэлэлцүүлэгт оролцохоор танхимд ирсэн хүмүүсийг бүртгэх
<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөх, баримтжуулах
<ul style="list-style-type: none"> • Оролцогчдын саналыг цуглуулах, бүртгэх саналын товъёог бэлтгэх

Үнэлгээний багийн зүгээс үнэлгээний урьдчилсан дүнг танилцуулахдаа оролцогч талуудын онцлог, чадавх, цаг хугацааны байдлыг харгалзаж үзэх нь чухал байдаг. Хуулийн болон шинжлэх ухааны нарийн мэргэжлийн хэллэг эсвэл хэт ерөнхий буюу бүрхэг тайлбар дүгнэлтээс татгалзах хэрэгтэй. Танилцуулгыг олон хүнд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхийн тулд үзүүлэн материал давхар ашиглах, зураг, бодит жишээ, хүснэгт, графикийг танилцуулга буюу илтгэлдээ оруулаарай. Ингэснээр бичиг үсэггүй, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй гээд хэлэлцүүлэгт оролцож буй бүх хүмүүст мэдээллээ жигд хүргэх боломжтой юм.¹⁶

Хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулахад чиглүүлэгчийн үүрэг маш чухал. Ялангуяа, оролцогч талуудын тэгш оролцоог хангах, анхаарч буй асуудалд төвлөрсөн олон талын үзэл бодлын мэтгэлцээн өрнүүлэх, судалгаанд тусгагдаагүй шинэ мэдээлэл, баримт, асуудлыг илрүүлэх, ухааж ойлгоход чухал үүрэгтэй. Тийм учраас чиглүүлэгчийн хувьд хэлэлцүүлэгт сайтар бэлтгэх шаардлагатай байдаг. ХЭНБҮ-ний хэлэлцүүлгийг хийх үед талуудын хооронд хурц ширүүн асуулт, хариулт өрнөх, улмаар харилцан хариуцлага нэхсэн зөрчилдөөн гарах тохиолдол байдаг. Нэгэнт хүний эрхийн зөрчил, талуудын үүрэг, хариуцлагын асуудал яригдаж буй учраас аль нэг талыг буруутгах аргагүй юм. Харин хэлэлцүүлгийг удирдан чиглүүлж буй хүний зүгээс үүнийг аль болох үр ашигтай мэтгэлцээн рүү чиглүүлэх шаардлагатай байдаг. Чиглүүлэгч нь сэдвийн хэн нэгнийх нь талд орж болохгүй нэн ялангуяа хурцадмал байдал үүсэхэд уур амьсгалыг зөөлрүүлэх аргуудыг ашиглаарай.

Хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг бүрэн тэмдэглэж, дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Зарим ээдрээтэй, нөлөөллийн цар хүрээ ихтэй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд олон тооны хоорондоо зөрчилдсөн олон санал хүлээн авах тохиолдол гардаг.¹⁷

¹⁶ Сонгогчдын Боловсрол Төв. Иргэний танхим-Иргэний оролцоо: гарын авлага.

¹⁷ Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл. Олборлох салбарт олон

Хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг судлах нь

- Хүлээн авсан санал зөвлөмжийг нягтлан шалгаж, утга санааг нь зөв ойлгосон эсэхийг баталгаажуулах
- Хүлээн авсан бүх саналуудыг ангилах, дотоод товъёог бэлтгэх
- Саналуудын тоо, хэн хэлсэн, юуны тухай зэргээр шинжлэх
- Үнэлгээний явц, дүнтэй холбоотой саналуудад хариу тайлбар бэлтгэх
- Нэмэлт хэлэлцүүлэг хийх хэрэгцээг тодорхойлох
- Хэлэлцүүлгийн тайланг боловсруулах, дүнг үнэлгээний тайланд оруулах

Тавантолгойн ХЭНБҮ-ний урьдчилсан дүнг оролцогч талуудаар хэлэлцүүлэх уулзалтыг үнэлгээний баг ХҮЭК, Цогтцэций сумын удирдлагатай хамтран сайтар бэлтгэж зохион байгуулсан нь маш үр дүнтэй болсон. Энэ талаарх мэдээллийг уг үнэлгээний тайланд тусгайлан оруулсан юм.

Тавантолгойн ХЭНБҮ-ний урьдчилсан дүнг танилцуулах зөвлөлдөх уулзалтын тухай

Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүрээнд Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний урьдчилсан тайланг орон нутгийн засаг захиргаа, иргэд, бизнесийн байгууллага зэрэг оролцогч талуудад танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх, санал зөвлөмж боловсруулах зорилго бүхий олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд зохион байгуулсан.

Энэхүү олон талт хэлэлцүүлэгт ХНХЯ, Цогтцэций сумын ИТХ, ЗДТГ-ын дарга, ажилтнууд, Авто тээврийн үндэсний төв, Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс болон Тавантолгой ХК, Гашуун сухайт авто зам, нүүрс тээвэрлэгч компаниудын удирдлагууд, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумын Засаг захиргаа, иргэд, малчдын төлөөлөл, Цогтцэций сумын жижиг, дунд бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцож, тус тусын байр сууриа илэрхийлж, санал солилцсон.

Хэлэлцүүлэгт Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс болон Тавантолгой ХК-ийн шийдвэр гаргах эрх бүхий удирдах ажилтнууд оролцож, эдгээр компани байгалийн баялгийг зохистой ашиглах, байгаль орчны холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллаж буй талаараа товч танилцуулсан.

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний урьдчилсан тайлангийн гол дүгнэлт, санал зөвлөмжийг судалгааны багийн ахлагч, доктор Д.Бямбажав танилцууллаа. Үнэлгээний тайланд байгаль орчин, орон нутгийн түншлэл, хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэг өргөн хүрээтэй, олон асуудалд холбогдох хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг тусгаж, зохих санал зөвлөмжийг боловсруулсан байна. Танилцуулга мэдээлэл сонссоны дараагаар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгийн явцад Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэгт холбогдох хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах, төслөөс үүдэлтэй байгаль орчинд, хүн амын бүлгүүдэд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх талаар олон тооны санал дэвшүүлж, харилцан ярилцсан юм.

Уул уурхайн компаниуд нь талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан тээвэрлэлтийн гэрээ байгуулж ажиллах, ингэснээр жолооч нарын хувийн хариуцлага бус, компани хариуцлага хүлээдэг тогтолцоотой болох, уул уурхайн компаниуд тулгарсан

байгаль орчны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх хамтын сан, хамтын зөвлөлтэй болох, байнга зөвшилцөх замаар сангийн хэмжээг өргөтгөх, Цагаан овоо багийг нүүлгэн шилжүүлэх, сумын төвийг чиглэсэн том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тээвэрлэлтийг хязгаарлах, шинэ маршрутаар явуулах, сум, багийн төвийн орчинд мод тарих, цэцэрлэгжүүлэх, залуучууд руу хандсан нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх зэрэг саналууд гарч, тухай бүрд тайлбар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнөсөн.

Хэлэлцүүлгийн төгсгөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний гол үр дүн нь нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд гарч буй хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор оролцогч талууд хоорондын зөвшилцлийн механизм бүрдүүлэх тухай Үнэлгээний тайланд гаргасан саналыг талууд бүгд дэмжиж, хамтран ажиллахаар санал нэгдсэн болно. Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд байгаль орчны, хог хаягдлын, тээвэрлэлтийн талаар нэгдсэн хяналт, мониторингийн тогтолцоотой болох, тулгарч буй бэрхшээл, саадыг шийдвэрлэх хүчин чармайлтыг хамтран гаргах, шаардлагатай төсөв, хөрөнгийг дундын санд төвлөрүүлж, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байх нь хамгийн зөв шийдэл гэдэгт санал нэгдлээ. Үүний зэрэгцээ зөвхөн дээрх 3 компани төдийгүй тус ордтой холбоотой ханган нийлүүлэлт хийж буй шатахуун түгээх, тээвэрлэлт, хүнсний үйлчилгээ зэрэг бусад компанийг нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд татан оруулж, хамтран ажиллах нь зөв гэсэн байр суурийг оролцогчид илэрхийлсэн болно.

Гэхдээ оролцогч талуудын зөвшилцлийн механизм бүрдүүлэх нь бүх талуудын хүчин чармайлт, харилцан ойлголцол, хөрөнгө оруулалт шаардах тул энэ ажлыг ХЭҮК болон Өмнөговь аймгийн Засаг даргын тамгийн газар хамтран дундын мэдээлэл харилцаа, зохицуулалтыг хийж, эхлэлийг тавьж өгөхийг хэлэлцүүлэгт оролцогчид хүссэн болно.

6 АЛХАМ

ДҮГНЭЛТ,
ЗӨВЛӨМЖ ТАНИЛЦУУЛАХ

Дүгнэлт хийх

Зөвлөмж
боловсруулахОлон нийттэй
харилцах

ДҮГНЭЛТ ХИЙХ

ХЭНБҮ-ний төгсгөлд үнэлгээний үр дүнд тодорхойлсон үндсэн асуудлууд, тэдгээрээс хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг авч үзсэн шинжилгээг нэгтгэн дүгнэнэ. ХЭНБҮ-ний тайлан том хэмжээтэй, асуудлыг олон талаас дэлгэрэнгүй авч үзсэн дүн шинжилгээ байдаг учраас гол үр дүнг эргэн авч үзэж, нэгтгэж танилцуулах нь чухал юм.


Үнэлгээний дүгнэлтийг янз бүрийн хэлбэрээр хийж болно. Зарим ХЭНБҮ-ний тайланд хүний эрх тус бүрт нөлөөлж буй нөлөөллийн эрчим, цар хүрээг тодорхой шалгуурын дагуу эрэмбэлж танилцуулсан байдаг.

Дүгнэлтийг хүний эрхэд нөлөөлж буй асуудал тус бүрээр хийх жишээ хүснэгт

Хүний эрхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс				
Бага цалин хөлс				
Ноцтой байдал	Хамрах хүрээ	Эрхийг сэргээх боломж	Дахин давтагдах магадлал	Бодлого, үйл ажиллагааг өөрчлөх боломж
Эвлэлдэн нэгдэх эрхийн хязгаарлалт				
Ноцтой байдал	Хамрах хүрээ	Эрхийг сэргээх боломж	Дахин давтагдах магадлал	Бодлого, үйл ажиллагааг өөрчлөх боломж

Олон цогц асуудлыг хамарсан, маш олон хүний эрхийн нөлөөллийн дүгнэлт хийж буй тохиолдолд дээрх аргыг хэрэглэхийн зэрэгцээ гол асуудлуудыг хэд хэдэн сэдэв болгон бүлэглэх, улмаар сэдэвчилсэн үнэлгээний дүгнэлтийг тус бүрт нь хийж болно.


Тавантолгойн ХЭНБҮ-ний дүгнэлтийг хийсэн арга зүй



ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ


ХЭНБҮ-ний зөвлөмж нь дүгнэлттэй шууд уялдаатай, хүний эрхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар бодлогын болон үйл ажиллагааны ямар тодорхой өөрчлөлт шаардлагатай болохыг тодорхой илэрхийлсэн байх хэрэгтэй. Тодорхой зөвлөмж боловсруулах гол тулгуур нь үнэлгээний явцад цуглуулж дүн шинжилгээ хийсэн мэдээлэл, оролцогч талуудын санаа бодол, зөвлөмжүүд байдаг. Зарим сөрөг нөлөөллийг үүсгэж буй шалтгаан харьцангуй тодорхой бөгөөд эгзэгтэй байдаг бол зарим нь нарийн ээдрээтэй, хуримтлагдсан шинжтэй байдаг. Энэ тохиолдолд асуудлын суурь шалтгааныг шинжлэх оюуны аргуудыг ашиглах хэрэгтэй байдаг.

Суурь шалтгааны шинжилгээ хийх жишээ загвар



Зөвлөмжийг боловсруулахад тухайн хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн эрчим, цар хүрээ зэргээс хамаарч ямар арга замуудыг санал болгосон нь илүү үр дүнтэй вэ гэдгийг сайтар тунгаах хэрэгтэй гэж үздэг. Үүнд нөлөөллийн менежментийн шатлалыг ашиглаж болно. Энэ шатлалыг байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд нилээд ашигладаг. Сөрөг нөлөөллийн эсрэг хамгийн үр дүнтэй арга зам бол нөлөөллийг арилгах гэж үздэг. Түүний дараа нөлөөллийг бууруулах, ингээд зөрчигдсөн эрхийг сэргээх, эцэст нь нөхөн олговор буюу орлуулах арга байдаг. Гэхдээ хүний эрхийн үнэлгээнд орлуулах арга замыг зөвлөхдөө маш болгоомжтой хандах хэрэгтэй юм.

Нөлөөллийн менежментийн шатлал



Зарим үнэлгээний тайланд зөвлөмжийг хүний эрхийн нөлөөллийн эрэмбийн дагуу тусгасан байдаг.

Асуудлын эрэмбэ дарааллаар зөвлөмж танилцуулах жишээ хүснэгт

Асуудлын эрэмбэ	Сөрөг нөлөөлөл	Зөвлөмжүүд

Тавантолгойн ХЭНБҮ-ний тайланд зөвлөмжүүдийн сэдэвчилсэн асуудал тус бүрээр бүлэг бүрийн төгсгөлд танилцуулсан бөгөөд тайлангийн төгсгөлд ерөнхий зөвлөмжүүдийг оруулсан. Энэ нь тухайн бүлэг асуудал тус бүрт харгалзах оролцогч талуудад илүү ойлгомжтой, тодорхой болгох зорилготой байсан.

Тавантолгойн ХЭНБҮ-ний сэдэвчилсэн зөвлөмж

- Орон нутгийн малчдын эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
- Мэргэжлийн байгууллагаас тоосжилтыг олон цэгт, тогтмол, ил тод байдлаар мониторинг хийж, тоосжилтын тархалт, тоосонцорын агууламж, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлох

- Суваг шуудууг байгуулахдаа эрсдлийг тооцох, огцом хазгай, бороо хураар шавар үүсэх буюу мал шаварт шигдэх, мал унахаас сэргийлсэн байдлаар засах
- Тавантолгойн бүлэг уурхайн төлж буй ус ашигласны төлбөрийн зохих хэсгийг зориулалтын дагуу сум орон нутгийн усны нөөцийг нэмэгдүүлэх, малчдын худаг, уст цэгүүдийг нэмэгдүүлэх, сайжруулахад зарцуулах
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх
- Зам дагуух малчид гомдол саналаа илгээх, шийдвэрлүүлэх механизм бий болгох
- Эрдэнэс Тавантолгой компанийн Цанхийн уурхайн 2015-2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Улаан нуурын талаарх орон нутгийн удирдлага, нутгийн иргэдийн илэрхийлсэн санал гомдлын дагуу арга хэмжээ авах
- Цанхийн уурхайн биет ба биет бус нөлөөлөлд өртсөн малчдын судалгааг гаргаж, нөхөн олговор болон тогтвортой амьжиргааг дэмжих шаардлагатай хөтөлбөрийг хэрэгжүүлэх

ХЭНБҮ-ний дүгнэлт, зөвлөмжийн дагуу эерэг өөрчлөлт гарч, хүний эрхийн хэрэгжилт хангагдах нь түүний үр дүнг илэрхийлэх гол үзүүлэлт юм. Зарим үнэлгээнд зөвлөмжүүдийг боловсруулахдаа хэрэгжих магадлал, бололцоог тооцож үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл хичнээн чухал, асуудлыг нэг мөр шийдэж чадах боловч бодит орчинд хэрэгжих магадлал маш бага арга замуудыг зөвлөх үү эсвэл хурдан шуурхай хэрэгжиж хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээнд бууруулах арга замыг сонгож зөвлөх үү гэдгийг харгалзах хэрэгтэй юм.

Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг оролцогч талуудад танилцуулах, бодлогын эерэг өөрчлөлтөд нөлөөлөх дараах арга замууд байдаг. Үүнд:

- Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг оролцогч талуудад танилцуулахдаа тэдгээрийн онцлогт тохирсон хэлбэр, хэмжээ, арга хэрэгслийг сонгох
- Үнэлгээний тайланг олон нийтэд нээлттэйгээр байршуулах, хэвлэн нийтлэх, ингэхдээ эрх эдлэгч талын байр суурийг харгалзах
- Үнэлгээний хураангуй тайланг олон нийтэд нээлттэй байршуулах, хэвлэн нийтлэх
- Үнэлгээний үр дүн, гол дүгнэлт зөвлөмжүүдийг олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглах
- Эрх эдлэгч болон бусад оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт, хамтын ажиллагааг эхлүүлэх
- Үүрэг хүлээгч талын төлөөлөлтэй тусгайлан уулзалт зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмжийг танилцуулах
- Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мониторинг хийх, дүгнэлтийг олон нийт, оролцогч талуудад танилцуулах

Үнэлгээний үр дүнд гарсан өөрчлөлтийн жишээ

Тавантолгойн ХЭНБҮ-ний үр дүнд Монгол улсын Засгийн Газар, холбогдох яамд, уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Тухайлбал “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтэд үүсч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаас гаргасан 1 дүгээр албан даалгаврын дагуу жолооч нарыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулж, тээврийн замд амрах ариун цэврийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт орох боломжоор хангах, шаардлага хангасан хоол хүнсээр үйлчлэх нөхцлийг бий болгох ажлыг эхлүүлсэн байна. Улмаар, Монгол Улсын Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг богино хугацаанд барьж ашиглалтад оруулах ажил эхэлсэн, Цогтцэций сум орчмын авто замын ажлууд хийгдсэн, АТҮТ-өөс хяналт тавьж ажиллах байцаагчдынхаа тоог нэмэгдүүлснээр жолооч нарын бичиг баримтын зөрчил буурч, хуурамч үнэмлэхтэй, мэргэжлийн ур чадвар сул, туршлага багатай жолооч нар хууль бус тээвэрлэлт хийх явдал буурсан эерэг үр дүнгүүд гарсан.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь тухайн жилийн хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг тодорхойлон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүр УИХ-д өргөн барьдаг. 2018 оны ээлжит илтгэлд ХЭНБҮ хүрээнд хийсэн хяналт шалгалт, судалгаанд үндэслэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх: Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт ба иргэдийн оролцоо”, “Нийслэлийн хот төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал” 2 бүлгийг боловсруулж, УИХ-аас шийдвэр гаргуулахаар 6 саналыг хүргүүлжээ.

Илтгэлийг 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолыг баталсан. Үүний үр дүнд **Тогтоолын 1.3.а хэсэг:** эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; **Тогтоолын 1.3.б хэсэг:** ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн байгаа орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгаж, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг Засгийн газарт даалгасан нь бодлого, хууль зүйн шинжилгээний нөлөөллийн томоохон ажил болсон юм.

ХАВСРАЛТ

Хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээ18

	Гэрээ	Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр
1.	Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц Парис, 1948.12.09	1967.04.05
2.	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц. Нью-Йорк, 7 March 1966.03.07	1969.09.05
3.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. Нью-Йорк, 1966.12.16	1976.01.03
3.a.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол. Нью-Йорк, 2008.12.10	2013.05.05
4.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Нью-Йорк, 1966.12.16	1976.03.23
5.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол. Нью-Йорк, 1966.12.16	1991.07.16
6.	Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц. Нью-Йорк, 1968.11.26	1971.11.11
7.	Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц. Нью-Йорк, 1973.11.30	1976.07.18
8.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц. Нью-Йорк, 1979.12.18	1981.09.03
8.a.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт. Нью-Йорк, 1995.12.22	Хүчин төгөлдөр болоогүй байна
8.b.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол. Нью-Йорк, 1999.10.06	2002.06.28
9.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц. Нью-Йорк, 1984.12.10	2002.02.23
9.b.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол. Нью-Йорк, 2002.12.18	2015.03.14
10.	Спортод апартеид бодлого явуулахын эсрэг олон улсын конвенц. Нью-Йорк, 1985.12.10	1988.04.03
11.	Хүүхдийн эрхийн тухай конвенц. Нью-Йорк, 1989.11.20	1990.09.02
11.a.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт. Нью-Йорк, 1995.12.12	2002.11.18
11.b.	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт. Нью-Йорк, 2000.05.25	2004.11.06
11.c.	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт. Нью-Йорк, 2000.05.25	2003.07.27
11.d.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол. Нью-Йорк, 2011.12.19	2015.12.28

12.		Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт хоёрдугаар протокол. Нью-Йорк, 1989.12.15	2012.06.13
15.		Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц. Нью-Йорк, 2006.12.13	2009.06.13
	15.а.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол. Нью-Йорк, 2006.12.13	2009.06.13
16.		Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц. Нью-Йорк, 2006.12.20	2015.03.14

БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ

Ярилцлага зохион байгуулсан

Байршил:

Өдөр

Цаг.....

Оролцогчид:

- Залуучууд
- Цагаан овоо багийн иргэдийн төлөөлөл
- Эмэгтэйчүүд

Анхааруулах зүйл: Судалгаанд оролцогчдод өөрсдөд нь ямар нэгэн сөрөг үр дагавар байхгүй, нэр ус дурьдагдахгүй, дүрс бичлэг хийхгүй учир аль болох чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх хэрэгтэйг анхааруулах

А. Нүүр хагарах – ярилцлага эхлүүлэх

Энэ судалгааны зорилгыг маш товч танилцуулах

Таван толгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанаас орон нутгийн иргэд, уурхайн ажилчид, тээврийн жолооч нарын эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх үндсэн зорилготой.

Оролцогчидтой танилцах

- Та хэдэн настай вэ? Гэр бүлийн байдал? Ямар ажил эрхэлдэг вэ?
- Энд амьдраад хэдэн жил болж байна вэ? Та бүхний амьдарч байгаа орчин нөхцөл, амьжиргаа ямархуу байна вэ? Сүүлийн жилүүдэд орчин нөхцөл хэрхэн өөрчлөгдөж байна /сайжирсан уу, муудсан уу/

1. Эрхийн талаарх ойлголт

Та өөрийн үндсэн эрхүүдээс хамгийн сайн эдэлж чадаж байгаа ямар эрх байна вэ? Мөн хамгийн их зөрчигдөж байгаа ямар эрх байна вэ?

Танай орон нутгийн иргэд өөрсдийн эрхийн талаар хэр мэддэг вэ? Ер нь орон нутагт иргэд өөрсдийн эрхийнхээ талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?

Таны эрх зөрчигдсөн гэж үзсэн үед ихэвчлэн хаана ханддаг вэ?

Хүний эрхийн хэрэгжилтийн тухай

Танай суманд үйл ажиллагаа явуулдаг уурхайн компаниудын зүгээс хөрс, агаар, усны бохирдлыг хэрхэн хэмжих, мэдээллийг иргэдэд хүргэх, ихэссэн тохиолдолд авах арга хэмжээ (замын дагуу ус цацах, хурд бууруулах, тоог цөөрүүлэх г.м.) зэргийг урьдчилан тохирсон эсэхийг мэдэх үү?

Танай суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниуд тоосжилтын талаар албан ёсны мэдээлэл тогтмол хугацаанд өгдөг үү? Энэ тал дээр сайн ажиллаж байгаа ямар компаниуд байна вэ?

Тоосжилт бий болоод байгаа гол гол эх үүсвэр юу вэ? Түүнийг хэрхэн шийдэх вэ?

Тоосжилтоос үүдэлтэй ямар бэрхшээл хүндрэл, сөрөг үр дагаврууд гарч байна вэ? Ямар нэгэн жишээ баримт дурьдана уу? Өвчлөл нэмэгдсэн үү? Эрүүл мэндийг үзлэгт тогтмол ордог уу? Эмчилгээнд зарцуулагдах зардал их болсон уу?

Уурхайн үйл ажиллагаа идэвхэжсэнээс хойш тоосжилтын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн бэ? Буурч байна уу? Нэмэгдэж байна уу?

Тоосжилтын хэмжээг бууруулах талаар ямар тодорхой арга хэмжээ авсан бэ? Үр дүнтэй ямар арга хэлбэр байна гэж бодож байна вэ? Сүү цагаан идээ хөтөлбөр гэж мэдэх үү? Та бүхэн хамрагдаж байсан уу?

Тоосноос өөр орчны бохирдол хог хаягдалтай холбоотой ямар асуудал тулгарч байна вэ? Энэ талаар ямар арга хэмжээ сум орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлж байна вэ? Тодорхой үр дүнд хүрсэн үү?

Ундны усаа хаанаас авдаг вэ? Усны чанар, хүртээмж ямар байна вэ? Уурхайгаас ус ашиглахтай холбоотой ямар нэгэн хэлэлцүүлэг явуулж байсан уу?

Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш ундны усны хэмжээ, чанарт ямар нэгэн өөрчлөлт орсон уу?

Хүн амын өсөлт, хэт төвлөрөл, хөл хөдөлгөөн ихтэй зэргээс шалтгаалан ямар сөрөг асуудлууд гарч байна вэ? Таны гэр бүл, таньдаг хүмүүсээс эрсдэлд өртөж байсан тохиолдол байна уу? Таньж мэдэхгүй олон төрлийн хүмүүс та бүхний санааг зовоодог уу? Гэмт хэрэг зөрчил их гардаг уу? Ямар төрлийн гэмт хэргүүд гардаг вэ?

Сумын төвийн замын тэмдэг, тэмдэглэгээ, явган хүний гарц шаардлага хангаж байна уу? Машин техникийн хөдөлгөөний аюулгүй байдал ямар байна вэ?

Хүүхэд залуучуудад зориулсан зам тээврийн ослоос сэргийлэх, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар мэдээлэл, сургалт явагддаг эсэх?

Уурхайн зүгээс жолооч, ажилчдад сахилга батыг хэрхэн сахиулах, орон нутгийн иргэдийн эрхийг зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах, процедурыг тодорхойлсон эсэхийг мэдэх үү?

Та бүхэн уурхайд хандан гомдол санал гаргаж байсан уу, түүнийг хэрхэн шийдвэрлэж байсан бэ?

Уурхай болон түүнтэй холбоотойгоор сум, орон нутгийн захиргааны зүгээс аливаа дарамт шахалт үзүүлж байсан тохиолдол бий юу?

Та бүхэн уурхайн болон холбогдох асуудлаар үг хэлэх, бусадтайгаа эвлэлдэн нэгдэхэд ямарваа хөндлөнгийн саад тотгор учирч байсан уу, одоо бий юу?

Уурхайн нутаг дэвсгэрт байсан иргэд болон малчдыг нүүлгэн шилжүүлэлт хэрхэн явагдсан бэ? Нөхөн төлбөр олгогдсон эсэх?

Орон нутгийн засаг захиргаа, компаний удирдлага орон нутгийн иргэдэд уул уурхайн ажлын үе шатын талаар, түүний үр дүнд үүсэх сөрөг үр дагавар, түүнийг бууруулах талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн үү? Тухайлбал:

- Ямар сөрөг үр дагавар гарч болох
- Дуу чимээ, тоосжилтыг намдаах арга хэмжээ авах эсэх

- Ус , хөрсний бохирдол үүсэх эсэх
- Усны хэрэглээ, цэвэр усны хангамжийг хэрхэн шийдвэрлэх
- Бэлчээрийн асуудал
- Зэрлэг амьтад, ховор ургамлыг хэрхэн хамгаалах
- Орон нутаг, иргэдэд нөхөн төлбөр олгох асуудал
- Шилжин байршихад туслах
- Бараа бүтээгдэхүүн худалдан авах
- Ажлын байраар хангах
- Эмнэлэг, сургуулийн боломжийг хэрхэн нэмэгдүүлэх
- Байгаль орчны нөхөн сэргээлт гэх мэт

Дээрхээс одоо хэрэгжиж байгаа нь аль вэ?

Та бүхний ажиглаж буйгаар уурхайн компанийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл хэнд илүүтэй тусч байна вэ, эерэг нөлөөлөл хэнд их байна вэ?

Бидний судалгаанд оролцсонд баярлалаа.

АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ХУУДАС

Хүний Эрхийн Үндэсний Комисстой хамтран тус судалгааны байгууллага нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумын нутаг дахь Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж байна. Судалгааны үр дүнг хүний эрхийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах зорилгоор ХЭҮК-д хүргүүлж, иргэд, бусад оролцогч талуудад танилцуулна. Та энэ судалгаанд идэвхтэй оролцож туслалцаа үзүүлнэ үү.

ХЭСЭГ 1. ОРОЛЦОГЧДЫН ТУХАЙ

1. Таны харъяалал

1. Цогтцэций сум
2. Өмнөговь аймгийн бусад сумд
3. Бусад

2. Таны ажилладаг компанийн нэр юу вэ?

.....

3. Та нүүрс тээврийн жолоочийн ажлыг хэдий хугацаанд хийж байгаа вэ?

..... жилсар

4. Таны нас _____?

5. Таны хүйс?

1. Эрэгтэй
2. Эмэгтэй

6. Таны боловсрол?

- | | |
|-------------------------|-----------------------------|
| 1. Дээд боловсрол | 2. Мэргэжлийн боловсрол |
| 3. Бүрэн дунд боловсрол | 4. Бүрэн бус дунд боловсрол |
| 5. Бага боловсрол | 6. Бусад |

7. Таны өөрийн сарын дундаж орлого

- | | |
|--------------------------|-----------------------|
| 1. 1,0 сая төгрөг хүртэл | 2. 1,0-2,0 сая төгрөг |
| 3. 2,0-3,0 сая төгрөг | 4. 3,0-4,0 сая төгрөг |
| 5. 4,0-5,0 сая төгрөг | 6. 5,0 саяаас дээш |

8. Та гэрлэсэн үү?

1. Тийм
2. Үгүй

9. Та хүүхэдтэй юу?

1. Тийм
2. Үгүй

10. Таны нүүрс тээвэрлэж буй машин хувийн өмч үү, компанийн өмч үү?

1. Миний хувийн өмч
2. Компанийн өмч
3. Бусад

11. Таны ажилладаг компани Монголын компани уу, Хятадын компани уу?

1. Монгол компани
2. Хятадын компани
3. Бусад

ХЭСЭГ 2. НҮҮРС ТЭЭВРИЙН ЖОЛООЧ, АЖИЛТНУУДАД ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДЛУУД

12. Таны хувьд ажлын нөхцөлтэй холбоотой хамгийн их тулгамдаж буй 3 асуудал юу вэ?

.....

.....

.....

13. Таны ажлын нөхцөлд дараах арга хэмжээ ямар ач холбогдолтой вэ? (5-1 хүртэл ач холбогдлоор нь үнэлнэ үү.)

№	Арга хэмжээ	Маш чухал	Чухал	Бага зэрэг	Чухал биш	Мэдэхгүй
		5	4	3	2	1
1	Хөдөлмөрийн гэрээ байгуулах					
2	Нийгмийн даатгалд хамрагдах					
3	Эрүүл мэндийн даатгалд хамрагдах					
4	Үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх					
5	Төрийн хяналт, оролцоо					
6	Бусад.....					

14. Нүүрс тээврийн замд осол гарч буй гол шалтгаан юу вэ? (5-1 хүртэл ач холбогдлоор нь үнэлнэ үү.)

№	Зардал	5	4	3	2	1
1	Замын эвдрэл их					
2	Тэмдэг тэмдэглэгээ муу					
3	Жолооч нар дүрэм зөрчдөг					
4	Жолоочийн ур чадвар муу					
6	Бусад.....					

15. Та хөдөлмөр, аюулгүй байдлын сургалтанд суудаг уу?

1. Сард нэгээс доошгүй удаа
2. Улиралд нэгээс доошгүй удаа
3. Жилд нэгээс доош удаа
4. Сууж байгаагүй

16. Та ихэнхдээ уртын тээвэрт явдаг уу, богинын тээвэрт явдаг уу?

1. Уртын /Уурхайгаас Цагаан хад хүртэл/
2. Богинын /Цагаан хаднаас хилийн цаана хүртэл/
3. Уртын урт /Уурхайгаас хилийн цаана хүртэл/

17. Хэрэв уртын тээвэрт явдаг бол дунджаар хэдий хугацаа зарцуулж байна вэ?

.....

18. Хэрэв богинын тээвэрт явдаг бол дунджаар хэдий хугацаа зарцуулж байна вэ?

.....

19. Хэрэв уртын уртад явдаг бол дунджаар хэдий хугацаа зарцуулдаг вэ?

.....

20. Нүүрсний тээвэр хийхэд дараах үйлчилгээ хүртээмжтэй байдаг уу? (5-1 хүртэл ач холбогдлоор нь үнэлнэ үү.)

№	Үйлчилгээ	Их хүртээмжтэй	Хүртээмжтэй	Дунд	Хүртээмжгүй	Байхгүй
		5	4	3	2	1
1	Ундны цэвэр ус					
2	Бензин түлш					
3	Хоол хүнс					
4	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
5	Халуун усны газар					
6	Амрах газар					
7	Нийтийн бие засах газар					
8	Бусад.....					

21. Таны хувьд сэтгэлзүйн зөвлөгөө авах үйлчилгээ хэрэгцээтэй байдаг уу?

Тийм 2. Үгүй

22. Зам тээврийн аваар осол гарсан тохиолдолд үүсэх эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авсан уу?

№	Зардал	Тийм	Үгүй	Тийм бол хувиараа даатгуулсан уу, компаниас тань хамруулсан уу	
		1	2	Хувиараа	Компани
1	Жолоочийн хариуцлагын даатгал				
2	Гэнэтийн осолын даатгал				
3	Тээврийн хэрэгслийн даатгал				
4	Амь насны даатгал				

23. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлнэ үү? (5-1 хүртэл ач холбогдлоор нь үнэлнэ үү.)

№	Зардал	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Байхгүй
		5	4	3	2	1
1	Гаалийн хяналт					
2	Эмнэлгийн анхан шатны тусламж					
3	Цагдаагийн туслалцаа					
6	Бусад.....					

24. Зам тээвэр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар дараах байгууллагууд танд анхааруулга, мэдээлэл өгдөг үү?

№	Асуудал	Замын цагдаа	Мэргэжлийн хяналт	Уул уурхайн компаниуд	Тээврийн компаниуд	Бусад	Үгүй
		1	2	3	4	5	6

1	Аваар ослын мэдээлэл						
2	Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээлэл						
3	Аваар ослоос сэргийлсэн санамж, зөвлөгөө						
4	Хувийн эрүүл мэндийн санамж						
5	Замын эвдрэлийн санамж						

25. Таны хувьд сүүлийн нэг жилд нүүрс тээврийн ажилтай холбоотой дараах эрх тань зөрчигдөж байсан тохиолдол бий юу?

№	Эрх	Тийм	Үгүй	Санахгүй байна.
		1	2	3
1	Хөдөлмөрийн хэвийн нөхцлөөр хангуулах			
2	Эвлэлдэн нэгдэх			
3	Ажил хаях			
5	Цалин хөлс авах			
6	Илүү цагийн хөлс авах			
7	Эрүүл мэндээ хамгаалуулах			
8	Өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх			
9	Бусад			

26. Таны хувьд дараах асуудал сүүлийн нэг жилийн хугацаанд тохиолдож байсан уу?

№	Эрх	Тийм	Үгүй
		1	2
1	Гэмт халдлагад өртсөн		
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадаагүй		
3	Хөдөлмөрийн хөлсөө авч чадаагүй		
4	Хулгайн гэмт хэргийн хохирогч болсон		
5	Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн		
6	Бэлгийн замын өвчин туссан		
7	Бусад		

27. Та эрүүл мэндийн үзлэгт хэр тогтмол хамрагддаг вэ?

1. Улирал бүр
2. Жил бүр
3. Хааяа
4. Огт хамрагддаггүй
5. Мэдэхгүй

28. Таны бодлоор нүүрс тээврийн жолооч нарын дунд дараах үйлдэл их гардаг уу?

№	Үйлдэл	Маш	Их	Заримдаа	Хааяа	Бараг үгүй
		5	4	3	2	1
1	Маргалдаж зодолдох					
2	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох					
3	Мими хэрэглэх					
4	Биеэ үнэлэгч авах					
5	Шороон замаар очир дайрах					
6	Цагдаад авилгал өгөх					
6	Бусад.....					

Та бидний асууснаас өөр санал, хүсэлт байвал чөлөөтэй хуваалцана уу.

Судалгаанд идэвхитэй оролцсон Танд баярлалаа!



ТАВАНТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН НҮҮРС ОЛБОРЛОХ,
ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Энэхүү тайлан нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын захиалгаар Бодлогын инновацийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний үр дүн болно.

Энэхүү Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг Швед Улсын Байгаль орчны агентлаг, НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төслийн санхүүжилтээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын удирдлагын оролцоо, дэмжлэгийн хүрээнд зохион байгууллаа.

Үнэлгээг Бодлогын инновацийн хүрээлэнгийн судалгааны баг хэрэгжүүлж, эцсийн тайланг Японы Тохогүгийн их сургуулийн зочин судлаач, тус хүрээлэнгийн зөвлөх доктор Д.Бямбажав, тус хүрээлэнгийн захирал, докторант Ж.Мэндээ, үнэлгээний багийн судлаач, докторант Ө.Пүрэвсүрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл нар боловсруулсан болно.

Улаанбаатар хот
2018 оны 10 дугаар сар

©Бодлогын инновацийн хүрээлэн 2018 он

Иш татах: Д.Бямбажав, Ж.Мэндээ, Ө.Пүрэвсүрэн, Ч.Алтангэрэл: Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ. БИХ, ХЭҮК, НҮБХХ, 2018 он.

ГАРЧИГ

1. Удиртгал
2. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) гэж юу вэ?
3. Тавантолгойн бүлэг ордын ХЭНБҮ-ний зорилго, ажлын хүрээ
4. Үнэлгээний арга зүй
5. Цогтцэций сумын иргэдийн эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох үйл ажиллагаа
Цогтцэций сумын нөхцөл байдал
Тулгамдаж буй асуудлууд
Тоосжилт, агаарын бохирдол
Цагаан-Овоо багийн төвийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлж буй сөрөг нөлөөлөл
Хүн амын өсөлт ба нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж
Хөндөгдөж буй эрхүүд, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт
Зөвлөмж
6. Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа
Нүүрс тээврийн жолооч нарт тулгамдаж буй асуудал
Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн ажиллах, амьдрах орчны асуудал
Хөндөгдөж буй эрхүүд, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт
Зөвлөмж
7. Орон нутгийн малчдын эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
Тоосжилт
Усны чанар, хүртээмж
Бэлчээрийн доройтол, хомсдол
Малчдын аюулгүй амьдрах орчин
Нөлөөллийн менежмент
Хөндөгдөж буй эрхүүд, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт
Зөвлөмж
8. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
9. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

УДИРТГАЛ

Тавантолгойн нүүрсний бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа өнгөрсөн 10 гаруй жил огцом нэмэгдэж, түүний улмаас байгаль орчин, нийгмийн өргөн хүрээтэй, ноцтой нөлөөллүүд үүсч буйг олон улсын болон үндэсний байгууллагууд, судлаачид баримтад үндэслэн анхааруулж ирсэн байна. 2012 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) хамтран хэрэгжүүлсэн судалгааны тайланд “[...] нийт нутгийн 50 хувь нь лицензийн талбайд орсон, нийт бэлчээрийн талбайн 80 орчим хувь нь талхлагдалтад өртсөн, нутаг дэвсгэрт нь 3 том нүүрсний уурхай, нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэдэг 50 гаруй компани үйл ажиллагаа явуулж, шороон замаар тээвэрлэлт хийж байгаагаас Цогтцэций сумын иргэд, малчдын хувьд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх боломж, нөхцөл туйлын хомс болж байна. Тус сумын судалгаанд хамрагдсан иргэдийн хариултыг нэгтгэн үзэхэд, уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангагдах, газар эзэмших, өмчлөх, амьдрах орчноо чөлөөтэй сонгох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, үг хэлэх зэрэг хүний үндсэн болон нийгэм-эдийн засгийн эрхүүд зөрчигдөж байна” хэмээн дүгнэсэн байна.¹⁹


Дүрслэл 1. Тавантолгойн бүлэг орд дахь уурхайн үйл ажиллагааны ул мөр

(Эх сурвалж: Google earth)


(Улаан өнгөөр уурхайн хүрээг, ногоон өнгөөр Цогтцэций сумын төвийн хүрээг тэмдэглэв)




2004 он



2008 он



2013 он




2016 он

судалгаагаар бэлчээрийн доройтол, тоосжилт, усны хомсдол зэрэг асуудал улам даамжирч буйг анхааруулж, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг бууруулах тодорхой зөвлөмжүүдийг танилцуулсан байдаг.²⁰ Уг судалгаагаар 2004 оноос хойш Тавантолгойн орд газар дахь уурхайн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй шороон замууд ихсэж, Цогтцэций сумын төвийн орчим болон уурхайгаас Монгол Улс, БНХАУ-ын хил хүртэлх зам дагуу их хэмжээний хөрсний элэгдэл, эвдрэл үүсгэсэн болохыг онцолжээ.

Дүрслэл 2. 2003-2014 оны үед үүссэн замууд (Эх сурвалж: Тогтвортой эрдэс баялгийн хүрээлэн)

(Улаан өнгөөр 2 км тутамд 3 болон түүнээс дээш тооны зам үүссэн газрыг тэмдэглэсэн болно)



Тавантолгойн бүлэг ордоос БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ 2009-2012 онд асар хурдацтай нэмэгдсэн хэдий ч 2013 оноос БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнэ, эрэлт буурснаар тус орд газраас экспортлох нүүрсний хэмжээ эргэн буурсан байдаг. Харин 2016 оны 2 дугаар сараас нүүрсний үнэ огцом өсч, нүүрсний экспортын хэмжээ 25 сая тоннд хүрсэн бөгөөд үүний дийлэнхийг Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрс эзэлж байв. Улмаар 2017 онд Монгол Улсын нүүрсний экспорт улам бүр өссөөр 33 сая тоннд хүрсэн байна.²¹

²⁰ Тогтвортой эрдэс баялгийн хүрээлэн. Хариуцлагатай уул уурхай Монголд: Хамтын зүтгэл. 2016 он

²¹ УУХҮЯ, АМГТГ. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2017 оны 9 сар.

Дүрслэл 3. Монгол улсын экспортолсон нүүрсний хэмжээ /сая.тн/ (Эх сурвалж: УУХҮЯ)




Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хувьд орон нутгийн иргэдийн амьжиргаа, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого Тавантолгойн уурхайнуудаас улам бүр хамааралтай болсон тул 2014-2015 оны хугацаанд нүүрсний зах зээлийн уналт хүндээр туссан юм. Харин өнгөрсөн 3 жил гаруйн хугацаанд Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны эрчим, цар хүрээ хурдацтай нэмэгдсэн нь сумын эдийн засагт чухал хувь нэмэр оруулсан байна. Гэвч өмнөх судалгаанд анхааруулж байсан байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх асуудал 2016 оноос улам даамжирч, ноцтой үр дагавар үүсч буйд орон нутгийн удирдлага, иргэд санаа зовниж, зохих дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авахыг холбогдох олон улсын болон үндэсний байгууллагуудад санал хүсэлтээ хүргүүлсээр иржээ.

Тавантолгойн бүлэг ордоос нүүрс экспортлох дэд бүтцийн бүс нь уурхайгаас зүүн урагш чиглэсэн Гашуунсухайт хилийн боомт хүртэлх 240 орчим км зурвас газар бөгөөд нөлөөллийн хүрээ нь зарим хэсэгтээ 41 км хүртэл өргөнтэй.²² Энэ бүсэд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай автозам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын далан, нүүрс тээвэрлэлтэд ашиглаж байсан шороон зам, түр хугацаанд ашиглаж буй шороон зам, Оюу Толгойн баяжмал тээврийн замын зарим хэсэг зэрэг багтаж байна.

²² Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих" төсөл, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. 2015 он. 86-р хуудас.

Дүрслэл 4. Тавантолгойн бүлэг ордоос Гашуун сухайт боомт хүртэлх нүүрс тээврийн зөвшөөрөлтэй автозам



Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээврийн автозам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгийг дайран өнгөрдөг. Түүнчлэн, Ханбогд сумын Хайрхан багийн нутагт Цагаан хадны гаалийн хяналтын бүс дэх нүүрс ачилт, буулгалтын үйл ажиллагаа, хүн амын төвлөрлөөс үүдсэн байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл нь 2010 оноос эхлэн олон жил даамжирсан асуудал болсон билээ. Дээрх шалтгаанаар Цагаан хадны хяналтын бүсийн үйл ажиллагааг 2013 он болон 2017 онд зогсоож байсан ч Засгийн газраас дахин үргэлжлүүлэх шийдвэр гаргаж байв.

2017 оны 3 дугаар сарын байдлаар Тавантолгойн нүүрсний уурхайнуудаас Гашуунсухайтын чиглэлд нийт 71 аж ахуйн нэгжийн 4500 орчим тээврийн хэрэгсэл ачаа тээвэрлэж байсан байна.²³ 2017 оны 6 сарын үед энэ чиглэлд 40-50 км урт дараалал үүсэх, улмаар жолооч нар олон хоног зам дээр хонох, зөвшөөрөлгүй шороон замаар нүүрс тээвэр хийх зэрэг асуудал тулгамдах болжээ. Түүнчлэн нүүрс тээврийн ачаалал нэмэгдсэний улмаас Цагаанхадны гаалийн хяналтын бүсийн орчимд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл эрс ихэссэн байна.

2017 оны 7 дугаар сарын дундаас замын нэвтрэх ачаалал эрс буурч, тээврийн хэрэгслийн зогсолт ихсэж, 130 гаруй км дугаарлах болсон. Энэ нь БНХАУ-ын талаас хилээр нэвтрүүлэх нүүрс тээврийн хэрэгслийн гарцыг бууруулж, хяналт шалгалтаа чангаруулсан, нүүрс тээвэрт оролцогч тээврийн хэрэгслийн тоо 6000 гаруй болж өссөн, “Уртын урт” буюу Тавантолгойн

23 АТҮТ. Гашуунсухайт, Ганц модны чиглэлийн тээврийг “ХОНОГИЙН НЭГДСЭН ГРАФИК” -т оруулжээ. 2017 оны 3 сарын 28. <https://www.transdep.mn/cat.php?articles/642.html>

уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээвэрлэх маршрут нээсэн, тээврийн үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалт сул зэрэг хүчин зүйлстэй холбоотой байв.



Зураг 1. 130 гаруй км үргэлжилсэн Гашуун сухайт хүртэлх нүүрс тээврийн зам
(Эх сурвалж: Ройтерс агентлаг, 2017 оны 10 дугаар сарын 29)

Энэ үед зориулалтын бус замаар нүүрсний тээвэр хийх зөрчил огцом нэмэгдэж, Ханбогд сумын Жавхлант багийн бэлчээрийн газрыг доройтуулсан байдаг. Үүнийг таслан зогсоохоор сумын удирдлагууд, албан хаагчид, малчид, иргэд, цагдаа хамтран ээлжээр эргүүлд гарч, Оюутолгой ХХК-иас техник хэрэгслийн тусламж авч, малчидтайгаа зөвлөлдсөний дагуу нүүрс тээврийн замын гарц, малын гармуудын дагуу замыг хаах хүртэл арга хэмжээ авч байжээ.²⁴



Зураг 2. Зориулалтын бус газраар явж буй нүүрсний ба түлшний автомашинууд, Ханбогд сумын Жавхлант баг, 2017 оны 9 сар. (Эх сурвалж: Ө.Баттогтох)²⁵

2017 оны 11 дүгээр сарын 29-нд Монгол Улсын Засгийн газраас 320 дугаар тогтоолыг баталж Тавантолгойн нүүрсний тээвэрлэлтэд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг арилгах зорилготой дараах арга хэмжээг хэрэгжүүлэх болсон.

²⁴ Орд.мн. Нүүрс тээврийн замыг хаалаа. 2017 оны 11 сарын 30. <http://www.ord.mn/index.php?newsid=13568>

²⁵ <https://www.facebook.com/uulii.battogtoh/videos/1957128767867209/>

Үүнд:

- Гашуунсухайт-Ганц модны хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэмэгдэх хүртэлх түр хугацаанд нүүрсний тээвэрлэлтийг Тавантолгойн нүүрсний ордоос Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл, Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайт боомт хүртэл чиглэлээр тус тус зохион байгуулах,
- Хилийн боомтоор нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн тоо хэмжээтэй уялдуулан нүүрсний ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зохицуулалт хийж ажиллах,
- Цагаан хадны гаалийн хяналтын бүс болон Гашуунсухайтын боомт хооронд нүүрсний тээвэрлэлт хийхдээ тус чиглэлийн орон нутгийн чанартай шороон зам ашиглах арга хэмжээ авч, гаалийн хяналтын бүсийн талбайд нүүрс буулгах, ачих үйл ажиллагааг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай байхаар зохион байгуулан хяналт тавьж ажиллах
- Гашуунсухайт боомтод орчин үеийн рентген аппарат, хяналтын тоног төхөөрөмж худалдан авах болон зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлэх
- Нүүрс тээвэрлэлтийн болон гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчны талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдалд тогтмол хяналт тавьж ажиллах арга хэмжээг холбогдох төр, орон нутгийн байгууллагын удирдлагад даалгасан байна.

2018 оны эхээр нүүрс тээврийн зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслийн тоо 9000 орчим болж, Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээврийн зам дээрх дараалал Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл буюу 20 гаруй км үргэлжилсэн байдалтай, уурхайн амнаас ачих, гаалийн хяналтын талбайд буулгах, ачих хэсэгт урт дараалал үүссэн, жолооч нар олон өдөр, хоногийг зам дээр, урт дараалал дунд өнгөрүүлж, түүнээс улбаатай нийгмийн асуудлууд болон хүний эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ба олон нийтийн цахим сүлжээгээр ихээхэн тархаж байсан билээ.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан ХЭҮК-оос санаачлан Швед Улсын Байгаль орчны агентлаг, НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төслийн хүрээнд “Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-г хийх, энэ явцад орон нутгийн иргэд болон нүүрс тээврийн үйл ажиллагаанд оролцогч жолооч, бусад ажилтнуудын эрхийн асуудлыг үнэлэх ажлын даалгаврыг боловсруулж, нээлттэй сонгон шалгаруулалт зарласны дагуу энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэв.

ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ (ХЭНБҮ) ГЭЖ ЮУ ВЭ?

2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөл “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын хүрээг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг баталсан юм.²⁶ “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь бизнесийн үйл ажиллагаанд “Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” (цаашид ХЭНБҮ гэх) хийх суурь үзэл баримтлал болдог.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь үндсэн 3 тулгуур зарчмаас бүрддэг. Үүнд:

- **Нэгдүгээр зарчим - Хамгаал.** Төр нь зохистой бодлого, зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Үүнд бизнесийн байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалах үүрэг ч хамаарна.
- **Хоёрдугаар зарчим - Хүндэл.** Аж ахуйн нэгж байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчимд тулгуурлана. Аж ахуйн нэгж байгууллага нь эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой. Аж ахуйн нэгж байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох, хамааралтай байх нь энэ зарчимд харшилна.
- **Гуравдугаар зарчим - Эрхийг сэргээ.** Эрх нь зөрчигдсөн иргэд буюу хохирогчид эрхээ хамгаалах шүүхийн ба шүүхийн бус тогтолцоог бий болгох шаардлагатай. Төр нь хуулийн хүрээнд хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдэд шүүх болон захиргааны аргаар хариуцлага тооцох ажлыг хариуцах ёстой. Мөн төрийн зүгээс хохирсон иргэдэд мэдээллийн болон бусад шаардлагатай туслалцааг үзүүлэх тогтолцоог бий болгож, компаниудаас иргэдийн гомдлыг хэлэлцэх, хохирлыг барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохыг шаардаж, хяналт тавих хэрэгтэй. Компаниуд иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, яриа хэлэлцээрийн зарчмаар шийдвэрлэх механизмтай байх шаардлагатай.

ХЭНБҮ нь тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох үйл явц юм. ХЭНБҮ-ний гол зорилго нь нөлөөллийг тодорхойлж, гарч болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга замуудыг илрүүлж, тодорхойлох байдлаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал юм.²⁷

ХЭНБҮ нь дараах зарчимд үндэслэдэг. Үүнд:

- ХЭНБҮ нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хүний эрхийн стандарт, хэм хэмжээг мөрдлөг болгох
- Үнэлгээний үйл явцад оролцогч талуудын оролцоо, тэгш эрхийг хангах
- Ил тод байдлыг хангах

26 UN Human Rights Council, “Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations ‘Protect, Respect and Remedy’ Framework” 2011

27 James Harrison. “Measuring Human Rights: Reflections on the Practice of Human Rights Impact Assessment and Lessons for the Future.” Warwick Law School Legal Studies Research Paper. 2010, Vol. 26.

ХЭНБҮ нь тухайн төслийн хэрэгжилтийн өмнөх (ex ante), хэрэгжилтийн дараах (ex post), эсвэл хэрэгжилтийн явцад тус тус байж болно. Хэрэгжилтийн өмнөх буюу “Ex ante” үнэлгээ нь тухайн төслийн үйл ажиллагааг төлөвлөх, боловсруулах, холбогдох байгууллагаар батлуулах үйл явцын нэг хэсэг буюу үүсэж болзошгүй нөлөөллийг тодорхойлох явдал юм. Хэрэгжилтийн дараах буюу “Ex post” үнэлгээ нь төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад болон дараа нь гарсан бодит нөлөөллийг илрүүлж, засаж сайжруулах арга замуудыг тодорхойлоход чиглэдэг.

ХЭНБҮ-г хөндлөнгийн ба дотоод гэж ангилж үзэж болно. Дотоод нөлөөллийн үнэлгээ нь тухайн байгууллагын дотоод мониторинг, үнэлгээний нэг хэсэг болон хэрэгждэг. Өөрөөр хэлбэл байгууллагын үйл ажиллагааны хэм хэмжээ, менежментийн тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжинэ гэсэн үг юм. Энэ нь ex ante болон ex post үнэлгээг аль алиныг агуулж болно. Мөн хөндлөнгийн байгууллага, шинжээчид хийсэн гадаад үнэлгээ байж болно.

ТАВАНТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН ХЭНБҮ-НИЙ ЗОРИЛГО, АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын боловсруулсан “Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” хийх ажлын даалгаварт дараах 4 чиглэлд үнэлгээ хийхийг тусгасан байна. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөр эрхлэх зэрэг эрхэд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлж, үнэлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн арга хэмжээний санал зөвлөмж гаргах
- Нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны улмаас малчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг үнэлэх
- Нүүрс тээвэрлэлтэд оролцож буй ажилчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөр эрхлэх зэрэг эрхийн хэрэгжилтийг үнэлэх
- Цогтцэций сумын жишээнд тулгуурлан хөдөлгөөнт хүн амын тоо огцом өссөнөөс үүдэлтэйгээр гарч буй болон болзошгүй хүний эрхийн болон нийгмийн эрсдлүүдийг үнэлэх зэрэг болно.

Эдгээр чиглэлийн дагуу энэ бүс нутагт өрнөж буй уул уурхай ба нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааны байгаль орчин (агаарын бохирдол, тоосжилт, бэлчээр, хөрсний эвдрэл, усны нөөц, хангамж гэх мэт), нийгмийн (эрүүл мэнд, амьжиргаа, соёл, нийгмийн харилцаа, төрийн үйлчилгээ гэх мэт) нөлөөлөлтэй харилцан уялдаатайгаар хүний эрхэд үзүүлж буй шууд ба дам нөлөөллийг тодорхойлох зорилгыг гүйцэтгэгч байгууллагын зүгээс дэвшүүлж хэрэгжүүлээ.

Нөлөөлөлд өртөгч талуудыг орон нутгийн иргэд, малчид, нүүрс тээврийн жолооч ба ажилчид гэсэн үндсэн бүлгийн хүрээнд авч үзсэн. Нөлөөлөл үзүүлэгч талуудыг уул уурхайн компаниуд, тэдгээрийн гэрээт туслан гүйцэтгэгчид, нүүрс тээврийн компаниуд, бусад холбогдох төрийн байгууллагуудын хүрээнд авч үзсэн болно. Энэхүү үнэлгээ нь хүний эрхэд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээг талуудын оролцоо,

зөвлөлдөх уулзалтуудын үндсэн дээр тодорхойлж, хамтарсан шийдэлд хүрэхэд туслан оролцох зарчим баримталсан болно. Тиймээс энэ үнэлгээнд судалгааны ажлын зэрэгцээ оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, баримт, мэдээлэлд үндэслэсэн хамтарсан шийдлүүдийг тодорхойлох ажил чухал үүрэгтэй байсан.




Зураг 3. Үнэлгээний урьдчилсан үр дүнгийн хэлэлцүүлэг
(Цогтцэций сум, 2017 оны 6 дугаар сарын 29) (Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч,
төрийн албан хаагчид, уул уурхайн компаниуд, иргэдийн төлөөлөл)

ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үнэлгээний ажлыг дараах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.

1. Үнэлгээ хийх арга зүй, ажлын төлөвлөгөөг боловсруулах
2. Үнэлгээ хийх ажлын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ХЭҮК-той хамтран боловсруулах
3. Үнэлгээнд холбогдох хууль эрх зүй, бодлого стандарт, өмнөх судалгааны тоймыг боловсруулах
4. Өмнөговь аймагт судалгааны баг ажиллаж, тоон ба чанарын мэдээлэл цуглуулах
5. Үнэлгээний сэдэвчилсэн тайланг оролцогч талуудад танилцуулж, санал шүүмж авах
6. Үнэлгээний эцсийн тайлан, зөвлөмжүүдийг танилцуулах

Үнэлгээг хийх арга зүй үндсэн 3 шат буюу бүрдэл хэсэгтэй байв. Үүнд: Үе шат тус бүрийг дараах хэсэгт танилцуулав.

**I шат**

Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх
Хүний эрхийн дүн шинжилгээ хийх

**II шат**

Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх
Үнэлгээний урьдчилсан дүнг оролцогч талуудаар хэлэлцүүлэх

**III шат**

Хүний эрхийн зөрчил, эрсдлийг шинжлэх
Дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах

I шат

- **Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх:** Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа, түүний байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн талаарх өмнөх судалгаа, мэдээлэл, шинжээчдийн байр суурьт дүн шинжилгээ хийх замаар оролцогч талууд, ялангуяа эрх нь хөндөгдөгч болон нөлөө үзүүлэгч талууд, нөлөөллийн цар хүрээ, холбогдох бодлого, арга хэмжээ зэрэг асуудлыг судлав.

Энэхүү үнэлгээг хийхэд чухал ач холбогдолтой нижгээд судалгааны ажлууд өмнө хийгдсэн нь хүний эрхийн нөлөөллийн хүрээг оновчтой тодорхойлох, бодлогын шийдлүүдийг боловсруулахад чухал ач холбогдолтой байв. Энд дараах судалгаа, үнэлгээний ажлуудыг онцлон дурдаж болно. Үүнд:

2012 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хэрэгжүүлсэн “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх нөлөө” сэдэвт судалгааны тайлан. <http://mn-nhrc.org/index.php?newsid=5292>

2015 онд Австралийн Квинсландын их сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэнгийн хэрэгжүүлсэн Таван Толгойн бүс нутаг дахь уул уурхайн үйл ажиллагаанаас орон нутгийн байгаль орчин, нийгэм, уламжлалт мал аж ахуй, соёлд үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаа. <https://www.csr.m.uq.edu.au/research/adra-home>

2015 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд хийгдсэн “Таван Толгойн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ”-ний эхний тайлан.

<http://www.minis.mn/9.CIA%20report%20TT.pdf>

Түүнчлэн, Тавантолгойн бүс нутаг дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа (НҮБХС, 2017), Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн өрхүүдийн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх судалгаа (Дэлхийн банк, 2015) зэрэг сэдэвчилсэн судалгаа, үнэлгээний ажлууд хийгдсэн нь чухал ач холбогдолтой байлаа.

- **Хүний эрхийн дүн шинжилгээ хийх:** Нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан гол анхаарах хүний эрхийн асуудлуудыг тодорхойлсон.

Хүснэгт 1. Хүний эрхийн олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүд дэх хэм хэмжээ*(Улаан өнгөөр энэ үнэлгээний явцад анхаарч авч үзэх эрхүүдийг тэмдэглэв)*

Хүний эрх	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
Амьд явах эрх	3-р зүйл	6-р зүйл		16.1-р зүйл
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх				16.2-р зүйл
Эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх	3-р зүйл	9-р зүйл		16.13-р зүйл
Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрлөхөөс ангид байх эрх	4-р зүйл	8-р зүйл		16.4-р зүйл
Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгүүлэхээс ангид байх эрх	5-р зүйл	7-р зүйл		16.13-р зүйл
Эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрх	6-р зүйл	16-р зүйл		14-р зүйл
Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх	7-р зүйл	14, 26-р зүйл		14-р зүйл
Дайныг аливаа хэлбэрээр сурталчилсан, алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгаанаас ангид байх эрх		20-р зүйл		
Эрх нь зөрчигдвөл эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрх	8-р зүйл	9-р зүйл		16.12-р зүйл
Хараат бус шүүхээр шударгаар шүүлгэх эрхтэй	10-р зүйл	9, 14-р зүйл		16.14-р зүйл
Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхээс ангид байх эрх	11-р зүйл	15-р зүйл		
Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууцад халдахаас ангид байх эрх	12-р зүйл	17-р зүйл		16.13-р зүйл
Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх	13-р зүйл	12-р зүйл		16.18-р зүйл
Хэн боловч мөрдөлт мөшгилтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрх	14-р зүйл			
Иргэний харьяалалтай байх эрх	15-р зүйл			15-р зүйл

Хүүхэд асрамж, туслалцаа авах эрх	25-р зүйл	10, 24-р зүйл	10-р зүйл	16.11-р зүйл
Гэрлэх, өрх тусгаарлах эрх	16-р зүйл	23-р зүйл	10-р зүйл	16.11-р зүйл
Эд хөрөнгө өмчлөх эрх	17-р зүйл			16.3-р зүйл
Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх	18-р зүйл	18-р зүйл		16.15-р зүйл
Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх	19-р зүйл	19-р зүйл		16.16-р зүйл
Тайван хуран цуглах эрхтэй	20-р зүйл	21-р зүйл		16.16-р зүйл
Эвлэлдэн нэгдэх эрхтэй	20-р зүйл	22-р зүйл		16.10-р зүйл
Улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрх	21-р зүйл	25-р зүйл		16.9-р зүйл
Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх	22-р зүйл		9-р зүйл	16.5-р зүйл
Хөдөлмөрлөх эрх	23-р зүйл		6-р зүйл	16.4-р зүйл
Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх	23-р зүйл		6-р зүйл 7-р зүйл	
Үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ажил хаях эрх	23-р зүйл	22-р зүйл	8-р зүйл	
Эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх	25-р зүйл		11-р зүйл	
Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	25-р зүйл			16.2, 16.6-р зүйл
Сурч боловсрох эрх	26-р зүйл		13-р зүйл	16.7-р зүйл
Нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй, өөрийн туурвисан бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрх	27-р зүйл		15-р зүйл	16.8-р зүйл
Өөрөө засан тохинох эрхтэй			1-р зүйл	
Эрх чөлөөгөө хасуулсан хүний хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх		10-р зүйл		
Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйг үндэслэл болгон эрх чөлөөг хасуулахгүй байх эрх		11-р зүйл		
Гадаадын иргэний албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин хянуулах эрх		13-зүйл		

Угсаатан, шашны болон хэлний цөөнхөд багтдаг хүмүүсийн соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрх		27-р зүйл		
Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	8-р зүйл	9-р зүйл		16.12-р зүйл
Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 сарын 28-ны 64/292-р тогтоол			

II шат

- **Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх:** Үнэлгээний баг Улаанбаатар хот, Өмнөговь аймаг, БНХАУ-ын Баяннуур аймгийн Ганц Мод боомт зэрэг газар ажиллаж мэдээлэл цуглуулсан.

Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулсан арга ба эх сурвалж

Мэдээлэл цуглуулсан арга	Эх сурвалж
Хоёрдогч эх сурвалжийн тойм	Байгууллагын баримт бичгүүд Үнэлгээний тайлан, төлөвлөгөө Судалгаа, статистикийн мэдээлэл Хэвлэлийн нийтлэл, сурвалжлага Агаарын чанар ба бусад мониторингийн мэдээлэл
Ярилцлага (50 хүн)	Орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөл, малчид, нүүрс тээврийн жолооч нар, төрийн байгууллагын ажилтнууд, аж ахуйн нэгжүүдийн удирдлага, ажилтнуудын төлөөлөл
Асуулга судалгаа (500 хүн)	Цогтцэций сумын төв болон Цагаан-Овоо багийн иргэдийн төлөөлөл (350) Нүүрс тээврийн жолооч нар (150)
Бүлгийн ярилцлага (8 удаа)	Эмэгтэйчүүд, Цагаан-Овоо багийн иргэд, ахлах сургуулийн сурагчид, төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жолооч нар
Ажиглалт (2017 оны 3 сар, 6 сар)	Цогтцэций сумын төв ба Цагаан-Овоо баг, Тавантолгойн уурхай, нүүрс тээврийн зам, түүний дагуух зогсоолууд, бэлчээр, Ханбогд сумын төв ба Жавхлант баг, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Гашуунсухайт боомт, Ганц мод боомт
Цахим сүлжээн дэх мэдээллийн дүн шинжилгээ	Нүүрс тээврийн жолооч нарын Фэйсбүүк группын хүний эрхийн нөлөөлөлд холбогдох мэдээлэл, Гашуунсухайт авто зам болон бусад холбогдох байгууллагын цахим сүлжээн дэх мэдээлэл

Түүнчлэн үнэлгээний урьдчилсан дүнг оролцогч талуудаар хэлэлцүүлэх үеэр илэрхийлсэн санал, шүүмжид дүн шинжилгээ хийсэн.

III шат

- Мэдээллийн нарийвчилсан дүн шинжилгээнд үндэслэн сэдэвчилсэн асуудал тус бүрийн тухайд хүний эрхийн зөрчил, эрсдлийг тодорхойлж, нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагаар нь эрэмбэлсэн. Үүнд дараах аргачлалыг баримталсан.

Хөндөгдөж буй хүний эрхийн тайлбар, сэдэвчилсэн асуудал тус бүрт анхаарах шаардлагатай нөлөөлөгч хүчин зүйлс, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт боловсруулах

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
Хөндөгдөж буй эрх:				
Тухайн эрхийн товч тайлбар				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				

Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, анхаарч үзэх эрэмбийг тодорхойлох, ингэхдээ дараах шалгууруудын дагуу 1-3 хүртэлх оноогоор үнэлэх

Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)

(3) Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц

(2) Хүний амьдралын суурь нөхцөл, хэрэгцээг хязгаарласан, өмч хөрөнгөд хохирол учруулсан

(1) Бусад нөлөөлөл

Х - Нөлөөллийн хамрах хүрээ (1-3)

(3) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 50-иас дээш хувь

(2) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10-50 хувь

(1) Нөлөөлөлд хамаарахуйц хүмүүсийн 10 хүртэлх хувь

С - Эрхийг сэргээх боломж (1-3)

(3) Бэрхшээлтэй: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгоход олон хүчин зүйлээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөхгүй байх магадлал их, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж муу

(2) Харьцангуй бололцоотой: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь харьцангуй цөөн хүчин зүйлсээс хамаарах, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж бий

(1) Хялбар: Зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх нь зөрчигдөхөөс өмнөх нөхцөл байдлыг бий болгох нь олон хүчин зүйлсээс хамаарахгүй, эрхийг сэргээсэн гэж хүлээн зөвшөөрөх өндөр магадлалтай, хохирлыг нөхөн олгох, орлуулах боломж ихтэй

М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

(3) Эрхийн зөрчил давтагдах магадлал өндөр

(2) Эрхийн зөрчил давтагдах магадлал дунд

(1) Эрхийн зөрчил давтагдах магадлал бага


Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I					
II					
III					
IV					

- Сэдэвчилсэн асуудал тус бүрээр болон үнэлгээний ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг үнэлгээний багийнхан боловсруулсан болно.

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ИРГЭДИЙН ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох үйл ажиллагаа

Тавантолгойн нүүрсний бүлэг орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, Улаанбаатар хотоос 540 км, Монгол улс ба БНХАУ-ын хилээс 240 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгадаас 90 км зайтай газар оршдог. Өнөөгийн байдлаар тус бүлэг ордын Ухаа худгийн уурхай Цогтцэций сумын төвд хамгийн ойр буюу 5 км орчим зайтай байрлаж байна.




Дүрслэл 5. Тавантолгойн орд газар дахь уурхайн газар (Эх сурвалж: Тавантолгой Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ)

Таван толгойн нүүрсний бүлэг орд нь 7.4 тэрбум орчим тонн нүүрсний нөөцтэй, үүнээс 5.1 тэрбум тонн нь коксжих нүүрсний үндсэн нөөц эзэлж байгаа бол 1.9 тэрбум тонн нь эрчим хүчний өндөр чанарын нүүрс гэх тооцоо байдаг. 2017 онд Тавантолгойн бүлэг ордоос БНХАУ руу экспортолсон нүүрсний нийт хэмжээ өмнөх жилүүдээс давж, 17 сая тонн болсон. Нүүрсний зах зээлийн таатай орчинд уг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа урт хугацаанд үргэлжлэх боломжтой юм. Гэвч дэлхийн улстөр, эдийн засгийн нөхцөл байдал, БНХАУ-ын төрийн бодлого болон нүүрсний зах зээлийн өөрчлөлтөөс хамаарч тус ордоос нүүрс олборлож, экспортлох үйл ажиллагаа удаашрах, зогсох эрсдэл бий. Одоогийн байдлаар Монгол Улсын төрийн өмчит

“Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК, хувийн өмчит “Энержи Ресурс” ХХК -ийн гэсэн 3 компани тус орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин, олборлолт явуулж байна.


Таван толгойн нүүрсний бүлэг ордын судалгаа 1953 оноос хийгдэж, 1966 оноос уг ордыг говийн аймгуудын дулааны цахилгаан станц, өрхийн нүүрсний хэрэгцээнд ашиглаж эхэлжээ. Тус уурхай 1994 онд хувьчлагдаж, төрийн өмч давамгайлсан, орон нутгийн “Тавантолгой ХК” болж, дотоодын зах зээлд үргэлжлүүлэн нүүрс нийлүүлэх болжээ. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн улмаас коксжих нүүрсний эрэлт нэмэгдэж, 2004 оноос “Тавантолгой” ХК Хятадын зах зээлд коксжих нүүрс гаргаж, экспортын нүүрсний эхлэлийг тавьсан байна.



Дүрслэл 6. Тавантолгой компанийн нүүрс борлуулалтын хэмжээ /сая.тн/²⁸


2005 онд дотоодын 14 компани (MCS, Петровис, Шунхлай зэрэг) хамтран “Энержи Ресурс ХХК”-ыг байгуулж, 2006 оноос Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох уурхайн барилгын ажлыг албан ёсоор эхэлсэн. 2006 онд “Ашигт малтмалын тухай хууль” шинэчлэгдэн батлагдаж, Тавантолгойн бүлэг орд нь стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын жагсаалтад орсноор уг хуулийн дагуу 2008 онд Засгийн газар Энержи Ресурс компанитай хэлэлцээр хийж, Ухаа худаг (нийт талбайн 4%-тай тэнцэх)-аас бусад ашиглалтын лицензийн талбайг төрийн мэдэлд шилжүүлэн авсан. Энержи Ресурс компани 2009 оноос нүүрсний экспортоо эхэлж, улмаар 2010 оны 10 дугаар сард тус компани Хонгконгийн хөрөнгийн биржид бүртгүүлж, хувьцаагаа арилжаалжээ.

²⁸ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Цахим тайлан. 2018 он <https://e-reporting.eitimongolia.mn/reportList>



Дүрслэл 7. Энержи Ресурс компанийн нүүрс борлуулалтын хэмжээ /сая.тн/29

Монгол Улсын Засгийн газар төрийн эзэмшлийн талбай (Баруун болон Зүүн Цанх)-г зах зээлийн эргэлтэд оруулах, дэд бүтэц (дулааны цахилгаан станц, төмөр зам, үйлдвэрлэлийн зам, усны хангамж, хил, гаалийн байгууламж г.м.)-ийн асуудлыг шийдэх зорилгоор төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой ХК”-ийг байгуулж, 2011 оноос нүүрс экспортолж эхэлсэн байна.



Дүрслэл 8. Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс борлуулалтын хэмжээ /сая.тн/ 30

²⁹ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Цахим тайлан. 2018 он <https://e-reporting.eitimongolia.mn/reportList>


³⁰ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Цахим тайлан. 2018 он <https://e-reporting.eitimongolia.mn/reportList>, Эрдэнэс Тавантолгой. Нүүрс олборлолтын мэдээ. 2018. <http://erdenestt.mn/otbowj>

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өмнөговь аймгийн Цогтцэций сум нь 7.2 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, далайн түвшнээс 1200-1791 метрийн өндөрлөгт, бүхэлдээ говь цөлийн бүсэд оршдог. Нутаг дэвсгэрийн хэмжээ харьцангуй жижиг буюу Өмнөговь аймгийн нийт 15 сумдаас 12-т ордог. Уул уурхайн томоохон төслүүд байрладаг Гурвантэс сум (27.9), Ханбогд сум (15.2)-тай харьцуулахад нутаг дэвсгэрийн хэмжээ маш бага юм. Аймгийн төвийг эс тооцвол хүн амын нягтралаар аймгийн хэмжээнд хамгийн өндөр буюу 1.03-тай байна.

Цогтцэций сум нь Сийрэст, Билгэх, Цагаан-Овоо, Өгөөмөр гэсэн 4 багтай. Тус сумын Цагаан-Овоо, Сийрэст багуудын 2557.4 га нутаг дэвсгэр дээр Тавантолгойн уурхайн олборлолтын үйл ажиллагаа явагдаж байна. Түүнчлэн, экспортын нүүрс тээвэрлэх 44.4 км засмал зам, 55.9 км төмөр замын трассын зориулалттай далан дайран гарч байна.³¹ Өмнө дурдсанчлан, нүүрс тээврийн олон тооны шороон замууд тус сумын нутаг дэвсгэрийг дайран гарсан байна.

2017 оны 12 дугаар сарын байдлаар Цогтцэций сумын хүн ам 7422, нийт 2441 өрх албан ёсны бүртгэлтэй байна. Уул уурхайн эрчимжилттэй холбоотой тус сумын хүн ам сүүлийн 5 жилд огцом нэмэгджээ. Үүнээс гадна уул уурхайн олборлолт, тээвэр, бусад холбогдох үйл ажиллагаанд оролцогч 8000-10000 орчим хөдөлгөөнт хүн ам Цогтцэций сумын нутаг дэвсгэрт ажиллаж, амьдардаг гэж үздэг.



Дүрслэл 9. Цогтцэций сумын хүн амын өсөлт

³¹ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.

Өнөөгийн байдлаар сумын хүн амын 88 хувь буюу 6506 нь сумын төвд, 12 хувь буюу 916 нь хөдөө амьдарч байна.³² Нийт хүн амын дунд сумын төвд амьдардаг хүмүүсийн хувь аймгийн хэмжээнд хамгийн өндөр нь Цогтцэций сум байна. Өмнөговь аймгийн хүн ам харьцангуй ихтэй, томоохон уурхай бүхий сумд болох Гурвантэс сумын хүн амын 57 хувь нь сумын төвд амьдардаг бол Ханбогд сумынх 80 хувьтай байна. Бусад сумдын хувьд дунджаар хүн амын 30 орчим хувь л сумын төвд амьдардаг.

Цогтцэций суманд нийт 289 малчин өрх байна. Тус сум нийт 130 мянган малтай, түүний 60 орчим хувь нь ямаа, 30 орчим хувь нь хонь, 6 орчим хувь нь адуу, 2 орчим хувь нь тэмээ, мөн 2 хувь нь үхэр байна. Малын тоо сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдсэн. Ялангуяа түүний 90 хувь болох бог мал маш их өссөн байна. 2013 онд нийт 37 мянган ямаа, 21 мянган хонь тоолуулсан бол 2017 онд ямаа 75 мянга, хонь 42 мянга болжээ.

Сумын хэмжээнд улсын төсөвт 6 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Сумын эдийн засгийн уламжлалт салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн 10 гаруй жилд уул уурхай эрчимжиж, “Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс тавантолгой” ХК зэрэг уул уурхайн томоохон компаниуд олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байна. 2014 оны байдлаар сумын хэмжээнд 288 аж ахуй нэгж, жижиг бизнес эрхлэгч 1290 иргэн үйл ажиллагаа явуулж байсан. Худалдаа үйлчилгээний газрууд жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал: Эмийн сан-5, Хүнсний үйлдвэрийн тоо-10, Зочид буудал-29, Хүнсний дэлгүүр-36, Супермаркет-10, Хүнсний бөөний төв-5, Нийтийн хоолны газар-37 болж нэмэгдсэн байна.³³

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Тоосжилт, агаарын бохирдол

Сумын төв (Өгөөмөр баг) болон Цагаан-Овоо багийн иргэдээс авсан судалгаагаар 80 орчим хувь нь тоосжилт, агаарын бохирдлыг бууруулах асуудлыг хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж үзэж байна.


³² Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.

³³ Цогтцэций сумын танилцуулга.



Дүрслэл 10. Сумын төв орчимд амьдарч буй иргэдийн хувьд хамгийн их тулгамдаж буй асуудлууд (Асуулгын судалгааны дүн)

Цогтцэций сумын Цаг уурын ажиглалтын харуул нь 2015 онд сумын төв орчмын тоосжилтын хэмжилт хийх DustTrak багаж ашиглан сумын төв орчмын тоосжилтын түвшинг сард 4-5 удаа 24 цагийн дунджаар хэмжих болсон байна. Гэвч хэмжилт хийх аргачлал, баримтжуулалт, мэдээллийн хадгалалтын горимыг нарийвчлан тодорхойлоогүй, албан хаагчдын орон тооны өөрчлөлтөөс хамаарч тасалдах, шинээр орсон албан хаагч уг төхөөрөмжийг ашиглах аргад суралцах, түүнээс хамаарч алдаа гаргах магадлал үүсэх зэрэг асуудлууд тулгарсан байна. Тус харуулаас 2017 онд сумын төв орчмын тоосжилтын хэмжилт хийсэн дүнг сарын дунджаар дараах графикт танилцуулсан байна.



Дүрслэл 11.

Цогтцэций сумын цаг уурын ажиглалтын харуулаас сумын төв орчмын агаар дахь PM10 буюу том ширхэгт тоосонцорыг хэмжсэн дүн, 2017 он

Дээрх хэмжилтийн дүн нь Цогтцэций сумын төвийн орчмын тоосжилт нь хавар, зуны саруудад зөвшөөрөгдөх түвшнээс хоёр дахин, түүнээс илүү хэтэрсэн болохыг харуулж байна.

Монгол Улсад агаарын чанар, агаарын бохирдлын асуудлыг 2012 онд батлагдсан “Агаарын тухай хууль”-иар зохицуулдаг. Энэ хуулийн дагуу аж ахуйн нэгжүүд уурхайн болон ойр орчмын агаарын чанарт байнгын хяналт тавьж, агаарын чанарын байдал стандартын түвшнээс өөрчлөгдсөн тохиолдолд олон нийт болон орон нутгийн засаг захиргаанд мэдэгдэх, бохирдлыг бууруулах шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.

Агаарын тухай хууль нь Улаанбаатар болон аймгийн төвүүдийн агаарын чанартай холбоотой асуудалд төвлөрч, аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлага, орон нутгийн нөлөөллийн бүсүүдийн асуудлыг орхигдуулсаар байна. Уг хууль болон байгаль орчны талаарх хуулиудад тоосжилтыг хянах, бууруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон журам байхгүй байна. Байгаль орчны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжүүд нарийвчилсан үнэлгээний тайланд зааснаар гадаад, дотоод орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдаг. Зөвшөөрөгдөх хэмжээг 2016 онд шинэчлэн батлагдсан Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016-аар тогтоосон.

Хүснэгт 3. Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж (MNS 4585:2016)

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж
Химийн нөлөөлөл			
Хүхэрлэг хий (SO ₂)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	450 50 20
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	20 минутын дундаж 1 цагийн дундаж 8 цагийн дундаж	мкг/м ³	60000 30000 10000
Азотын давхар исэл (NO ₂)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	200 50 40
Озон (O ₃)	8 цагийн дундаж	мкг/м ³	100
Нийт тоосонцор	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	500 150 100
PM 10 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	100 50
PM 2.5 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	50 25
Хар тугалга (Pb)	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м ³	1 0,25
Бенз-а-пирен (C ₂₀ H ₁₂)	24 цагийн дундаж	мкг/м ³	0,001

Тавантолгойн 3 уурхайн хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөөнийхөө дагуу уурхайн орчмын агаарын чанар, тоосжилтын хэмжилтийг хийж байна. Гэвч хэмжилтийн агуулга, хүрээ, аргачлал, үр дүнгийн ил тод байдал учир дутагдалтай байна.

Эрдэнэс Тавантолгой компанийн Байгаль орчны шинжилгээний хөтөлбөрт дурдсанаар компани нь сард нэг удаа Dusttrak DRX 8533 багажаар уурхайн талбайн дотор 8 цэгт TSP буюу тоосонцорын нийт хэмжээ, нарийн, том ширхэгт ба нарийн ширхэгт тоосонцорын хэмжилтийг сар бүр хийхийн зэрэгцээ хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл, азотын давхар исэлийн хэмжилтийг хагас жилд нэг удаа хийдэг байна. Уг хөтөлбөрт дурдсанаар агаарын чанарын хөндлөнгийн хяналтыг жилд нэг удаа хийх ёстой байна. Гэвч энэ хэмжилтийн мэдээлэл нь ил тод бус учраас нягтлах боломжгүй байна. Бидний олж үзсэн мэдээлэл нь 2018 оны 5 сарын тоосонцорын 3 үзүүлэлтээр зөвхөн 2 цэгт хэмжилт хийсэн товч тайлан байсан болно.

Тавантолгой ХК нь уурхайн талбай ба түүний орчмын нарийн ба том ширхэгт тоосонцор, тоосонцорын хэмжээ, дуу шуугиан /дБА/, салхины хурд, харьцангуй чийгшил, агаарын температур гэсэн үзүүлэлтээр агаарын чанарын хэмжилтийг сард 2 удаа, хөндлөнгийн хяналтыг жилд 2 удаагийн давтамжтайгаар хийдэг байна. Уурхайн талбай орчмын 4 цэгээс гадна Цагаан-Овоо багийн төв буюу Тавантолгой ХК-ийн уурхайн тосгон, түүнээс баруун тийш Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайн хөрсний овоолго хүртэлх завсрын бүс гэсэн 2 цэг дээр хэмжилт хийдэг байна. Хэмжилтийн дүнг зөвхөн компанийн дотоод хэрэгцээ, холбогдох төрийн байгууллагын хяналт шалгалт хийгдэх тохиолдолд танилцуулдаг байна. Бид хэмжилтийн протокол тэмдэглэл, хөндлөнгийн хяналт шинжилгээний тайлантай компани дээр зохион байгуулсан уулзалтын үеэр танилцсан.



Зураг 4. Тавантолгой ХК-ийн тоосжилтын хэмжилт хийхэд ашиглаж буй DustTrak TSI 8530 зөөврийн багаж

Жилд 2 удаа хийгддэг хөндлөнгийн хяналт шинжилгээний дүн нь тухайн үеийн цаг агаарын байдал, уурхайнуудын хөдөлгөөний эрчим, зам усалгаа зэргээс шалтгаалах тул агаарын чанарыг бодитой хэмжиж дүгнэхэд хангалтгүй юм. Ийм өрөөсгөл байдал жилд нэг удаа хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэхээр төлөвлөсөн Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд мөн адил ажиглагдаж байна.

Энержи Ресурс компани нь Ухаа худаг уурхай, Цогтцэций сумын төв, эргэлтийн усан сан зэрэг газруудад 1-10 саруудад сар бүр агаарын чанарын хэмжилт хийдэг байна. Хэмжилтийг DustTrak TSI 8530 багажаар, хэмжилтийн суурь, тэмдэглэгээ бүхий тогтсон 10 орчим цэгт хийдэг. Хэмжилтийн үр дүнг орон нутгийн удирдлагад танилцуулдаг байна. Үнэлгээ хийж буй байгууллагын зүгээс 2013-2017 оны жил бүрийн тоосжилтын хэмжилтийн тайлантай танилцах хүсэлт тавьж хэвлэсэн хувилбараар хүлээн авсан. Энержи Ресурс компани нь зөвхөн PM2.5 буюу нарийн ширхэгт тоосонцорыг хэмжиж байгаа нь маш учир дутагдалтай байна. Сар бүр агаарын чанарын хэмжилт хийдэг ч яагаад агаарын чанарын бусад үзүүлэлтийн дагуу хэмжилт хийдэггүй нь тодорхойгүй байна. Түүнчлэн, 2013 оны хэмжилтийг 1-11 сард хийсэн бөгөөд 11 сард хэмжилт хийсэн 7 цэгийн 5-д нь нарийн ширхэгт тоосонцор зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн дүн гарсан байна. Гэтэл 2014 оноос 1-10 сард л агаарын чанарын хэмжилт хийдэг болсон байна. Цаашлаад, тоосжилт ихэсдэг 1-3 сарын хэмжилтийг хийхдээ “багажны ажиллах горимоос шалтгаалаад өвөл цаг агаар хүйтэн үед буюу 1-3 сард хэмжилтийн хугацааг богиносгосон бөгөөд дээж авах давтамжийг ойрхон хийсэн” гэдэг шалтгаанаар өөр аргачлалаар хийсэн нь учир дутагдалтай юм. Бусад компаниудын хувьд мөн адилаар хэмжилтийн багаж өвөл хүйтэнд удаан цагаар ажиллахгүй гэдэг шалтгаанаар хэмжилтээ өөр аргачлалаар хийсэн байхыг үгүйсгэхгүй.

Энержи Ресурс компани 2014 оноос Ухаа худаг уурхайн орчмоос гадна Цогтцэций сумын төвийн орчмын 5 цэгт нарийн ширхэгт тоосонцорын хэмжилт хийх болсон байна. Түүнчлэн, салхины хурд, чиглэлийг давхар хэмжиж тайланд тусгаж иржээ. 2014-2016 оны тайланд дурдсанаар сумын төв цэгт 2 удаа (2015, 2016 оны 1 сард, салхи баруун хойноос), сумын зүүн хойно цэгт 1 удаа (2015 оны 2 сар, салхи баруун хойноос), сумын зүүн урд цэгт 1 удаа (2016 оны 1 сард, салхи баруун хойноос) тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.01-0.03 мкг/м³-ээр хэтэрсэн байна. Товчоор хэлбэл, энэ хугацаанд сумын төвийн орчмын агаар дахь нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ стандартад заасан түвшнээс хэтэрсэн тохиолдол тун цөөн байсныг эдгээр тайланд бичжээ. Салхины чиглэлийн хувьд баруун урдаас буюу уурхайн зүгээс салхилах үед хэмжилт хийсэн нэг ч тохиолдол алга байна. 2017 оны тайланд сумын төвийн цэгт хийсэн хэмжилтээр 1-4, 10-р сард нарийн ширхэгт тоос зөвшөөрөгдөх хэмжээнээс 2-3 дахин хэтэрсэн болохыг дурджээ. Эдгээр тайланд дурдсан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тоосонцорын шалтгааныг сумын төвийн дотоод тоосжилт их, айл өрхүүдийн яндангийн утаа, нүүрс тээврийн шороон замын нөлөөлөл гэж тайлбарласан байна. Эндээс үзэхэд, Энержи Ресурс компани нь Цогтцэций сумын төвийн агаарын чанарт хяналт шинжилгээг хийх зорилго тавьсан нь сайшаалтай сайн туршлага боловч агаарын чанарын бүрэн, бодитой хэмжилт хийхээс зайлсхийсэн, зөвхөн компанийн эрх ашиг, нэр хүндийг хамгаалахад чиглэсэн мэдээллийг л танилцуулсан гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 4. Уул уурхайн компаниудын тоосны хэмжилтийн өнөөгийн байдал

Компани	Тоосжилтын хэмжилтийн цэгүүд	Тоосжилтын хэмжилтийн үзүүлэлт	Тоосжилтын хэмжилтийн давтамж	Тоосжилтын хэмжилтэд ашигладаг багаж	Хэмжилтийн дүнг орон нутагт танилцуулдаг эсэх
Энержи Ресурс	Нийт 12 цэг: Уурхай, сумын төв, технологийн зам, завсрын хэсэг	PM2.5 (Нарийн ширхэгт тоосонцор),	Нэг цэгт 24 цаг хүртэлх хугацаатай, сард 1 удаа	Зөөврийн Dust Trak TSI 8530 – 1 ширхэг	Тийм (Удирдлагад)
Эрдэнэс Тавантолгой	Нийт 11 цэг: Уурхай, технологийн зам	Тоосны ерөнхий агууламж, PM2.5, PM10 1m ² талбайд унах тоосны жин	30 минутын хугацаатай, 7 хоногт 1 удаа Сар бүр	Зөөврийн Dust Trak DRX 8533 – 1 ширхэг Унац цуглуулах 22 см диаметртэй юүлүүртэй шилэн бортог	Үгүй
Тавантолгой	Нийт 6 цэг: Уурхай, уурхайн тосгон, завсрын бүс	PM2.5, PM10	30 минутын хугацаатай, сард 2 удаа	Зөөврийн Dust Trak TSI 8530 – 1 ширхэг	Үгүй

Тавантолгойн орд дахь 3 уурхайн тоосжилтын хяналт шинжилгээ хийж буй өнөөгийн байдалд хэд хэдэн ноцтой дутагдал байна. Нэгд, өмнө дурдсанчлан Монгол Улсын стандартад заасан аргачлалын дагуу биш хэмжилтийн үзүүлэлт, хэмжих хугацаа нь зөрөөтэй байдлаар хэмжилт хийж байна. Жишээ нь Энержи Ресурс компани зөвхөн нарийн ширхэгт тоосонцор хэмжиж байгаа нь ил аргаар нүүрс олборлох үед үүсэх тоосжилтын гол бүрэлдэхүүн болох том ширхэгт тоосонцорын хэмжээ, тархалтыг үл ойшоосон хандлага юм. Эрдэнэс Тавантолгой ба Тавантолгой компанийн хувьд тоосжилтын хэмжилт хийх хугацаа нь стандартад зааснаас богино учраас стандартад заасан 24 цагийн болон жилийн дундаж ямар байгааг тодорхойлох боломжгүй, түүний улмаас шинжлэх ухааны үндэстэй дүн шинжилгээ хийх боломжгүй, цаашид ямар зорилгоор хэрхэн ашиглах нь тодорхойгүй, хэрэгцээгүй мэдээлэл гаргаж байна. Эрдэнэс Тавантолгой компани байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө нийт тоосонцорыг хэмжих, унац цуглуулах хэмжилт хийнэ гэсэн боловч үр дүн нь ил тод биш, үнэхээр хийдэг эсэх нь тодорхойгүй байна.

Нэг бүлэг ордод нэгэн зэрэг олборлолт хийж буй хөрш 3 уурхайн хувьд тоосны хэмжилтийн арга зүй нь ялгаатай, мэдээлэл солилцдоггүй, мэдээлэл нь ил тод бус байх тул тоосжилтыг бодитой хэмжих, байгаль орчинд, нийгэмд, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар “компаниудын гаргаж буй хүчин чармайлт маш хангалтгүй” хэмээн дүгнэж байна. Олон улсын нийтлэг болон сайн туршлагаас үзэхэд Тавантолгойн бүлэг ордын хэмжээний нүүрсний уурхайн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг өдөр тутам, тасралтгүй хяналт шинжилгээ хийж, хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд ажилчид болон орон нутгийн иргэдэд цаг тухайд нь мэдээлж байх нийтлэг жишиг

байна.³⁴

Тавантолгойн бүлэг ордоос олборлолт хийж буй 3 компани нь нүүрсний ил уурхайн байгаль орчин, нийгэм, ажилчдын эрүүл мэндэд нөлөө үзүүлэгч гол хүчин зүйл болох тоосжилтын хяналт, шинжилгээнд тун хариуцлагагүй хандаж иржээ. Ойролцоогоор 20-30 сая төгрөгийн үнэтэй нэг ширхэг Дасттрак багажаар жилдээ 20 орчим сая тонн нүүрс олборлож, хамгийн багадаа 1000 тонн тоос ялгаруулж буй эдгээр 3 уурхайн тоосжилтыг хэмжих, хяналт тавих ямар ч бололцоогүй юм. Говийн хуурай бүсэд, 7000-10000 орчим хүн байнга амьдарч, ажиллаж буй суурингаас 2-10 км зайд нүүрсийг ил аргаар олборлож байгаа нөхцөлд хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг зөв тодорхойлж, хариу арга хэмжээ авах боломжийг хааж байна.

Тоосжилтын нөлөөлөл

Байгалийн болон хүний үйл ажиллагааны явцад тоосонцор агаарт шууд хаягдахаас гадна өөр бусад хийн бохирдуулагчид агаарт хоорондоо нэгдэн хувирч тоосонцорыг үүсгэнэ.³⁵

Томоохон хот суурин газрын тоосжилтод нарийн ширхэгт тоосонцор (PM2.5) голлох нөлөөтэй байдаг. Энэ төрлийн тоосонцор нь ихэвчлэн автомашин ба айлуудын яндангийн утаа, дулааны цахилгаан станц, хүнд үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой ялгарах хийнээс үүдэлтэй байдаг. Харин том ширхэгт тоосонцор (PM10) нь барилга, уул уурхай, шороон зам, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, хөрсний элэгдэл эвдрэл зэргээс ихээхэн хэмжээгээр үүсэх эрсдэлтэй байдаг. Нүүрсний ил уурхайгаас ялгарах тоосонд том ширхэгт тоосонцор зонхилдог бөгөөд энэ нь хөрс хуулах, овоолго хийх, нүүрс ачих, тэсэлгээ хийх, шороон замаар нүүрс тээвэрлэх зэрэг уурхайн талбай дахь олборлох үйл ажиллагаанаас үүсэхийн зэрэгцээ нүүрсний овоолго, хаягдлын овоолго, тээврийн хөдөлгөөн зэргээс дэгддэг.



Эрүүл мэндийн судалгаагаар тоосонцор нь холбогч эд үүсгэх, цочроох, хордуулах, харшил үүсгэх шинж чанартай, амьсгалын замаар хүний бие махбодид нэвтрэн орж улмаар хамрын хөндий, залгиур, төвөнхийг үрэвсүүлдэг болохыг тогтоосон. Уушгинд голчлон 5 микрон (микро грамм) хүртэлх хэмжээтэй тоос нэвтрэн орох ба түүнээс том ширхэгтэй эрдсийн тоос амьсгалын замын дээд хэсгийн салст бүрхэвч болох хамар,

хоолойд шүүгдэж үлддэг байна. Энэ нь амьсгалын замын дээд хэсгийн үрэвсэл буюу гуурсан хоолойн үрэвсэл үүсгэдэг.³⁶

³⁴ Австралийн Засгийн Газар. Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр. Агаарын бохирдол, дуу чимээ, чичиргээ. 2009. <https://archive.industry.gov.au/resource/Programs/LPSD/Documents/AirborneContaminantsMongolian.pdf>

³⁵ Цаг уур орчны шинжилгээний газар. Агаарын чанарын хяналт шинжилгээний тойм. 2008 он.

³⁶ Coal Services. Protecting against airborne dust exposure in coal mines. 2016. http://www.coalservices.com.au/wp-content/uploads/2016/12/NEW-CS-Dust-Booklet_Final-artwork.pdf

Агаарын тоосжилт их байхын хамгийн их аюул нь уушги тоосжих буюу пневмокониоз өвчин гэж үздэг. Тоосыг удаан амьсгалснаас болж уушги тоосжих өвчин үүснэ. Нүүрсний тоосоор үүссэнийг антракоз, төмрийн тоосоор үүссэнийг сидероз зэрэг олон төрөл байдаг. Уушги тоосжих өвчний хамгийн хүнд хэлбэр нь силикоз буюу уушги цахиуржих өвчин юм. Энэ нь цахиурын давхар исэл ихтэй тоосны нөлөөгөөр үүснэ. Уул уурхай, нүүрсний уурхайн хөрсний давхаргын найрлагад цахиурын исэл их хэмжээтэй байдаг.³⁷

Нүүрсний ил уурхайн орчимд амьдарч буй хүн амын дунд дараах бүлгийн хүмүүс эрүүл мэндийн сөрөг нөлөөлөлд өртөх магадлал өндөр гэж үздэг. Үүнд:

- Нялх хүүхэд, бага насны хүүхэд, өсвөр насныхан
- Жирэмсэн эмэгтэйчүүд
- Өндөр настнууд
- Багтраа, бронхит, сүрьеэ зэрэг амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгсөд
- Зүрх судасны өвчнөөр өвчлөгсөд
- Чихрийн шижин өвчнөөр өвчлөгсөд

Тоосонцор нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй дараах анхдагч шинж тэмдгүүд байдаг.

- Ханиалгах
- Амьсгал давчдах
- Багтраа өвчин даамжирах
- Цацлага, антибиотик зэрэг эмийн хэрэглээ ихсэх
- Найтаах
- Нүд улайх
- Зүрхний үйл ажиллагаа доголдох³⁸

Сумын төвийн орчимд тоосжилт ихсэж амьсгалын замын өвчин, төрөлтийн хүндрэл, харшил, зүрх судасны өвчин зэрэг өвчлөл нэмэгдэхийн зэрэгцээ сэтгэл санаа, эд материалын хохирол гарч байгаа гэх мэдээлэл, зовнилыг сумын удирдлагууд, иргэдийн зүгээс ихээхэн мэдээлж байв. Тэдгээрээс нийтлэг давтагдсан болон зарим онцлох санал гомдлыг дараах хүснэгтэд харууллаа.

³⁷ Монгол улсын Хөдөлмөрийн яам. Бичил уурхайн хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлс, түүнээс урьдчилан сэргийлэх нь. 2015 он

³⁸ Агаар дахь бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл. <http://www.tsag-agaar.gov.mn/>

Тоосжилттой холбоотой тулгамдаж буй нийтлэг асуудлууд	Зарим онцлох жишээ
<p><u>Өвчлөл</u></p> <ul style="list-style-type: none"> Амьсгалын тогтолцооны өвчлөл, харшил маш их болсон. Ялангуяа, хүүхдүүдийн дунд өвчлөл ихэссэн. Цогтцэцийд ирснээс хойш тоос шорооны харшилтай гэж оношлогдсон хүн олон. Хавар болоход том хүн, хүүхэд гэлтгүй нийтээрээ тоосны харшил эхэлдэг. Уул уурхайд ажилладаг хүмүүсийн хувьд архаг бронхит, ларингет зонхилдог. Жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний үеийн хүндрэл гарах нь ихэссэн. Их тоостой үед хоолой хорсох, хэлний уг, чихний уг загатнах зэргээр мэдрэгддэг. Бололцоогүй айлын хүүхдүүд сургууль руугаа өглөө үүрээр алхахад утаа, машины тоос ихтэйгээс өвчлөл их гардаг. <p><u>Санхүү, эд материалын хохирол</u></p> <ul style="list-style-type: none"> Хувь хүн, өрхийн эрүүл мэндийн зардал нэмэгдсэн. Ноос, ноолуур, махны чанар зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг бууруулдаг. Гэрийн эд хогшил, өмч хөрөнгө тоос, шороонд дарагддаг. <p><u>Сэтгэл санааны дарамт</u></p> <ul style="list-style-type: none"> Төрөх хүүхдийн эрүүл мэндэд маш их санаа зовж стресс үүсдэг. Нялх хүүхдээ гадаа салхилуулахад эрсдэлтэй. Сүрьеэ өвчин огцом нэмэгдэж байна гэж болгоомжилж байна. 	<p><i>“Салхи тогтуухан оройд бид агаар амьсгалж болохгүй, битүү тоос буудаг, үүнээсээ болоод амьсгалын замын өвчлөл тасрахгүй байна. 11 сараас ханиад тасардаггүй, эм тан уугаад л, гайгүй болно, дахиад л ханиалгаад байдаг”</i></p> <p><i>“Би өмнө нь харшилгүй байсан. Энд ирээд харшилтай болсон. Саяхан хот яваад 10 хоног харшлаа үзүүлээд ирсэн. Эмч нар тоосны харшил гэж оношилсон. Энэ мэтчилэн эрүүл мэндийн зардал нэмэгдсэн”</i></p> <p><i>“Тонус өгдөггүй эмэгтэй гэж бараг байхгүй болсон гэж эмэгтэйчүүдийн эмч ярьж байсан. Одоогоор урагт нөлөөлсөн зүйл байхгүй, яваандаа гарна”</i></p> <p><i>“Миний ойр дотны охид хүүхнүүдийн ярьж байгаагаар 2017, 2018 онд лав л 4, 5 ураг нь амьгүй болсон тохиолдол бий”</i></p> <p><i>“Өглөө эрт хичээлдээ явахад өвөл харанхуй байдаг. Нохой их дайрдаг, утаанд юу ч үзэгдэхгүй, дээрээс нь унаатай айлууд хүүхдээ хүргэх гээд олон машинууд явдаг болохоор битүү манарсан юманд л хүүхэд алхаж байдаг”</i></p> <p><i>“Манай нэг цагдаа эмнэлэгт үзүүлэл хамранд нь тоос ихээр орсноос идээт үрэвсэл үүссэн гэсэн онош гарсан”</i></p> <p><i>“Сүүлийн 5 жилд сүрьеэгийн 18 тохиолдол илэрчихээд байна. Энэ бол яах аргагүй тоосжилттой холбоотой. Ерөөсөө л амьсгалын замаар халдварладаг өвчин. Өвчин авчихаад тодорхой хугацаанд тээгээд бусдад халдаагаад яваад байдаг юм байна”</i></p>


Өмнө дурдсан Тавантолгойн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс үзэхэд Цогтцэций сум нь 10000 хүн амд эзлэх амьсгалын тогтолцооны өвчлөлөөр сумдаас хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Цогтцэций сумын хэмжээнд оношлогдсон өвчлөлийн 49.3 хувь нь амьсгалын тогтолцооны өвчлөл байгаа ба нийт өвчлөлд амьсгалын тогтолцооны өвчлөлийн эзлэх хэмжээ 2006–2014 онд жил бүр нэмэгдсээр 32.7-оос 55.7 хувь хүртэл өссөн байна.³⁹ 2006–2014 онуудад амьсгалын тогтолцооны өвчлөл бүхий л улиралд тэргүүлж, ялангуяа өвлийн улиралд нийт өвчлөлийн 41.7 хувь, зун нийт өвчлөлийн 21.3 хувийг амьсгалын тогтолцооны өвчин эзлэх болсон нь амьдрах орчны бохирдлоос шалтгаалж байна.⁴⁰

³⁹ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Хуудас 82-83

⁴⁰ Мөн тэнд. Хуудас 84.

Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн танилцуулсан мэдээллийг үзэхэд 2017 оны байдлаар 3190 удаагийн өвчлөл бүртгэгдсэний 53 хувь нь амьсгалын тогтолцооны өвчлөл байна.

Дүрслэл 12. Цогтцэций сумын хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 2017 он⁴¹



Тоосжилтын шалтгаан

Тавантолгойн бүлэг уурхай нь Цогтцэций сумын төвд ойр зайд оршдог хийгээд говийн бүс салхи шуурга ихтэй байдаг учраас олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь тоосжилтын үндсэн шалтгаан болдог. Үүнийг орон нутгийн оролцогч талуудын өгсөн мэдээлэл болон өмнөх судалгаа нотолж байна.

“Баруун өмнөөс салхилвал хар хөшиг татчихдаг”

Цогтцэций сумын иргэн

Уурхайн хөрс хуулалт, тэсэлгээ, овоолго, уурхай доторх болон гадагш хийж буй нүүрс тээвэрлэлтээс дэгдсэн тоос салхины чиглэлээр ойр орчимдоо тархаж байна гэж иргэд үзэж байна. Иргэдийн үзэж буйгаар уурхайн зүгээс буюу баруун өмнө зүгээс салхитай үед сумын төв орчмын тоосжилт огцом ихэсдэг байна. Түүнчлэн уурхайн үйл ажиллагаа түр зогссон үед тоосжилт багасч байсан гэдгийг хэлж байна.

⁴¹ Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны мэдээлэл. 2018 оны 2 сарын 28.



Зураг 4. Тавантолгойн уурхайн талбайгаас үүссэн тоос
(Цагаан-Овоо багийн хойд талаас, 2018 оны 3 сар)

Энэ бүс нутаг нь жилийн 4 улиралд 19-35 хувьд нь тогтуун, салхигүй байдаг бол үлдсэн хувьд нь баруун, баруун хойно, баруун өмнө зүгийн салхи улирлаас хамааран зонхилдог байна.⁴² Үүнээс үзэхэд сумын төвийн баруун өмнө оршдог бүлэг уурхай тоосжилтын гол шалтгаан байх бүрэн үндэстэй юм.

Ил уурхайн олборлолт, тээвэрлэлтээс үүсдэг тоосжилт нь хэмжээ, тархац, агаарын бохирдолд үзүүлэх нөлөөгөөр ялгаатай байдаг. Жижиг хэмжээний тоосонцор нь салхинд туугдахдаа том хэмжээний тортогоос илүү хол замыг туулдаг. 10 микроноос бага хэмжээтэй тоосонцор нь салхины хүчээр алсад очих боломжтой. Салхины хүч, тоосонцорын хэмжээ, чийгшил зэрэг хүчин зүйлс тоосны тархалтанд нөлөөлнө.⁴³

Хүснэгт 5. Тоосонцорын агаарт байх хугацаа ба тархалт

Тоосонцорын төрөл	Тайлбар	Агаарт байх хугацаа	Тархах зай
Нийт жинлэгдэгч бодис (TSP)	Агаар дахь олон төрлийн тоосонцоруудын нийлбэр	Хэдэн минутаас хэдэн цаг хүртэл	Эх үүсвэрээс салхины чиглэлийн дагуух ойролцоох газар
Том ширхэгт тоосонцор (PM10)	Ширхэгийн голч нь 2.5-10 микроноос хэмжээтэй тоосонцор.	Хэдэн өдөр хүртэл	100 км хүртэл
Нарийн ширхэгт тоосонцор (PM2.5)	Ширхэгийн голч нь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосонцор.	Хэдэн өдрөөс хэдэн долоо хоног хүртэл	Хэдэн зуу, мянган км хүртэл

Өмнөх судалгаанд Тавантолгойн уурхайн нүүрсний давхаргыг суллахын тулд хийдэг тэсэлгээний улмаас шороо, чулуу, тоос 130-150 метрийн өндөрт дээш дэгддэг. Шороо, чулуу, том ширхэгтэй тоос нь орчин тойрныхоо 100-300 метрийн дотор унадаг бол нарийн ширхэгтэй тоосон үүл нь зонхилох салхины дагуу зөөгдөж 7-8 км зурвас газар, 20-30 минутын дотор унаж дуусдаг гэж тооцсон байна.⁴⁴

⁴² Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Хуудас 111

⁴³ Австралийн Засгийн Газар. Агаарын бохирдол, дуу чимээ, чичиргээ. 2009 он.

⁴⁴ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Хуудас 111

Уурхайн талбай доторх том оврын тээврийн хэрэгслийн шороон замын тоосны хэмжээ, тархац нь агаарын чийгшил, замын усалгаа зэргээс хамаарч ялгаатай байна. Тавантолгойн бүсэд харьцангуй чийгшил өвлийн улиралд ихсэн 60-70% болж, зун температур өндөр учир өдрийн цагт 30-50% хүртэл багасдаг байна.⁴⁵ Гэвч өнөөг хүртэл Тавантолгойн уурхайн бүсийн тоосжилтын эх үүсвэрүүд, тоосжилтын тархац, байгаль, нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаар хээрийн цогц хяналт шинжилгээнд үндэслэсэн судалгаа хийгдээгүй байна. Тавантолгойн уурхайн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тоосжилттой холбоотой хэсэг нь бие даасан суурь судалгаанд тулгуурлаагүй, уурхайн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнүүд, бусад хоёрдогч эх сурвалжуудыг ашиглаж хийгдсэн нь учир дутагдалтай байна.

Сумын баруун талаар 30 нүүрсний машин хойш чиглээд явсанаас 2-3 минутын дараа салхины чигээр маш их боргио хийсч байдаг.

Цогтцэций сумын иргэдтэй хийсэн ярилцлага

Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайгаас Гашуунсухайтын зам хүртэлх нүүрс тээвэрлэлтийн шороон замаас их хэмжээний тоосжилт үүсдэг.




Зураг 5. Эрдэнэс Тавантолгойн уурхайн нүүрс тээврийн замын тоос (2018 оны 3 сар)

хэмжилтийн нэг цэг болох Ухаа худаг уурхайн баруун урд хэсэг, Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс тээврийн шороон замаас 400 метрийн орчимд нарийн ширхэгт тоосонцор стандарт түвшингээс 0.008-0.153 мг/м³-ээр хэтэрсэн байна.⁴⁶ Эрдэнэс Тавантолгой компанийн 2018 оны 5 сард хийсэн хэмжилтээр Зүүн борлуулалтын хяналтын пүүний байрны гадаа нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 2.96 дахин их, том ширхэгт тоосонцорын хэмжээг зөвшөөрөгдөх хэмжээнээс 2.33 дахин их, нийт тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.58 дахин их байсан байна.⁴⁷

Оюу Толгойн уурхайн орчимд хийсэн тоосны тархацын талаарх судалгаагаар салхины хүч, газарзүйн онцлог болон замын элэгдэл зэрэг хүчин зүйлсээс хамаарч уурхайн тоосны тархац уурхайн орчимд биш уурхайгаас зайтай газруудад хүрч, бохирдол нь их байж болохыг тогтоосон байна.⁴⁸ Тийм учраас Тавантолгойн бүлэг уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоосны тархацыг хэмжих, загварчлахдаа зөвхөн уурхайн орчимд их, түүнээс холдох тусам хэмжээ нь буурдаг гэдэг явцуу ойлголтыг өөрчлөх, нарийвчилсан хяналт шинжилгээ хийх шаардлагатай юм.

Сумын дотоод замын тоос

Сумын төвийн орчимд үүсч буй тоосжилтын хоёр дахь гол шалтгаан бол сумын төвийн дотоод авто замын хөдөлгөөнөөс үүсч буй тоосжилт юм. Хатуу хучилттай зам багатай, тээврийн хэрэгслийн тоо, хөдөлгөөн их, олон машин хурдтай давхих зэрэг шалтгаанаар сумын төв орчмын тоосжилт сүүлийн жилүүдэд ихэссэн болохыг оролцогч талууд хүлээн зөвшөөрч байна. Иргэдээс авсан асуулга, судалгааны дүн ч үүнийг нотолж байна.



Дүрслэл 16. Цогтцэций сумын төв орчмын тоосжилтод дараах эх сурвалжууд ихээр нөлөөлж байна гэж үзсэн иргэдийн хувь

⁴⁶ Энержи Ресурс. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2017 оны биелэлтийн тайлан.

⁴⁷ Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. 2018

⁴⁸ Troy Sternberg and Mona Edwards. Desert Dust and Health: A Central Asian Review and Steppe Case Study. Int. J. Environ. Res. Public Health 2017, 14, 1342

Сумын хэмжээнд такси үйлчилгээ үзүүлдэг олон машин тоосжилт ихтэй шороон замаар хурдтай давхих зэргээр тоос босгодог байна. Иргэдийн хувьд ч ялгаагүй тоос дэгдэмтгий шороон замтай хэсгээр хурдаа сааруулах, тоосжилт үүсэхээс сэргийлэх талаар төдийлэн анхаардаггүй нь ажиглагдсан. Харин сумын сургуулиудын хувьд сургуулийн ойролцоох машины замбараагүй хөдөлгөөнийг хязгаарлахын тулд сургуулийн орчныг моджуулах, хашаажуулах, зориулалтын зогсоол байгуулах, эргүүл ажиллуулах арга хэмжээ авсан нь үр дүнтэй болжээ.

Цогтцэций сумын удирдлагын зүгээс сумын дотоод замын тоосжилтыг бууруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хатуу хучилттай замыг нэмэгдүүлэх, зорчигч тээврийн автобусны үйлчилгээ, зогсоолтой болох ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 6. Цогтцэций сумын төв орчмын тоосжилт (Наад талд сумын дотоод шороон замын тоос, цаад талд уурхайн зүгээс салхиар туугдсан тоос, 2018 оны 3 сар)

Түүнчлэн, Даланзадгад сумаас Дундговь аймгийн Цогт-Овоо сумаар дайран Улаанбаатар хот руу явах хатуу хучилттай авто замаар Цогтцэций сумын төв хүртэлх шороон замаар зорчигч тээврийн хэрэгслүүдээс гадна Тавантолгойн бүлэг уурхай, Оюутолгой уурхай, дэд бүтэц, түлшний хангамжийн зэрэг аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслүүд олноор явдгаас их хэмжээний хөрсний элэгдэл эвдрэл, тоосжилт үүсдэг байна. Энэ 59.6 километр шороон зам нь сумын төв рүү ойртох хэсэг буюу баруун хойд талаас 20 орчим километр газар олон салаалсан байдалтай, хөрсний элэгдэл эвдрэл ихтэй болохыг сумын удирдлага болон иргэд онцолж байсан нь бидний ажиглалтын судалгааны үр дүнтэй тохирч байна.

Агаарын чанар, тоосжилтын мэдээлэл


Тавантолгойн бүлэг уурхайн үйл ажиллагаа эрчимжсэн сүүлийн 10 орчим жилд Цогтцэций сумын иргэдийн зүгээс тоосжилт ихсэж, амьсгалын тогтолцооны өвчлөл нэмэгдэж, амьдрах орчин, эд хөрөнгөд хохирол учирч байгаа талаар гомдол санал гаргаж ирсэн боловч агаарын чанар, тоосжилттой холбоотой хяналт шинжилгээ, байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээлэл маш хомс байна.

Дээрх 3 компаниас зөвхөн Энержи Ресурс компани иргэдийн оролцоотой тоосны хэмжилт хийдэг гэж мэдээлсэн боловч иргэд хэрхэн оролцож, хяналт тавьдаг нь бүрхэг байна. Түүнчлэн, хяналт шинжилгээний дүнг зөвхөн орон нутгийн удирдлага, холбогдох албаны хүмүүсийн хүсэлтээр танилцуулдаг учраас жирийн иргэд энэ талаарх мэдээлэл авах боломж бага байна.

Уул уурхайн компаниуд ямар багаж ашигладаг, яаж хэмждэгийг бид мэдэхгүй. Энержи Ресурс байсхийгээд л тоос, усны түвшин хэмжинэ гээд орон нутгийн иргэдээс төлөөлөл оролцуулаад явж байна гэж зөндөө сонссон. Үнэхээр уул уурхайн компанийн ус, тоосжилт хэмжиж байгаа бол багаж нь чухам ямар юм байдаг, үр дүн нь ямар байна гэж бидэнд мэдээлсэн юм байхгүй. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тоосжилт хэмждэг багаж тавина гэж орсон байдаг. Гэхдээ энд тавьсан гэх юм байхгүй. Тэр багаж нь нүдэнд үзэгдэхгүй жижиг юм байдаг юм болов уу?


Цогтцэций сумын иргэн

Орон нутгийн удирдлага нь компаниудаас агаарын чанарын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч, иргэдэд мэдээлэх, өөрсдийн хэмжилтийн мэдээтэй харьцуулах зэргээр мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авсан арга хэмжээ дутмаг байна. Иргэдээс авсан асуулга судалгаанаас үзэхэд сумын төвийн иргэдийн 70 гаруй хувь нь агаарын чанар, тоосжилттой холбоотой хяналт шинжилгээний мэдээлэл авж байгаагүй байна.



Дүрслэл 13. Агаарын чанар, тоосжилттой холбоотой мэдээлэл авдаг уу? (Цогтцэций сумын төв, Цагаан-Овоо багийн иргэдээс авсан судалгаа)

Тоосжилттой холбоотой мэдээллийг орон нутгийн захиргааны байгууллагаас, Энержи Ресурс компаниас, мөн хэвлэл мэдээлэл зэрэг бусад эх сурвалжаас авдаг байна. Харин төрийн ба орон нутгийн өмчит 2 компаниас тоосжилттой холбоотой мэдээлэл авсан тохиолдол тун цөөн байна.



Дүрслэл 14. Тоосжилттой холбоотой мэдээллийг аль байгууллагаас авч байсан бэ?

Тоосжилтыг бууруулах арга хэмжээ

Тавантолгойн уурхайн үйл ажиллагаа эрчимжсэн сүүлийн 10 орчим жилд Цогтцэций сумын иргэдийн зүгээс тоосжилт ихсэж, амьсгалын тогтолцооны өвчлөл нэмэгдэж, амьдрах орчин, эд хөрөнгөд хохирол учирч байгаа тухай гомдол санал гаргаж ирсэн боловч Монгол улсын Засгийн газрын холбогдох байгууллагууд, орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниуд дорвитой арга хэмжээ аваагүй байна.

Нүүрсний ил уурхай нь асар их хэмжээний хатуу хаягдал болон тоос ялгаруулдаг. Дэлхийн банкны судалгаагаар нүүрсний ил уурхайгаас 1000 тонн нүүрс олборлох тутамд дунджаар 10 тонн орчим хөрсний овоолго үүсч, 0.06-0.1 тонн орчим тоос дэгддэг байна.⁴⁹ Олон улсын туршлагаас үзэхэд нүүрсний ил уурхайн тоосжилт үүсгэгч эх үүсвэр тус бүрээс ялгарах тоосжилтыг хэмжиж, түүнийг ихээс бага руу эрэмбэлж, хамгийн их тоосжилт үүсгэгч эх үүсвэрт авах арга хэмжээг технологийн ба санхүүгийн хамгийн оновчтой хувилбараар төлөвлөж хэрэгжүүлдэг байна.

Уул уурхайн компаниуд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тоосжилтыг бууруулах талаар авах арга хэмжээг тусгахдаа зөвхөн уурхайн дотоод замын усалгааг сайжруулах ажил төлөвлөсөн боловч зам арчилгааны шинэ технологи нэвтрүүлэх, замын хучилтаа сайжруулах, тоосжилтын бусад эх үүсвэрүүд болох хөрсний овоолго, нүүрс овоолох, нүүрс

⁴⁹ Pollution Prevention and Abatement Handbook. 1998. https://www.ifc.org/wps/wcm/connect/79a98080488552b5ac5cfe6a6515bb18/coal_PPAH.pdf?MOD=AJPERES

ачих, тэсэлгээ хийхэд үүсэх тоосжилтыг бууруулах ажлуудыг багтаасан цогц арга хэмжээ төлөвлөхгүй, хөрөнгө зарцуулахгүй байна. Компаниуд тус бүртээ ойн зурвас байгуулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх зэрэг хөтөлбөр хэрэгжүүлдэг боловч тоосжилтыг бууруулахад ямар үр нөлөө үзүүлж байгаа нь бүрхэг байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын цахим тайлангийн системээс авсан мэдээллээр 2017 онд дээрх гурван компани Агаарын бохирдлын төлбөрт нийт 20 орчим тэрбум төгрөг зарцуулжээ. Агаарын бохирдлын төлбөр гэдэг нь “бохирдуулагч нь төлөх ёстой” гэдэг зарчимд суурилагдсан ойлголт юм. Үүний дагуу байгаль орчны бохирдол үүсгэсэн этгээд нь бохирдлын хэмжээндээ дүйцэх төлбөр төлдөг учраас эдийн засгийн үр ашгаа тооцох агаад ингэснээр бохирдлын хэмжээг аль болох бууруулах сэдэлтэй болно. Бохирдлын хэмжээгээ бууруулсан бол төлбөр нь багасахын зэрэгцээ урамшуулал, хөнгөлөлт эдлэх боломж олгох нь нийтлэг байдаг. Түүнчлэн төлбөрийн зохих хувийг бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, дүйцүүлэн хамгаалах зэрэг үйл ажиллагаанд зарцуулах ёстой.

Монгол Улс 2010 оноос Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөр хурааж эхэлсэн бөгөөд нүүрсний салбар гол төлбөр төлөгч болжээ. Уг хуулийн 7.1-д зааснаар олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно. Засгийн газраас хуульд заасан хамгийн бага үнэлгээгээр буюу 1 килограмм тутамд 1 төгрөг буюу 1 тонн түүхий нүүрс тутамд 1000 төгрөгийн төлбөр хурааж байна. 2016-2017 онд Тавантолгойн бүлэг уурхайгаас улсын төсөвт 40 орчим тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Эрдэнэс Тавантолгой компанийн 2018 оны батлагдсан төсвийг үзэхэд энэ онд 10 сая тонн түүхий нүүрс олборлож, агаарын бохирдлын төлбөрт 10 тэрбум төгрөг төлнө.⁵⁰

Түүнчлэн, уг хуулийн 7.3-д автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр тогтоосон бөгөөд том оврын ачаа тээврийн хэрэгсэл тутамд жилд 7500-9500 төгрөг байна.

Агаар бохирдуулсны төлбөрийг 2011 оноос “Цэвэр агаар” сангаар дамжуулан зарцуулж эхэлсэн ч тус сангийн үйл ажиллагаан дахь авлигын асуудал хүндэрч, улмаар 2015 онд татан буугдсан байна. Түүнээс хойш агаарын бохирдлын төлбөрийн ихэнх нь улсын нэгдсэн төсвийн том “тогоо” руу орох болж, зарим хэсэг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Агаарын бохирдлын эсрэг үндэсний хороогоор дамжин зарцуулагдах болсон. 2018 онд УИХ-аар хэлэлцэж баталсан “Агаарын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өмнөх санг “Агаарын бохирдлын эсрэг сан” гэдэг нэртэйгээр дахин байгуулах болж 2019 оны 1 сараас эхлэн агаарын бохирдлын төлбөр уг санд төлөгдөх болов.

Агаарын тухай болон агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлал, мөн Агаарын бохирдлын эсрэг үндэсний хөтөлбөрт нүүрсний уурхай орчмын агаарын бохирдлын асуудал, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн эрсдлийн талаар орхигдсон нь иргэдийн эрх зөрчигдөх суурь шалтгаан болж байна. Үндсэндээ 2010 онд Агаарын бохирдлын төлбөрийг хурааж эхэлснээс

⁵⁰ Эрдэнэс Тавантолгой ХК. 2018 оны батлагдсан төсөв. <http://erdenestt.mn/ihpoex/ykzhxj/tg2/>

хойш нүүрсний уурхайн шууд болон дам нөлөөнд автсан Цогтцэций суманд агаарын бохирдолтой тэмцэх, тус сумын бүртгэлтэй 7000 гаруй, мөн тооны бүртгэлгүй иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зориулж нэг ч төгрөг зарцуулаагүй байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт уул уурхайн нөлөөллөөс үүсч буй тоосжилтыг бууруулах, иргэдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авахаар тусгасан байна. 2018 оны 5 дугаар сард Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарын байгуулсан Хамтын ажиллагааны гэрээнд тоосжилтыг бууруулахад чиглэсэн хэд хэдэн зүйл орсон байна. Үүнд:

- Эрдэнэс Тавантолгой компани нь уурхайн хотхоноос Цогтцэций сумын төв хүртэлх авто замыг 2018-2020 онд барьж байгуулна.
- Эрдэнэс Тавантолгой компани нь Гашуунсухайтын зам хүртэлх нүүрс тээвэрлэлтийн 8.2 км шороон замыг хатуу хучилттай авто зам болгоно.
- Эрдэнэс Тавантолгой компани нь “Тонн баялаг - 1 мод” хөтөлбөрийн хүрээнд сумаас тогтоосон газарт мод тарьж, арчлалт хамгаалалтыг гэрээнд заасан хугацаанд хариуцна.
- Эрдэнэс Тавантолгой компани нь тоосжилт, орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
- Гэрээний хүрээнд хийсэн ажлуудаа 6 сар тутам иргэдэд мэдээлнэ.

Цогтцэций сумын Засаг даргын тамгын газраас тоосжилтыг бууруулах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд:

- 2017 онд 90 сая төгрөгөөр ногоон байгууламжаа нэмэгдүүлэх чиглэлээр ажил хийсэн, цаашдаа тогтмол нэмэгдүүлэх
- 2018 онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын төв доторх 2.2 км замыг хатуу хучилттай болгох
- Авто тээврийн үндэсний төвтэй хамтраад автобусны зогсоол тавиулж, автобус явуулах болсон
- Агаарын бохирдлын төлбөрийг орон нутагт хүртээмжтэй хуваарилах тухай хүсэлтийг УИХ-ын гишүүн Л. Энхболдод хүргүүлсэн
- Тоосжилтын асуудлыг шийдэх зорилго бүхий олон талт оролцогчдын уулзалт, хурал зохион байгуулсан зэрэг ажлыг дурджээ.

ЦАГААН-ОВОО БАГИЙН ТӨВИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Нөлөөллийн шалтгаан

Одоогийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн төв нь 1960-аад оноос Тавантолгойн нүүрсний уурхайн тосгон байсан. Тавантолгой уурхайг Засгийн газрын өмч хувьчлалын комиссын хурлын 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 42 тоот тогтоолоор 51 хувийг нь орон нутгийн өмч, 49 хувь нь хувийн

өмчтэй Тавантолгой ХК болгон хувьчилсан. 2013 оны байдлаар Монголын томоохон компаниудын нэг болох Ажнай Корпораци болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдүүд Тавантолгой ХК-ийн 37 орчим хувийг эзэмшиж байна.⁵¹ Тавантолгой компаний төв оффис нь Цагаан-Овоо багийн төв дээр байдаг.

2006 онд Энержи Ресурс компаниас Тавантолгойн бүлэг ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн 96 хувийг Монгол Улсын Засгийн газар шилжүүлэн авч, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ордын жагсаалтанд оруулсан байна. Өмнөх хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орсон байсан Цагаан-Овоо тосгоны газар Эрдэнэс Тавантолгой компаний ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хэвээр үлджээ.

2010 онд Тавантолгойн Цанхийн ордын Зүүн хэсгээс (Зүүн Цанхи) хөрс хуулалтын ажлыг эхлүүлж, 2011 оноос нүүрс экспортоо эхлүүлсэн. Эрдэнэс Тавантолгой компани 2012 онд Цанхийн ордын Баруун хэсгийн (Баруун Цанхи) Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусгасан. Үүний дагуу Баруун Цанхийн уурхайн хөрсний овоолго тэлэхдээ Цагаан-Овоо багийн төвийн нутаг дээр хийгдэх болсон. 2011 онд Их Айлчин ХХК-ийн хийсэн Зүүн Цанхийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд Зүүн Цанхийн уурхайн байгаль орчны нөлөөллийн 5 км бүсэд Цагаан-Овоо багийн төв хамрагдаж байсан. Үүнээс үзэхэд Эрдэнэс Тавантолгой компаний хувьд Тавантолгойн ордыг бүрэн ашиглахад Цагаан-Овоо баг, түүний дунд багийн төвийн нутагт байгаа айл өрхүүд, Тавантолгой ХК-ийн төв оффисийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болох нь тодорхой байжээ. Харамсалтай нь нүүлгэн шилжүүлэлтэд хийхэд шаардлагатай суурь судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхгүйгээр өнөөдрийг хүрсэн байна.

Эрдэнэс Тавантолгой компани 2011 оноос Баруун Цанхид олборлолт явуулах олон улсын консоциумыг шалгаруулах ажлыг эхлүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй. Эрдэнэс Тавантолгой компани 2012 онд Баруун цанхид хөрс хуулалтыг эхлүүлж, 2013 оны 2 сард олборлолтыг эхлүүлсэн. Олборлолтын хэмжээ ихсэж 2015 онд Баруун Цанхиас олборлосон нүүрс 3.8 сая тонн болов. Энэ хэмжээгээр уурхайн эдэлбэр газар дахь газрын ашиглалт нэмэгдэж, ил уурхайн карьер, ачилт, тээвэрлэлтийн зам, хаягдлын овоолгын талбай өргөжсөн. 2016 онд Баруун цанхийн олборлолтыг тодорхойгүй хугацаагаар зогоосон байсныг 2017 оны 2 сараас сэргээж олборлолтын хэмжээг нэмэгдүүлсэн байна.


Ийнхүү 2013 оноос Баруун Цанхийн уурхай олборлолтоо эхлүүлснээс хойш Цагаан-Овоо багийн төвийн иргэд, аж ахуйн нэгжийн эрхийн асуудал хурцадсан. Баруун Цанхийн уурхайн хаягдлын овоолго багийн төвд улам бүр ойртож, нүүрс тээвэрлэлтийн замтай холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ихэссэн. 2015 онд хийсэн Тавантолгойн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланд “Таван толгойн уурхайн бүс нутаг дахь эрүүл мэндийн байгууллагын бүртгэлээс үзвэл оршин суугчдын өвчлөлийн байдал багуудаар харилцан адилгүй байгаа бөгөөд Цогтцэций сумын 4 багаас Цагаан-Овоо багийн өвчлөл 2007 онд сумын нийт өвчлөлийн 38.5 хувийг эзэлж байсан бол

⁵¹ Ажнай Корпорацийг үүсгэн байгуулагч, УИХ-ын гишүүн асан Д.Бат-Эрдэнэ 2012 оныг хүртэл Тавантолгой ХК-ийн ТУЗ-ын даргын албыг хашиж байв.

2013 онд талаас илүү хувийг эзлэх болсон байна” гэж дүгнэсэн байна.⁵² Өмнөх хэсэгт дурдсанчлан, зөвхөн Тавантолгой ХК тоосжилтын хэмжилт хийхдээ Цагаан-Овоо багийн төвийг хамруулдаг. Тоосжилт, чичиргээ, дуу чимээнээс эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөс сэргийлж олон айл өрх Цогтцэций сумын төв рүү шилжин амьдрах болсон. Байнга оршин сууж буй иргэдийн хувьд эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаар байнгын сэтгэл зовнил, сэтгэл санааны дарамттай амьдрах болсон байна.

Нөлөөллийн цар хүрээ

2014 онд хийгдсэн судалгаагаар Цагаан-Овоо багийн төвд нийт 137 өрх амьдарч, ихэнх нь газраа өвчилж авсан болохыг дурджээ.⁵³ Цогтцэций сумын удирдлагын бидэнд өгсөн мэдээллээр 2018 оны байдлаар Цагаан-Овоо баг нь 200 гаруй өрхтэй, 2300 гаруй хүн амтай. Багийн төв дээр тоосжилт их, усны хүртээмж, чанар муу учраас багийн иргэдийн дийлэнх нь сумын төв дээр болон хөдөө амьдарч байна. Багийн төвийн барилга тосгон дээр байдаг. Гэвч хүн



Дүрслэл 15. Цагаан-Овоо баг ба Тавантолгойн бүлэг уурхай, нүүрс тээвэрлэлтийн тойм зураг

Цагаан-Овоо багийн төвийн орчимд тоосжилт, усны хомсдол, газар, бэлчээрийн хомсдол зэргээс үүссэн амьсгалын замын өвчин, төрөлтийн хүндрэл, харшил, зүрх судасны өвчин зэрэг өвчлөл нэмэгдэхийн зэрэгцээ сэтгэл санаа, эд материалын хохирол гарч байгааг сумын удирдлагууд, иргэд мэдээлж байна. Тэдгээрээс нийтлэг давтагдсан болон зарим онцлох санал, гомдлыг доор харууллаа.

⁵² Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Хуудас 82.

⁵³ Бодлогын судалгааны хүрээлэн. Хуудас 39.

Тоосжилттой холбоотой тулгамдаж буй нийтлэг асуудлууд	Зарим онцлох жишээ
<p><u>Өвчлөл</u></p> <ul style="list-style-type: none"> Амьсгалын тогтолцооны өвчлөл, зүрх судасны өвчлөл, харшил их болсон. Жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний үеийн хүндрэл гарах нь ихэссэн. Арьсны бохирдол ихэссэн <p><u>Санхүү, эд материалын хохирол</u></p> <ul style="list-style-type: none"> Хувь хүн, өрхийн эрүүл мэндийн зардал нэмэгдсэн. Гэрийн эд хогшил, өмч хөрөнгө тоос, шороонд дарагддаг. Элэгдэл, арчилгаа цэвэрлэгээ нэмэгдсэн. Малын уушги, дотор эрхтэн бохирдсон байдаг. <p><u>Сэтгэл санааны дарамт</u></p> <ul style="list-style-type: none"> Төрөх хүүхдийн эрүүл мэндэд ихэд санаа зовж стресс үүсдэг. Уушги тоосжих өвчин, зүрхний шигдээс, бронхит огцом нэмэгдэж байна гэж болгоомжилж байна. Уурхайн отвалийн нарийн ширхэгт цагаан тоос хүүхдийн эрүүл мэндийг хордуулж байна гэж эмээж байна. 	<p>“Манай хүн Тавантолгойд ажилладаг байсан. Бурхан болоод 21 ч хоноогүй байна. Хоёр уушгиндаа хатгаа авсан байсан. Эмнэлгийн сүүлийн дүгнэлтээр зүрхний шигдээс гэсэн. Ажлаа хийж байгаад гэнэт муудаад түргэн дуудаад эмнэлэгт очоод нас барсан”</p> <p>“Сүүлийн 5 жилийн дотор Цагаан-Овоо баг дээр хоёр дахь удаагаа зүрхний шигдээсээр хүн нас барлаа. Амь насыг нь аврах ямар ч боломжгүй байсан. Тэр нь хүнд элемент амьсгалын замаар дамжин уушгинд орж хордуулсантай холбоотой”</p> <p>“2017 оны 3 сараас 2018 оны 3 сарыг 1 жилээр гэж тооцоход 8 жирэмсэн эхийн ураг амьгүй болсон. Энэ мөн л хүчилтөрөгчийн дутагдал. Цусан дахь хордлого их хэмжээтэй байгаа учраас дархлаа суларч байна. Хүчилтөрөгч дутагдсанаас ихэс цусан хангамжгүй болсноос ураг амьгүй болж байна”</p> <p>“Миний төрсөн эгчийн охин 3 хүүхэдтэй. Хүүхдээ төрүүлэх гэж нилээд зүдэрсэн. Анхны хүүхэд нь тархины даралттай, өрөөсөн нүд нь хараа муутай гэх мэт хүндрэлүүд гарсан. Сүүлийн 2 хүүхдээ сумын төв рүү шилжиж очиж байж гайгүй төрүүлсэн. Энэ нь тоосжилттой холбоотой хүчилтөрөгч дутагдлаас үүдэлтэй байх”</p> <p>“Манай говь голдуу л урдаасаа салхилдаг. Цагаан-Овоод урдаасаа салхилах үед бужигнасан хар нүүрс л бидний дээр буудаг”</p> <p>“Бид нар Тавантолгойн тосгонд амьдарч байгаад жоохон хүүхэдтэй учраас их тоосжилтоос зугатааж сумын төвд нүүж ирчихээд байна”</p> <p>“Тавантолгойд бид гэрт амьдардаг байсан, гэрийн тооно, амбаар савны нүх сүвээр нүүрсний нарийн ширхэгтэй тоос орж байдаг. Бүх л юм хар болсон байдаг”</p> <p>“Энд өмнөөсөө салхилвал говийн угалз дотор амьдарч байгаа юм шиг л байдаг. Гал тогоог арчиж цэвэрлээд ямар ч нэмэр байхгүй эргээд тоос дарчихдаг”</p> <p>“Хөмүүл түүхэд гар хав хар болдог, сайн угааж байж л идэж байна”</p>

Усны чанар, хүртээмжтэй холбоотой тулгамдаж буй нийтлэг асуудлууд	Зарим онцлох жишээ
<ul style="list-style-type: none"> Ундны усаа Цогтцэций сумын төвөөс зөөдөг Ундны усны үнэ өндөр, нэмэлт зардал үүсдэг. Усны чанар муу Усны нөөц, зардал болон эрх зүйн хувьд гүний худаг гаргах эрсдэлтэй болоод байна. 	<p>“Тосгоноос алхам газарт ухаад худаг гаргах эрхгүй болчихсон. Байгаа худгууд нь бүгд усгүй болчихсон. Тосгоны хашаан дотор Эрдэнэс Таван толгой худгаа гаргачихсан, тэрнээс нь Таван толгой ажиллагсаддаа худалдаж авч өгдөг”</p> <p>“ЭТТ 1 тонн усыг 96 төгрөг биш 20-30 дахин илүү үнээр 3000 үнээр өгнө гээд байна”</p> <p>“Цагаан-Овоо руу ус зөөж байна. 1 литр нь 3 төгрөг бол сумын төв дээр 1 төгрөг байдаг”</p> <p>“Энержийн уснаас авахад зүгээр, өөр худгаас авахад 2 өдөр болоод ус буцалгагчны дотор тал хужиртчихдаг”</p> <p>“Би цалин мөнгөө авсан үедээ суман дээр байдаг “Болор” цэвэр уснаас авдаг. Ихээр авч дийлэхгүй”</p> <p>“Багийн төв Тавантолгойн ашиглалтын лицензтэй талбай учраас худаг ус гаргах хэцүү”</p>
<p>Малын бэлчээрийн чанар, хүртээмж</p>	
<ul style="list-style-type: none"> Багийн төвийн өрхүүдийн малын бэлчээр уурхайн талбайд орж хашигдсан Уурхайн тоосжилт бэлчээр, ургамлын чанарт сөргөөр нөлөөлсөн 	<p>“Баруун Цанхи манай малын бэлчээр байсан”</p> <p>“Улаан нуур дээр зусдаг байлаа, өвөл хүүхдүүд очиж гулгаж тоглох үе байв. Одоо Улаан нуурын усыг хаагаад овоолго хийчихсэн”</p> <p>“Уурхайг тойрсон гүн шуудуунд мал орж эрсддэг”</p> <p>“Мал алаад идэхээр баас нь ногоон байдаг бол манай энд бор, хар, шар болчихсон”</p>
<p>Уурхайн бусад нөлөөлөл</p>	Зарим онцлох жишээ
<ul style="list-style-type: none"> Олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны дуу чимээний нөлөөлөл их Нүүрс тээврийн хэрэгслүүдийн ялгаруулдаг утаа, хий эрүүл мэндийн эрсдэлтэй Уурхай тэсэлгээнээс чичэргээ их мэдрэгддэг 	<p>“Энэ олон машины дуу чимээ биднийг өдөр шөнөгүй амраадаггүй”</p> <p>“Одоо нүүрсний машинууд тосгоны зүүн талаас 500 метрт оочерлож байна. Машинаа байнга асаалттай байлгадаг болохоор ч тэр үү, бензин үнэртдэг”</p> <p>“Тэсэлгээ хийхэд бүх юм доргидог, урьдчилсан мэдээ, тогтсон өдөр, цаг гэж байхгүй”</p>

Нүүлгэн шилжүүлэх бодлого, арга хэмжээ

2014 онд Дэлхийн банкны санхүүжилтээр Тавантолгойн Цанхийн зүүн уурхайн нөлөөллийн бүс дэх өрхүүдийн нүүлгэн шилжүүлсэн байдалд үнэлгээ хийж, сайжруулах төлөвлөгөөг боловсруулсан байна.⁵⁴ Энэ үнэлгээнд Цагаан-Овоо багийн төв орчмын нутаг дэвсгэр 2015 оноос Тавантолгойн уурхайн хаягдлын овоолгын талбай болохоор Техник, эдийн засгийн үндэслэлд тодорхойлсон байгааг онцолж, овоолгын байршлыг өөрчлөх, ингэх боломжгүй

⁵⁴ Бодлогын судалгааны хүрээлэн. 2014

бол багийн төвийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах шаардлагатай болохыг зөвлөжээ.⁵⁵

2015 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хийсэн Тавантолгойн уурхайн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг дараах 3 үндэслэлээр тайлбарлажээ. Үүнд:

- Тавантолгойн уурхайн эдэлбэр газар тэлж, ялангуяа Баруун Цанхийн уурхайн овоолго Цагаан-Овоо багт 1.5 км хүртэл зайд ойртсон, цаашлаад ойрын 30 жилд уурхайн олборлолт үргэлжилбэл Цагаан-Овоо багийн эргэн тойронд овоолго, карьерууд бий болно.
- Тавантолгойн нүүрсний уурхай орчимд агаарын тоосжилт их, агаар дахь хүхэрлэг хийн хэмжээ бүс нутгийн бусад хэсгээс хамгийн их байгаа нь Цагаан-Овоо багийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж, цаашид ноцтой эрсдэл учруулж байна.
- Таван толгойн бүс нутаг дахь уул уурхай, үйлдвэрлэлийн усны хэрэгцээ нэмэгдэж, бүс нутгийн хүн амын усны үндсэн эх үүсвэр болох уурхай орчмын нутгийн бага гүний усны түвшин буурч, одоо усны хомсдолтой байгаа Цагаан-Овоо багийн төвийн иргэд цаашид улам усны гачигдалд орох эрсдэлтэй.⁵⁶

Цагаан-Овоо багийн Иргэдийн нийтийн хурлаар нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг сүүлийн жилүүдэд хэлэлцэж, санал гомдлоо Эрдэнэс Тавантолгой болон төрийн холбогдох албаны хүмүүс, сум, аймгийн удирдлагуудад хүргүүлж байжээ. Өмнөговь аймгийн ИТХ-ын даргын захирамж гарч, аймгийн хурлын тэргүүлэгч, төлөөлөгч, сумын удирдлагууд орсон ажлын хэсэг байгуулагдаад 2 удаа хуралдсан байна. Эхний хуралдаан нь Цагаан-Овоо тосгонд болж тосгоныг яаралтай нүүлгэх шаардлагатай гэсэн шийдвэр гаргасан байна. Цогтцэций сумын удирдлага газар төлөвлөлтийн дагуу Цагаан-Овоо багийн иргэд шилжин суурьшихад зориулсан газрыг шинэ суурьшлын бүсэд байхаар төлөвлөсөн ч одоогоор ямар нэгэн дэд бүтэц тавигдаагүй, зөвхөн цахилгааны шугам татах төсөв батлагдсан гэж сумын удирдлага мэдээлсэн.

2018 оны 2 дугаар сард Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын үеэр Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх ажлын талаар Эрдэнэс Тавантолгой компаний төлөөлөлтэй уулзаж, цаашдын боломжуудыг хэлэлцсэн байна. Эрдэнэс Тавантолгой компаний зүгээс Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх асуудлаар Засгийн газрын түвшинд шийдвэр гарах шаардлагатай гэж мэдэгдэн тодорхой арга хэмжээ авалгүй явж ирсэн. 2018 оны 5 дугаар сард Өмнөговь аймаг, Эрдэнэс Тавантолгой компанийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний 4.7.2-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийн газар болон эд хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн байгуулагаар хийлгэн тодорхой хэсгийг хариуцна” гэж тусгасан байна.

Цагаан-Овоо багийн иргэдийн хувьд Эрдэнэс Тавантолгой компанийн Цанхийн уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Баруун Цанхийн уурхайн Техник, эдийн засгийн үндэслэл, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө зэрэг нэн чухал баримт бичгүүдтэй танилцаж,

⁵⁵ Хуудас 39.

⁵⁶ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.

мэдээлэл авч байгаагүй, энэ талаар компанийн зүгээс танилцуулсан, хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулаагүй байна. Нөгөө талаас, аймаг, сумын удирдлагын зүгээс энэ талаарх мэдээллийг компаниас гаргуулж, нутгийн иргэдэд хүргэх талаар арга хэмжээ авалгүй ирсэн байна.


Цагаан-Овоо багийн төвийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг цаг алдагүй авч хэрэгжүүлэх, орчны хяналт, шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Цаашид иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлыг тооцуулах, шүүхээр нөхөн төлбөр тогтоолгох арга хэмжээ авах шаардлагатай гэдгийг орон нутгийн иргэд, зарим иргэний нийгмийн байгууллагууд илэрхийлж байна.

Цагаан-Овоо багийн асуудал нь хамгийн ойр үйл ажиллагаа явуулж байгаа, биет нөлөөлөл ихтэй гэдэг үндэслэлээр зөвхөн Эрдэнэс Тавантолгой компанийн Баруун Цанхийн уурхайн хариуцлага байдлаар хязгаарлагдахгүйгээр бусад уурхай, дэд бүтцийн хуримтлагдах нөлөөлөлд орж байгааг харгалзан үзэж, нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөх, зохион байгуулахдаа талуудын оролцоо, хамтын ажиллагааг сайтар хангах хэрэгтэй юм. Нүүлгэн шилжүүлэлтийн гол хариуцагч нь Эрдэнэс Тавантолгой ХК ба Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар байх ёстой боловч Тавантолгой ХК-ийн зүгээс Цагаан-Овоо тосгонд амьдарч буй ажиллагсад, тэдгээрийн гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргааны тогтвортой нөхцлийг бүрдүүлэхийн тулд нүүлгэн шилжүүлэлтийн урт хугацааны төлөвлөгөөнд чухал үүрэгтэй оролцох нь маш чухал байна.

ХҮН АМЫН ӨСӨЛТ БА НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ


Цогтцэций сум 2006 онд 2121 хүн амтай байсан бол Тавантолгойн бүлэг уурхай ажиллаж эхэлснээр 2010 он гэхэд 3366 болж, түүнээс хойш тасралтгүй өссөөр 2017 оны байдлаар 7422 болсон байна. Цогтцэций суманд бүртгэлтэй хүн амын өсөлтийн зэрэгцээ нүүрс олборлолт, тээвэрлэлтийн олон аж ахуйн нэгжүүдийн ажилтнууд, хувь хүмүүс, бусад туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд, дэд бүтцийн төслүүдэд ажиллагсад зэрэг суманд бүртгэлгүй хөдөлгөөнт хүн амын тоо 2011 оноос хойш хурдацтай нэмэгдсэн байна. Цогтцэций сумын удирдлагуудын баримжаа тооцооллоор 9000 орчим хөдөлгөөнт хүн сумын нутаг дэвсгэрт оршин сууж байна.⁵⁷

⁵⁷ Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл-2017. Албан хэрэгцээнд зориулав. 2018 он. Хуудас 22.



Дүрслэл 16. Цогтцэций сумын хүн амын өсөлт

Цогтцэций сумын иргэдээс авсан асуулгын судалгаанаас үзэхэд иргэдийн дийлэнх олонх нь хүн амын өсөлтийн улмаас нийгмийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд нэмэлт ачаалал үүсч, хүртээмж буурсан гэж үзэхийн зэрэгцээ 41 хувь нь хулгайн гэмт хэрэг “маш их болсон” гэдэгтэй санал нийлж /маш их, их, дунд гэсэн хариултын нийлбэр - 78 хувь/, түүнчлэн олонх иргэд охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд санаа зовних болсон байна.



Дүрслэл 17. Цогтцэций сумын хүн амын өсөлтийн нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаарх иргэдийн санаа бодол

Дээрх асуулгын үр дүн болон судалгааны бусад мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бүртгэлтэй ба бүртгэлгүй хүн амын өсөлтийн улмаас Цогтцэций сумын хувьд дараах асуудлууд тулгамдаж буйг тодорхойлов. Үүнд:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж

Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн төсөв нь сумын албан ёсны бүртгэлтэй хүн ам буюу 7400 орчим хүнээр тооцогддог. Гэвч хөдөлгөөнт хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний зардал жил бүрийн төсөвт тусгагддаггүй учраас эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлдөг байна.


Хөдөлгөөнт хүн амаас болж нэмэлт ачаалал үүүсдэг учраас эмч, сувилагчдын ажил ихсэж, хүн бүрд хүрэхгүй болдог. Хүн нэмж авах гэхээр төсөв хязгаартай. Нэг эмч, сувилагчийн ажлын ачаалал их. Ажлын ачааллаас болж алдаа гаргах эрсдэл бий.

Цогтцэций сумын эрүүл мэндийн байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагаас

Хүн амын төвлөрөл ихэссэнтэй холбоотойгоор Цогтцэций болон Ханбогд сумын эмнэлгийн статусыг 2012 онд “Сум дундын эмнэлэг” болгож, эмч, ажилтнуудын орон тоо, зардал төсвийг тодорхойлсон байна. Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн шинэ байр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,2 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж, 2016 оны 4 сард ашиглалтад орсон бөгөөд 5 тасаг, 50 ортой. Тус эмнэлэг нь 9 их эмч, 10 сувилагч, 27 бусад эмнэлгийн ба техникийн ажилтнуудтай байна.⁵⁸

2013 оноос хойш Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн төсвийн санхүүжилт тасралтгүй нэмэгдсэн байна. Цогтцэций сумын 2018 оны төсвийн санхүүжилтийг 2013 оныхтой харьцуулахад Өмнөговь аймгийн ихэнх сумдаас 40-50 хувиар илүү өссөн байна. Гэвч уул уурхайн мега төслийн нөлөөлөлд орсон, бүртгэлтэй хүн амын тоогоор ойролцоо Ханбогд сумтай харьцуулахад төсвийн санхүүжилтийн өсөлт 50 гаруй хувь бага байна. Өөрөөр хэлбэл Ханбогд сумын эрүүл мэндийн байгууллагын 2013 оны улсын төсвийн санхүүжилтийг 2018 оныхтой харьцуулбал 160 хувийн өсөлттэй байгаа бол Цогтцэций сумын хувьд 108 хувьтай байна. Ханбогд сумаас ялгаатай чухал онцлог бол Цогтцэций сумын төвийн чанх дэргэд орших Тавантолгойн бүлэг уурхайн холбоотой олон тооны аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаа эрхэлж байдаг. Сумын Засаг даргын тамгын газрын мэдээллээр Тавантолгойн ойр орчимд 30 гаруй хоолны гэр, гуанз, 30 гаруй дугуй засвар, дэлгүүр эрүүл ахуйн шаардлагатай хангахгүй бохир орчинд ажиллаж, Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайтын зам дагуу 25 км хүртэл нүүрс тээврийн компаниудын 80 гаруй кэмпүүд байна. Үүнээс гадна нүүрс тээвэрлэлтийн том, жижиг 120 гаруй аж ахуйн нэгжид харьяатай 7000 гаруй жолооч, ажилтнууд ажиллаж байна. Эрүүл мэндийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу Сум дундын эмнэлэг эдгээр хөдөлгөөнт хүн амд тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлага байнга гардаг учраас эмнэлгийн төсвийн хүрэлцээ, ажилтнуудын ачаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлдөг байна.

⁵⁸ Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл-2017. Албан хэрэгцээнд зориулав. 2018 он.



Дүрслэл 18. Цогтцэций, Ханбогд сумын Сум дундын эмнэлгийн төсвийн санхүүжилт /сая төгрөг/

Төсвийн хүрэлцээ муудсан, эмнэлгийн эмч, ажилтнуудын ачаалал нэмэгдсэний улмаас төвөөс алслагдсан газарт хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй болох, урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо багасах, илүү цагаар ажиллах, хүлээлгийн цаг ихсэж үйлчлүүлэгчид гомдол санал гаргах, эмч, сувилагч дутагдалтайн улмаас шөнийн ээлжинд дараалан гарснаар алдаа гарах эрсдэл ихсэх зэрэг асуудлууд тулгарч байгааг эмнэлгийн ажилтнууд онцлон хэлж байна. Хүн амын тоо ойролцоо Ханбогд, Гурвантэс сумдын эмнэлгүүд 2017 онд 6900 болон 3111 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн бол энэ үзүүлэлт Цогтцэций сумын эмнэлгийн хувьд 2523 байна.⁵⁹ Цогтцэций сумын эмнэлэг 2016, 2017 онуудад жилд дунджаар 15000 орчим үзлэг хийсэн байна. 2010 оноос өмнө хүн амын өсөлт хэвийн байх үед бусад сумдын адилаар жилд дунджаар 5000 орчим үзлэг хийдэг гэсэн тооцоолол байна.

Ажлын ачаалал маш их, нэг хүн гэхэд 2 хүний ажлыг хийж байна. Шөнийн цагаар их ажилладаг. Компанийн ажиллагсад оройн цагаар ихэвчлэн ирдэг. 23.00 цаг хүртэл амбулаторын үзлэг шиг л байдаг. Илүү цаг гарахаар төсөв хөрөнгө хүрэхгүйгээс мөнгийг нь олгож чаддаггүй.

Цогтцэций сумын эмчтэй хийсэн ярилцлагаас

2016-2017 оны байдлаар Цогтцэций сумын эмнэлэгт бүртгэгдсэн нийт өвчлөл дунджаар 4000 орчим байгаа нь Ханбогд сумаас 2 дахин, Гурвантэс сумаас 1.5 дахин их, бусад сумдаас 15-20 дахин их байгаа нь тус эмнэлгийн ачаалал ихээхэн нэмэгдэж буйг нотолж байна.⁶⁰ Хөдөлгөөнт хүн амын дунд амьсгалын тогтолцооны өвчлөл, бэлгийн замын халдварт өвчин, ажлын ачаалал, нөхцөлөөс хууч өвчин сэдрэх, архидалт, осол гэмтэлтэй холбоотой эмнэлгийн тусламж

⁵⁹ Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл-2017. Албан хэрэгцээнд зориулав. 2018 он. Хуудас 14.

⁶⁰ Мөн тэнд.

үйлчилгээ авах тохиолдол их байна. Түүнчлэн, Цогтцэций сумын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 2016-2017 онд жилд дунджаар 1200 байгаа нь Ханбогд /600/, Гурвантэс /400/ сумтай харьцуулахад 2-3 дахин өндөр байна.

Цогтцэций сумын хүн амын өсөлтөд уул уурхайн компанид ажиллах, бусад ажлын болон бизнесийн боломжууд хайж шилжин ирсэн залуучуудын хувь нэмэр их байдаг. 2017 оны байдлаар нийт хүн амд 25-35 насны залуучууд 48 хувь эзэлж байна. Үүнтэй холбоотойгоор жирэмслэлт, төрөлт ихтэй. 2017 оны байдлаар Цогтцэций сумын харъяат 203 эх амаржсан бөгөөд түүний 159 нь сумын эмнэлэгт амаржсан байна. Хүн амын тоо ойролцоогоор Ханбогд сумын эмнэлэгт 115, Гурвантэс сумын эмнэлэгт 101 эх амаржсан бол бусад сумдын хувьд энэ тоо дунджаар 30-40 орчим байдаг.⁶¹ Цогтцэций сумын эмнэлэгт 4 эх баригч ажиллах ёстойгоос зөвхөн нэг л эх баригч эмч ажиллаж байна. Тиймээс эх баригчийн хувьд 2-3 хоног ээлжгүй ажиллах, нойр муутай, ачаалал ихтэй ажиллах асуудал тулгардаг. Шөнийн ээлжинд нэг сувилагч ажиллах бөгөөд төрөх болон бусад тасгаа нэгэн зэрэг хариуцдаг байна. Жирэмсэн нэг эмэгтэйд 40 минутаас 1 цагийн хооронд үзлэг хийгддэг. Эмч цөөн, ачаалал ихтэй байдаг учраас хүмүүс бухимдах тохиолдол нилээд гардаг байна.

Залуучууд, хөдөлгөөнт хүн ам ихтэй, түүнчлэн нүүрс тээвэрт олон хоногоор явах үед гардаг эрсдэл зэргээс бэлгийн замын халдварт өвчин их байдаг. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү өвчний илрэл нэмэгдэж байгаа нь урагт нөлөөлөх, амьгүй төрөх эрсдэл дагуулж байна гэж сумын эмч нар онцолж байна. Сумын эмнэлгээс бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв хөрөнгө байхгүй, ажлын ачааллаас анхаарал хандууж чаддаггүй байна. Түүнчлэн Цогтцэций сумын Өрхийн эмнэлэг өөрийн машин байхгүй учраас явуулын сургалт, урьдчилан сэргийлэх ажил хийх боломж багатай, дан суурин байдлаар ажилладаг ажээ.

Цогтцэций сумын хүн амд залуучуудын эзлэх хувь өндөр, гэр бүлээрээ сумын төвд оршин сууж буй уурхайчин болон бусад ажилчид олон учраас 0-5 насны хүүхдүүдийн хүн амд эзлэх хувь 8.2 хувь бөгөөд бусад сумдаас 1-3 хувь өндөр байна. Тоосжилт, агаарын бохирдлын улмаас бага насны хүүхдүүдийн дунд амьсгалын тогтолцооны өвчлөл ихтэй, хүүхэд эрүүл өсч торниход хүнд байгааг сумын эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд болон иргэд анхааруулж байна.

Боловсролын үйлчилгээний хүртээмж

Цогтцэций сумын хүн амын 42 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаа нь боловсролын үйлчилгээний эрэлт хэрэгцээ өндөр болохыг нөхцөлдүүлж байна. 2017 оны байдлаар 0-18 насны нийт 3416 хүүхэд байгаагийн 1407 буюу 45 хувь нь 0-5 насны хүүхэд, үлдсэн 55 хувь нь сургуулийн насны хүүхэд байна.⁶²

⁶¹ Мөн тэнд. Хуудас 6.

⁶² Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс. Өмнөговь аймгийн 2017 оны 12 сарын нийгэм эдийн засгийн танилцуулга. 2018 он.



Дүрслэл 19. Цогтцэций сумын 0-18 насны хүүхдүүд /2017 он/


2013 оныг хүртэл Цогтцэций суманд Түвдэнгийн Борын нэрэмжит Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль үйл ажиллагаа явуулж байсан. Тус сургууль 440 хүүхдийн багтаамжтай. 2010 оноос сумын хүн өссөнөөр ачаалал хэтэрч 3 ээлжээр хичээллэх болсон байна. 2013 онд Энержи Ресурс компани, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар хамтран Цогтцэций сумын Ерөнхий боловсролын 6-р сургууль буюу “Мөрөөдөл” цогцолбор сургуулийг ашиглалтанд оруулжээ. Энэ цогцолбор нь 640 хүүхдийн сургууль, 114 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байртай. Энержи Ресурс компанийн зүгээс уг шинэ сургуулийг дэмжих 5 жилийн хөтөлбөр хэрэгжүүлж, энэ хүрээнд боловсролын менежментийн шинэ тогтолцоо нэвтрүүлэх, гадаад хэлний ба математикийн гүнзгийрүүлсэн шатны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, нийслэлийн шилдэг сургуулиудын нэг болох Орчлон сургуулиас багш нарыг урьж ажиллуулах зэрэг үйл ажиллагаа явуулжээ. Шинэ 6-р сургуульд 2013-2014 онд буюу Тавантолгойн уурхайн олборлолт, экспорт нэмэгдсэн үед 740 хүүхэд сурч байсан бол, нүүрсний экспорт буурсан, ялангуяа Энержи Ресурс сул зогсолт хийх болсон 2015-2016 онд 640 хүүхэд болж буурч байжээ.⁶³

Өнөөгийн байдлаар ерөнхий боловсролын дээрх 2 сургууль нийт 1080 хүүхдийн багтаамжтай боловч 1800 орчим хүүхэд суралцаж байна. Түүний 800 орчим нь 6-р сургууль, үлдсэн 1000 орчим нь Т.Борын нэрэмжит сургуульд суралцаж байна. Орон нутгийн иргэд, сурагчидтай хийсэн уулзалт ярилцлагаас үзэхэд 6-р сургууль нь нэг ангид хичээллэх хүүхдийн тоог 30-аас хэтрүүлдэггүй, сурагчдын чөлөөт цагаа өнгөрөөх орчинг хангасан, орой 6 цагаас хойш сургууль дээр хүүхэд байх ёсгүй зэргээр хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг байна. Сурагчдын дийлэнх нь Энержи Ресурс компанид ажиллагсад болон шилжин суурьшсан айлын хүүхдүүд байдаг гэсэн ойлголт нийтлэг байна.

Харин Т.Борын нэрэмжит сургуулийн хувьд ачаалал хэтрэлт 6-р

⁶³ НҮБ-ын Хүүхдийн Сан. Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл: Судалгааны үр дүн ба зөвлөмжүүд. 2017 он. Хуудас 25.

сургуулиас 5 дахин их байна. 2013 онд сумын хүн ам 6108 байсан үед 6-р сургууль ашиглалтанд орж тухайн үед үүссэн сургуулийн ачааллыг бууруулж байсан ч хүн ам үргэлжлэн өссөөр 2017 онд 7422 болсон. Энэ өсөлтөөс үүдэн Т.Борын нэрэмжит сургуулийн ачаалал 2013 оны өмнөхтэй адил их ачаалалтай, 3 ээлжээр хичээллэж байх үетэй адил түвшинд очсон байна. Ийнхүү ачааллын хэтрэлттэй нөхцөлд сурагчид сургууль дээрээ чөлөөт цагаа өнгөрөөх боломжгүй болжээ. Хүүхдүүдийн хувьд сумын төвд хичээлээс гадуур чөлөөт цагаа өнгөрөөх газар байхгүй учраас гол төлөв гадуур сагсан бөмбөг, компьютер тоглоом, бильярд тоглох зэргээр чөлөөт цагаа өнгөрөөдөг байна.



Дүрслэл 20. Хүн амын өсөлтөөс сургуулийн ачаалал ихэссэн эсэх (Иргэдийн асуулга судалгаа)

Өмнөх хэсэгт дурдсанчлан Цогтцэций сумын хүн амын өсөлтийн нөлөөгөөр төрөлт, бага насны хүүхдийн тоо огцом ихэссэн. 2017 оны байдлаар 3-6 нас буюу сургуулийн өмнөх насны нийт 1009 хүүхдүүд байдгаас нийт 550 хүүхдийн багтаамжтай 3 цэцэрлэгт 800 орчим хүүхэд боловсрол эзэмшиж байна. Одоогийн байдлаар 200 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.


Гэмт хэрэг, нийгмийн хэв журам

Гэмт хэргийн гаралт

Цогтцэций сумын хүн амын өсөлт, ялангуяа хөдөлгөөнт хүн амтай холбоотой гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил нэмэгдсэн байна. Сумын цагдаагийн албаны мэдээллээр гэмт хэрэг үйлдэгчдийн дунд хөдөлгөөнт хүн ам зонхилдог байна. 2018 оны I улирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сумын хэмжээнд гэмт хэргийн гаралт 60 хувиар өссөн үзүүлэлттэй байна гэж

мэдээлсэн. Сумын цагдаагийн ажилтнууд гэмт хэргийн гаралт нэмэгдсэн гол шалтгаан нь хөдөлгөөнт хүн ам ихэссэнтэй холбоотой гэж үзэж байна.

Өмнөговь аймаг дахь уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа төвлөрч байгаа Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын хэмжээнд 2017 онд нийт 228 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд энэ нь Өмнөговь аймгийн хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн 49 хувь болж байна. Аймгийн хэмжээний нийт гэмт хэргийн 18 хувь нь Цогтцэций суманд бүртгэгджээ.⁶⁴ Ханбогд сумын хувьд нутаг дэвсгэрт нь Гашуунсухайт хүртэлх нүүрс тээврийн зам дайрч өнгөрдөг, түүнчлэн Цагаан Хадны гаалийн хяналтын бүс тус сумын Хайрхан багийн нутагт байдаг учраас гэмт хэргийн гаралт өндөр байх гол шалтгаан болдог. Цогтцэций сумын хувьд 2016 онд 66 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2017 онд 82 болж 24 хувиар өссөн байна. Ханбогд сумын хувьд 2016 онд 51 гэмт хэрэг 2017 онд 108 болж бүртгэгдсэн нь энэ 2 сумын хувьд Тавантолгойн бүлэг уурхайн нүүрс олборлолт, тээвэр ихэссэнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил нэмэгдсэн болохыг нотолж байна (Дүрслэл 21).⁶⁵ Цогтцэций сумын хэмжээнд гэмт хэргийн гаралтын тооны хувьд нэгдүгээрт эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хоёрдугаарт өмчийн хулгайн гэмт хэрэг, гуравдугаарт зам тээврийн гэмт хэрэг ордог байна.



Дүрслэл 21. Цогтцэций, Ханбогд сумын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Замын хөдөлгөөний аюулгүй байдал

Сумын төвийн дотоод замын хөдөлгөөний эрчим ихэссэн нь иргэд, хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулж байна. Учир нь төвийн шороон замын хөдөлгөөнөөс тоос шороо дэгдэж харагдах орчин хязгаарлагддаг, ялангуяа хүнд даацын тээврийн хэрэгслүүд их хэмжээний тоос шороо босгож, хөрсний элэгдэл эвдрэл үүсгэдэг байна. Түүнчлэн, тээврийн хэрэгслүүд хурд

⁶⁴ Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс. Өмнөговь аймгийн 2017 оны 12 сарын нийгэм эдийн засгийн танилцуулга. 2018 он.

⁶⁵ Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс. Жилийн эцсийн нэгтгэл тайлангууд. 2015-2018.

хэтрүүлэх зэрэг замын хөдөлгөөний дүрэм зөрчих нь их байдаг. Сумын төвийн замын тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй, замын цагдаагийн газрын зохицуулалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сул болохыг орон нутгийн иргэд хэлж байна.

Сумын төвийн 2 сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар сургуулиудын зүгээс фосфортой ханцуйвч өмсгөх, замын хөдөлгөөний дүрэм заах, сургууль орчимд хашаа, хаалт хийх зэрэг арга хэмжээ авч байгаа ч сумын төвийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай байна. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад анхаарал хандуулж, камержуулах, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, эрсдэл ихтэй цэгүүдийг тодорхойлж, иргэдийн оролцоотой орчныг сайжруулах, хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатайг нутгийн иргэд, хүүхдүүд, бусад оролцогч талууд анхааруулж байна.

Жендерт суурилсан хүчирхийлэл

Ахлах сургуулийн сурагчидтай хийсэн ярилцлагаар Цогтцэций сумын төвөөр дайран өнгөрч буй, ойролцоо ажиллаж буй хөдөлгөөнт хүн ам их байдаг нь эмэгтэй хүүхдүүдэд эрсдэл учирдаг болохыг хэлж байлаа. Оройн цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн үл таних хүмүүс их байдаг. Ганц нэгээрээ явж буй охид, эмэгтэйчүүдийг дуудах, айлгах ичээх зэрэг тохиолдол гардаг. Үүнтэй холбоотой өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн аюулгүй байдалд санаа зовних байдал ихэссэн байна.

Нүүрс тээвэрт олон хоногоор ажиллах, ажлын нөхцөл, ачааллаас сэтгэлзүйн хямралд орох, архи хэтрүүлэн хэрэглэх, амрах хугацаандаа архи уудаг зэрэг шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал нэмэгдэх эрсдэл байна.

“Хөдөлмөрийн насны өндөр цалинтай хүмүүсийн дунд архидалт их байна гэдэг харамсалтай л юм. Архины хордлоготой хүмүүс их ирдэг. 14 хоног ажиллаад 7 хоног амрахдаа эмнэлэгт архины эмчилгээ хийлгэж байгаа хүн цөөнгүй байна”


Цогтцэций сумын эмнэлгийн эмчтэй хийсэн ярилцлагаас

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сумын удирдлагаас зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Нэгд, Цогтцэций сум сэтгэл зүйч эмчтэй болсон бөгөөд тусламж үйлчилгээ шаардлагатай хүмүүстэй уулзах, гэр бүлүүдэд нь зөвлөгөө өгдөг. Сэтгэл зүйч эмчийн хэрэгцээ их хэрэгтэй байдгийг жолооч нараас авсан судалгаа мөн харуулж байна. Хоёрт, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг байгуулж, 2 сургууль, 3 цэцэрлэг дээр эцэг эхчүүдтэй нь хамтарсан сургалт хийсэн байна.

Нийгмийн гадуурхал, ялгаварлал

2006 онд Цогтцэций сумын хүн ам 2121 байсан нь 2010 онд 3000 гаруй болж, өнөөдөр 7500 орчим болсон. Энэ хурдацтай өсөлт нь Тавантолгойн бүлэг ордыг ашиглах болсонтой холбоотой олон хүн Цогтцэций суманд шилжин

суурьших болсонтой холбоотой. Богино хугацаанд үүссэн хүн амын механик өсөлтөөс болж иргэдийн дунд нутгийн уугуул иргэн, шилжин суурьшигч буюу суугуул иргэд гэж ялгарлах, ялгаатай байдлаар харилцах хандлага байна. Цогтцэций сумын төвийн иргэдтэй хийсэн ярилцлагаас дүгнэхэд иргэдийн дунд уугуул, суугуул гэдгээс болж ялгаварлагдах, зөрчил үүсэх, ялангуяа төрийн байгууллагад ажиллах, нийгмийн үйлчилгээ авахад сөргөөр нөлөөлөх тохиолдол нилээд байдаг байна. Үүнийг сумын төвийн иргэдээс авсан асуулга судалгаа мөн нотолж байна.



Дүрслэл 22. Дараах асуудал сүүлийн нэг жилд тохиолдож байсан гэж хариулсан иргэдийн хувь

Гол төлөв Энержи Ресурс компанийн ажилчид гэр бүлийн хамтаар амьдардаг “Цэций хороолол” хажуудаа сургууль, цэцэрлэгийн цогцолбортой, Ухаа худаг уурхайн ажилчдын “Галерей” кэмпэд ойр, дэд бүтэц, тохижилтын хувьд сумын төвийн бусад суурьшлын хэсгээс харьцангуй ялгаатай учраас сумын төв дотроо тусдаа суурьшлын хэсэг мэт ойлголт хүчтэй байдгаас хүмүүсийн харилцаанд уугуул, суугуул гэдэг зөрчил үүсэх тохиолдол байдаг байна. Энэ нь социал сүлжээний орчин болон өдөр тутмын амьдралд тохиолддог болохыг ярилцлага, ажиглалт харуулж байна.

Уул уурхайн компаниудад ажилладаг, шилжин суурьшсан иргэдийг “газрын баялаг дуусахаар буцаад явах хүмүүс” гэдэг байдлаар ялгаварлаж харьцах, ялангуяа төрийн албанд сонгогдох эрхээ эдлэх, улс төрийн амьдралд оролцоход гадуурхах, ялгаварлах хандлага байдаг байна. Нөгөөтэйгүүр, сүүлийн жилүүдэд ажил, зах зээлийн боломж хайж шилжин суурьшиж буй иргэдийн хувьд төрийн ба нийгмийн үйлчилгээ авахад ялгавартай хандах, гадуурхах байдал гардаг тул мэдээлэл авах, санал гомдлоо илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг байна. Сумын уугуул оршин суугчид, 2010 оноос хойш

ирсэн шилжин суурьшигч хүн амын хооронд үүсч болзошгүй эдийн засаг, нийгэм, соёлын ялгаа, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, цаашид нэг сум, нэг нутаг гэдэг хамтын үнэлэмжийг бий болгох бодлого үгүйлэгдэж байна. Ийм бодлого байдаггүйн улмаас жишээ нь сумын 2 сургуулийн хүүхдүүдийн хооронд уугуул, суугуул, уурхайд ажиллагсдынх ба бусад гэдэг хандлага бий болсон байна. Түүнчлэн, ихэнх иргэд хог цэвэрлэх, мод тарих зэрэг олон нийтийг хамарсан ажилд хойрго хандаж, идэвх оролцоо сул байдаг нь нийгмийн харилцаан дахь эв нэгдэл сул байгаатай холбоотой юм.

Орчны бохирдол, эрүүл ахуй

Сумын хүн ам өсөхийн хирээр сумын төвийн айлууд, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдал нэмэгдсээр байна. Сумын хогийн цэгийг ландфил хийх замаар булшилж, шинэ хогийн цэг нээсэн ч иргэд хуучин хогийн цэг дээр хогоо хаясаар байгаа нь орчны бохирдлыг үүсгэж байна. Өмнө нь сумын эрчим хүчний салбар хатуу хог хаягдлын менежментийг давхар хариуцдаг байсныг Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч өөрчилж, 2018 оноос 20-иод ажилтантай хот тохижилтын тусдаа компани шинээр байгуулан хариуцуулж эхэлжээ.

Нүүрс тээврийн зам дагуух олон гэр, хоолны газар, засвар үйлчилгээний газрууд, тэдгээрийн зохион байгуулалт, төлөвлөлтгүй бөөгнөрлийн орчинд хог хаягдал хуралдаж, орчныг бохирдуулж байна. Сумын засаг дарга захирамж гаргаж, эдгээр газруудаар шалгалт хийхэд Гашуунсухайт замын 25 дугаар км-ийн шалган нэвтрүүлэх газар хүртэлх 80 гаруй газар гэр, аж ахуйн нэгжийн кэмп, худалдаа, хүнс, үйлчилгээний цэгүүд байжээ. Эдгээрийн зөвхөн 4 нь газрын зөвшөөрөлтэй, бусад нь дур зоргоороо барилга, байшин, гэр барьж үйл ажиллагаа явуулж байв. Замын дагуу нэгдсэн журмаар газар олгож, холбогдох эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг тавьж хэрэгжүүлээгүй учраас ямар нэгэн хяналт байхгүй, ойр орчимд хог хаягдал, эзэнгүй нохой маш их байна.



Зураг 6. Гашуун сухайтын авто замын эхлэлээс 6 дахь км-т байрладаг төлөвлөлт, зохион байгуулалтгүй худалдаа, үйлчилгээний цэг

Гашуунсухайтын авто замын эхлэлээс 4 болон 6 дахь км-т төлөвлөлт, зохион байгуулалтгүй худалдаа, үйлчилгээний цэг үүсч, олон тооны гэр, зөөврийн байшин замбараагүй бөөгнөрсөн байдалтай байна. Нүүрсний тээврийн жолооч нар амрах, дэлгүүрээр үйлчлүүлэх, хоол унд идэх, машин техникээ засаж сэлбэх түр зогсоол байдлаар ашигладаг. Эдгээр цэгт зориулалтын машины зогсоол, цахилгаан ба усан хангамж, стандартын бие засах газар зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах наад захын нөхцөл бүрдээгүй байна. Хүнд даацын олон тооны машин эдгээр цэг рүү орж гардаг, олон салаа шороон зам үүсгэдэг учраас энэ орчин дахь хөрсний элэгдэл эвдрэл маш их. Дээрх гарамуудын урд хэсгээр малын бэлчээр нь байх малчдын хувьд тоосжилт, бэлчээрийн талхлагдалт хүнд асуудал болсон байна. Эндээс үүсч буй тоосжилт хойшоо чиглэлтэй салхиар Цогтцэций сумын төвд хүрэх боломжтой. Түүнчлэн, машины засвар үйлчилгээтэй холбоотой түлш, масло асгах, үйлчилгээний газрууд шингэн хог хаягдлаа хаях зэргээр хөрсний бохирдол үүссэн байна.

Сумын Засаг даргын тамгын газрын зүгээс дээрх 2 газарт төлөвлөлтгүй ажиллах болсон 30 гаруй халуун ус, гуанз, засварын газруудыг нэг цэгт төвлөрүүлэх, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд, машины зориулалтын зогсоол байгуулах ажлыг санаачилж нүүрс тээврийн компаниудтай хамтран ажиллахыг зорьсон боловч нийт 120 орчим аж ахуйн нэгжүүдээс 20 орчим нь хариу өгчээ. 3 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай энэ ажилд нүүрс тээврийн компаниудын хамтын ажиллагаа, зүтгэл дутагдсан байна. 2018 онд сумын Засаг даргын тамгын газраас зориулалтын тээвэр ложистикийн төв байгуулах санал гаргасан 2 аж ахуйн нэгжид газрын зөвшөөрөл олгож, одоогоор төвийн зураг төслийг боловсруулж дууссан, хөрөнгө оруулалтаа аж ахуйн нэгжүүд хариуцахаар төлөвлөгөө хийгдсэн байна.

Хөндөгдөж буй эрхүүд, нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Анхаарах шаардлагатай нөлөөлөгч хүчин зүйлс, үйл ажиллагаа, эрсдлийн талаарх дүгнэлт

Хөндөгдөж буй эрх: Амьд явах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	3-р зүйл	6-р зүйл		16.1-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Амьд явах эрх нь хүний амь насыг аливаа дур зоргын халдлагаас хамгаалах, амь насыг аврах зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн эрх болно. Хүний амьд явах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас иргэнээ хамгаалах төрийн үүрэг болно.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
Нөлөөлөл: Тавантолгойн бүлэг уурхайн тоосжилттой холбоотойгоор Тавантолгой ХК-нд ажилладаг, Цагаан-Овоо багийн төвд амьдардаг иргэний эрүүл мэнд муудаж, амь насаа алдсан гэдэг гомдол бүхий иргэд байна.				

Хөндөгдөж буй эрх: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
				16.2-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг хэлнэ. Орчны бохирдол гэдэгт агаарын, усны, хөрсний гэх мэт органик бохирдлоос гадна дуу чимээний, хог хаягдлын, гэрлийн гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй органик бус бохирдлыг хамааруулдаг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Нөлөөлөл: Цогтцэций сумын төвийн орчимд тоосжилт ихсэж амьсгалын замын өвчин, төрөлтийн хүндрэл, харшил, зүрх судасны өвчин зэрэг өвчлөл нэмэгдэхийн зэрэгцээ сэтгэл санаа, эд материалын хохирол гарч байна. Цогтцэций сум нь 10000 хүн амд эзлэх амьсгалын тогтолцооны өвчлөлөөр сумдаас хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Ялангуяа, Цагаан-Овоо багийн өвчлөл 2007 онд сумын нийт өвчлөлийн 38.5 хувийг эзэлж байсан бол 2013 онд талаас илүү хувийг эзлэх болсон байна. Цогтцэций сумын хүн амын өсөлт, ялангуяа хөдөлгөөнт хүн амтай холбоотой гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил нэмэгдсэн байна.

Нүүрс тээврийн зам дагуух олон гэр, хоолны газар, засвар үйлчилгээний газрууд, тэдгээрийн зохион байгуулалт, төлөвлөлтгүй бөөгнөрлийн орчинд хог хаягдал хуралдаж, орчныг бохирдуулж, тээврийн ажилтнууд, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.

Хөндөгдөж буй эрх: Эрүүл мэндээ хамгаалуулах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	25-р зүйл			16.2, 16.6-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Хүн бүр эрүүл мэндийн зохистой үйлчилгээг цаг хугацаанд нь авах, төрөл бүрийн эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, үйлчилгээний нөхцлөөр хангагдсан байх, эрүүл байх боловсрол мэдээлэл авах боломж, эрүүл мэндтэй холбоотой шийдвэрт оролцох эрхтэй.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн төсөв нь сумын бүртгэлтэй хүн ам буюу 7400 орчим хүнээр тооцогддог. Гэвч хөдөлгөөнт хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний зардал жил бүрийн төсөвт тусгагддаггүй учраас эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Тоосжилт ихсэж, амьсгалын тогтолцооны өвчлөл нэмэгдэж, амьдрах орчин, эд хөрөнгөд хохирол учирч байгаа талаар гомдол санал гаргаж ирсэн боловч агаарын чанар, тоосжилттой холбоотой хяналт шинжилгээ, байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээлэл маш хомс байна. Зарим мэдээлэл нь төөрөгдүүлсэн шинжтэй байгаа нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг зөрчиж байна.

Хөндөгдөж буй эрх: Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 сарын 28-ны 64/292-р тогтоол
Тухайн эрхийн товч тайлбар	
Хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм.	
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт	
Цагаан-Овоо багийн төвийн иргэд усны хомсдолтой, усаа сумын төвөөс зөөж хэрэглэдэг, өндөр үнээр худалдаж авдаг, гүний худаг гаргах нь эрх зүй, эдийн засгийн эрсдэлтэй байна. Цаашид усны гачигдалд улам бүр орох эрсдэлтэй.	

Хөндөгдөж буй эрх: Сурч боловсрох эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	26-р зүйл		13-р зүйл	26-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Сурч боловсрох эрхийн агуулгад хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох, техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боломж хүртээмжтэй байх, хувь этгээд, байгууллагаас сургууль байгуулах, албан бус боловсрол олгох зэрэг ойлголт орно.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
2013 онд сумын хүн ам 6108 байсан үед 6-р сургууль ашиглалтанд орж тухайн үед үүссэн ачааллыг бууруулж байсан. Харин түүнээс хойш хүн ам улам өсч 2017 онд 7422 болсноор Т.Борын нэрэмжит сургуулийн ачаалал 2013 оны өмнөхийн адил их ачаалалтай, 3 ээлжээр хичээллэх түвшинд очсон байна. Цогтцэций сумын хүн амын өсөлтийн нөлөөгөөр төрөлт, бага насны хүүхдийн тоо огцом ихэссээр байна. 2017 оны байдлаар 3-6 нас буюу сургуулийн өмнөх насны нийт 1009 хүүхдүүд байдгаас нийт 550 хүүхдийн багтаамжтай 3 цэцэрлэгт 800 орчим хүүхэд боловсрол эзэмшиж, үлдэх 200 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.				
Хөндөгдөж буй эрх: Эд хөрөнгө өмчлөх эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	17-р зүйл			16.3-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Хүн бүр хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх ёстой.				

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Эрдэнэс Тавантолгой компани нүүлгэн шилжүүлэлт хийхэд шаардлагатай суурь судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхгүйгээр өнөөдрийг хүрсэн нь иргэдэд санхүү, эд материалын хохирол учруулж байна.

Хөдөлгөөнт хүн амын өсөлтийн улмаас хулгайн гэмт хэрэг ихсэж иргэдийн өмчид хохирол учирч байна.

Хөндөгдөж буй эрх: Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	17-р зүйл			16.3-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Энэ эрх нь аливаа хүн өөрийн улсын дотоодод болон гадаад оронд зорчих, түр буюу урт хугацаанд оршин суух, шилжилт хөдөлгөөн хийж, засаг захиргааны шилжилт бүртгэлд хамрагдах, өөр хот суурин, улс оронд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, улмаар эх орондоо буцан ирэх зэрэг өргөн агуулгыг хамааруулдаг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Нүүлгэн шилжүүлэлтэд хийхэд шаардлагатай суурь судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхгүйгээр өнөөдрийг хүрсэн нь Цагаан-Овоо багийн иргэд урт хугацаанд оршин суух газраа сонгох, төлөвлөх боломжийг хязгаарлаж байна.

Хөндөгдөж буй эрх: Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
				16.12-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Аливаа хүн төр, нийгмийн болон иргэдийн нийтлэг эрх ашигт хохирол учруулахаар оршин байгаа зөрчил, дутагдлыг арилгуулах буюу нийгмийн хэв журам, хууль зөрчсөн асуудлын талаар, мөн өөрийн болон бусдын эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд өргөдөл гаргах эрхтэй, нөгөө талаас уг гомдол, өргөдлийг шийдвэрлэх, хариу өгөх үүргийг төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар хүлээдэг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Цогтцэций сумын төв, Цагаан-Овоо багийн орчмын агаар, хөрсний бохирдол, иргэд, айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх асуудлаар УИХ, Засгийн газар, холбогдох төрийн байгууллага, Эрдэнэс Тавантолгой компанид иргэд, сумын удирдлага хандаж байсан боловч асуудал хэрхэн хэлэлцэгдэж, ямар шийдвэр гарсан нь тодорхойгүй үлддэг.

Түүнчлэн, тоосжилттой холбоотой иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар гомдол, санал хүсэлт илэрхийлдэг боловч хүлээн авч, шийдвэрлэх үүрэгтэй төрийн байгууллагууд анхаарал хандуулалгүй ирсэн. Эрдэнэс Тавантолгой компанид иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх тогтолцоо хэрэгждэггүй.

Хөндөгдөж буй эрх: Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	19-р зүйл	19-р зүйл		16.16-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Иргэдээс авсан асуулга судалгаанаас үзэхэд сумын төвийн иргэдийн 70 гаруй хувь нь агаарын чанар, тоосжилттой холбоотой хяналт шинжилгээний мэдээлэл авдаггүй байна.

Иргэд 3 уурхайн Техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө зэрэг нэн чухал баримт бичгүүдтэй танилцаж, дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжгүй байна. Аймаг, сумын удирдлагын зүгээс энэ талаарх мэдээллийг компаниас гаргуулж, орон нутгийн иргэдэд хүргэх талаар арга хэмжээ авалгүй ирсэн байна.

Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, эрэмбэ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	3	3	2	3
	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	2	3	2	3
	Амьд явах эрх	3	1	3	2
	Мэдээлэл авах эрх	1	3	2	3
II	Сурч боловсрох эрх	1	3	2	3
	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	2	1	3	2
	Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	2	1	2	2
III	Эд хөрөнгө өмчлөх эрх	2	1	2	2
IV	Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх	1	1	2	2

Дараах шалгууруудын дагуу 1-3 хүртэлх эрэмбээр үнэлсэн.

Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)

Х - Нөлөөллийн хамрах хүрээ (1-3)

С - Эрхийг сэргээх боломж (1-3)

М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

ЗӨВЛӨМЖ

Тоосжилтыг бууруулах

- Уул уурхайн компаниуд ил уурхайн тоосжилт үүсгэгч эх үүсвэр тус бүрээс ялгарах тоосжилтыг хэмжиж, түүнийг ихээс бага руу эрэмбэлж, хамгийн их тоосжилт үүсгэгч эх үүсвэрт авах арга хэмжээг хамгийн оновчтой хувилбараар тодорхойлж, цогц хөтөлбөр хэрэгжүүлэх
- Эрдэнэс Тавантолгой компани нь өөрийн уурхайн хотхоноос Цогтцэций сумын төв хүртэлх авто замыг 2019 онд багтаан нэн яаралтай барьж байгуулах
- Эрдэнэс Тавантолгой компани нь Гашуунсухайтын зам хүртэлх нүүрс тээвэрлэлтийн 8.2 км шороон замыг хатуу хучилттай болгох ажлыг яаралтай дуусгаж, ашиглалтад оруулах
- Сумын дотоод дахь авто замын тоосжилтыг бууруулахад чиглэсэн цогц хөтөлбөрийг боловсруулж, сумын холбогдох төрийн байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын оролцоотой хэрэгжүүлэх, хатуу хучилттай замын хэмжээг нэмэгдүүлэх
- Агаарын бохирдолтой тэмцэх сангаас агаарын бохирдлын төлбөрийн зохих хувийг Цогтцэций сумын орчмын тоосжилтыг бууруулах арга хэмжээнд зарцуулах
- Даланзадгад-Цогтцэций чиглэлийн 59 км замыг хатуу хучилттай болгох ажлыг Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой, Энержи Ресурс, Оюу Толгой зэрэг аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх

Тоосжилт, агаарын чанарын хяналт шинжилгээг сайжруулах

- Тавантолгойн 3 уурхай орчны агаарын чанар, тоосжилтын хяналт шинжилгээ хийх аргачлал, нөөц, давтамж, ил тод байдлыг сайжруулах
- Тавантолгойн 3 уурхай агаарын чанар, тоосжилтын байнгын, тасралтгүй хяналт шинжилгээ хийх олон улсын жишгийг нэвтрүүлэх
- Цогтцэций сумын Цаг уурын ажиглалтын харуул хэмжилт хийх аргачлал, баримтжуулалт, мэдээллийн хадгалалтын горимыг нарийвчлан тодорхойлох, уг төхөөрөмжийг ашиглах, үр дүнг мэдээлэх чадавхийг нэмэгдүүлэх
- Цогтцэций сумын төвийн орчмын агаарын чанар, тоосжилтын судалгааг бие даасан хараат бус судалгааны байгууллагаар хийлгэх

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай болон Агаарын бохирдлын тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулж, агаарын бохирдлын төлбөрийн 50 хүртэл хувийг тухайн орон нутгийн байгаль орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалт хийх
- Агаарын бохирдолтой тэмцэх сангаас агаарын бохирдлын төлбөрийн зохих хувийг Цогтцэций сумын орчмын агаарын чанарын хөндлөнгийн судалгаа хийх, байнгын хяналт шинжилгээ хийх ажилд зарцуулах
- Агаарын тухай хууль болон байгаль орчны хуулиудад тоосжилтыг хянах, бууруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох, холбогдох журам, стандартыг боловсруулах
- Агаарын тухай болон агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлал, мөн Агаарын бохирдлын эсрэг үндэсний хөтөлбөрт нүүрсний уурхай орчмын агаарын бохирдлын асуудал, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн эрсдлийн талаар тусгах

Цагаан-Овоо багийн иргэдийн эрүүл мэнд, тогтвортой амьжиргааг хамгаалах

- Эрдэнэс Таван Толгой компани Цагаан-Овоо багийн төвийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, үүнд иргэдийн оролцоог хангах
- Нүүлгэн шилжүүлэлтийн гол хариуцагч нь Эрдэнэс Тавантолгой ХК ба Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар байх ёстой боловч Тавантолгой ХК-ийн зүгээс Цагаан-Овоо тосгонд амьдарч буй ажиллагсад, тэдгээрийн гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргааны тогтвортой нөхцлийг бүрдүүлэхийн тулд нүүлгэн шилжүүлэлтийн урт хугацааны төлөвлөлтөд манлайлах үүрэгтэй оролцох
- Орчны хяналт, шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлэх
- Иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлыг тооцуулах, шүүхээр нөхөн төлбөр тогтоолгох арга хэмжээ авах

Цогтцэций сумын хүн амын өсөлттэй холбоотойгоор тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх


- Сум дундын эмнэлгийн статусыг дээшлүүлэх
- Хүн амын бүртгэлийг шинэчлэх, хүн амын суурь судалгаа хийх
- Залуучууд, залуу гэр бүлд чиглэсэн эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх
- Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэгийн хүний нөөцийг нэмэгдүүлэх
- Сургууль, цэцэрлэгийн шинэ цогцолбор барьж байгуулах
- Сумын төвийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн цогц хөтөлбөр боловсруулж, цагдаагийн байгууллага хяналтаа сайжруулах, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах
- Камержуулах, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, эрсдэл ихтэй цэгүүдийг тодорхойлж, иргэдийн оролцоотой орчныг сайжруулах, хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх

- Нүүрс тээврийн зам дагуух олон гэр, хоолны газар, засвар үйлчилгээний газруудад хамтарсан шалгалт зохион байгуулах, хууль, журамд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэдийг төвлөрсөн тээвэр, ложистикийн төвд ажиллуулах

НҮҮРС ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа

2004 онд анх БНХАУ руу нүүрс экспортолж эхлэх үеээс 2011 оныг хүртэлх хугацаанд нүүрсний ачаа тээврийг шороон замаар хийж байсан. 2009 оноос Ухаа худгийн уурхайгаас нүүрс экспортолж эхэлсэн бөгөөд шороон ба сайжруулсан шороон замаар нүүрс хийх автомашины тоо нэмэгдсэн. 2010 оноос “Энержи ресурс” ХХК өөрийн санхүүжилтээр Ухаа худгийн уурхайгаас Гашуунсухайтын хилийн боомт хүртэлх 240 км замыг 2011 онд ашиглалтанд оруулсан байна. Тус компанийн хувьд нүүрс тээвэрлэлтээ энэ замаар хийх болсон боловч бусад компаниудаас нүүрс тээвэрлэгчид зам ашигласны төлбөрийг өндөр байна гэдэг шалтгаанаар ихэнх тээвэрлэгчид өмнө ашиглаж байсан сайжруулсан шороон замаар нүүрс тээвэрлэсээр байсан.



Дүрслэл 23. Нүүрс тээврийн засмал зам ба шороон зам (2012 он)

Нүүрс тээврийг шороон замаар хийснээс тоосжилт ихэсч үзэгдэх орчин хязгаарлагдах, гүн ховил үүсэх зэрэг шалтгаанаар осол аваар их гарч, олон хүн амь насаа алдаж байсан. 2010-2012 оны 10 сарын байдлаар Өмнөговь аймагт нүүрсний зам дээр 310 зам тээврийн осол гарснаас 26 хүн нас барж, 44 хүн

хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл авсан байна.⁶⁶ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Авто тээврийн газраас замыг хэсэгчилэн хаах хүртэл арга хэмжээ авч байжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 299 дүгээр тогтоолоор уг хатуу хучилттай авто замыг “Эрдэнэс МГЛ” ХХК худалдан авсан. Говийн зам компани хариуцаж байсан уг авто замын ашиглалт, тээврийн горимыг хэвээр хадгалах, засвар арчлалт болон бусад үйл ажиллагааг хэвийн явуулах үүргийг Эрдэнэс Монгол компанийн харьяа Гашуунсухайт Авто Зам ХХК-д хариуцуулж гүйцэтгүүлэхээр болсон.

Өмнийн говийн байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, тээвэрчдийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, тусгай зориулалтын авто замаар тээвэрлэлт хийх Монгол Улсын стандартыг мөрдүүлэх зорилгоор нүүрс тээврийн замын ашиглалтын төлбөрийг бууруулах шаардлага тулгарсан. Ийнхүү Эрдэнэс Монгол ХК болон Гашуун Сухайт Авто Зам ХХК нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй зөвшилцөж 2013 онд нэг тонн нүүрс тутмаас зам ашигласны төлбөрт 4.2 доллар авах тарифтай байсныг 2014 онд 1.5 доллар, улмаар 2015 онд 1.25 доллар болгож бууруулсан байна. Ингэснээр зардал хэмнэх зорилгоор шороон замаар олон тооны хүнд даацын тээврийн хэрэгслүүд зорчих байдал зогссон билээ. Харин урт дараалалтай үед шороон замаар явж дараалал дайрах, бичиг баримтын зөрчилтэй жолооч хяналт шалгалтаас зайлсхийх зэрэг зорилгоор шороон замаар тээвэрлэлт хийх явдал бүрэн зогсоогүй байна.




Зураг 7. Шороон замаар явж дараалал дайрч буй байдал (Эх сурвалж: Цагаан хадны жолооч нарын Фэйсбүүк групп, 2018 оны 4 сарын 5)

⁶⁶ Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн мэдээлэл, 2012 он

Монгол, БНХАУ-ын хил дээр орших Гашуунсухайт боомт нь 1992 онд анх байгуулагдсан, Монгол Улсын Говийн бага дархан цаазтай газрын хилийн бүс дотор байршдаг, Өмнөговь, Дундговь аймгийн хүн ам хилийн худалдаа хийдэг, Оюутолгойн зэсийн баяжмал, Тавантолгойн нүүрс гэсэн Монгол Улсын эрдэс баялгийн экспортын гол урсгал болдог боомт юм. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 108 дугаар тогтоол, УМХГ-ын даргын 2003 оны 61 дүгээр тушаалаар 2003, 2005 онуудад бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж аймгийн мэргэжлийн хяналтын газрын Хилийн мэргэжлийн хяналтын хэлтэс болон 34 орон тоотойгоор хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулдаг.

Тус боомтоор 2010-2015 оны хооронд жилд дунджаар 115 мянган ачааны автомашин хилээр гардаг байсан бол 2016 онд хилээр гарах ачааны автомашин 214 мянга болж боомтын ачаалал огцом нэмэгдэж, улмаар 2017 онд энэ тоо 280 мянгад хүрсэн байна.



Дүрслэл 24. Гашуунсухайт боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо

1992 онд Гашуунсухайт боомт байгуулагдсанаас хойш Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт уг боомтоос 23 км зайтай орших Цагаан хад гэдэг газар цөөн хэдэн байшин, гэр бүхий суурьшил үүссэн байна. 2006 оноос Тавантолгойн уурхайгаас нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд Цагаан хадны Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийлгэн экспортлох болсон.⁶⁷ 2010 оны байдлаар Цагаан хадны орчимд 30 гаруй малчин өрх амьдарч байсан байна.⁶⁸

⁶⁷ Засгийн газрын ээлжит хуралдаан боллоо. 2013 оны 6 сарын 24. <http://vip76.mn/content/18129>

⁶⁸ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих" төсөл, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. 2015 он. 177-р хуудас.



- Суурьшил
- Малчин айл

Дүрслэл 25. Цагаан хад, 2004 он (Эх сурвалж: Google Earth)



Дүрслэл 26. Цагаан хадны өмнөд хэсэг дэх үйлчилгээний газрууд, гаалийн хяналтын талбайнууд, 2016 он (Эх сурвалж: Apple Maps)

Тавантолгой компанийн нүүрсний экспорт нэмэгдэхийн хэрээр Цагаан хадны гаалийн хяналтын бүсээр дамжих нүүрс тээвэр нэмэгдэж, байгаль орчин, хөрс, агаарын чанар, орчмын бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл тулгамдаж эхэлсэн. Түүнчлэн, энэ газар төрөл бүрийн үйлчилгээ эрхлэх хүмүүсийн тоо нэмэгдэж, дэлгүүр, хоолны газар, ахуйн үйлчилгээний газрууд олширч, газар ашиглалт ихээхэн тэлжээ.

Цагаан хадны нүүрс дамжуулан буулгах газруудын байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ огт хийгдэлгүйгээр үргэлжилж

байв. 2010 оноос Энержи Ресурс, түүний дараа Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрсний экспорт эхэлж, тус бүс дэх нөхцөл байдал хүндэрсэн байдаг. 2012 онд Цагаан хадны орчны агаарт хийсэн хэмжилтээр том ширхэглэлт тоосны дундаж агууламж “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2007 стандартад заасан хүлцэх хэмжээнээс 45 дахин их, нарийн ширхэглэлт тоосонцор 34-35 дахин их байсан байна.⁶⁹

2013 оны 6 сард Монгол Улсын Засгийн газрын 225 дугаар тогтоолоор Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн гаалийн хяналтын бүс байгуулах шийдвэр гарч Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг зогсоосон байна. Түүнчлэн, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам Цагаан хадны гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтоох, нөхөн сэргээх зардлыг тооцох ажлыг эхлүүлсэн гэж тухайн үед мэдэгдэж байв.⁷⁰

Тус газарт нүүрс дамжуулан буулгах талбай бүхий аж ахуйн нэгж, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, хувь хүмүүс Засгийн газрын дээрх шийдвэрийг эсэргүүцэж холбогдох байгууллагуудад хүсэлт хүргүүлж байжээ. Үүнд “Цагаан хаданд ажиллаж байгаа үндэсний аж ахуйн нэгжүүд нь Гаалийн хяналтын бүс байгуулахын тулд 2-5 тэрбум төгрөг зарцуулсан. Иймд энэ газар үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгасан тохиолдолд үндэсний 100 гаруй аж ахуйн нэгжид багагүй хохирол учирна. Түүнчлэн тэнд ажиллаж, амьдарч байгаа 10,000 орчим иргэн ажлын байр, орлогогүй болох юм. Энэ нь ажлын байрыг нэмэгдүүлэх төр, засгийн бодлогод эсрэгээр нөлөөлж байна”, “Цагаан хад дахь нүүрс буулгах үйл ажиллагааг улам сайжруулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи ашиглах, байгаль орчноо хамгаалах, Цагаан хадыг орчин үеийн боомт хот болгоход бид өөрсдийн бололцоогоо дайчлан Засгийн газар, орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллахад бэлэн байна” гэж онцолсон байна.⁷¹

2015 оны байдлаар Цагаан хад орчимд ажиллаж, амьдарч буй иргэд ундны ус зөөврөөр хэрэглэж, цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй, эмнэлэг, засаг захиргааны байгууллагын үйлчилгээ авдаггүй байсан. Цагаан хад орчимд 30-40 дэлгүүр, хоолны газар, ахуйн үйлчилгээний цэг ажиллаж байсан ч эрүүл ахуйн чанар стандартыг мөрддөггүй, ямар нэгэн татвар хураамж төлдөггүй байв.⁷² 2016 оны эхэн үеэс нүүрсний экспортын хэмжээ нэмэгдэхэд Цагаан хадны орчмын хөдөлгөөнт хүн ам дахин өссөн байна.

⁶⁹ Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2012 оны 4/2056 дугаар албан бичиг.

⁷⁰ Монголын Үндэсний Олон Нийтийн Цахим Хуудас. Цагаан Хадны иргэд, байгууллагууд эсэргүүцлээ илэрхийлэв. 2013 оны 8 сарын 12. <http://www.mnb.mn/i/4131>

⁷¹ Мөн тэнд.

⁷² Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. 2015. 173



Зураг 8. Цагаан хадны суурьшил, үйлчилгээний газрууд бүхий хэсэг цэг (2018 оны 3 сар)

2017 оны 7 дугаар сараас Гашуунсухайт боомтоор гарах тээврийн хэрэгслийн урт дараалал үүссэнтэй холбоотой Засгийн газрын 320-р тогтоол гарч Гашуунсухайт-Ганц модны хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэмэгдэх хүртэлх түр хугацаанд нүүрсний тээвэрлэлтийг Тавантолгойн нүүрсний ордоос Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл, Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайт боомт хүртэл чиглэлээр тус тус зохион байгуулах, түүнчлэн Цагаан хадны гаалийн хяналтын бүс болон Гашуунсухайтын боомт хооронд нүүрсний тээвэрлэлт хийхдээ тус чиглэлийн орон нутгийн чанартай шороон зам ашиглах шийдвэр гаргасан.

Энэ шийдвэр нь 100 гаруй км үргэлжилсэн дарааллыг бууруулсан боловч Цагаан хадны орчимд их хэмжээний авто тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт хүн амын бөөгнөрөл үүсгэсэн байна. Үндсэндээ Тавантолгойн уурхайгаас нүүрс ачиж ирээд Цагаан хадны нүүрс дамжуулах талбайд буулгах дараалал, тус талбайгаас нүүрс ачих дараалал, нүүрс ачсан машин Цагаан хаднаас Гашуунсухайт боомт хүртэлх замд нийлэх дараалал, түүнээс цааш Гашуунсухайтын боомт хүртэлх 23 км зам дээрх зэрэг олон давхар дараалал үүсгэсэн байна. Улмаар асар их тоосжилт бүхий орчинд олон мянган жолооч нар олон өдрөөр хүлээх нөхцөл бий болгожээ.


2018 оны 8 дугаар сард Засгийн газраас Тавантолгойн уурхайн гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайт боомт хүртэл тээвэр хийх зөвшөөрлийг эргэн сэргээсэн байна. Тиймээс өнөөгийн байдлаар энэ тээвэрлэлтэд оролцогчдын нэрлэж заншсанаар “Уртын урт”, “Урт”, “Богино” гэсэн 3 маршрутаар Тавантолгойн бүлэг ордоос Гашуунсухайт боомт хүртэл нүүрс тээвэрлэж байна.

Дүрслэл 27. Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээвэрлэх маршрут

	Тавантолгойн уурхай	Гашуунсухайт боомт
Уртын урт	245 км	
	Тавантолгойн уурхай	Цагаан хад
Урт	220 км	
		Цагаан хад Гашуунсухайт
Богино		25 км

НҮҮРС ТЭЭВРИЙН ЖОЛООЧ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Энэ үнэлгээний хүрээнд үнэлгээний баг нүүрс тээврийн жолооч нараас санамсаргүй түүврийн аргаар асуулга судалгаа авсан. 2018 оны 3 дугаар сард Тавантолгойн уурхайгаас 6 км дэх зогсоол, зам дагуу, Цагаан хад орчимд дараалалд зогсож буй жолооч нараас судалгаа авсан. Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийг доор харууллаа. Энэ нь нийт жолооч нарын хүн ам зүйн ерөнхий төлөв байдлыг төлөөлөхүйц үндэслэлтэй болно.



Дүрслэл 28. Нүүрс тээврийн жолооч нарын судалгаанд оролцогчдын мэдээлэл

Асуулга судалгаа болон бусад эх сурвалжаас авсан мэдээллээс үзэхэд нүүрс тээврийн жолооч нар ямар аж ахуйн нэгжид харъяалагдаж байгаагаасаа хамаарч хэд хэдэн бүлэгт хамаарч байна. Үүнд:

- Тээвэрлэлтээ өөрөө хариуцдаг Энержи Ресурс компанийн жолооч нар
- Монгол Улсын иргэдийн хөрөнгө оруулалттай ачаа тээвэрлэлтийн эрх бүхий аж ахуйн нэгжийн жолооч нар
- БНХАУ-ын иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалттай, Монгол иргэний нэр дээр бүртгэлтэй аж ахуйн нэгжийн жолооч нар
- Монгол Улсад бүртгэлтэй хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр нүүрс тээврийн ажилд оролцож буй цөөн тооны жолооч нар зэрэг болно.



Дүрслэл 28. Нүүрс тээврийн жолооч нарын тээврийн хэрэгслийн өмчлөл, аж ахуйн нэгжийн харъяалал (Асуулга судалгааны дүн, 2018 оны 3 дугаар сар)


ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ

Жолооч нартай хийсэн ярилцлагаас ямар аж ахуйн нэгжид харъяалагдаж буйгаас хамаарч цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн ба эрүүл мэндийн даатгалд хамрагддаг зэрэг нь ихээхэн ялгаатай байна. Жолооч нарын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой бүх төрлийн даатгалыг бүрэн хариуцдаг, жолооч бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, холбогдох хөдөлмөр, эрүүл ахуйн хууль, тогтоомж, дүрэм, журмыг баримталдаг аж ахуйн нэгж маш цөөн байна. Үндсэндээ Энержи Ресурс компани ба цөөн хэдэн тээврийн эрх бүхий аж ахуйн нэгжүүд үүнд хамаарч байна. Энержи Ресурс компани нь 600 орчим жолоочтой байна.

Энержи Ресурс компанийн жолооч нарын хувьд хөдөлмөрлөх, амьдрах орчин нөхцөл сайтар хангагджээ. Тухайлбал, жолооч нарын нийгмийн асуудал (орон сууц, сургууль, цэцэрлэг) шийдэгдсэн, эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд тогтмол хамрагддаг, мэргэжлийн зэргийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад хамрагдаж, компанитайгаа гэрээ байгуулан ажилладаг. Тээврийн хэрэгслийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийдэг, хөдөлмөр-амралтын горимыг мөрдүүлж хэвшүүлсэн, стандартын кэмп болон амралтын байраар хангагдсан байна.

“Монгол” компани буюу Монгол улсын иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, эзэмшлийн компаниуд нь тээврийн хэрэгслийн тоо, үйлдвэрлэлийн бааз, техник хангамж, хөдөлмөрийн хуулийн шаардлагуудыг мөрдөж буй эсэхээр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Жолооч нарын өгүүлснээр зарим “Монгол” компаниуд нь хөдөлмөрийн гэрээ байгуулдаг, уурхай орчимд болон зам дагуу өөрсдийн бааз болон кэмптэй байдаг учраас амрах боломжтой байдаг, эрүүл мэндийн ба нийгмийн даатгалд хамруулдаг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулдаг зэрэг давуу талтай боловч цалин хөлс бага, цалин хөлсөө гэрээнд зааснаар олгодоггүй, машин эвдэрч гэмтэхэд жолоочийн хариуцлагад тооцох, цалингаас суутгах, техникийн оношлогоо үзлэг, засварыг шуурхай хийдэггүй зэрэг сул талуудтай байна. Тийм учраас олон жолооч “Хятад” компани буюу Монгол иргэн, аж ахуйн нэрээр бүртгэлтэй боловч БНХАУ-ын иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, эзэмшлийн аж ахуйн нэгжид ажиллах байдал их байна.

Цагдаа нар тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийн торгууль, төлбөрийг зөвхөн хувь жолоочид ноогдуулдаг нь жолооч нарт санхүүгийн дарамт үүсгэх, авлига өгөх нөхцлийг бүрдүүлэхээс гадна тээврийн аж ахуйн нэгжүүд хариуцлагаас мултрах нөхцлийг бүрдүүлдэг.



Дүрслэл 29. Та эрүүл мэндийн үзлэгт хэр тогтмол хамрагддаг вэ?

“Хятад” компанийн хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулах явдал тун цөөн, үндсэндээ орчуулагч, зуучлагчаар дамжуулж аман гэрээ хийдэг. Жолооч нар БНХАУ-д очиж машины эзэдтэй аман гэрээ хийгээд нүүрс тээвэрлэлтэд оролцдог. Энэ ангилалд жолооч нарын дийлэнх хувь нь хамрагдаж байна. Машиныг эзэмшигч тал нь машины даатгал, засвар үйлчилгээг бүрэн хариуцдаг боловч жолооч нар өөрсдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой бүхий л эрсдлээ хариуцдаг байна. “Хятад” компаниудын жолооч нарын дийлэнх нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалгүй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдах нь бага байна.

Өмнөх компани бидний итгэлийг алдсан. Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд компаниас төлнө гэж хэлчихээд дараа нь цалингаас суутгадаг. Тиймээс бид хувь хятадын машин барьж байна. Хувь хятад хүний нэг авах тал нь хангамжийг сайн өгдөг. Жолоочийн зүгээс машин хүйтэн, кабин дулаалмаар байна гэхэд шаардлагыг хүлээж аваад биелүүлдэг.


Замд явж байгаа тохиолдолд кабиндаа хонохоос өөр аргагүй. Уурхай дээр мөн адил кабиндаа хононо. Харин монгол компанийн жолооч уурхайд ачих үеэр өөрсдийн компанийн кэмпэд амардаг.

Хятад эзэнтэй Монголын нэр дээр явдаг юм байна лээ. Яг эзэдүүд нь бол дандаа Хятадууд. Гэрээ хийхдээ Монгол компани дээр хийчихдэг юм байна лээ.

Хятад компани бол эвдрэл гэмтлээ заагаад өгчих, та амарч бай, усанд орж бай гээд амраачихдаг, сайн амраана, за бэлэн болсон машинаа аваад яв гэдэг.

Амь даатгал байхгүй, нийгмийн даатгал байхгүй, эрүүл мэнд бүр ч байхгүй, гэрээ ч байхгүй, Зүгээр л ачиж аваачаад мөнгөө авна.

Жолооч нартай хийсэн ярилцлагаас



Дүрслэл 30. Та хөдөлмөр, аюулгүй байдлын сургалтанд суудаг уу?

2018 оны 1 дүгээр сараас өмнө зөвхөн Энержи Ресурс компани өөрийн тээврийн хэрэгслээр нүүрс тээвэрлэж, ингэхдээ жолооч бүртэй хариуцлагын гэрээ байгуулж, хөдөлмөр аюулгүй байдлын сургалтад хамруулж, холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу нүүрс тээвэрлэлтийн ажлыг зохион байгуулж, жолооч нарт хөдөлмөр, амралтын горимыг мөрдүүлж ажиллаж байна. Гэхдээ зах зээлийн эрэлт (Хятадын талын худалдан авалт) нэмэгдсэн тохиолдолд туслан гүйцэтгэгч компани болон хувиараа тээвэрлэгч нартай гэрээ хийдэг байна. Энержи Ресурс компанийн тайлбарласнаар ихэнх тээврийн компаниуд Хятадын хөрөнгө оруулалтай, хятад менежменттэй компаниуд байдаг тул үйл ажиллагааны хувьд тогтворгүй, гэрээний үүрэг хариуцлага огт биелүүлдэггүй учир гэрээний хэрэгжилт хангалтгүй байдаг.

Эмч энд байхгүй, Энержид л байдаг гэсэн. Бид нарт бол тийм юм байхгүй. Бие өвдвөл аптека орж өвчин намдаах эм уучихдаг.

Жоохон даарах ч юмуу тийм үед их ханиалгадаг. Нүүрс буулгасны дараа бас. Энэ ажилтай л холбоотой байх гэж ойлгоод байгаа. Зүв зүгээр л байсан юм чинь.

Дугуй хагарлаа гэхэд өөрсдөө л аргална, заримдаа үйлчилгээ гарч ирнэ, тогтсон юм байхгүй. Хагархай дугуйтай явбал дугуй шатна, нүүрс шатна.


Жолооч нартай хийсэн ярилцлагаас

Харин Эрдэнэс Тавантолгой ХК болон орон нутгийн Тавантолгой ХК нь нүүрс худалдан авагч компаниуд (Шэнхуа, Чалко, Вэйнсвэй, Пушин г.м.)-д тээвэрлэлтийн асуудлаа даатгаж, тээвэрлэлтийн компаниудад ямар нэгэн шаардлага тавихаас зайлсхийдэг байна. Засгийн газрын шийдвэрээр 2018 оны 1 дүгээр сараас эхлэн бүх уул уурхайн компаниуд нүүрс тээврийн аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулсаны дараа Авто тээврийн үндэсний төв “С” болон “Д” зөвшөөрлийг олгох зохицуулалт хийгдээд байгаа боловч Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой компаниуд энэ асуудалд нилээд хойрго хандаж байна.

2018 онд Зам тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулсан шалгалтаар нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн 60 орчим хувь нь стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй байгааг тогтоосон байна.⁷³ Түүнчлэн, Авто тээврийн үндэсний төвөөс 2018 оны 5 дугаар сард хийсэн техникийн хяналтын үзлэгээр уурхайгаас Гашуунсухайт чиглэлд нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байгаа 124 аж ахуй нэгжийн нийт 6452 хүнд даацын тээврийн хэрэгсэлд үзлэг хийжээ. Үүнээс 3799 нь буюу 28 хувь нь “Хүнд даацын автотээврийн хэрэгсэл”, техникийн ерөнхий шаардлага MNS 6278:2011 стандартын шаардлага хангаагүй байсан бөгөөд 3790 нь өнгө үзэмж, 69 нь тоормос, 31 нь жолооны шаардлага хангаагүй, 9 тээврийн хэрэгсэл гэрэл дохионы бүрэн байдлыг хангаагүй байсан байна.⁷⁴

⁷³ <https://smartcar.mn/news/169>


⁷⁴ Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээврийн үйл ажиллагаанд цогц хяналт тавьж байна. <http://mminfo.mn/news/view/18658>



Дүрслэл 31. Сүүлийн нэг жилийн хугацаанд жолооч нарт тохиолдож байсан асуудлууд, хувиар

Түүнчлэн, нүүрс тээврийн жолооч нарт хөдөлмөрийн нөхцлийн хувьд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Тавантолгой бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явагдаж буй Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутагт ажиллаж, амьдарч бусад иргэдийн нэгэн адил агаарын бохирдол (нүүрсний болон тээвэрлэлтийн тоосжилт), ундны болон ахуйн хэрэглээний усны гачигдалтай орчинд ажиллаж, амьдардаг.
- Нийт жолооч нарын 90 хувь нь (Энержи Ресурс компаниас бусад) эрүүл мэндийн үйлчилгээ (анхан шатны тусламж, оношлогоо, эмчилгээ)-нд хамрагдах боломжгүй байна.
- Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу олгогдсон эрх (долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл байна, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна, илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл, илүү цагийн хөлс авах, хүнд нөхцөлд ажилласны нэмэгдэл авах г.м.)-ээ эдлэх боломжгүй байна.



Дүрслэл 32. Нүүрсний тээвэр хийхэд дараах үйлчилгээ хүртээмжтэй байдаг уу?
(5-1 хүртэл оноогоор үнэлнэ үү.)

- Нүүрс тээвэрлэлтийн ажилд оролцож буй уул уурхайн компани (Энержи Ресурсаас бусад бүх), нүүрс худалдан авагч тал (БНХАУ-ын нүүрсний компани, борлуулагч), тээврийн аж ахуйн нэгж нь тээвэрлэлтийн асуудалд холбогдох хууль (Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль), дүрэм, журам, стандартыг мөрдөх ажлыг биелүүлэх сонирхолгүй байгаагийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдаж, жолооч нар эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх, амьдрах боломж хязгаарлагдмал байна.



Зураг 9. Нүүрс тээврийн жолоочийн машины кабины дотор тал

Өвөл, зунгүй л машиндаа хоноглоно. Өвөлд бол кабин халаагч, паараа ажиллуулаад л амарна даа.

Өвөл бол хэцүү, хүн өөрөө даарч хөрөхгүй кабин халаагчтай байлаа гэхэд машин хөлдөөд, дор хаяад машин аслаа гэхэд тормос шөрмөс нь зуураад л тэгээд цуваагаараа зогсох асуудал гарна.

Амрах газар байхгүй, нэг газар амрах гээд орхиод явбал тоноод хаячихна.

Замд дараалалд зогсож байсан нэг залуу амьдаараа шатаж үхэж байсан. Яаж ч чадахгүй, хаанаас ч галын машин ирэх юм. Бидний энэ машинд байгаа галын хор чинь унтрааж дийлэхгүй байгаа юм чинь.


Жолооч нартай хийсэн ярилцлагаас

- Төрийн үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд, халамж, шүүх, захиргаа, нийгмийн хэв журам сахиулах г.м.) авах эрх хязгаарлагдмал, түүнийг хангах механизм бүрдээгүй байна.
- БНХАУ-ын нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэний хувьд эрхээ хамгаалуулах боломжгүй. БНХАУ-ын харъяат иргэд, аж ахуйн нэгжтэй хөдөлмөрийн маргаанаа шийдвэрлүүлэх механизм байхгүй байна. Хятадын талд хэрэг, зөрчилд өртсөн жолооч нарын эрхийг хамгаалах механизм байхгүй. Өвөрмонгол иргэд хөтөч буюу зуучлагчаар ажиллаж, шаардлагатай тохиолдолд Хил хамгаалах ерөнхий газрын албан хаагчид Хятадын талтай холбогдож, асуудлыг зохицуулахыг оролддог.

Хятадад цагдаа нар зоддог гэж ярьдаг. Зарим нь ч манайхны буруу юм байгаа л байх, гэхдээ Хятадууд их хэрцгий зодож жанчаад байдаг.

Хятад талд асуудал гарахад хандах байгууллага, хүн юу ч байхгүй. Монгол талын хөтөч гээд нэг өвөрмонгол хүн л бий. Тэр нь бид нарт ямар ч хамаагүй. Тэр нь машин тэрэг эвдэрвэл ингэлээ тэглээ гэж ярьж өгдөг.


Жолооч нартай хийсэн ярилцлагаас



Дүрслэл 33. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлнэ үү?
(5-1 хүртэл ач холбогдлоор нь үнэлнэ үү)


Урт дараалал, түгжрэл

Нүүрс тээврийн жолооч нараас авсан асуулга судалгаагаар хамгийн ихээр тулгамдаж байгаа 3 хүртэлх асуудлыг нэрлэхийг хүссэн бөгөөд түүний үр дүнг доорх дүрслэлд харуулаа.



Дүрслэл 34. Нүүрс тээврийн жолооч нарын хувьд тулгамдаж буй гол асуудлууд (Асуулгын судалгааны нэгтгэсэн дүн, 2018 оны 3 сар)

Жолооч нарын хувьд асар их цаг хугацааг урт дараалалд хүлээж өнгөрөөдөг. Уртын тээвэр нь уурхайн амнаас нүүрс ачаад Цагаан хадны гаалийн хяналтын бүсэд нүүрсээ буулгаад эргээд уурхайн ам руу явахад үүсдэг дараалалд дийлэнх хугацааг зарцуулдаг байна. Богинын тээвэрт Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс нүүрс ачих, түүнийг Гашуунсухайт, Ганц модны боомтоор нэвтрүүлж, БНХАУ-ын нутаг дэвсгэрт нүүрсээ буулгах зэрэгт тус бүр дараалалд орох, бичиг баримт бүрдүүлэх, машины үзлэг оношлогоо, хилээр буцаж орж ирэхэд мөн нилээдгүй хугацаа зарцуулдаг. 2018 оны 3 дугаар сард үнэлгээний багийн хийсэн асуулга судалгаагаар богино ба уртын маршрутаар тээвэр хийхэд дунджаар хэд хоног зарцуулж буйг асуухад дараах дүн гаржээ.



Дүрслэл 35. Урт, богинын маршрутаар нүүрс тээвэр хийхэд зарцуулж буй дундаж хугацаа (Асуулгын судалгааны нэгтгэсэн дүн, 2018 оны 3 дугаар сар)

20-10 гаруй км үргэлжилсэн урт дараалал болон уурхай ам, гаалийн хяналтын бүсэд нүүрс ачих, буулгах үеийн дараалал, түгжрэл нь жолооч нарын эрүүл мэнд, сэтгэл санаа, санхүүгийн байдалд олон талын сөрөг нөлөөлөл учруулдаг. Үүнд:

- Зам дагуу нийтийн бие засах газар ховор учраас машины кабиндаа шил саванд, гадаа ил задгай бие засах болдог. Эмэгтэй жолооч нарын хувьд энэ илүү хүндрэлтэй байдаг. Харин 2018 оны 5-6 дугаар сард Гашуунсухайт зам компани зам дагуу хэд хэдэн цэгт нийтийн энгийн бие засах газрууд байгуулжээ.

Энд чинь бид хагас нойртой, хагас хоолтой, за хувцсаа тайлж унтана гэж байхгүй. Дандаа л машиндаа унтацгаана. Урд талын тэрэг хөдлөөд явбал босож харайгаад тэргээ урагшлуулна. Үнэнийг хэлэхэд бараг л гайгүй дэглэмтэй шорон шиг л явж байна.

За эрчүүд ч яахав энд тэнд очоод бие засчихна. Эмэгтэй бид нар чинь бүтэн өдөржингөө шээсээ бариад орой болохыг хүлээгээд явж байдаг. Цагаан хадан дээр байгаа 00-уудаа бүгдээрэнг нь цоожилчихно. Ядаж нэг гоё нэгдсэн 00-той байгаасай л гэж бодох юм.

Эмэгтэй жолооч нартай хийсэн ярилцлагаас



Зураг 10. Цагаан хадны гаалийн хяналтын бүсэд үүссэн урт дараалал ба орчны бохирдол

- Зам дагуух 30 гаруй хоолны газрууд, дуудлага ба зөөврөөр хоол зардаг иргэдийн үйлчилгээнд холбогдох байгууллагууд эрүүл ахуйн хяналт тавьдаггүй учраас их эрсдэлтэй.


- Олон цагаар дараалалд зогсож чанарын шаардлага хангаж буй эсэх нь тодорхойгүй хоол хүнс хэрэглэснээр ходоод хямрах, өвдсөн хүн их байдаг.
- Ихэнх жолооч нар машины кабинд өөрсдөө хоол хийж иддэг. Үүнтэй холбоотой газ дэлбэрэх, битүү чанагч буудах, түлэгдэх, гэрэлтүүлэг муу орчинд гараа гэмтээх тохиолдлууд их гардаг.
- Олон цагаар дараалалд зогсох үеэр жолооч нар архи уух, маргалдаж зодолдох, гэмт хэрэгт өртөх эрсдэл нэмэгддэг. Цагдаагийн байгууллагын зүгээс хяналт тавьдаг боловч дараалал дундуур явж архи зардаг олон машинуудыг хянах боломжгүй байдаг байна. Боомтын ажлын цагийн хуваарийн дагуу Ням гарагт хил хаагддаг бөгөөд энэ өдөр жолооч нарын дунд архидалт ихэсдэг байна.

Хөгшин чинь урдуур нь орчих уу гэж найрсаг хэлэхийн оронд шууд дайрдаг. Үүнээс болж Цагаан хаданд настай жолооч бага залууг хөнөөсөн хэрэг байна.

Урдуур дайрч орох нь маш их. Чадалтай нь чадалгүйгээ, эсвэл бүлэглээд ч гэдэг юм уу, буугаад ирэхэд цохиод унагадаг, олуулаа явж байгаа бол бөөрөлхдөг.


Жолооч нартай хийсэн ярилцлагаас

- Урт дараалалд машины эд ангийг хулгайлах гэмт хэрэг их гардаг байна. Жолооч нар цагдаад мэдэгддэг боловч гэмт хэрэгтнийг илрүүлсэн тохиолдол тун бага байдаг. Гол төлөв жолооч нар машинаа түр орхих, шөнө амарч буй цагаар хулгайн гэмт хэрэг гардаг байна. Жолооч нарын өгүүлснээр БНХАУ-ын нутаг дэвсгэрт зам дагуух хяналтын камер олон тул машинаа зам дээр түр орхих зэрэгт хулгайд эд зүйлээ алдах асуудал гардаггүй байна.
- Жолооч нар машиндаа олон хоногоор хоноглож байгаа нь ууц нуруу, арьсны өвчнөөр өвчлөх, хууч өвчтэй хүмүүсийн өвчин сэдрэх тохиолдол гардаг байна. 60-аас дээш настай жолооч нар цөөнгүй байна. Түүнчлэн, цөөн тооны эмэгтэй жолооч нар ажиллаж байна. Жолооч нар усанд орох, гараа угаах зориулалтын орчин байхгүй учраас бохирдолтой холбоотой амьсгалын тогтолцооны, арьсны өвчин их байдаг гэж мэдээлж байна.
- Олон хоног дараалалд хүлээсний улмаас замын хөдөлгөөний дүрэм зөрчиж урсгал сөрөх, зориулалтын бус шороон замаар явж дараалал дайрах тохиолдол их гардаг. Энэ нь зам тээврийн осол, цагдаад торгуулах, саатуулагдах, жолооч нарын хооронд маргаан зөрчил үүсгэдэг байна.
- Цагаан хаданд ажиллаж байгаа цагдаагийн хөдөлгөөнт бүлэг Цагаан хад болон Ханбогд суманд эрүүлжүүлэх болон түр саатуулах байр байхгүйгээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн, согтуу этгээдийг өөрсдийн ажлын өрөө болон гэртээ харгалзах, улмаар сэжигтнийг аймгийн төв рүү 200 км тээвэрлэн хүргэдэг байна.
- Олон хоног дараалалд түгжирч зогсох, замын хөдөлгөөнтэй холбоотой уур бухимдал үүсэх, гэр бүлээсээ хол, олон хоногоор бохир орчинд ажилладаг зэрэг шалтгаанаар жолооч нарын дунд сэтгэл санааны хямрал, сэтгэл гутралд орох явдал их байдгийг өгүүлж байна. Үүнийг асуулга судалгааны дараах дүн нотолж байна.



Дүрслэл 36. Таны хувьд сэтгэлзүйн зөвлөгөө авах үйлчилгээ хэрэгцээтэй байдаг уу?

Асуулга судалгаагаар жолооч нараас доорх графикт харуулсан асуудлууд хэр их тохиолддог болохыг тандав. 1-5 хүртэлх оноогоор авч үзвэл эдгээр асуудлын ихэнх нь жолооч нарт нийтлэг тулгарч байна гэж дүгнэж болно. Ялангуяа жолооч нарын дунд архи уух, замын хөдөлгөөний дүрэм зөрчихтэй холбоотой маргалдаж зодолдох, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, дүрэм зөрчсөн болон техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэл жолоодсон гэдэг үндэслэлээр цагдаад торгуулах, саатуулагдах үед авлига өгөх тохиолдол их байдгийг харуулж байна. Жолооч нартай хийсэн ярилцлагын үеэр ч эдгээр асуудлыг олон жолооч нар онцлон хэлж байсан юм.




Дүрслэл 37. Нүүрс тээвэрлэлтийн явцад дараах асуудлууд гардаг эсэх

ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ

Зам тээврийн осолд өртөх магадлал өндөр байна. 2010-2012 онд хатуу хучилттай болон шороон замаар нүүрс тээвэрлэлт явагдаж байхад жилд 300 гаруй зам тээврийн осол гарч нийт 30 хүн нас барсан байдаг. 2016-2017 оны зам тээврийн осол гэмтлийн мэдээллийг харьцуулж үзэхэд жилд 1500 орчим зам тээврийн осол гарч, түүний улмаас 10 орчим хүн амь насаа алдаж, олон арван хүн бэртэж гэмтэж, мөн эд хөрөнгийн хохирол амсаж байна. Дунджаар тооцвол өдөрт 4-5, 1 сард 125 орчим осол гарч, сар бүр 1 хүний амь нас хохирч байна. Үнэлгээний багийнхан 2018 оны 3 дугаар сард Цогтцэций суманд ажиллахад он гарсаар 26 осол гарч, 4 хүн нас барж, 6 хүн гэмтсэн болохыг орон нутгийн цагдаагийн хэлтсээс мэдээлсэн. 2013-2014 онд нүүрс тээвэрлэлтийн хэмжээ багассан, замын осол, хэрэг зөрчил цөөрсөн гэж үзвэл 2010-2018 онд Гашуунсухайтын нүүрс тээврийн замд гарсан ослын улмаас наад зах нь 50 гаруй хүний амь нас үрэгдсэн байна.

Асуулга судалгаагаар жолооч нараас нүүрс тээврийн замд гарч буй ослын шалтгааныг 1-5 хүртэлх оноогоор үнэлэхийг хүсэхэд дараах дүн гарсан. Жолооч нарын үзэж буйгаар Гашуунсухайтын зам эвдрэл ихтэй байгаа нь ослын ноцтой шалтгаан болдог байна. Замын эвдрэл, нүх, бартаа саадыг тойрч гарах үед эсрэг урсгалын машинтай мөргөлдөх, ар талын машиныг чиргүүлээр гуядах, огцом хурдаа хассаны улмаас машин онхолдох зэрэг осол зонхилдог байна.



Дүрслэл 38. Зам тээврийн осол гарч буй шалтгаануудыг үнэлнэ үү

Жолооч нар замын хөдөлгөөний дүрэм зөрчдөг явдал осол гарахад ихээр нөлөөлдөг гэж үзсэн. Үүнд хурд хэтрүүлэх, дүрэм зөрчиж урсгал сөрөх, гүйцэж түрүүлэх, бүрэн бус техникээр хөдөлгөөнд оролцох зэрэг зөрчил зонхилдог байна. Ялангуяа, хүнд даацын машиныг жолоодохдоо хурд хэтрүүлснээс болж үүсэх эрсдлийг мэдэхгүй, тооцохгүйгээс осол их гардаг. Зөвхөн 4 шалган нэвтрүүлэх цэгээс бусад газар хяналтын камер байхгүй тул дүрмийн зөрчлийг сайтар хянах боломжгүй хэвээр байна.

Түүнчлэн, мэргэжлийн зэрэггүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтанд хамрагдаагүй, туршлагагүй жолооч нар их байдгаас осол их гардаг гэж үзэж байна. Үүнийг орон нутгийн цагдаагийн байгууллага ч мөн онцолж байв. Ялангуяа, УБ хотод жолооны ангиллыг хууль бусаар олгодог (ойролцоогоор 100-150 мянган төгрөг гэх мэдээлэл байна) нь жолооны эрхийн үнэмлэхгүй залуучуудаар машин бариулах, машинаа урагшлуулах асуудал гарсаар байна. Ийм шалтгаанаар зун их, дээд сургуулийн амралт эхлэхэд оюутнууд олноор ирдэг талаар жолооч нар болон цагдаа нар өгүүлж байсан.

Осол гарч буй шалтгаан бол залуучууд юм. Шууд мөнгөөр үнэмлэх авчихсан. 17-той хүүхэд бүх ангилал авчихсан явж байна. Надтай таарч л байсан.

Замын эвдрэл тойрох гээд шөнө мөргөлддөг. Эвдрэл их. Тусгаарлах зураас байхгүй.

Эвдрэлтэй газар гэдгийг мэддэг нь байна, мэддэггүй нь байна.


Архидалт бол байна. Хуучин оочергүй байхад архидалт бага байсан. Одоо оочерт байхдаа архи уудаг. Тэгээд оочер татах үед ажил хийж байгаа хүн юм чинь согтуугаар машинаа урагшлуулдаг. Энэ үедээ аваар осол, зөрчил гарах тохиолдол бий.

Зарим жолооч нар архи ууснаас болж урсгал сөрж орж ирдэг.

Зун оюутнууд хичээл тараад ирэхээр хэцүү. Аваар их гарна. Үнэмлэх бол 100, 150 цаас өгөөд гаргачихдаг, тэр тал дээр цагдаа сайн ажиллах ёстой.

Дүрмээ баримталдаггүй жолооч нарын асуудал хүндрэлтэй. Шөнө орой гэрлээ шилжүүлэхгүй байна. Урдаас ирж байхад нөгөө замын эвдрэлийг улаан цайм тойрч урдуур орчих гээд байдаг.

Жолооч болон цагдаагийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас



Дүрслэл 39. Нүүрс тээврийн жолоочоор ажилласан хугацаа (Асуулга судалгаа, 2018 оны 3 сар)

Тавантолгой нүүрс тээврийн замын дагуу эмнэлгийн болон онцгой байдлын салбар нэгж байхгүй бөгөөд осол гарсан тохиолдолд харъяаллын сум (Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо) эсвэл Тавантолгойд ажиллаж байгаа уурхайн эмнэлэг, аврах албаны тусламж ирэх хүртэл цаг алдах, ингэснээр амь нас алдах, нүүрс тээврийн хөдөлгөөнийг удаан хугацаагаар саатуулдаг.

Манай энэ зам чинь уурхайн амнаас боомт хүртэл 237 км байдаг. 100 км юм уу 150 км дээр осол аваар гарлаа гэж бодоход яах вэ? Жишээ нь 7 хоногийн өмнө айхтар осол гарсан. Явж байсан машины араас өөр нэг машин мөргөж чихэгдсэн. Жолоочийн 2 хөл нь тасарсан учраас маш их цус алдаад байхад юу ч үгүй шамбийсан машинаас хүнээ татаж авч чадахгүй байсан. Ингээд Оюу Толгой компаниас тусламж хүсэж, түүний дагуу компанийн аврах анги тасдагч хөрөөтэй, эмнэлгийн багтайгаа ирсэн. Нөгөө хүнийг Оюу Толгойн кэмп рүү авч яваад эмчилгээ хийсний дараа УБ хот руу онгоцоор нисгэсэн. Харамсалтай нь хотод очоод 2-3 хоног болоод гэмтлээ даалгүй өнгөрчихсөн.

Цагаан хадны Гаалийн хяналтын бүсийн цагдаагийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Энержи Ресурс компани нь тээврийн хэрэгслээ бүрэн хянаж, шаардлагатай үед эмнэлгийн болон техникийн тусламж үзүүлэх тогтолцоо, хүч хэрэгсэлтэй. Харин Эрдэнэс Тавантолгой болон Тавантолгойн уурхай зөвхөн өөрсдийн талбайд эмнэлгийн тусламж үзүүлэх журамтай. Тавантолгой-Гашуунсухайтын замд тээвэр хийж буй 7000-10000 жолооч нарт Цагаан хадны бүсэд хувиараа төлбөртэй үйлчилгээ үзүүлж буй хоёр эмчтэй, эмийн сан болон анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэх нэгж байхгүй байна.

Эрдэнэс Тавантолгой ХК болон Тавантолгой ХК нь зөвхөн нүүрс олборлолт, борлуулалтын ажилд анхаарч, нүүрс тээврийн ажилд оролцож буй жолооч нарын асуудлыг хариуцахаас зайлсхийж ирснээс нүүрс тээврийн ажилд оролцож буй жолооч нарын хөдөлмөр, амралтын горим алдагдаж, хууль, дүрэм, журам сахиулах боломжгүй нөхцөлд хүрээд байна. Ингэснээр Энержи Ресурс болон цөөн тооны аж ахуйн нэгжээс бусад нүүрс тээвэрлэлтийн байгууллагууд Монгол Улсын дараах хууль тогтоомжийг зөрчсөөр байна.

Зөрчигдөж буй хууль тогтоомж

Хөдөлмөрийн тухай хууль

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Эрүүл ахуйн тухай хууль

Нийгмийн даатгалын тухай хууль

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Хог хаягдлын тухай хууль

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

Жолоочийн даатгалын тухай хууль

Татварын ерөнхий хууль

Компанийн тухай хууль

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль

Журам

Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх журам (ЗТБХБЯ, 2009)

Автотээврийн хэрэгслийн техникийн үзлэг явуулах журам (ЗТЯ, 2013|10|21, <http://www.legalinfo.mn/annex/details/6116?lawid=9641>)

Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам (2012|59, <http://www.legalinfo.mn/annex/details/6010?lawid=9458>)

Автотээврийн хэрэгслээр мэргэшсэн жолооч бэлтгэх журам, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр (ЗТБХБЯ, БСШУЯ, 2010|161\229)

Ачаа тээвэрлэлтийн зөвшөөрөл (Авто тээврийн үндэсний төв) <https://www.transdep.mn/?subm/45.html>)

Хоолны газрын нийтлэг журам (ХХААХҮЯ, 2010|206 <http://www.legalinfo.mn/annex/details/5447?lawid=8195>)

Олон улсын гэрээ, хэлэлцээр

Монгол Улс, БНХАУ-ын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яам хоорондын протокол (<http://www.nartam.org/22.html>)

ЦАГААН ХАДНЫ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН АЖИЛЛАХ, АМЬДРАХ ОРЧНЫ АСУУДАЛ

2016-2017 онд Тавантолгойн бүлэг уурхайн нүүрсний экспорт нэмэгдэж Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн орчмын байгаль орчин, хөрс, агаарын чанар, хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх нөхцөл, орчмын бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл улам ихэссэн байна. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл уурхайн орчинтой ижил түвшинд болсон хэдий ч Цагаан хадны нүүрс дамжуулан буулгах газрууд буюу талбайд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, агаарын чанар, хөрс, усны бохирдлын хяналт шинжилгээ огт хийгдэлгүй, үйл ажиллагаа нь үргэлжилсээр байна.



Зураг 11. Цагаан хадны орчим дахь нүүрс тээвэрлэлтийн байдал

Түүнчлэн, энэ бүсэд төрөл бүрийн үйлчилгээ эрхлэх хүмүүсийн тоо нэмэгдэж, дэлгүүр, хоолны газар, ахуйн үйлчилгээний газрууд олширч, газар ашиглалт ихээхэн тэлсэн байна. 2018 оны 6 дугаар сарын байдлаар Цагаан хад орчимд ажиллаж, амьдарч буй иргэд ундны усны хэрэгцээгээ зөврөөр (1 литр усны үнэ 60 төгрөг) болон савласан цэвэр усаар хангаж байна.

Цагаан хадны бүсэд олон арван хоолны газар, дэлгүүр, ахуйн үйлчилгээний цэгүүд байна. Газрын болон бусад зөвшөөрөл огт авахгүйгээр дураараа газар ашиглаж, гэр, байшин барьдаг учраас тоо нь хэлбэлзэж байдаг. Багийн удирдлагын өгсөн мэдээллээр газрын зөвшөөрөлтэй 3 л газар байна.



Зураг 12. Цагаан хадны бүс дэх үйлчилгээний төв цэг



Зураг 13. Цагаан хадны үйлчилгээний төв цэгийн гол гудамжууд

Энэ бүс цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй хэвээр байна. Цагаан хадны бүсэд төлөвлөлт огт хийгдэлгүйгээр байшин, гэрүүд баригдсан, тус бүртээ зөөврийн цахилгаан үүсгүүр, зуух хэрэглэдэг учраас гал түймэр гарах эрсдэл ихтэй гэж үзэж байна.



Зураг 14. Цагаан хадны зарим үйлчилгээний газрууд

2017 онд Засгийн газраас 100 гаруй км үргэлжилсэн дарааллыг бууруулах талаар зохих арга хэмжээ авсан боловч үүний сөрөг тал болж, Цагаан хадны орчимд авто тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт хүн амын бөөгнөрөл ихэд нэмэгдсэн байна. Тавантолгойн уурхайгаас нүүрс ачиж ирээд Цагаан хадны нүүрс дамжуулах талбайд буулгах дараалал, тус талбайгаас нүүрс ачих дараалал, нүүрс ачсан машин Цагаан хаднаас Гашуун сухайт хүртэлх замд нийлэх түгжрэл, түүнээс цааш Гашуунсухайтын боомт хүртэлх 23 км зам тус бүрт дараалал үүссэн байна. Их хэмжээний тоосжилт бүхий орчинд үйлчилгээ эрхэлж буй иргэд, тэдний гэр бүл, хүүхдүүд, олон мянган жолооч нар олон өдрөөр хүлээх нөхцөл үүссэн байна.


Энд бол ямар ч компани усалгаа хийчихгүй байна. Тэр хашаан дээр оочерлож байхад шагайгаар татсан түйрэм дотор байна. Тийм юман дунд л хоол ундаа хийж идэж байна. Хийж идэхгүй ч яахав, өлсөж үхэлтэй биш.

Тэгээд энд Цагаан хадан дээр хүмүүс гацчихсан, ингээд олон хоног гацахаараа хүмүүс архи уудаг.

Би нэг жил болоход уушги өвддөг, энд хүн эмчлэх газар байхгүй, энд эмч бол байхдаа байхгүй, ядаж компаниас нэг эмч гаргадаг бол.

Жолооч нартай хийсэн ярилцлагаас

Зураг 15. Цагаан хад ба БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх Ганцмодны нүүрс ачих, буулгах талбайн зохион байгуулалтын ялгаа




Цагаан хадны нүүрс ачих, буулгах талбай руу орох, гарах хэсэг дэх дараалал



Ганц модны нүүрс ачилт, буулгах талбай

Цагаан хадны гаалийн хяналтын бүс нь Ханбогд сумын Хайрхан багийн нутагт байрладаг. Статистикийн үндэсний хорооны мэдээллээр тус багийн бүртгэлтэй хүн ам 2014 онд 177 байсан бол 2017 онд 352 болж өссөн байна. Бүртгэлтэй хүн амын дотор 0-14 насны хүүхэд 75 байна. Багийн хэмжээнд малчин өрх бүртгэгдээгүй байна.⁷⁵

⁷⁵ УСХ. 1212.mn Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.



Дүрслэл 40. Ханбогд сумын Хайрхан багийн бүртгэлтэй хүн ам

Мөн энэ бүс нь хөрсний эвдрэл элэгдэл ихтэй, хотгор газар учраас бороо хур ихээр ороход үерт автах өндөр эрсдэлтэй. 2018 оны 7-8 дугаар сард үерт автсан. Хөрсний бохирдол, ил задгай хог хаягдал маш их, нийтийн бие засах газаргүй энэ орчинд олон хоног үргэлжилсэн үер болсон. Холбогдох газраас ариутгал хийсэн боловч энэ байдал дахин давтагдах магадлал өндөр, түүнээс улбаалан халдварт өвчин дэгдэх, олон хүн эрүүл мэндээрээ хохирох эрсдэл их байна.



Зураг 16. Цагаан хадны бүс дэх ил задгай хог хаягдал

2017 оны 2 дугаар сард Цагаан хадны бүсэд цагдаагийн байнгын хяналт бий болгох зорилгоор 30 албан хаагчтай цагдаагийн тасаг байгуулагдсан. Одоогийн байдлаар замын цагдаагийн болон хэв журмын байцаагчид, эрүүгийн төлөөлөгч зэрэг 24 албан хаагчтай ажиллаж байна. Цагдаагийн тасаг нь 2018 оны 3 дугаар сарын байдлаар өөрийн байргүй, "Алтан говь" нүүрс ачиж, буулгах талбай ажиллуулдаг аж ахуйн нэгжийн байранд байрлаж байна. Эрдэнэс Тавантолгой компанийн санхүүжилтээр 4 машин авсныг ашиглаж байна. Замын хөдөлгөөний хяналт болон Цагаан хадны гаалийн бүсийн хэв журмыг сахиулахад цагдаагийн тасгийн хүний нөөц, санхүүжилт, техник хэрэгсэл хүрэлцдэггүй байна.

Цагаан хадны бүсэд эмч ажилладаггүй. Эмийн сан ажилладаг ч зөвшөөрөлтэй эсэх, холбогдох хяналт шалгалт хийгддэг эсэх нь тодорхой бус байна. Хайрхан багийн төвд эмч ажиллуулах, ажлын байр, амьдрах газар зэргийг багтаасан төсөв батлагдсан боловч энэ орон тоон дээр 2018 оны 3 дугаар сарын байдлаар хүн ажилд ороогүй байна. Хувиараа эрүүл мэндийн үзлэг хийж, үйлчилгээ үзүүлдэг нэг эмч байдаг. Ихэнх тохиолдолд гэнэтийн өвчлөл зэрэг асуудал гарвал Ханбогд сумын түргэн ирэх хүртэл уг эмчээс анхны тусламж авдаг байна.

Цагаан хадны бүсэд ажиллаж, амьдарч буй иргэдийн хүүхдүүд хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой үр дагавар бүхий орчны бохирдолтой, замын хөдөлгөөний аюул дунд байна. Сургуулийн насны хүүхдүүд зун сургууль амрахад эцэг, эх дээрээ Цагаан хадны бүсэд ирдэг байна.



Зураг 17. Цагаан хадны бүсэд амьдарч буй хүүхдүүд

ХӨНДӨГДӨЖ БУЙ ЭРХҮҮД, НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЛИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Анхаарах шаардлагатай нөлөөлөгч хүчин зүйлс, үйл ажиллагаа, эрсдлийн талаарх дүгнэлт

Хөндөгдөж буй эрх: Амьд явах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	3-р зүйл	6-р зүйл		16.1-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Амьд явах эрх нь хүний амь насыг аливаа дур зоргын халдлагаас хамгаалах, амь насыг аврах зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн эрх болно. Хүний амьд явах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас иргэнээ хамгаалах төрийн үүрэг болно.				

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Дунджаар тооцвол өдөрт 4-5, 1 сард 125 орчим осол гарч, сар бүр 1 хүний амь нас хохирч байна. 2013-2014 онд нүүрс тээвэрлэлтийн хэмжээ багассан, замын осол, хэрэг зөрчил цөөрсөн гэж тооцвол 2010-2018 онд Гашуунсухайтын нүүрс тээврийн замд гарсан ослын улмаас наад зах нь 50 гаруй хүний амь үрэгдсэн байна. Замын эвдрэл, туршлагагүй, хууль бусаар жолооны эрх авсан жолооч нар олон, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоход тавих хяналт хангалтгүй зэрэг шалтгаанаар осол их гарч байна.

Хөндөгдөж буй эрх: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
				16.2-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг хэлнэ. Орчны бохирдол гэдэгт агаарын, усны, хөрсний гэх мэт органик бохирдлоос гадна дуу чимээний, хог хаягдлын, гэрлийн гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй органик бус бохирдлыг хамааруулдаг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Олон арван километр үргэлжилсэн урт дараалал болон уурхайн ам, гаалийн хяналтын бүсэд нүүрс ачих, буулгах үеийн дараалал, түгжрэл нь жолооч нарын эрүүл мэнд, сэтгэл санаа, санхүүд олон талын сөрөг нөлөөлөл учруулж байна. Асар их тоосжилт бүхий орчинд олон өдрөөр хүлээх нөхцөл үүссэн байна.

Цагаан хад бүс цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй хэвээр байна. Цагаан хадны бүсэд төлөвлөлт огт хийгдэлгүйгээр байшин, гэрүүд баригдсан, тус бүртээ зөөврийн цахилгаан үүсгүүр, зуух хэрэглэдэг учраас гал түймэр гарах эрсдэл ихтэй байна. Мөн энэ бүс нь хөрсний эвдрэл элэгдэл ихтэй, хотгор газар учраас бороо хур ихсэхэд үерт автах өндөр эрсдэлтэй.

Цагаан хадны бүсэд ажиллаж, амьдарч буй иргэдийн хүүхдүүд эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг үр дагавар бүхий орчны бохирдолтой, замын хөдөлгөөний ихээхэн эрсдэл, аюул дунд байна.

Хөндөгдөж буй эрх: Эрүүл мэндээ хамгаалуулах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	25-р зүйл			16.2, 16.6-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Хүн бүр эрүүл мэндийн зохистой үйлчилгээг цаг хугацаанд нь авах, төрөл бүрийн эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, үйлчилгээний нөхцлөөр хангагдсан байх, эрүүл байх боловсрол мэдээлэл авах боломж, эрүүл мэндтэй холбоотой шийдвэрт оролцох эрхтэй.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Нийт жолооч нарын 90 хувь нь (Энержи Ресурс компаниас бусад) эрүүл мэндийн үйлчилгээ (анхан шатны тусламж, оношлогоо, эмчилгээ)-нд хамрагдах боломжгүй байна. Тавантолгой нүүрс тээврийн замын дагуу эмнэлгийн болон онцгой байдлын салбар нэгж байхгүй. Цагаан хадны гаалийн хяналтын бүсэд эмч байхгүй, Эмийн сан ажилладаг ч зөвшөөрөлтэй эсэх, холбогдох хяналт шалгалт хийгддэг эсэх нь тодорхой бус байна.

Хөндөгдөж буй эрх: Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх**Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 сарын 28-ны 64/292-р тогтоол

Тухайн эрхийн товч тайлбар

Хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Жолооч нар болон Цагаан хадны оршин суугчид ундны болон ахуйн хэрэглээний усны гачигдалтай орчинд ажиллаж, амьдардаг. Зам дагуу нийтийн бие засах газар ховор учраас машины кабиндаа шил саванд, гадаа ил задгай бие засах болдог. Эмэгтэй жолооч нарын хувьд энэ илүү хүндрэлтэй байдаг.

Хөндөгдөж буй эрх: Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх**Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт**

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт

Монгол улсын үндсэн хууль

23-р зүйл

6-р зүйл

16.4-р зүйл

7-р зүйл

зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Хөдөлмөрийн шударга, таатай нөхцлийг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа буюу ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ажилтнуудын бие махбодь, оюун санааны халдашгүй байдал, өөрийн болон гэр бүлийн амьжиргааг тэтгэж хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлс авах гэсэн үндсэн хүрээнд авч үзсэн байдаг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Жолооч нарын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой бүх төрлийн даатгалыг бүрэн хариуцдаг, жолооч бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, холбогдох хөдөлмөр, эрүүл ахуйн хууль, тогтоомж, дүрэм, журмыг баримталдаг аж ахуйн нэгж маш цөөн байна.

Жолооч нар Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу олгогдсон эрх (долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл байна, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна, илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл, илүү цагийн хөлс авах, хүнд нөхцөлд ажилласны нэмэгдэл авах г.м.)-ээ эдлэх боломжгүй байна.

Хөндөгдөж буй эрх: Халдашгүй дархан байх эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	3-р зүйл	9-р зүйл		16.13-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулахгүй байх нь халдашгүй байх эрхийн үндсэн агуулга юм. Халдашгүй байх эрхийн хүрээнд эрх чөлөөтэй байх, бие махбодийн, орон байрны, нууцын, нэр төрийн, өмчийн болон захидал харилцааны халдашгүй байх эрхийг хамааруулж ойлгоно.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
БНХАУ-ын нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэн хөдөлмөр, эд хөрөнгийн маргааны улмаас зодуулах, хууль бусаар хоригдох, шийтгүүлэх тохиолдол гарч байна. БНХАУ-ын харъяат иргэд, аж ахуйн нэгжтэй хөдөлмөрийн маргаанаа шийдвэрлүүлэх механизм байхгүй байна. Хятадын талд хэрэг, зөрчилд өртсөн жолооч нарын эрхийг хамгаалах механизм байхгүй.				

Хөндөгдөж буй эрх: Нийгмийн хамгаалал хүртэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	22-р зүйл		9-р зүйл	22-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Аливаа хүн өвчлөх, эцэг эх болох, осол гэмтэлд орох, ажилгүйдэл, хөгжлийн бэрхшээл, өндөр насалсан болон нас баралтаас шалтгаалсан орлогын хомсдол, орлогогүй болохоос үүдэлтэй нийгмийн хамгааллын болон эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, мөнгөн тэтгэлэг хүртэх зэрэг эрхийг ерөнхийлэн “Нийгмийн баталгаа” гэж нэрлэдэг.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
Жолооч нарын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой бүх төрлийн даатгалыг бүрэн хариуцдаг, жолооч бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, холбогдох хөдөлмөр, эрүүл ахуйн хууль, тогтоомж, дүрэм, журмыг баримталдаг аж ахуйн нэгж маш цөөн байна.				

Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, эрэмбэ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I	Амьд явах эрх	3	1	3	3
	Хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах эрх	2	3	2	3
	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	2	3	2	3
	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	2	3	3	3
II	Халдашгүй дархан байх эрх	2	1	2	2
III	Нийгмийн хангамж эдлэх, нийгмийн даатгалд хамрагдах эрх	2	2	1	2
	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	1	3	2	2

Дараах шалгууруудын дагуу 1-3 хүртэлх эрэмбээр үнэлсэн.

- Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)
- Х - Нөлөөлийн хамрах хүрээ (1-3)
- С - Эрхийг сэргээх боломж (1-3)
- М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

ЗӨВЛӨМЖ

Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй жолооч нарын эрүүл, аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлэхэд төрийн болон орон нутгийн удирдах байгууллага, уул уурхайн компани, нүүрс худалдан авагч компани, тээврийн аж ахуйн нэгж болон хувь жолооч нарын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа маш чухал юм.

Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн нөхцөл байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

- Засгийн газар ажлын хэсэг байгуулж, Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн асуудлыг цогцоор шийдвэрлэх богино, дунд, урт хугацааны стратеги, төлөвлөгөөг боловсруулж, эл төлөвлөгөөг хэрэгжүүлэх олон талт механизмийг бүрдүүлэх, Эрдэнэс Таван Толгой компани энэхүү ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлэх
- Ажлын хэсэг нь Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, урт хугацаа (15-20 жил), дунд хугацаа (8-10 болон 3-5) болон богино хугацаа (1 жил)⁷⁶-ны хөгжлийн бодлогыг боловсруулах, дээрх бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг салбар, яам, агентлаг тус бүрийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулах
- АТҮТ зөвхөн зөвшөөрөлтэй кэмптэй, хөдөлмөр, эрүүл ахуйн болон тээврийн хуулийн стандарт шаардлагыг хангасан тээврийн аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох

Нүүрс тээвэрлэлтийн замын аюулгүй байдлыг сайжруулах

- "Гашуунсухайт" авто зам компани нүүрс тээвэрлэлтийн замын арчилгаа, зам засварын ажлын хурд, хяналт, аюулгүй байдлыг сайжруулах
- "Гашуунсухайт" авто зам компани дэргэдээ зам засвар, арчлалтын нэгж байгуулах, шаардлагатай засвар арчлалтыг шуурхай зохион байгуулах
- "Гашуун сухайт" авто зам, Замын цагдаагийн хэсгээс явуулж буй аюулгүй байдлын сургалтыг тогтмолжуулж, жолооч нар давхар эмнэлгийн үзлэг (нийгмийн халдварт өвчин)-т ордог байх журам гаргах, энэ үзлэгийн төлбөрийг холбогдох тээврийн ба уул уурхайн компаниас гаргах
- "Гашуун сухайтын боомтод замын цагдаагийн болон авто тээврийн байцаагч нарыг ажиллуулж, БНХАУ-ын талаас нэвтэрч байгаа техник хэрэгсэлд үзлэг хийж, шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй буцаах тогтолцоог бий болгох
- "Гашуунсухайт" авто зам компани ЦЕГ, ЗЦГ, АТҮТ-тэй хамтран замын хөдөлгөөний дүрэм сахиулах, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгах,

⁷⁶ Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (6 дугаар зүйл)

замын гэмтэл, осол болон хөдөлгөөнд нөлөөлж болох байгаль цаг уурын хүчин зүйлсийн талаар мэдээлэх тогтолцоо бий болгох

- “Гашуунсухайт” авто зам компани ЦЕГ, ЗЦГ, АТҮТ-тэй хамтран дүрэм зөрчсөн, согтууруулах ундаа хэрэглэсэн, мэргэжлийн үнэмлэхгүй хүнд жолоо шилжүүлсэн, дараалал дайрсан, замгүй газраар явсан тухай мэдээлэл авдаг байнгын утас, хаяг бий болгож, мэдээллийн дагуу зөрчил гаргасан жолооч, түүний хамаарах тээвэрлэгч аж ахуйн нэгжид торгуулийг ноогдуулдаг, олон нийтэд зарлах
- Гашуунсухайт авто зам ХК, АТҮТ, тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд хамтран нүүрс тээвэрлэлтийн бүх техник хэрэгсэлд GPS суулгаж дараалал дайрах, замгүй газраар давхих, хөдөлгөөний хурд хэтрүүлэх явдлыг хянах, зөрчил гаргасан этгээд болон түүний хамаарах тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцох
- Улсын хилээр гарсан жолооч нар тухайн тээврийн хэрэгсэлтэй буцаж хил нэвтэрдэг байх тогтолцоонд шилжиж хилээр нэвтэрч буй авто машин болон жолооч нар бүртгэлтэй болж, жолоо шилжүүлэх асуудлыг багасгах

Нүүрс тээвэрлэлтийн жолооч нарын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах

- Эрдэнэс Таван Толгой ХК ба Тавантолгой ХК нь нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй “тээвэрлэлтийн гэрээ” байгуулах ажлыг хэвшүүлэх, холбогдох стандарт, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, таниулах, мөрдүүлэх ажлын гүйцэтгэх нэгжийг шинээр зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, техник хэрэгслээр хангах
- Тавантолгойн 3 уурхайн компаниуд хөдөлмөр, эрүүл мэнд болон тээвэрлэлтийн хууль, дүрэм, журмыг зөрчсөн аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулахгүй, байгуулсан гэрээг цуцлах байдлаар ажиллах,
- ЭМЯ болон Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар нүүрс тээвэрлэлтэд оролцож буй иргэд болон бусад хөдөлгөөнт хүн амын дунд нийгмийн халдварт өвчин тархахаас сэргийлэх үзлэг оношилгоо хийх, шаардлагатай үед эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах
- Гашуунсухайтын нүүрс тээврийн замын дагуу нийгмийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөний дүрэм мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх
- Гашуунсухайтын нүүрс тээврийн жолооч нарт яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх нэгжийг Цогтцэций сумын эмнэлгийн харъя байгуулж, шаардлагатай нөөц, төсөв хөрөнгийг батлах
- Тээвэрчдийг баталгаат хоол хүнс, тав тухтай, эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амрах нөхцлийг бүрдүүлэх зорилготой Амралт, авто зогсоолын цогцолборыг Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр дэх улсын хилийн зурваст барих тухай МУ-ын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх

- Цогтцэций сумын нутагт байгаа 4 болон 6 дугаар гармын орчимд байрласан аж ахуйн нэгж, үйлчилгээний газар, хувь иргэдийг эмх журам, зохион байгуулалтад оруулах, тээвэр, ложистикийн төвийг байгуулах
- Тээвэрчдийг хоршоолол, нийгэмлэгийн зохион байгуулалтад оруулах, байгаль орчныг бохирдуулахгүй, нийгмийн хэв журам зөрчихгүй байгаа үлгэр жишээч байдлыг сурталчилж, дэмжих
- Мэргэжлийн сэтгэлзүйч ажиллуулах, жолооч нартай холбоотой судалгаа, тандалтыг хийх, тэдний эрх ашгийг хамгаалж буй байгууллага, хувь иргэдтэй хамтран ажиллах
- Цагаанхадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг зогсоох
- Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах наад захын нөхцлийг хангах хүртэл Цагаанхадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг зогсоох
- Дээр дурдсан Засгийн газрын ажлын хэсэг Цагаанхадны гаалийн хяналтын бүсийн талаарх төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, богино, дунд, урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- Цагаанхадны гаалийн хяналтын бүс дэх компани, аж ахуйн нэгжүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хуулийн дагуу хийх, холбогдох менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Хөдөлмөр, эрүүл ахуйн стандартыг мөрдөөгүй, мөрдөхөөс татгалзсан тээврийн байгууллагууд, нийтийн хоолны газар, засвар үйлчилгээний газрын үйл ажиллагааг зогсоох, Зөрчлийн болон холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах

ОРОН НУТГИЙН МАЛЧДЫН ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Тавантолгойн бүлэг уурхайн ойр орчимд болон Гашуунсухайтын зам дагуу нутаглаж буй малчин өрхүүдтэй уулзаж ярилцан, орчны ажиглалт хийсний үндсэн дээр дараах 5 гол асуудал нэн тэргүүнд тулгамдаж байгааг тодорхойллоо.

ТООСЖИЛТ

Уурхайн үйл ажиллагаа болон замын хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтоос малчдад үзүүлж нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн талаар өнөөг хүртэл хөндлөнгийн байгууллагын хэд хэдэн үнэлгээ, судалгаа хийгдэж, зөвлөмж гаргасан байдаг. 2012 онд ХЭҮК-ын судалгааны тайланд дараах дүгнэлт, зөвлөмж тусгагдсан байна. Үүнд:

- Уул уурхайн компаниуд бүгд тоос тоосжилт бий болгоход нөлөөлж байгаа атлаа бие бие рүүгээ түлхэх хандлага ажиглагдаж байна. Төрийн холбогдох байгууллага хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлж ажиллах,
- Цогтцэций, Ханбогд сумын төв болон агаарын бохирдол, тоос тоосжилт ихтэй газар агаарын чанарын үнэлгээ хийх багаж төхөөрөмжийг суурилуулах, үүнтэй холбоотой тандалт судалгааг байнга хийх,

- Уул уурхайн нөлөөлөл малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгааг судалгаанд оролцогчид дурдсан тул мал эмнэлгийн үйлчилгээг идэвхжүүлэх, уушги дэлүү, дотор эрхтэн нь гэмтсэн, өвчилсөн малыг мэргэжлийн байгууллагаар оношлуулах, судлуулах арга хэмжээг зохион байгуулах⁷⁷

2015 онд Австрали, Монгол судлаачдын хамтарсан багийнхны хийсэн судалгааны тайланд тоосжилтоос малчдын амьдралд учирч буй эрсдлийг онцлон үзэж дараах гол дүгнэлт зөвлөмжийг тусгасан байна.

*“Ихэнх цагаа гадаа өнгөрөөдөг, газар дэлхийдээ ойр амьдардаг хүмүүсийн хувьд тоосны бохирдол нь амьдралын чанарт нь нөлөөлөх ноцтой асуудал болдог. Уул уурхайн үйл ажиллагааны явцад агаарын чанар болон тоосжилтоос үүдэлтэй хүн, малын эрүүл мэнд, бэлчээрийн чанар, малчин айл өрхүүдийн гэр, малын хот хороон дахь бохирдол зэрэг нөлөөнд тогтмол, ил тод байдлаар мониторинг хийж, тоосжилтын нөлөөнд эмзэг байгаа оршин суугчдыг дэмжиж байх шаардлагатай”.*⁷⁸

Харамсалтай нь дээрх дүгнэлт, зөвлөмжийн дагуу холбогдох төрийн байгууллага, орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниудын зүгээс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Өнөөгийн байдлаар Тавантолгойн бүлэг уурхайн орчмын тоосжилт малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаад уулзаж ярилцсан бүх малчид төдийгүй энгийн иргэд ч санаа зовниж байна. 2012 онд хийгдсэн судалгаагаар тодорхойлсон тоосжилтын улмаас малын уушги, дотор эрхтэн, нүд өвчилсөн, өнгө нь өөрчлөгдсөн тухай асуудал өнөөдөр ч олон удаа дурдагдаж байна. Энэ талаар мэргэжлийн байгууллагаас судалж, нөлөөллийг тогтоох ажил өнөө хир хийгдээгүй л байна. Тоосжилт зөвхөн уушги, дотор эрхтэнд биш малын урагт нөлөөлж байна гэдэг зовнил малчдын дунд байна.

Тоосжилтын нөлөөлөл зөвхөн уурхай, замын ойр орчимд биш тэдгээрээс 10-20 км-т нутаглаж байгаа малчин айлуудын малын эрүүл мэндэд нөлөөлж байгаа гэдгийг малчид өөрсдийн жишээгээр тайлбарлаж, санаа зовниж байна. Өмнөх хэсэгт дурдсанчлан Говийн бүст үүссэн тоосонцор 10-20 км-ээс хэдэн зуун км-т салхинд туугдан тархах боломжтой гэдэг судалгааны дүнгээс үзэхэд уурхай, зам, тэдгээрийн орчин дахь тоосжилт, мөн хөрсний элэгдэл эвдрэлээс суларсан тоос, тоосонцор орон нутгийн малчдын гомдол бүрэн үндэслэлтэйг харуулж байна.⁷⁹ Гэвч мэргэжлийн байгууллагаас тоосжилтыг олон цэгт, тогтмол, ил тод байдлаар мониторинг хийж, тоосжилтын тархалт, тоосонцорын агууламж, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөлөл зэргийг тодорхойлохгүйгээр малчдын гомдлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байна. Үүнд уул уурхайн компаниуд, төр, орон нутгийн байгууллагуудын нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа чухал юм. Нэг аймагт, зэргэлдээ суманд үйл ажиллагаа явуулж буй Оюу Толгой компанийн тоосжилтыг бууруулах, мониторинг хийх хөтөлбөрийн жишээ, туршлагаас ч суралцах, нэвтрүүлэх боломж байна.

Малчдын хувьд ихэнх цагаа мал маллаж гадаа өнгөрөөдөг учраас тоосжилтын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл их байх магадлал өндөр. Малчдын хувьд амьжиргааны үндсэн эх үүсвэр болох малынхаа эрүүл мэнд,

⁷⁷ Тогтвортой эрдэс баялгийн хүрээлэн. Хариуцлагатай уул уурхай Монголд: Хамтын зүтгэл. 2016 он

⁷⁸ Мөн тэнд.

⁷⁹ Troy Sternberg and Mona Edwards. Desert Dust and Health: A Central Asian Review and Steppe Case Study. Int. J. Environ. Res. Public Health 2017, 14, 1342

үнэ цэнийг илүү анхаарч, санаа нь зовниж байна. Доорх хэсэгт тоосжилтын улмаас малчдын амьдралд тулгарч буй гол асуудлууд, зарим онцлох жишээг танилцуулав.

Тоосжилттой холбоотой тулгамдаж буй нийтлэг асуудлууд	Зарим онцлох жишээ
<p><u>Малын өвчлөл</u></p> <ul style="list-style-type: none"> Малын уушги, дотор эрхтэн, нүдний өвчлөл гарч байна. <p><u>Санхүүгийн хохирол</u></p> <ul style="list-style-type: none"> Малын ноос, ноолуур, мах зэрэг түүхий эдийн үнэ буурсан. Хоол хүнсэнд нэмэлт зардал үүсч байна. <p><u>Сэтгэл санааны дарамт</u></p> <ul style="list-style-type: none"> Малын эрүүл мэндэд маш их санаа зовж стресс үүсдэг. 	<p>“Манай нэг ямаа, нэг хонь уушги нь усжаад хэвлийгээр нь цул ус болсон байсан”</p> <p>“Тоостой бударгана идэхээр баас нь тас хар юм гардаг. Чийг өгөөд 2-3 хоног гайгүй, тэгээд л буцаад хэвээрээ. Малын уушги эрээн болдог. Уушги нь цоохорлочихсон байдаг”</p> <p>“Энэ жилийн гарч байгаа төл нус нь гоожоод, цээж нь хэржигнэсэн юм гардаг. Хүнээр бол хатгаа авчихсан юм шиг л юм байдаг”</p> <p>“Би ноднин ноолуур өгч байхдаа яг нүдээрээ үзсэн. Бид нар өөрснөө харахад зүгээр сайхан л ноолуур. Гэтэл манай эндхийн ноолуурыг цохиход доод талын цаасан дээр тоос шороо унаж байна лээ. Харин энэ хойд талын чигийн ноолуурыг 2 цохиход юу ч гарахгүй байсан. Үнэхээр түйрэн байгаа нь үнэн л юм байна лээ. Авахгүй гээд байгаа тэр улсуудын буруу биш л юм байна лээ. Би анх уурлаж л байсан, гэтэл үнэхээр тоос шороотой юм байна лээ”</p> <p>“Заримдаа малын гэдэс дотор хүн идэхийн аргагүй хар юм байна”</p> <p>“Хүмүүс манай энэ хавиас мал авахдаа дуртай биш шүү дээ”</p> <p>“Мал уушгиар их өвдөх маягтай байна. Би энэ бужигнасан их нүүрс, түйрэнгийн нөлөө болов уу гэж боддог. Уг нь манайх чинь одоо 20 хэдэн км-т байгаа айл шүү дээ. Тийм байхад түйрэн гээч ирж байна уу гээд би бодоод байдаг. Одоо яадаг юм байгаа юм ёстой мэдэхгүй.</p> <p>“Малын нүд өвдөнө. Бас л энэ тоос түйрэнтэй л холбоотой байх”</p>

УСНЫ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумын малчидтай хийсэн ярилцлага, орчны ажиглалт, орон нутгийн усны асуудлаарх хэлэлцүүлэг,⁸⁰ статистик мэдээллийн дүн шинжилгээ, өмнөх судалгааны дүнд үндэслэн усны чанар, хүртээмжтэй холбоотой дараах үндсэн асуудлууд тулгамдаж байгааг тодорхойллоо.

Мэдээлэл, иргэдийн оролцоо хомс

Тавантолгойн нүүрсний бүлэг уурхайн ус ашиглалтаас газрын доорх ба гадаргын усны нөөцөд үзүүлж буй нөлөөллийн талаар нутгийн малчид санаа зовниж байна. Бүлэг уурхайнуудын өнөөгийн ба ирээдүйн ус ашиглалтын хэмжээ, зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээлэл хомс байна.

⁸⁰ 2018 оны 6 сард Өмнөговь аймгийн ИТХ-аас Үйлдвэрлэл, уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаа усны хэрэглээ, түүнд тавих хяналт сэдвээр Цогтцэций, Ханбогд сумдад хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт хамгийн их ус ашиглаж буй нь Энержи Ресурс компанийн Нүүрс угаах үйлдвэрийн газрын доорх ус ашиглалт, түүнээс орчмын усны хүртээмжид үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл дутмаг байна. Тус компани 2011 оноос “Оролцоонд суурилсан усны хяналт шинжилгээний хөтөлбөр” хэрэгжүүлж уурхайн орчмын малчдын худаг, Цогтцэций сумын төв, нүүрсний зам дагуу иргэдийн оролцоотой хэмжилт хийдэг болсон байна. Өнөөгийн байдлаар тус компани орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 1 сард 1 удаа хэд хэдэн цэгт усны хэмжилт хийж, үр дүнг орон нутгийн удирдлагад танилцуулдаг боловч малчдын хувьд энэ талаарх мэдээлэл багатай байна. Түүнчлэн, уул уурхайн компаниудад үл итгэх хандлага түгээмэл байдаг нийтлэг хандлагаар усны хэмжилт, мониторингийн мэдээлэлд ч үл итгэх байдал ажиглагдаж байна.⁸¹

Нөгөөтэйгүүр, Нүүрс угаах үйлдвэрийн ус ашиглалтын хэмжээ, газрын доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл зэрэг чухал шаардлагатай мэдээллийг мэргэжлийн бус, энгийн иргэдэд ойлгомжтой үг хэллэг, үзүүлэлт, хэмжигдэхүүнээр тайлбарлаж танилцуулсан мэдээлэл дутагдалтай байна. Жишээ нь орон нутагт болсон хэлэлцүүлгийн үеэр уул уурхайн компаниудын танилцуулга доторх л/сек, сая м³ зэргийг литрээр, тонн-д шилжүүлж тайлбарлах, нэгдсэн ойлголт эхэлж бий болгох талаар орон нутгийн иргэд хэлж байсан.

Эрдэнэс Тавантолгой компани нөлөөллийн бүс дэх малчдын худгийн усны түвшин, усны чанарын хяналт шинжилгээ хийдэг боловч малчдын хэлснээр хэмжилт хийх тогтсон цаг байдаггүй, иргэдийн оролцоо байхгүй, иргэдэд эргэж мэдээлэл өгдөггүй байна.

Газрын доорх усны нөөцийг бага, гүний болон гүний уст давхаргын гэж ангилдаг. Бага гүний уст давхаргууд харьцангуй нимгэн, нарийн, газрын гадаргаас 10 м хүртэл, усны гүн нь 5 м-ээс бага байх нь элбэг, борооны усаар тэжээгддэг, усны чанар нь цэврээс давсархаг хүртэл байдаг. Их гүний уст давхаргууд нь томоохон хэмжээний тунамал хурдаст сав газарт 400 м хүртэл гүнд оршдог. Эдгээр гүний уст давхаргын дээр зузаан шаварлаг хагшаас байх тул тэжээгдэл муутай буюу үл нөхөгдөх чанартай бөгөөд ус нь давсархаг байдаг. Бага гүний уст давхаргууд унд, ахуйн хэрэглээ, МАА, тухайн орчны газрын доорх уснаас хамааралтай ургамал, ногооны ус чухал эх үүсвэр болдог.⁸² 2008 оноос хойш хийгдсэн хэд хэдэн судалгаагаар Тавантолгойн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа цаашид эрчимжсэн тохиолдолд 2030 оноос одоогийн тогтоосон газрын доорх их гүний усны нөөц хүрэлцэхгүй болох эрсдэл байгааг тооцоолсон байна.⁸³ Малчдын хувьд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Баруун, Зүүн цанхийн уурхай, холбогдох дэд бүтэц улам хөгжиж, үйл ажиллагаа нь өргөжихөд газрын доорх их гүний усны ашиглалтад үзүүлэх нөлөөлөл, ялангуяа Балгасын улаан нуурын усны нөөцөд ямар нөлөөлөл үзүүлэх талаар мэдээлэл хомс байна. Хэдийгээр мэдээлэл хомс байгаа боловч Балгасын улаан нуурыг ашиглах нь говийн усны нөөц, байгаль-экологийн тэнцвэрт нөхөшгүй сөрөг нөлөөтэй гэдэг байр суурьтай иргэд олон байна. Балгасын улаан нуурын бодит нөөцийг анх 444 /сек гэж тооцоолсон боловч 2008 онд

⁸¹ 2014 онд Өмнийн говийн бүсийн иргэдийн дунд хийсэн асуулгын судалгаагаар иргэдийн 11 хувь нь л уул уурхайн компаниудад итгэдэг гэсэн байна (ХБСХ, Өмнөд говийн усны талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тодорхойлох судалгаа. 2014).

⁸² Тогтвортой эрдэс баялгийн хүрээлэн. Хариуцлагатай уул уурхай Монголд: Хамтын зүтгэл. 2016 он


⁸³ Мөн тэнд.

КюЖиЭкс (QGХ) компанийн хийсэн үнэлгээгээр нөөц нь анхны тооцооллоос бага байх магадлалтай, усыг уурхайн, үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр олборлосноор усны түвшин доошлох болон бусад сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй гэдэг дүгнэлт хийж байсан. Засгийн газраас нөөцийн хэмжээг 404 л/сек гэж тогтоосон боловч нөөцийн тооцоолол маргаан дагуулсаар байна.⁸⁴ Ийм нөхцөл байдалд орон нутгийн иргэд, малчдад уурхай, үйлдвэрийн зориулалтаар ус ашиглах бодлого, тооцоолол, эрсдлийн талаар мэдээллийг хүртээмжтэй болгож, оролцоог сайжруулахгүйгээр үр дүнгүй гомдол санал, хардлага, маргаан үргэлжилсээр байж болохыг орон нутгийн хэлэлцүүлгүүдээс ажиглаж дүгнэв.

Малчдын худгийн хүрэлцээ муу

Говийн бүсийн малчдын хувьд худгийн хүрэлцээ тулгамдсан асуудал байж ирсэн. Тавантолгойн бүлэг ордын орчимд нутаглаж буй малчдын хувьд худгийн ус нь малаа бүрэн услахад хүрэлцэхгүй шавхардаг, ус нь дундарч ширгэсэн учраас шинээр худаг гаргах хэрэгтэй болдог, худаг шавхарч ус хүрэлцэхгүй байгаа Баруун Нарангийн уурхайн гүний худгаас малаа услах шаардлагатай болдог зэрэг бэрхшээлүүдийг дурдаж байна. Малчдын үзэж буйгаар худгийн усны түвшин буурсанд бороо хур багассан, малын тоо толгой ихэссэн, уурхайнууд газрын гүний ус их хэмжээгээр ашиглах болсон нь нөлөөлсөн байна. Орон нутгийн усны хэлэлцүүлгийн үеэр Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчийн мэдээлснээр 2018 оны зун Цогтцэций сумын малчид худаг уснаас болж маргалдан нэгнийхээ амь насыг егүүтгэсэн эмгэнэлт хэрэг гарсан байна.


Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Өмнөговь аймгийн зүүн бүсийн ихэнх сумдын хувьд худгийн тоо нэмэгдсэн бол Цогтцэций сумын хэмжээнд малчдын худгийн тоо сүүлийн жилүүдэд огцом буурсан байна.⁸⁵ Гэтэл уул уурхайн нөлөөлөлд өртсөн Ханбогд сумын хувьд 2012 оноос 2015 онд худгийн тоо 100 орчим тоогоор нэмэгдсэн байна.



Дүрслэл 41. Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумд дахь малчдын худгийн тоо


⁸⁴ Ус 2030. Хуудас 24.

⁸⁵ УСХ. Худаг, усан сан, уст цэгийн тоо. 2018. http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_1001_031V1



Дүрслэл 42. Цогтцэций сумын малчдын худгуудын тоо

Малчдын энгийн худгууд 2012 онд 160 орчим байсан нь 90 орчим болж буурсан байна. Цогтцэций сумын Цагаан-Овоо багт малчны энгийн уурхайн худаг 60 орчим байснаас 10 хүрэхгүй шахам болсон байна.




Дүрслэл 43. Цогтцэций сумын багуудын худгийн тоо

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журамд заасны дагуу ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг дараах арга хэмжээнд зарцуулах ёстой. Үүнд:

- Усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх;
- Усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлуулах цэгийг сайжруулах;
- Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;
- Усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

Энэхүү үнэлгээний явцад ба орон нутагт болсон усны хэлэлцүүлгийн үеэр сумын удирдлага, малчид Тавантолгойн уурхайнуудын төлж буй ус ашигласны төлбөр зориулалтын дагуу сум орон нутгийн усны нөөцийг нэмэгдүүлэх, малчдын худаг, уст цэгүүдийг нэмэгдүүлэх, сайжруулахад зарцуулагдахгүй байгаа асуудлыг хөндөж байсан. Ухаа худаг уурхай ус ашигласны төлбөрт 2016 онд 352 сая төгрөг, 2017 онд 1 тэрбум 466 сая төгрөг Өмнөговь аймагт төлсөн байна.⁸⁶ Энэ төлбөрөөр Тавантолгойн уурхайн нөлөөллийн бүс нутагт хийгдсэн ажил, цаашдын төлөвлөлтийн талаарх ил тод мэдээлэл алга байна.

⁸⁶ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Цахим тайлангийн систем. 2018



Дүрслэл 44. Энержи Ресурс компаниас
Өмнөговь аймагт төлсөн ус ашигласны төлбөр, сая.төг /2013-2017/

Улаан нуурт үзүүлж буй сөрөг нөлөөлөл

Тавантолгойн уурхайн хойд хэсгээр нутагладаг малчид, сумын удирдлагаас Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайн лицензийн талбайн баруун урд буланд байрших хур бороо, үерийн усаар тэжээгддэг Улаан нуурын урсгалыг боож шуудуу ухсан, хаягдлын овоолго хийсэн нь Улаан нуурыг бүрмөсөн ширгэхэд хүргэнэ гэж үзэн шаардлага хүргүүлсэн байна.

Нутгийн малчны энэ талаар өгүүлснийг доор сийрүүлээ.

“Таван толгой ХК Улаан нуурын зүүн талд олборлолтоо хийж байна. Хойд талд нь Хишиг-Арвин компанийн кэмп байгаа, мөн Эрдэнэс Тавантолгойн хөрс хуулалтынхан байгаа. Улаан нуур баруун урд талаасаа урсаж газрын гадарга дээр тогтдог устай газар. Энд Цогтцэций, Ханхонгорын бүх тэмээнүүд амьдардаг, бударганаа идээд, нуураасаа услаад явдаг. Гэтэл Эрдэнэс Таван толгой хуулсан хөрсөө Улаан нуурын ордог эх үүсвэр дээр асгачихсан учраас ус орох боломжгүй болсон. Бороо ороод уулын хяраас бууж ус тогтдог байсныг хаачихсан болохоор усгүй болчихсон. Нуурыг дагаж байдаг ургамал хатаад энэ сайхан нуур байхгүй болж байна. Малчид хурал дээр хэлэхэд хөрсөө гүүр байгуулаад зохицуулж өгье гэдэг ч одоо болтол байхгүй. Бүгд л орон нутгийн харилцааны ажилчидтай, тэд нар мэдээллийг сонсоод шийдэж чаддаггүй, сонслоо, мэдлээ л гэдэг. Хийгдсэн ажил байхгүй байна”

Тавантолгойн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд дурдсанаар Улаан нуурын талбай 1990, 2014 оны байдлаар хатаж ширгэсэн байдалтай байна. Ерөнхийдөө төслийн үйл ажиллагаа эрчимжихээс өмнө хур тунадас, усархаг байдлаас хамааран устай эсвэл ширгэсэн жилүүд ээлжилж байсан бол сүүлийн жилүүдэд ихэнх хугацаанд ширгэсэн байдалтай байна.⁸⁷ Уг тайланд ухсан хонхор, нүх, овоолго, олборлолт зэрэг уул уурхайн үйл ажиллагааны улмаас 22

⁸⁷ Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ. Хуудас 62-63

сайрын 10 сайрын ус хурах талбай эвдрэлд өртөж Улаан нуурын уурхайн талаас ирэх тэжээгдлийн урсацыг хаасан нь шууд нөлөөлсөн байна. Мөн ил уурхайд орж ирж байгаа шүүрлийн ус их биш гэх боловч түүнийг хэмжсэн тоо баримт одоогоор байхгүй, цаашдаа шүүрлийн улмаас Улаан нуурын хотгорын хэмжээнд усны түвшин аажмаар буурах нөлөөлөл үүсч болзошгүй гэж дүгнэжээ.⁸⁸

Эрдэнэс Тавантолгой компанийн Цанхийн уурхайн 2015-2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Улаан нуурын талаарх орон нутгийн удирдлага, нутгийн иргэдийн илэрхийлсэн санал гомдлын дагуу авах арга хэмжээ огт байхгүй, Улаан нуурт үзүүлэх байгаль орчны нөлөөллийн талаар тодорхой арга хэмжээ төлөвлөгөөгүй байна.



Зураг 18. Улаан нуурын сайр, Цанхийн уурхайн овоолгын орчим бэлчиж буй тэмээн сүрэг


БЭЛЧЭЭРИЙН ДОРЙТОЛ, ХОМСДОЛ

Уул уурхайн эдэлбэр газрын орчимд нутаглаж буй малчдын хувьд уурхайн эдэлбэр газар, түүнийг дагасан зам, дэд бүтцийн байгууламжуудын газар ашиглалтын талбай нэмэгдэж малаа бэлчээх, отор нүүдэл хийх бэлчээрийн хэмжээ багасч байна. Ялангуяа Тавантолгойн бүлэг орд ба Баруун Нарангийн уурхайн завсрын бүсэд нутаглаж буй малчдын хувьд 2 талаасаа бэлчээрийн газар хумигдаж байна.

Гашуунсухайтын зам дагуу нутаглаж буй малчдын хувьд хатуу хучилттай зам, төмөр замын суурь далангийн ажлын үлдэц, хуучин ашиглаж байсан нүүрс тээврийн шороон зам, нүүрс тээврийн урт дараалал үүсэх үед нүүрсний машинууд замаас гарч дураараа явж эвдсэн газрууд зэрэг замын нөлөөллөөр малаа чөлөөтэй бэлчээж хариулахад бэрхшээлтэй болж байна.

Бэлчээрийн газар уул уурхай, нүүрс тээврийн замын нөлөөлөлд өртсөний зэрэгцээ Цогтцэций сумын нийт малын тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн явдал нь бэлчээрийн чанар, хүртээмж буурахад нөлөөлсөн чухал хүчин зүйл юм.

⁸⁸ Мөн тэнд. Хуудас 134-135



Дүрслэл 45. Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдын малын тоо /1998-2017/

Цогтцэций сумын хувьд 1999-2001 оны зуд болохоос өмнө малын тоо өсч 150 мянга орчим болсон ч зуднаар 30 орчим мянган мал хорогдож малын тоо буурчээ. Түүний дараагаар малын тоо аажмаар өсч 2008 онд 150 мянгад хүрсэн ч 2009 оны зуднаар мал сүргийнхээ 50 гаруй хувийг алдаж, олон малчид хохирол амссан байна. 2011 оноос малын тоо эргэн өсч 2014 онд өмнөх 150 мянгыг давж 2015-2017 онд 250 орчим мянга болж улам нэмэгдсэн байна. Цогтцэций сум нь нийт 7.2 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр Өмнөговь аймагтаа жижиг сумдын нэг юм.

Уулзаж ярилцсан малчид сүүлийн жилүүдэд малын тоо огцом нэмэгдэж бэлчээрийн даац хүрэхгүй байх, отор нүүдэл хийх газар олдохгүй байх, өөр газраас малчид оторлож ирснээс маргаан зөрчил үүсэх зэрэг асуудал тулгарч байгааг хэлж байсан. Түүнчлэн, оторлоод нүүхэд худаг ус ашиглахтай холбоотой маргаан үүсэх явдал нилээд гардаг байна. Отор хийхэд үүсэх бэрхшээл, эрсдлээс шалтгаалж отор нүүдэл хийхгүй өнжих айлууд байдаг байна. Гэвч отор хийлгүй өнжсөн айлуудын хувьд бэлчээрийн гарц дараа жил нь мууддаг. Ялангуяа, гантай, бэлчээрийн гарц тааруу жилд отор нүүдэл хийхтэй холбоотой бэлчээр, худаг ус ашиглалтын шалтгаантай маргаан зөрчил ихэсдэг байна.

МАЛЧДЫН АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН

Уурхайн орчны аюулгүй байдал

Тавантолгойн уурхайн орчимд нутаглаж буй малчин айлуудын эрүүл мэнд, эд хөрөнгөд шууд нөлөөлж байгаа дараах үндсэн 3 асуудал байна.

Нэгд, Эрдэнэс Тавантолгойн Цанхийн уурхайн эдэлбэр газрын тойруулан ухсан суваг шуудуу нь бороо хуртай үед усаар дүүрч, түүнээс ус уухаар очсон мал унах, шаварт шигдэх байдлаар үхэх, гэмтэх тохиолдол гарч байна. Суваг

шуудууг байгуулахдаа энэ эрсдлийг тооцолгүй огцом хазгай, бороо хураар шавар үүсэх буюу мал унах, шаварт шигдэх эрсдэлтэй хийснээс малчид хохирол амсаж байна. Малчдын зүгээс тэрхүү суваг шуудууг мал унахаас сэргийлсэн байдлаар засах санал гаргаж байсан боловч компанийн зүгээс тодорхой арга хэмжээ авч байгаагүй байна.

Зуны цагт жоохон бороо орвол ус гүйчихнэ. Эрэгний шороо нь ороод лаг шавар болдог. Яг хавх шиг болно.

Отвалаа тойруулж ноднин сүрхий шуудуу ухсан. Гэтэл ус дүүрч манай 3 ботго шаварт сууж, хоёр нь гарч чадсан, нэг нь үхсэн. Шаварт шигдсэн байхыг нь уурхайнхан татаж гаргаад хаясан байсан. Түүнийг нь би 2 хоногийн дараа мэдэж авсан. Би гомдол гаргаагүй, тэгээд орхисон.

Би энэ шуудуугаа бул, янзал гээд ноднин зунаас гомдол гаргаад л байна. Бороо хур ихтэй үед бол осол давтагдана.

Манай дүүгийн унагатай гүү шуудуунд унаж үхсэн. Компани руу утсаар хэлдэг. Байгаль орчнынхондоо хэлье л гэдэг. 3 саяар үнэлээд 1.750 мянган төгрөг өгөх болсон ч одоо хүртэл өгөөгүй л байна.

Малчидтай хийсэн ярилцлагаас

Хоёрт, уурхайн орчимд олон тооны эзэнтэй, эзэнгүй нохой байдаг нь малчдад эрүүл мэнд, эд хөрөнгийн эрсдэл учруулж байна. Эрдэнэс Тавантолгойн уурхайн хөрсний овоолгын орчимд нэг айлын 8 ботгыг эзэнгүй ноход барьсан хэрэг гарсан байна. Энэ талаар хохирсон малчин сумын захиргаа болон цагдаад мэдэгдсэн ч хариуцлага хэн хүлээх нь тодорхойгүй, хохирлоо барагдуулж чадаагүй байна.

Малчдын мэдээлснээр уурхайн орчимд байдаг туслан гүйцэтгэгч компаниудын кэмпүүд нохой тэжээдэг боловч нүүх үедээ нохойгоо үлдээгээд явдгаас болж золбин ноход олширсон. Түүнчлэн, сумын төвийн хүн ам өсч хулгай, бусад гэмт хэрэг нэмэгдсэн тул айлууд нохой тэжээх нь ихэссэн байна.

Сумын удирдлага жил бүр нохой устгах ажлыг зохион байгуулдаг боловч хангалттай хэмжээнд хүрч чадахгүй, золбин ноход эрсдэл учруулсаар байна. Нохой устгалыг шинээр байгуулагдсан тохижилт үйлчилгээний компани хариуцаж ажиллахаар болж, дэс дараалсан арга хэмжээ авах болжээ. Гэвч уурхайн эдэлбэр газар, ялангуяа хөрсний овоолгын орчимд эзэнгүй нохой байхаас сэргийлэх арга хэмжээг компаниудын зүгээс авахгүй бол малчдын аюулгүй байдлыг хангахад бэрхшээлтэй юм.

Гуравт, уурхайн орчмын айлуудад Тавантолгойн бүлэг уурхайн тэсэлгээний ажлаас дуу чимээ, доргилт хүчтэй мэдрэгддэг байна. Дуу чимээний, чичиргээний нөлөөллийг хэмжиж хянах ажил хийгддэггүй учраас малчид өөрсдийн эрүүл мэнд, эд хөрөнгөд ямар нөлөөлөл үзүүлж байгааг мэдэх боломжгүй байна. Уурхайн компаниудын зүгээс тэсэлгээний хуваарь, холбогдох мэдээллийг малчдад өгдөггүй байна. Малчдын анзаарснаар өдөр, үдээс хойш гол төлөв тэсэлгээ хийдэг ч тогтсон өдөр, цаг байдаггүй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал



Зураг 19. Гашуунсухайтын нүүрсний зам дагуу нутаглаж буй малчин айл

Гашуунсухайтын нүүрс тээврийн зам дагуух малчидтай хийсэн ярилцлага, орчны ажиглалтаас үзэхэд дараах гол асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

Нэгд, нүүрс тээврийн машинд бод, бог мал дайруулах тохиолдол гарч байна. Нүүрс тээврийн машинууд хурд хэтрүүлж явдаг, шөнө тээвэр хийдэг, малын гарам цөөн, өргөн биш учраас мал зориулалтын бус олон газраар зам гардаг зэрэг шалтгааныг малчид онцолж байна. Бэлчээрийн гарц тааруу үед зам дагуу малаа бэлчээх, зам гарах шаардлага үүсдэг байна.

Малчид малаа дайруулсан тохиолдолд хэнд, хаана хандахаа мэдэхгүйгээр хохирч үлддэг. Хэрэв дайрах үед харсан тохиолдолд жолоочтой нь тохиролцох байдлаар хохирлоо барагдуулдаг байна.

2 жилийн өмнө нэг хуц дайруулсан. Хэн дайрсан нь мэдэгдэхгүй, их олон машин зорчдог. Бяц дайрчихсан байсан. Ер нь л хүн байхгүй бол дайрчих гээд байдаг, хүнтэй бол арай гайгүй хурдаа хасаж явдаг. Мэдэгдээгүй, чимээгүй өнгөрсөн. Харин хүмүүсийг хараг гэж бодоод өдөржин зам дээр нь байлгаад орой нь замаас гаргаж хаясан.

Бэлчээр хоёр талдаа, малаа зөндөө дайруулсан, эзэн нь олдоггүй. Өдрийн цагаар нэг хонио дайруулаад нэг хүн баригдаж тодруулсан, гэхдээ мөнгө аваагүй. Анх Говийн зам байхад бол дор бүр бүртгүүлдэг байсан, сүүлдээ учир нь олдохоо байсан.

Нутгийн малчидтай хийсэн ярилцлагаас

Малчид малаа хариулахдаа морь, тэмээгээр биш машин, мотоцикл ашиглах болсон нь орон нутагт нийтлэг болсон. Малаа мотоцикл, машинаар малладаг учраас хэрэв хангалттай хэмжээнд замыг намасгаж гарам гаргаагүй бол гармаар гарахад бэрхшээлтэй болдог байна.

Хоёрт, нүүрс тээврийн жолооч нар зам дагуух малчдын худгаас ундны болон ахуйн зориулалтаар ус авдаг байна. Ингэхдээ засмал замаас гарч

замгүй газраар малчдын худаг руу ирдэгээс болж хөрс эвдэгдэж түйрэн үүсдэг байна. Түүнчлэн, малчдын худгийг эвдэх, худгийн хажууд машинаа угаах, мал хуй үргээдэг байна. Ялангуяа, худгийн орчимд хөрсний эвдрэл элэгдэх үүсгэх байдал олон газар байна. Тухайн автомашин, жолоочийн харъяа аж ахуйн нэгж тодорхой бус учраас гомдол гаргах боломж байдаггүй өнгөрдөг байна.

Гуравт, зам дагуу хог хаягдал их учраас малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Жолооч нар гялгар ууттай хог, хуванцар сав, ариун цэврийн цаас зэрэг хог хаях нь их байдаг, түүнээс мал идэх тохиолдол их гардаг байна.

НӨЛӨӨЛЛИЙН МЕНЕЖМЕНТ

Олон улсын болон Өмнийн говийн бүс нутаг дахь уул уурхай, дэд бүтцийн төслүүдийн жишиг болгон баримталж ирсэн бодлогоор тухайн төслийг бүтээн байгуулах, түүний дараа олборлолт, тээвэрлэлт зэрэг ашиглалтын үйл ажиллагаанаас болж биет ба биет бус нөлөөлөлд орох өрхүүдийг тодорхойлж, нөхөн олговор олгох, амьжиргааг нь урт хугацаанд дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байна. Биет нөлөөлөл тухайн уурхай, үйлдвэр, дэд бүтцийн төслийн улмаас айл өрх нэг байршлаас нөгөө рүү нүүн шилжих шаардлага үүсч, түүнээс үүдсэн өмч хөрөнгийн ба бусад хохирол, алдагдал юм. Энэ нь гол төлөв үнэлэгдэж, орлуулагдаж эсвэл нөхөн төлөгдөж болдог биет эд хөрөнгийг хамардаг. Жишээ нь, малчин өрх уурхайн эдэлбэр газарт өвөлжөө бууцтай байсан бол түүнийг нүүлгэн шилжүүлэхдээ өмнөхөөс дордуулахгүй байхуйц бэлчээрийн газар, өвөлжөө бууц, шинэ газар дасан зохицох, эрсдлийг давахад зориулсан дэмжлэг, бусад тогтвортой амьжиргааг дэмжихэд зориулсан нөхөн олговрын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Үүнийг Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж буй Оюу Толгойн уурхай болон Тавантолгойн бүлэг ордоос олборлолт хийж буй Энержи Ресурс компанийн Ухаа Худгийн уурхай олон улсын зохих стандартын дагуу хэрэгжүүлсэн байдаг. Монгол улсад энэ талаарх хууль эрх зүйн зохицуулалт, нарийн шаардлага хэм хэмжээ байдаггүй учраас тухайн компанийн бодлого, нийгмийн хариуцлага, хөрөнгө оруулагчдын шаардлага зэргээс болж ялгаатай хэрэгжиж байна.

Уурхай, үйлдвэр, дэд бүтцийн төслийн нөлөөллийн улмаас газраа чөлөөлж, нүүн шилжих шаардлага үүсээгүй боловч төслийн улмаас байгаль орчин, нийгмийн олон янзын нөлөөлөлд өртөж, түүний улмаас амьжиргааны нөөц бололцоо нь хумигдаж, амьжиргааны эх үүсвэрээ алдах эрсдэл байдаг. Оюу Толгой, Энержи Ресурс компаниудын хувьд энэ нөлөөллийн бүсийг төслийн онцлог, компанийн бодлого, нөлөөллийн үнэлгээний дагуу өөр өөрөөр тогтоосон байдаг. Энержи Ресурс компанийн нөлөөллийн бүсийн хамрах хүрээтэй холбоотой, нөлөөллийн бүсийн өрхүүдтэй гэрээ хийх, нөхөн олговор олгосонтой холбоотой маргаан, санал гомдол одоог хүртэл байна.



Зураг 20. Цанхи уурхайн баруун хойд талд нутагладаг малаа усалж буй малчин

Энержи Ресурс компани нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны шаардлагын дагуу Ухаа худаг уурхайн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж, түүний дагуу 13 малчин өрхөд үзүүлэх нийгмийн нөлөөллийг бууруулах, заримыг нь нүүлгэн шилжүүлэх, мониторинг хийх, малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж иржээ.⁸⁹ Тус компанийн мэдээлснээр Орон нутгийн хамтын ажиллагааны хэлтэс 4 ажилтантай, орон нутагтай харилцах асуудлыг хариуцан ажилладаг байна. Орон нутагтай харилцахдаа олон талын төлөөллийг оролцуулсан Орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулан ажилладаг, ус, агаарын чанарын мониторинг хийдэг, орон нутагт, нөлөөллийн бүсэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг гэж мэдээлсэн. Тус компани орон нутгийн иргэдээс ирсэн санал гомдлыг өөрийн ажиллах журам бүхий Өргөдөл гомдол барагдуулах комиссоор дамжуулж 30 хоногийн дотор шийдвэрлэж, хариу мэдээлдэг байна.

Ухаа худаг уурхай анх байгуулагдахад 20 гаруй өрх нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан. Бууц барьж өгөх, ус гаргаж өгөх зэрэг асуудлыг шийдсэн.

Мал идээшихгүй байна гэдэг асуудал гарч байсан. Уурхай төвхнөөд ирсэн хойно тэр хүмүүс уурхайн хавиар нутаглаж л байгаа. Ногоо байгаа газраа малаа идээшлүүлээд явж байна.

Уурхайн зүгээс айл өрхүүдийг нүүлгэх машин тэрэг, бензин шатахуун гаргаж өгсөн. Бололцооны байсан гэж дүгнэж болно.

Энержи анх байгуулагдахад нөлөөллийн бүсийн цөөхөн айлд бууц барьж өгч байсан. Анх эхлэхдээ бол сайхан эхэлж байсан. Гэхдээ бусад уурхайг бодвол Энержи харьцангуй гайгүй, бусад уурхайг бол мэдэхгүй сүүлийн жилүүдэд бол байхгүй болсон.

Энержи Ресурсээс уурхайн нөлөөллийн хэсэгт байсан тодорхой хэмжээний бууц хороотой айлуудад нөхөн төлбөр олгож, бууц хороо олгох тэр тал дээр нэлээн ажилласан.

Малчидтай хийсэн ярилцлагаас

Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд уурхайн хөрсний овоолго хийх газар өвөлжөө бууц нь байсан айлуудыг нүүлгэн шилжүүлсэн, ингэхдээ нүүлгэсэн боловч худаг барьж өгөөгүй, мөнгийг нь дутуу өгсөн гэсэн гомдол гардаг байна.

2014 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хийсэн Цанхийн зүүн уурхайн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг шинэчлэхэд зориулсан судалгаагаар Эрдэнэс Тавантолгой компаниас нөлөөллийн менежментийг сайжруулах зөвлөмжийг дэвшүүлсэн байна. Уг судалгаанд дурдсанаар Зүүн Цанхийн уурхайн лицензийн талбайд өвөлжөөтэй 4 өрх, зуслан, намаржааны газартай 2 өрх, Зүүн Цанхийн уурхайн талбайгаас 5 км радиустай нөлөөллийн бүс тогтоовол өвөлжөө, хаваржаатай 5 өрх, зуслан, намаржаатай 15 өрх, нийт 26 өрх хамрагдаж байна. Эдгээрээс зөвхөн уурхайн лицензийн талбайд өвөлжөө нь байсан 2 өрхтэй гэрээ хийж, нүүлгэн шилжүүлж, нөхөн олговрын гэрээ байгуулсан байна. Эрдэнэс Тавантолгой компани бусад айл өрхүүдийн тухайд биет ба биет бус нөлөөллийг тогтоох, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, амьжиргааг дэмжих арга хэмжээ аваагүй байна. 2014 оны судалгаагаар 2010 онд Цанхийн уурхайн нөлөөлөлд өртсөн 15 айл бүгд уурхайн тоос, дуу чимээ, хөрсний эвдрэлийн нөлөөллөөс холдон нүүсэн байдалтай байсан.

Эрдэнэс Тавантолгой компанийн гэрээ хийж нүүлгэн шилжүүлсэн 2 айлын хувьд нүүлгэн шилжүүлэх гэрээний агуулга, нөхөн олговрын хүрээ, хэмжээг сонголтгүйгээр тулгах замаар хийснээс өөрсдийн эд хөрөнгийн бодит үнэлгээ, амьжиргаанд учрах эрсдлээ тооцуулах боломж олгоогүй гэж үздэг байна. Түүнчлэн, гэрээний дагуу хүлээсэн зарим үүргээ компани биелүүлэлгүй өдийг хүрсэн гэж гомдол гаргасан байна. Нүүлгэн шилжүүлсэн нэг айлд өвөлжөө барьж өгсөн боловч худаг гаргаж өгөх үүргээ биелүүлээгүйн улмаас шинэ газар өвөлжих боломжгүй болсон байна. Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд дотоод зохион байгуулалтын хувьд нүүлгэн шилжүүлэлтийн асуудалд явцуу байдлаар хандаж олон улс ба үндэсний компаниудын сайн жишиг, туршлагын дагуу хийх бүтэц зохион байгуулалт, хөрөнгө санхүүг шийдвэрлээгүй байна.⁹⁰ Уг судалгаанд Эрдэнэс Тавантолгой компани нэн яаралтай нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдийн судалгаа, үнэлгээ, нөхөн олговор, амьжиргааг дэмжих хөтөлбөр бловсруулж, сумын удирдлагатай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай болохыг анхааруулж, тодорхой төлөвлөгөөний, зохион байгуулалтын санал зөвлөмж дэвшүүлсэн байна. Гэвч өнөөдрийн байдлаар Эрдэнэс Тавантолгой компанийн зүгээс энэ талаар авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ алга байна. Үндсэндээ төрийн өмчит компани түрэмгийлсэн байдлаар малчдад ханддаг, малчид энэ компаниас нөхөн олговор, дэмжлэг тусалцаа авах боломжгүй гэдэг цөхөрсөн хандлага давамгайлж байна.

Энержи Ресурс компани Гашуунсухайтын авто замыг барихдаа замын нөлөөлийн бүсийг 500 м ба 5 км-ээр тогтоож, биет ба биет бус нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлжээ. Малчдын өгүүлснээр зарим айлуудыг нүүлгэн шилжүүлж өвөлжөө барьж өгөх, худаг гаргаж өгөх арга хэмжээ авч байжээ. Түүнчлэн, малчид нүүн шилжихгүйгээр шинэ худаг гаргуулах байдлаар тохиролцож байсан нь цөөнгүй байна. Зам баригдсаны дараа компанийн зүгээс өвлийн цагт малын өвс тэжээл өгөх, худаг ус, тоосны асуудлаар уулзах зэрэг арга хэмжээ авдаг байсан байна.

⁹⁰ Бодлогын судалгааны хүрээлэн.

Замын нөлөөлөлд орсон айлуудад уурхайн кэмпэд ажиллах, замын арчилгаа, хяналтын цалинтай ажил хийх зэргээр амьжиргааг дэмжих бодлого хэрэгжүүлж иржээ.

Харин Гашуунсухайт замыг төрийн мэдэлд шилжүүлж Гашуунсухайт авто зам компани хариуцах болсноор замын нөлөөллийн бүсийн айлууд орхигдсон гэж малчид хэлж байна. Зам дагуух хөрсний эвдрэл, тоосжилт, мал дайрагдах, жолооч нар худаг усны орчим хөрс эвдэх, бохирдуулах зэрэг асуудлаар малчидтай уулзах, зөвлөлдөх, тодорхой арга хэмжээ аваагүй байна.

ХӨНДӨГДӨЖ БУЙ ЭРХҮҮД, НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЛИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Анхаарах шаардлагатай нөлөөлөгч хүчин зүйлс, үйл ажиллагаа, эрсдлийн талаарх дүгнэлт

Хөндөгдөж буй эрх: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх				
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль 16.2-р зүйл
Тухайн эрхийн товч тайлбар				
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг хэлнэ. Орчны бохирдол гэдэгт агаарын, усны, хөрсний гэх мэт органик бохирдлоос гадна дуу чимээний, хог хаягдлын, гэрлийн гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй органик бус бохирдлыг хамааруулдаг.				
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт				
Эрдэнэс Тавантолгойн Цанхийн уурхайн эдэлбэр газрын тойруулан ухсан суваг шуудуу нь бороо хуртай үед усаар дүүрч, түүнээс ус уухаар очсон мал унах, шаварт шигдэх байдлаар үхэх, гэмтэх тохиолдол гарч байна.				
Уурхайн орчимд олон тооны эзэнтэй, эзэнгүй нохой байдаг нь малчдад эрүүл мэнд, эд хөрөнгийн эрсдэл учруулж байна. Зам дагуух хөрсний эвдрэл, тоосжилт, мал дайрагдах, жолооч нар зориулалтын бус замаар явах, худаг усны орчим хөрс эвдэх, бохирдуулах асуудал гарч байна.				

Хөндөгдөж буй эрх: Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	
Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 7 сарын 28-ны 64/292-р тогтоол
Тухайн эрхийн товч тайлбар	
Хүн бүр хангалттай хэмжээнд, аюулгүй, бие махбодийн хувьд хүртэх боломжтой усыг хүртээмжтэй байдлаар хувийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хэрэглэх эрх юм.	
Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт	
Улаан нуур нь ухсан хонхор, нүх, овоолго, олборлолт зэрэг уул уурхайн үйл ажиллагааны улмаас 22 сайрын 10 сайрын ус хурах талбай эвдрэлд өртөж, Цанхийн уурхайн хөрсний овоолго Улаан нуурын уурхайн талаас ирэх тэжээгдлийн урсацыг хааж шууд нөлөөлсөн байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Өмнөговь аймгийн зүүн бүсийн ихэнх сумдын хувьд худгуудын тоо нэмэгдсэн бол Цогтцэций сумын хэмжээнд малчдын худгийн тоо сүүлийн жилүүдэд огцом буурсан байна.	

Хөндөгдөж буй эрх: Эд хөрөнгө өмчлөх эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	17-р зүйл			16.3-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Хүн бүр хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх ёстой.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

2010 онд Цанхийн уурхайн нөлөөлөлд өртсөн 15 айл бүгд уурхайн тоос, дуу чимээ, хөрсний эвдрэлийн нөлөөллөөс холдон, өвөлжөө, хаваржаагаа орхин нүүсэн байдалтай байна. Нүүрс тээврийн жолооч нар зам дагуух малчдын худгаас ундны болон ахуйн зориулалтаар ус авдаг байна. Ингэхдээ малчдын худгийг эвддэг, худгийн хажууд машинаа угаадаг байна.

Хөндөгдөж буй эрх: Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
				16.12-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Аливаа хүн төр, нийгмийн болон иргэдийн нийтлэг эрх ашигт хохирол учруулахаар оршин байгаа зөрчил, дутагдлыг арилгуулах буюу нийгмийн хэв журам, хууль зөрчсөн асуудлын талаар, мөн өөрийн болон бусдын эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд өргөдөл гаргах эрхтэй, нөгөө талаас уг гомдол, өргөдлийг шийдвэрлэх, хариу өгөх үүргийг төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар хүлээдэг.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Төрийн өмчит компани түрэмгийлсэн байдлаар малчдад ханддаг, малчид энэ компаниас биет ба биет бус нөлөөллийн нөхөн олговор, дэмжлэг туслалцаа авах боломжгүй гэдэг цөхөрсөн хандлага давамгайлж байна. Малчид малаа дайруулсан тохиолдолд хэнд хаана хандахаа мэдэхгүйгээр хохирч үлддэг.

Хөндөгдөж буй эрх: Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрх

Хүний эрхийн үндэсний ба олон улсын баримт бичгүүд дэх заалт	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Монгол улсын үндсэн хууль
	19-р зүйл	19-р зүйл		16.16-р зүйл

Тухайн эрхийн товч тайлбар

Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

Нөлөөлөл, эрсдлийн талаарх дүгнэлт

Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт хамгийн их ус ашиглаж буй Энержи Ресурс компанийн Нүүрс угаах үйлдвэрийн газрын доорх ус ашиглалт, түүнээс орчмын усны хүртээмжид үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээлэл дутмаг байна. Эрдэнэс Тавантолгой компани нөлөөллийн бүс дэх малчдын худгийн усны түвшин, усны чанарын хяналт шинжилгээ хийдэг боловч хэмжилт хийх тогтсон цаг байдаггүй, иргэдийн оролцоо байхгүй, иргэдэд эргэж мэдээлэл өгдөггүй байна.

Хөндөгдөж буй хүний эрхэд үзүүлж нөлөөллийн эрчим, эрэмбэ

Эрэмбэ	Хөндөгдөж буй эрхүүд	Н	Х	С	М
I	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	2	3	2	3
	Мэдээлэл авах эрх	1	3	2	3
II	Ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх	1	3	2	2
	Өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх	2	1	3	2
	Эд хөрөнгө өмчлөх эрх	2	1	2	2

Дараах шалгууруудын дагуу 1-3 хүртэлх эрэмбээр үнэлсэн.

Н - Нөлөөллийн ноцтой байдал (1-3)

Х - Нөлөөлийн хамрах хүрээ (1-3)

С - Эрхийг сэргээх боломж (1-3)

М - Эрхийн зөрчил ойрын хугацаанд дахин үүсэх магадлал (1-3)

ЗӨВЛӨМЖ

- Мэргэжлийн байгууллагаас тоосжилтыг олон цэгт, тогтмол, ил тод байдлаар мониторинг хийж, тоосжилтын тархалт, тоосонцорын агууламж, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлох
- Суваг шуудууг байгуулахдаа энэ эрсдлийг тооцох, огцом хазгай, бороо хураар шавар үүсэх буюу мал шаварт шигдэх, мал унахаас сэргийлсэн байдлаар засах
- Тавантолгойн бүлэг уурхайн төлж буй ус ашигласны төлбөрийн зохих хэсэг зориулалтын дагуу сум орон нутгийн усны нөөцийг нэмэгдүүлэх, малчдын худаг, уст цэгүүдийг нэмэгдүүлэх, сайжруулахад зарцуулах
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх
- Зам дагуух малчид гомдол саналаа илгээх, шийдвэрлүүлэх механизм бий болгох
- Эрдэнэс Тавантолгой компанийн Цанхийн уурхайн 2015-2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Улаан нуурын талаарх орон нутгийн удирдлага, нутгийн иргэдийн илэрхийлсэн санал гомдлын дагуу авах арга хэмжээ авах

- Цанхийн уурхайн биет ба биет бус нөлөөлөлд өртсөн малчдын судалгааг гаргаж, нөхөн олговор болон тогтвортой амьжиргааг дэмжих шаардлагатай хөтөлбөрийг хэрэгжүүлэх

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүрээнд Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний урьдчилсан тайланг орон нутгийн засаг захиргаа, иргэд, бизнесийн байгууллага зэрэг оролцогч талуудад танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх, санал зөвлөмж боловсруулах зорилго бүхий олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд, 2018 оны 10 дугаар сарын 18-нд Өмнөговь аймгийн төвд, мөн сарын 19-ний өдөр Цогтцэций суманд танилцуулга, сургалтыг тус тус зохион байгууллаа.

2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд болсон Олон талт хэлэлцүүлэгт ХНХЯ, Цогтцэций сумын ИТХ, ЗДТГ-ын дарга, ажилтнууд, Авто тээврийн үндэсний төв, Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс болон Тавантолгой ХК, Гашуун сухайт авто зам, нүүрс тээвэрлэгч компаниудын удирдлагууд, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумын Засаг захиргаа, иргэд, малчдын төлөөлөл, Цогтцэций сумын жижиг, дунд бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцож, тус тусын байр сууриа илэрхийлж, санал солилцсон.

Хэлэлцүүлэгт Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс болон Тавантолгой ХК-ийн шийдвэр гаргах эрх бүхий удирдах ажилтнууд оролцож, эдгээр компани байгалийн баялгийг зохистой ашиглах, байгаль орчны холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллаж буй талаараа товч танилцуулсан.

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний урьдчилсан тайлангийн гол дүгнэлт, санал зөвлөмжийг судалгааны багийн ахлагч, доктор Д.Бямбажав танилцууллаа. Үнэлгээний тайланд байгаль орчин, орон нутгийн түншлэл, хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэг өргөн хүрээтэй, олон асуудалд холбогдох хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг тусгаж, зохих санал зөвлөмжийг боловсруулсан байна. Танилцуулга мэдээлэл сонссоны дараагаар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэ хэсэгт

1. Монгол Улсын хууль тогтоомж, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Тавантолгойн уурхайн үйл ажиллагаанд холбогдох хог хаягдал, усны хэрэглээ, хөрсний элэгдэл, авто замын эвдрэл, олон салаа зам, сумын төв дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, тоосжилт, улмаар түүний улмаас хүний эрүүл мэндэд гарч буй сөрөг нөлөөлөл, өвчлөл;
3. Уул уурхайн компаниудын тээвэрлэлтийн гэрээ, нүүрс олборлох, худалдан авагч компаниудын үүрэг хариуцлага, жолооч нарын эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн асуудал, хөдөлмөрлөх эрх, хариуцлага сахилга бат, хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч нарын хүрэлцээ;

4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээллийн уялдаа холбоо, гааль, цагдаагийн зэрэг байгууллагад холбогдох гомдол санал, хүнд суртал чирэгдэл;
5. Цогтцэций болон бусад сумын иргэд, малчдын эрүүл мэнд, уул уурхайн компаниудын ажилтнууд, бусад хөдөлгөөнт хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, хүн амд гарч буй өвчлөл, эмчилгээ, хүнсний аюулгүй байдлын хяналт;
6. Малчин өрх, мал аж ахуй эрхлэхтэй холбоотой хүний эрхийн асуудлууд, тухайлбал бэлчээрийн доройтол, худаг усны түвшин доошлох, усны хомсдол, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор болон компаниудад гаргасан санал хүсэлт, гомдлын шийдвэрлэлт, хариу өгөх механизм зэргийн талаар иргэд, төрийн албан хаагчдын зүгээс гомдол санал гаргаж, зарим шүүмжлэл хэлсэн болно.

Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч “Үнэлгээний зөвлөмжид дараах 4 асуудлыг тусгах саналтай байгаа илэрхийллээ. Үүнд:

- Сум дундын эмнэлгийн статусыг дээшлүүлэх
- Нүүрс тээврийн замын эхлэл буюу уурхай хоорондын 10 км авто замыг барих
- Агаарын бохирдлын төлбөрийг орон нутагт үлдээх
- Орон нутагт асуудлаа шийдвэрлэх хамтын удирдлагын тогтолцоог байгуулах зэргийг онцлон дурдсан болно.

Хэлэлцүүлгийн явцад Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэгт холбогдох хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах, төслөөс үүдэлтэй байгаль орчинд, хүн амын бүлгүүдэд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх талаар олон тооны санал дэвшүүлж, харилцан ярилцсан юм.

Уул уурхайн компаниуд нь талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан тээвэрлэлтийн гэрээ байгуулж ажиллах, ингэснээр жолооч нарын хувийн хариуцлага бус, компани хариуцлага хүлээдэг тогтолцоотой болох, уул уурхайн компаниуд тулгарсан байгаль орчны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх хамтын сан, хамтын зөвлөлтэй болох, байнга зөвшилцөх замаар сангийн хэмжээг өргөтгөх, Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх, сумын төвийг чиглэсэн том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тээвэрлэлтийг хязгаарлах, шинэ маршрутаар явуулах, сум, багийн төвийн орчинд мод тарих, цэцэрлэгжүүлэх, залуучууд руу хандсан нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх зэрэг саналууд гарч, тухай бүрд тайлбар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнөсөн.

Хэлэлцүүлгийн төгсгөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний гол үр дүн нь нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд гарч буй хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор оролцогч талууд хоорондын зөвшилцлийн механизм бүрдүүлэх тухай Үнэлгээний тайланд гаргасан саналыг талууд бүгд дэмжиж, хамтран ажиллахаар санал нэгдсэн болно. Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд байгаль орчны, хог хаягдлын, тээвэрлэлтийн талаар нэгдсэн хяналт, мониторингийн тогтолцоотой

болох, тулгарч буй бэрхшээл, саадыг шийдвэрлэх хүчин чармайлтыг хамтран гаргах, шаардлагатай төсөв, хөрөнгийг дундын санд төвлөрүүлж, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байх нь хамгийн зөв шийдэл гэдэгт санал нэгдлээ. Үүний зэрэгцээ зөвхөн дээрх 3 компани төдийгүй тус ордтой холбоотой ханган нийлүүлэлт хийж буй шатахуун түгээх, тээвэрлэлт, хүнсний үйлчилгээ зэрэг бусад компанийг нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд татан оруулж, хамтран ажиллах нь зөв гэсэн байр суурийг оролцогчид илэрхийлсэн болно.

Гэхдээ оролцогч талуудын зөвшилцлийн механизм бүрдүүлэх нь бүх талуудын хүчин чармайлт, харилцан ойлголцол, хөрөнгө оруулалт шаардах тул энэ ажлыг ХЭҮК болон Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар хамтран дундын мэдээлэл харилцаа, зохицуулалтыг хийж, эхлэлийг тавьж өгөхийг хэлэлцүүлэгт оролцогчид хүссэн болно.

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний эцсийн үр дүнг танилцуулах олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сарын 18-нд Өмнөговь аймгийн төвд, 19-нд Цогтцэций суманд танилцуулга, сургалтыг тус тус зохион байгууллаа.



Уулзалтыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадоржоор ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллан зохион байгуулж, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний эцсийн үр дүнг танилцуулж, оролцогч талуудын санал, байр суурийг сонсон хэлэлцлээ.

Уулзалт, хэлэлцүүлэгт Комиссын дарга Ж.Бямбадорж, Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Х.Сугир, Аймгийн Засаг дарга Н.Наранбаатар, Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч, тус аймаг дахь төрийн байгууллагууд, Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс болон Тавантолгой ХК-ийн шийдвэр гаргах эрх бүхий удирдах ажилтнууд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны мэргэжилтнүүд, бусад компани, аж ахуйн нэгжүүд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгдсэн тайлан, үндсэн дүгнэлт, санал зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл танилцууллаа. Үнэлгээний нэгдсэн тайланд байгаль орчин, орон нутгийн түншлэл, хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэг өргөн хүрээтэй, олон асуудалд холбогдох хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг тусгаж, зохих санал зөвлөмжийг боловсруулсныг дэлгэрэнгүй танилцуулсны дараагаар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгийг эхлүүлж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч хэлэхдээ “Энэ анхны уулзалт биш бөгөөд бид өнгөрсөн 6 дугаар сард Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар танилцуулах ийм уулзалтыг манай Цогтцэций сумын төвд зохион байгуулсан. Энэ удаа үүнд дурдсан асуудлыг дахин давтахгүйгээр хэлэлцэхийг хичээсэн ч “нөхцөл байдал улам хүндэрсэн”, “дордсон” гэсэн тодорхойлолт давтагдсаар байна. Хүн гэртээ гутлаа тайлаад хөл нүцгэн алхах эрхтэй байх. Гэтэл хөл нүцгэн 2 алхаад оймс харлана. Хөндлөнгийн хүнд энэ нь жижиг асуудал мэт санагдах байх. Тиймээс тоос тортог дунд, эмх замбараагүй нөхцөлд ажиллаж, амьдардаг олон мянган иргэдийнхээ эрх ашгийн төлөө дуугарахаас өөр аргагүйд хүрч, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадоржийг манай нутагт ирэх үед хүсэлт тавьж, манай нутгийн хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээг хийж өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан. Өнөөдөр энэ судалгааг бүрэн дүүрэн хийж гүйцэтгээд байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссынхонд баярлалаа. Цаашид энэ судалгаанд тулгуурлан олон асуудлыг шийдвэрлэх зам нээгдэх байх гэж найдаж байна” хэмээсэн болно.

Тэгвэл ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж “Хүний эрх гэж ерөнхий утгаараа хүний дайтай амьдрах боломж, нөхцөл юм. Энэ боломж, нөхцлийг бүрдүүлэхэд төрийн үүрэг, оролцоо чухал. Хүний хаана байна, тэнд нөхцөл, боломж бүрдүүлэх ёстой. Тавантолгой орчимд нөхцөл байдал хүнд, ноцтой байгааг талууд бүгд хүлээн зөвшөөрч байна. Хүлээн зөвшөөрсөн бол одоо байдлыг арилгах, сайжруулах талд ажиллах ёстой. Энэ хэлэлцүүлгээр үнэлгээнд та бүхний зөвлөмж, саналыг мөн авах, Ажлын хэсэг байгуулах саналтай байна” гэсэн санал гаргасны дагуу холбогдох яамд, төрийн байгууллага, орон нутгийн удирдлага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг байгуулахаар боллоо. Мөн дээрх үнэлгээний дүн бодит нөхцөл байдалд ойрхон, үнэн бодитой тул тал бүрийн төлөөлөл хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлж, тус судалгаанд тулгуурлан нэгдсэн Зөвлөмж боловсруулан батлахаар санал нэгдэв.

Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа. Үүнд:
Ажлын хэсгийн ахлагч:

1. Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

2. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч

Гишүүд:

3. Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл
4. Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Х.Мөнхбаяр

5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын мэргэжилтэн Г.Намчинсүрэн
6. Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн Н.Болормаа
7. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг
8. “Энержи Ресурс” ХХК-ийн Захиргааны албаны дарга Т.Ганболд
9. Орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Сэддорж
10. “Баян зам тээвэрчид” ТББ-ын тэргүүн М.Нямжав

“ТАВАНТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН НҮҮРС ОЛБОРЛОХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”

1. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

Тавантолгойн бүлэг ордоос БНХАУ руу экспортлох нүүрсний хэмжээ 2010 оноос байнга өсөн нэмэгдэж, нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа эрчимжсэний улмаас байгаль орчин, нийгмийн болон хүний эрхийн өргөн хүрээтэй, ноцтой сөрөг нөлөөллүүд үүсч буйг орон нутгийн иргэд, нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон үндэсний байгууллага, судлаачид судалгаа, баримтад үндэслэн анхааруулж ирсэн билээ. Гэвч эдгээр судалгаа, шаардлагад анхааруулж байсан байгаль орчин, нийгэм, хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх асуудал шийдвэрлэгдээгүй төдийгүй 2016 оны 2 дугаар сараас нүүрсний үнэ огцом өсч, нүүрсний экспортын хэмжээ хурдацтай нэмэгдсэнээр улам даамжирч, ноцтой үр дагаварт хүрч байна.

Тавантолгойн нүүрсний бүлэг ордын олборлолт, тээвэрлэлтэд оролцогч төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид заасан амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх, хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангуулах, мэдээлэл авах, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж, хуулийн дагуу шийдвэрлүүлэх зэрэг хүний эрхийг ноцтойгоор зөрчиж, цаашид дээрх эрхийн зөрчлүүд даамжрах хандлагатай байна.

Үүнд:

- Тавантолгойн бүлэг ордоос Гашуунсухайт боомт хүртэлх нүүрс тээврийн замд дундажлан тооцвол өдөрт 4-5 буюу 1 сард 125 орчим зам тээврийн осол гарч, сар бүр 1 хүний амь нас хохирч байна. 2010-2018 онд Гашуунсухайтын нүүрс тээврийн замд зам тээврийн осол болон бусад үйл ажиллагааны улмаас наад зах нь 50 гаруй хүний амь нас үрэгдсэн байна.
- Нүүрс олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож буй уул уурхайн компаниуд (Энержи Ресурс ХХК-иас бусад), нүүрс худалдан авагч тал (БНХАУ-ын нүүрсний компани, борлуулагч, тээвэрлэгчид), тээвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд тээвэрлэлтэд холбогдох хууль тогтоомж, (Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль болон бусад), дүрэм, журам, стандартыг мөрдөхгүй, чанд сахин биелүүлэхгүй байгаагийн улмаас замын хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдаж,

жолооч нарын амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрх ноцтой зөрчигдөж байна.

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэдийн хувьд хамгийн тулгамдаж, санаа зовниж буй асуудал нь Тавантолгойн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, агаарын бохирдол юм. Гэвч Тавантолгойн ордод олборлолт хийж буй уул уурхайн 3 компани агаарын чанар, тоосжилтын хэмжилт хийхдээ олон улсын ба үндэсний стандартыг баримталдаггүй, хэмжилтийн хамрах хүрээ, аргачлал, үр дүнгийн ил тод байдал хангалтгүй байгаа нь эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, цаашлаад тухайн орон нутагт ажиллаж, амьдарч буй иргэдийн амьд явах эрхэд сөргөөр нөлөөлж байгааг даруй анхаарч, зохих шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тоосжилтыг бууруулах, хяналт шинжилгээг сайжруулах, мэдээллийг ил тод болгох талаар өнгөрсөн хугацаанд аж ахуйн нэгжүүдийн зүгээс дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаа нь үнэлгээний явцад тогтоогдсон байна. Энэ хүрээнд уурхайн болон замын дэд бүтэц барьж байгуулах, бусад аргачлал, технологийг сайжруулах ажлууд төлөвлөсөн боловч хэрэгжилт удаашралтай, үр дүн тодорхойгүй байгааг онцлон тэмдэглэж байна.
- Эрдэнэс Тавантолгой компанийн Баруун Цанхийн уурхайн хөрсний овоолгоос 1-1.5 км орчим зайтай, уурхайгаас ачилт, тээвэрлэлт хийх тээврийн хэрэгслүүдийн зогсоолоос 0.6-1 км зайд байрлах Цагаан-Овоо багийн айл өрх, иргэд тус уурхайн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөж буй тул уг багийн төвийг нүүлгэн шилжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах, шаардлагатай нөхөн олговор олгох, тогтвортой амьжиргааг дэмжих цогц арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших Цагаанхадны гаалийн хяналтын болон үйлчилгээний бүсэд ажиллаж, амьдарч буй иргэд, тээврийн жолооч нарын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах наад захын шаардлага хангахуйц орчин, нөхцөл бүрдээгүй байна. Төвлөрсөн зохицуулалтгүй, олон тооны тээврийн хэрэгслүүдийн замын хөдөлгөөн, их хэмжээний тоосжилт, нүүрсний түйрэн, хөдөлгөөнт хүн амын хяналтгүй, албан бус суурьшил бүхий энэ бүсэд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирох эрсдэл өндөр байна. Иймд энэ бүс, түүнд байрлах гаалийн хяналтын талбай, нүүрс шилжүүлэн ачих газруудыг хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрхийг хангасан, эрчим хүч, усан хангамж, эрүүл ахуй, ариун цэврийн байгууламж зэрэг дэд бүтэц бүхий хүнд ээлтэй орчин бүрдүүлэх хүртэл үйл ажиллагааг нь түр зогсоох шаардлагатай байна.
- Тавантолгойн уурхайн тоосжилт, Цогтцэций сумын хүн амын өсөлт, түүний дотор нүүрс олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хөдөлгөөнт хүн амын өсөлтөөс үүдэлтэйгээр тус сумын хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал эрс нэмэгдсэн боловч уг хүн амд үйлчлэх хүний нөөц, төсөв хөрөнгө хүрэлцээгүйн улмаас чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ, ялангуяа уул уурхайн томоохон осол гарсан тохиолдолд нарийн мэргэжлийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх, боломж бүрдээгүй байна.

- Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайн орчмын ба Гашуунсухайтын зам дагуух малчдын амьжиргаа, хүн ба малын эрүүл мэнд, аюулгүй амьдрах орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байх тул тус сумын олон арван малчид аргагүйн эрхэнд суурьшсан нутгаасаа холдон нүүж “дүрвэх” байдалтай байна. Энержи Ресурс ХХК-иас бусад төр, хувийн хэвшлийн байгууллага, компанийн хувьд малчид болон иргэдийн гомдол саналыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх байнгын ажиллагаа бүхий санал, гомдол шийдвэрлэлтийн тогтолцоо дутагдалтай байна.
- Цогтцэций сум нь Тавантолгойн бүлэг уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн ноцтой нөлөөллийн төвд байгаа хэдий ч нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн нэмэлт эх үүсвэргүй байна. Агаарын бохирдол, усны хүртээмжийн талаар сумын засаг захиргааны зүгээс зохих арга хэмжээ авч ажиллах нөхцлийг хангахын тулд хуулиар тогтоосон уурхайн нөлөөллийн бүсэд зарцуулагдах ёстой ус ашигласны болон агаарын бохирдлын төлбөрийн зохих хувийг тухайн нөлөөлөлд өртөгч орон нутгийн мэдэлд шилжүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.
- Агаарын тухай хууль нь Улаанбаатар болон аймгийн төвүүдийн агаарын чанартай холбоотой асуудалд төвлөрч, аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлага, орон нутгийн нөлөөллийн бүсүүдийн асуудлыг орхигдуулжээ. Уг хууль болон байгаль орчны тухай хууль журамд тоосжилтыг хянах, бууруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон журам байхгүй байна.
- Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагаанд төрийн өмчит 1 уурхай, орон нутгийн өмчит 1 уурхай, хувийн хэвшлийн 1 уурхай, 130 гаруй нүүрс тээврийн компаниуд, олон арван ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд оролцож, эдгээрийн үйл ажиллагааны улмаас өргөн хүрээтэй, давхардаж хуримтлагдсан байгаль орчин, нийгмийн, хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүссэн байна. Монгол Улсын холбогдох хууль журмыг сайтар сахин мөрдөж, үйл ажиллагаандаа олон улсын сайн туршлагуудыг нэвтрүүлэн ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагууд байх боловч тус уурхайн олборлолт, тээвэрлэлтийн улмаас хуримтлагдах хүний эрх, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад нийт нөлөөлөгч талууд, түүний дотор уул уурхайн 3 компани, томоохон тээвэрлэгч ба ханган нийлүүлэгч компаниуд, төр, орон нутгийн холбогдох байгууллагуудын ойлголцол, ажлын уялдаа холбоо, хамтын хүчин чармайлт хэрэгтэй байгааг оролцогч талууд хүлээн зөвшөөрч, цаашид хамтран ажиллахаа илэрхийлж байгааг энд онцлон тэмдэглэж байна.

Ерөнхий зөвлөмж

Дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан “Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний тайланд хүний эрхийн дараах зөрчлүүдийг онцлон дурдаж, үүнд холбогдох хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар зохих арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийг оролцогч талуудад зөвлөж байна. Үүнд:

1. Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөж байгаа асуудлыг УИХ-ын Хүний эрхийн дэд хороогоор хэлэлцүүлж, хүний эрхтэй холбоотой зөрчлийг арилгах ажлын явцын талаар улирал бүр УИХ-д тайлагнах замаар зохих ахиц дэвшил гаргахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох;
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөхгүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, замын хөдөлгөөний аюулгүй байдалд хохирол учруулж, хүний эрхийн зөрчил гаргаж буй нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах шаардлагыг хүргүүлэх, улмаар одоогийн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн өргөн цар хүрээтэй, харилцан уялдаатай арга хэмжээг төрийн холбогдох байгууллага, уурхайн компаниуд, бусад аж ахуйн нэгжүүд авч, хамтран хэрэгжүүлэхийг даалгаж, хэрэгжилтийг тогтмол үнэлэх;
3. Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах наад захын нөхцлийг хангах хүртэл Цагаанхадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг түр зогсоох, мөн Хөдөлмөр, эрүүл ахуйн стандартыг мөрддөггүй, мөрдөхөөс татгалзсан тээврийн байгууллагууд, нийтийн хоолны болон бусад үйлчилгээ, засварын газруудын үйл ажиллагааг түр зогсоох, эдгээрийн гаргасан зөрчлүүдэд Зөрчлийн болон холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах;
4. Энэ тайланд тусгасан Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд гарч буй хүний эрхийн зөрчил, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Оролцогч талуудын зөвшилцлийн механизм бүрдүүлэх замаар байгаль орчны, хог хаягдлын, тээвэрлэлт зэрэг асуудлаар хамтарсан хяналт, мониторингийн тогтолцоотой болох, тулгарч буй бэрхшээл, саадыг шийдвэрлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг дундын санд төвлөрүүлж, хамтарсан шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах зэргээр хамтын хүчин чармайлт гарган ажиллахыг дэмжих;
5. Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах зорилго бүхий Оролцогч талуудын зөвшилцлийн механизмыг яаралтай байгуулан ажиллуулах, үүнд тус ордод олборлолт хийж буй уурхайн 3 компани болон ханган нийлүүлэлт хийж буй шатахуун түгээх, тээвэрлэлт, хүнсний үйлчилгээ зэрэг бусад компани, оролцогч талуудыг бүрэн хамруулж ажиллах бөгөөд үүнд холбогдох мэдээлэл харилцаа, зохицуулалтыг Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хамтран хэрэгжүүлэх:

“Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”

**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын захиалгаар
Бодлогын Инновацийн Хүрээлэн гүйцэтгэв.**

ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ТАВАНТОЛГОЙН БҮЛЭГ ОРДЫН НҮҮРС ОЛБОРЛОХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

(2020 оны 11 дүгээр сарын байдлаар)

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Тавантолгойн бүлэг орддын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны *Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг боловсруулж, улмаар орон нутгийн засаг захиргаа, иргэд, бизнесийн байгууллага зэрэг оролцогч талуудад танилцуулах*, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх, санал зөвлөмж боловсруулах зорилго бүхий олон талт уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций суманд, улмаар 10 дугаар сарын 28-ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад суманд тус тус зохион байгуулсан.

Эдгээр уулзалт, хэлэлцүүлэгт Хүний эрхийн Үндэсний Комисс, ЭМЯ, ХНХЯ, ЗТЯ, УУХҮЯ, Өмнөговь аймгийн болон Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын ИТХ, Засаг дарга, ажилтнууд, Авто тээврийн үндэсний төв, уул уурхайн болон нүүрс тээвэрлэгч компаниудын удирдлагууд, иргэд, малчдын төлөөлөл, жижиг, дунд бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцож, тус тусын байр сууриа илэрхийлж, санал солилцсон. Хэлэлцүүлэгт мөн Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс, Тавантолгой, Гашуун сухайт авто зам зэрэг компанийн удирдах ажилтнууд оролцож, эдгээр компани байгалийн баялгийг зохистой ашиглах, байгаль орчны холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллаж буй болон тулгамдсан асуудлуудын талаар товч танилцуулсан.

Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх явцад хүний эрхийг хангах, нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэд, малчид, уул уурхайн салбарын ажилтнууд, жолооч нарын эрүүл, аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн болон орон нутгийн удирдах байгууллага, уул уурхайн компани, нүүрс худалдан авагч компани, тээврийн аж ахуйн нэгж байгууллагууд болон жолооч нарын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа чухал гэдэгт оролцогчид санал нэгдсэн юм.

Цаашид Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд гарч буй хүний эрхийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Оролцогч талуудын зөвшилцлийн механизм бүрдүүлэх, байгаль орчны, хог хаягдлын, тээвэрлэлтийн зэрэг асуудлаар хамтарсан хяналт, мониторингийн тогтолцоотой болох, тулгарч буй бэрхшээл, саадыг шийдвэрлэх, шаардлагатай төсөв, хөрөнгийг дундын санд төвлөрүүлж, хамтарсан шийдвэр гаргах зэргээр хамтын хүчин чармайлт гаргах талаар хамтран ажиллахаар болсон. Оролцогч талуудыг хамруулсан зөвшилцлийн механизм бүрдүүлэхдээ тус ордод олборлолт хийж буй уурхайн компаниуд төдийгүй тус ордод ханган нийлүүлэлт хийж буй шатахуун түгээх, тээвэрлэлт, хүнсний үйлчилгээ зэрэг бусад компани, оролцогч талуудыг бүрэн хамруулж, зөвшилцлийн механизм байгуулах талаар саналууд гарсан болно.

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүний эрхийн зөрчлүүдийг арилгахад анхаарал хандуулж ажиллахыг хүсэж, Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх болон УУХҮЯ, Өмнөговь аймгийн болон Цогтцэций сумдын удирдлага, Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс, Тавантолгой зэрэг компани, байгууллагуудад хүргүүлэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж болон Ажлын албаны ажилтнууд УИХ-ын гишүүн Л.Энхболд, Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга Х.Сугир, Засаг дарга Н.Наранбаатар, Засаг даргын орлогч Х.Батболд, Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч, Засаг даргын орлогч Ц.Доржсүрэн, Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү, тэргүүн дэд захирал С.Эрдэнэбулган, Гашуун сухайт авто зам ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Болд, АТҮТ-ийн дэд захирал Ш.Батсайхан нар болон Баян зам холбоо, Тээвэрчдийн гэргий нарын холбоо зэрэг ТББ-ын тэргүүн, удирдлагуудтай уулзаж, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар санал, зөвлөмж хүргүүлж ажиллав. Улмаар Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2019 оны 4 дүгээр сард нүүрс тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, сумын Засаг дарга, банкны удирдлага, “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой”, “Энержи Ресурс” зэрэг компаний захирал болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, дээрх асуудлыг судалж, нөхцөл байдлыг сайжруулах талаар үүрэг даалгавар өгсөн байна.

Үнэлгээний зөвлөмжийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Тавантолгойн нүүрсний бүлэг ордын нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хийсэн Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах, хамтарсан мониторинг хийж, төрийн байгууллага, албан тушаалтнууд, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж өгөхөөр 2020 оны 10 дугаар сарын 27-31 өдрүүдэд тус аймгийн Даланзадад, Цогтцэций, Ханбогд сумдад ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилт, нөхцөл байдалтай танилцах ажлыг зохион байгууллаа. Ажлын хэсгийг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ч.Алтангэрэл ахалж, бүрэлдэхүүнд БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Батмөнх, МХЕГ-ын Геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн улсын байцаагч Б.Батбаатар, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн мөрдөгч Р.Гансүх, НҮБХХ-ийн “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төслийн зохицуулагч Р.Ариунбилэг, ХЭҮК-ын Тамгын газрын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн референт Б.Мөнх-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын хэлтсийн Өмнөговь аймаг дахь референт Г.Нарангоо нар ажиллалаа. Ажлын хэсэг Цогтцэций сумын Засаг дарга О.Бадарч, Засаг даргын орлогч Ц.Доржсүрэн, Сум дундын Цагдаагийн хэлтэс, уул уурхай, авто замын компаниудын удирдлага, холбогдох ажилтнуудыг оролцуулан уулзалт зохион байгуулж, Эрдэнэс-Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК, Тавантолгой ХК-ийн уурхай, Цагаан хадны гаалийн хяналтын талбай, бусад үйлчилгээний байгууллагууд, Тавантолгойн ордоос

Гашуунсухайт боомт хүртэлх нүүрсний тээвэрлэлтийн үйл ажиллагаа, зөвлөмжийн хэрэгжилттэй танилцсан болно.

Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (2018 он)-ний зөвлөмжийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулж байна.

Д/д	Зөвлөмжийн агуулга	Зөвлөмжийн хэрэгжилт
	Нүүрс тээвэрлэлтийн талаарх төрийн бодлого, стратегийг тодорхойлох;	
1	Монгол Улсын Засгийн газар ажлын хэсэг байгуулж, Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн асуудлыг цогцоор шийдвэрлэх богино, дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх олон талт механизм бий болгох, Эрдэнэс Тавантолгой ХК энэхүү ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн талаар Засгийн газраас ажлын хэсэг байгуулсан, тусгайлсан стратеги боловсруулсан тухай мэдээлэл байхгүй байна. Энэ хүрээнд “Нүүрс тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 320 тогтоол баталж, ЗТХЯ, БОАЖЯ, АТҮТ болон холбогдох бусад газрууд тогтоолын хэрэгжилтийг хангахаар хамтран ажиллаж байна. Мөн ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2018 оны 125 дугаар тушаалаар “Гашуунсухайт боомт чиглэлийн автозамаар нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, жолооч нарын хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах Ажлын хэсэг байгуулж, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх, тухайн үед үүсээд байсан нүүрс тээврийн урт дарааллыг зохицуулж ажиллажээ.
2	Ажлын хэсэг нь Тавантолгойн нүүрс тээвэрлэлтийн нөхцөл байдалтай танилцах, урт хугацаа (15-20 жил), дунд хугацаа (8-10 болон 3-5) болон богино хугацаа (1 жил)-ны хөгжлийн бодлогыг боловсруулах, уг бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг салбарын яам, агентлаг тус бүрийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулах;	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Уул уурхайн салбарын урт хугацааны төлөвлөлт боловсруулж салбар хоорондын уялдаа холбоог хангана” гэж заажээ. Үүний дагуу Тавантолгойн ордыг цогцоор ашиглах зорилгоор төмөр замын тээврийн дэд бүтцийг байгуулах, хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг сайжруулах, уг ордыг түшиглэн цахилгаан станц байгуулах, нүүрс боловсруулах, баяжуулах зэрэг ажлыг төлөвлөжээ. Энэ хүрээнд Тавантолгой - Гашуун сухайт чиглэлийн 240 км төмөр замыг Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрт 2 өртөө, 6 зөрлөгтэйгээр барьж байна. Уг төмөр зам нь 1 дүгээр зэрэглэлийн, уулзваргүй зам бөгөөд жилд 30 сая тонн хүртэлх нүүрс экспортлох боломжтой. Ингэснээр Тавантолгой бүлэг ордын уурхайн олборлолт 2-3 дахин нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Мөн Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн авто замын зэрэгцээ 250 км их даацын хатуу хучилттай автозам барихаар шийдвэрлэжээ. Одоогийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замаар өдөрт 1000-1300 хүртэл тээврийн хэрэгсэл нэвтэрдэг. Харин 250 км параллель авто зам ашиглалтад орсноор тээвэрлэлт 2.5 дахин өсч, нүүрсний экспорт нэмэгдэх тооцоолол хийжээ. ЗТХЯ, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас Таван толгой-Гашуунсухайт чиглэлд чингэлэгтэй тээврийн хэрэгслээр нүүрс тээвэрлэх бодлогыг 2019 оны 6 дугаар сард танилцуулжээ. Чингэлэгт тээвэр нь нүүрсний жингийн хорогдол багасах, ачилт, буулгалтаас шалтгаалан байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурах, хил нэвтрэх хурд нэмэгдэх зэрэг олон давуу талтай гэж үзсэн байна. Цаашид чингэлэг шилжүүлэн ачих терминал, логистикийн төв, гаалийн тусгай гарц, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Тавантолгойн уурхайн тоосжилт, агаарын чанарын хяналт шинжилгээг сайжруулах;		
1	Тавантолгойн ордод олборлолт хийж буй уурхайнуудын орчны агаарын чанар, тоосжилтын хяналт шинжилгээ хийх аргачлал, давтамж, ил тод байдлыг сайжруулах;	Тавантолгойн бүлэг ордод төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой, хувийн хэвшлийн Энержи Ресурс, орон нутгийн өмчит Тавантолгой компаниуд олборлолт хийдэг. Дээрх компаниуд агаарын чанарын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх тохиолдлыг шалгах, хэмжилтийн мэдээний жилийн динамикийг гаргах, агаар, орчны тоосны агууламж, органик бус хийн төлөвт бохирдуулагчид (хүхрийн исэл, азотын исэл, нүүрстөрөгчийн дан исэл), тоосны хуримтлалыг хянах зорилготой олон төрлийн хэмжилт, судалгааны ажлуудыг тогтмол гүйцэтгэж, үр дүнг төрийн байгууллага, сумын ЗДТГ болон иргэдэд мэдээлж ажиллаж байгаа тухай мэдээлэл ирүүлжээ.
2	Тавантолгойн ордод олборлолт хийж буй уурхайнууд агаарын чанар, тоосжилтын байнгын, тасралтгүй хяналт шинжилгээ хийх олон улсын жишгийг нэвтрүүлэх;	Энержи Ресурс ХХК нь үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо OHSAS 18001:2007 гэсэн олон улсын гурван төрлийн стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд тус компани Цогтцэций сумын 4 цэгт байгаль хамгаалагч, цаг уурын ажилтан болон иргэдийн төлөөлөлтэй хамтраад тоосны хэмжилт, мониторингийг сар тутам хийдэг байна. Тухайн орон нутгийн орчны тоосжилтийг тогтмол хянаж, иргэдэд нээлттэй мэдээлэх нь хариуцлагатай уул уурхайн чухал үзүүлэлт хэдий ч бусад уурхайн компаниудын мэдээлэл тодорхойгүй байна.
3	Цогтцэций сумын Цаг уурын ажиглалтын харуул хэмжилт хийх аргачлал, баримтжуулалт, мэдээллийн хадгалалтын горимыг нарийвчлан тодорхойлох, тоног төхөөрөмж ашиглах, үр дүнг мэдээлэх чадавхийг нэмэгдүүлэх;	Цогтцэций сумын ЗДТГ 2019 онд төсвийн хөрөнгөөр сумын төв орчмын агаарын чанарыг хэмжих 80.0 сая төгрөгийн өртөг бүхий Дасттрак багаж худалдан авч, тоосжилтын судалгаа, тоосны ширхэглэгийн хэмжилтийг 24 цагийн хугацаатайгаар хийж байна.
4	Цогтцэций сумын төвийн орчмын агаарын чанар, тоосжилтын судалгааг бие даасан хараат бус судалгааны байгууллагаар хийлгэх;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
5а	Агаарын тухай хууль болон байгаль орчны хуулиудад тоосжилтыг хянах, бууруулахад чиглэсэн аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох, холбогдох журам, стандартыг боловсруулах;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
6	Агаарын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлал, мөн Агаарын бохирдлын эсрэг үндэсний хөтөлбөрт нүүрсний уурхай орчмын агаарын бохирдол, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн эрсдэлийн талаар тусгах;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд 2018, 2019 онуудад өөрчлөлт оруулсан ч уурхай орчмын агаарын бохирдол, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн эрсдэлийн талаар тодорхой шийдвэр гаргаагүй байна.

7	Уурхайн хилийн шав, суваг шуудууг байгуулахдаа хэт огцом хазгай байх, бороо хураар шавар үүсэх буюу мал шаварт шигдэх эрсдэлийг тооцох, мал унахаас сэргийлсэн байдлаар засах;	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Цанхийн уурхайн Байгаль орчны менежментийн 2018 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланд дурдсанаар Цагаан-Овоо багийн Хужирын хонхор зэрэг 3 булгийн эхийг хашиж хамгаалжээ. Тухайн газар шаварлаг учир хашааны шонг бэхжүүлэх үүднээс хаягдал дугуй ашиглан бетон цутгалт хийсэн байна.
8	Мэргэжлийн байгууллагаас тоосжилтыг олон цэгт, тогтмол, ил тод байдлаар мониторинг хийж, тоосжилтын тархалт, тоосонцорын агууламж, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлох;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Хэдий Цогтцэций сумын ЗДТГ болон уул уурхайн компаниуд тоосжилтыг олон цэгт, тогтмол хэмжилт хийж буй мэдээлэл өгсөн ч тоосжилтын тархалт, тоосонцорын агууламж, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлох талаар мэргэжлийн байгууллагын нарийвчилсан судалгаа, үнэлгээ хийгдээгүй байна.
Цогтцэций сумын төвийн тоосжилтыг бууруулах, ус ашиглалтын талаар;		
1	Уул уурхайн компаниуд ил уурхайн тоосжилт үүсгэгч эх үүсвэр тус бүрээс ялгарах тоосжилтыг хэмжиж, түүнийг ихээхэн бага руу эрэмбэлж, хамгийн их тоосжилт үүсгэгч эх үүсвэрт авах арга хэмжээг хамгийн оновчтой хувилбараар тодорхойлж, цогц хөтөлбөр хэрэгжүүлэх;	Энэ хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК-иуд уурхайн талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн замд магнийн давс цацах туршилт хийжээ. Туршилтын ажил үр дүнтэй гарсан боловч эдийн засгийн хувьд өртөг өндөртэй байсныг уурхайн төлөөллүүд танилцуулгадаа дурджээ. Энержи Ресурс ХХК нь нүүрсний технологийн зам услахад усны нөөц хомс, өвлийн улиралд зам мөстөж, халтиргаа гулгаа үүсэх эрсдэлтэй тул усыг мананцаржуулах зэргээр замын тоосыг дарах шинэлэг технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Эрдэнэс Тавантолгой ХК нь горельник буюу неогений улаан хурдсыг уурхайн гол замуудад дэвсэж туршжээ. Туршилтын ажилд нийт 3280 м3 улаан шавар, 3844 м3 хайрга чулуурхаг материалыг 18.1 га талбай бүхий технологийн замд дэвссэн. Тоосжилтын судалгаа хэмжилтийг Дасттрак багажаар хийснээр дэвсэлт хийсэн замын хэсгээр тоосжилт харьцангуй буурсан үр дүн гаржээ.
2	Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайн хотхоноос Цогтцэций сумын төв хүртэлх авто замыг 2019 онд багтаан ашиглалтад оруулах;	Эрдэнэс Тавантолгой ХК, Өмнөговь аймаг хоорондын хамтын ажиллагааны гэрээг 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу эхний ээлжинд компанийн уурхайн ажилчдын хотхоноос Цогтцэций сумын төв хүртэлх авто замыг барьж байгуулах үүрэг хүлээсэн байна. 2020 оны 11 дүгээр сарын байдлаар уурхайн хотхоноос Цогтцэций сумын төв хүртэлх 13,2 км авто замын суурь далангийн газар шорооны ажил хийгдэж байсан бөгөөд тус замыг 2021 оны 10 сард ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.
3	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс ачих хэсгээс Гашуунсухайтын авто зам хүртэлх нүүрс тээвэрлэлтийн 8.2 км шороон замыг хатуу хучилттай болгож, ашиглалтад оруулах;	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн уурхайгаас Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай автозамтай холбох 8,2 км автозамын барилгын ажил гүйцэтгэх гэрээг 2017 оны 11 сард "Арж капитал" ХХК-тай байгуулж, 2019 онд уг замыг хатуу хучилттай болгож, ашиглалтад оруулжээ. Энэхүү авто зам ашиглалтад орсноор орон нутгийн иргэд, тээврийн жолооч нарын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл сайжрах, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдах, их хэмжээний тоосжилт зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулжээ.

4	Эрдэнэс Тавантолгой компанийн Цанхийн уурхайн 2015-2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Улаан нуурын талаарх орон нутгийн удирдлага, нутгийн иргэдийн илэрхийлсэн санал гомдлын дагуу авах арга хэмжээ авах;	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Цанхийн уурхайн Байгаль орчны менежментийн 2017 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланд дурдсанаар Улаан нуурын тэжээгдлийн нэг урсацыг отвал дарах болсон тул уг төлөвлөлтийг өөрчлөн зөвхөн зүүн тийш ахилтыг үргэлжлүүлэхээр төлөвлөжээ. Улмаар дарагдсан урсацыг сэргээх зорилгоор шинээр суваг байгуулан усны урсацыг саадгүй байдлаар нэвтрүүлэх боломжтой болгосон талаар тайлагнажээ.
5	Цанхийн уурхайн биет ба биет бус нөлөөлөлд өртсөн малчдын судалгааг гаргаж, нөхөн олговор олгох, тогтвортой амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх; Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Эрдэнэс Тавантолгой ХК нь жил бүрийн БОМТ-д 5 хүртэлх малчдын худгийг сэргээн засварлах, нөлөөлөлд өртөж буй талбайн 1 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тусган хэрэгжүүлж байна. Үүнээс өөр тодорхой мэдээлэл байхгүй.
1	Гашуунсухайт авто зам компани нүүрс тээвэрлэлтийн замын арчилгаа, зам засварын ажлын хурд, хяналт, аюулгүй байдлыг сайжруулах;	Үнэлгээний зөвлөмжийн дагуу Засгийн газрын 2019 оны 01 дүгээр албан даалгавар гарч, Гашуун сухайт авто зам ХХК-ийн бүтцэд замын засвар, арчлалтын нэгж шинээр байгуулан температурын хэв гажилтын заадас гагнах, авто зам дагуу зогсоол, ус зайлуулах хоолой суурилуулах, замын тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэн сайжруулах ажлуудыг тогтмол хийх болжээ. Мөн замын засвар, арчлалтын талаар 24 цагаар дуудлага хүлээн авах диспетчер ажиллуулж, 2018 онд 2.2 тэрбум, 2019 онд нийт 23.0 тэрбум төгрөгийн зам засвар, нөхөн сэргээлтийн ажил хийжээ. Авто зам дагуу бие засах газар, хогийн цэг бүхий тохижилттой 20 түр зогсоолыг шинээр бий болгожээ.
2	Гашуун сухайт авто зам компани ЦЕГ, АТУТ-тэй хамтран замын хөдөлгөөний дүрэм сахиулах, техникийн бүрэн байдлыг шалгах, замын гэмтэл, осол болон хөдөлгөөнд нөлөөлж болох байгаль цаг уурын хүчин зүйлсийн талаар мэдээлэх тогтолцоо байгуулах;	Гашуун сухайт авто зам ХХК нь авто замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах ажлын хүрээнд 408 ш тэмдэг, 400 ш дохионы шон суулгаж, сэргээн засварласан. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шалган нэвтрүүлэх цэгүүдэд 100 ширхэг төмөр бетон хаалт байгуулж, гэрээт цагдаагийн тасагтай хамтран осол ихээр гардаг цэгүүдийн судалгааг гаргаж, авто зам дагуу 4 байршилд мэдээллийн самбар суурилуулсан байна. Шалган нэвтрүүлэх цэгүүд орчимд хяналтын камерууд суурилуулж, бичлэгийг ухраан үздэг байна.
3а	Гашуун сухайт нүүрс тээврийн замын дагуу нийгмийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөний дүрэм мөөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх;	Гашуун сухайт авто зам компани ЦЕГ-тай хамтран замын хөдөлгөөний дүрэм сахиулах, техникийн бүрэн байдлыг шалгах, замын гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг хариуцах Гэрээт цагдаагийн тасаг байгуулан ажиллуулж байна. Уг тасаг нь Цогтцэций сумын Цагдаагийн хэлтэстэй хамтран дүрэм зөрчсөн, согтууруулах ундаа хэрэглэсэн, мэргэжлийн үнэмлэхгүй хүнд жолоо шилжүүлсэн, дараалал дайрсан, замгүй газраар явсан тухай мэдээлэл авдаг байнгын 24 цагийн ажиллагаатай утас, диспетчер ажиллуулж байна.

4	Гашуун сухайт авто зам ХХК, АТҮТ, тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд хамтран нүүрс тээвэрлэлтийн бүх техник хэрэгсэлд GPS суулгаж дараалал дайрах, замгүй газраар давхих, хөдөлгөөний хурд хэтрүүлэх явдлыг хянах, зөрчил гаргасан этгээд болон түүний хамаарах атээвэрлэгч аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцох;	Энержи Ресурс ХХК нь тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллагааг хэвшүүлэх зорилгоор тус компанийн нүүрс тээврийн бүх автомашинд GPS төхөөрөмж суурилуулж, хурд, хөдөлгөөнийг хянадаг байна. Үүнээс өөр аж ахуйн нэгжүүдээс үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй байна.
5	Улсын хилээр нэвтэрсэн нүүрс тээврийн жолооч наар тухайн тээврийн хэрэгслийг жолоодон буцаж хил нэвтрэх тогтолцоонд шилжих, жолоо шилжүүлэх асуудлыг багасгах;	Ковид-19 цар тахлын халдвар бүртгэгдэж, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр тухайн асуудал шийдвэрлэгдсэн байна. Тухайлбал, Улсын онцгой комиссын даргын тушаалаар Улс хоорондын ачаа тээвэрлэлтийг нэгдсэн удирдлагаар хангах, тээвэрлэлтэд үүсч буй хүндрэл, саатлыг арилгах үүрэг бүхий Шуурхай бүлгийг байгуулж, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар ахалжээ. Уг бүлэг нь улс хоорондын тээвэрлэлт, хилийн боомтод гарах хүндрэлийн талаар шаардлагатай арга хэмжээг авч, зохицуулалт хийн ажиллаж байна. Үүний үр дүнд хилээр нэвтэрч буй нүүрс тээврийн автомашин болон жолооч нар бүрэн бүртгэлд хамрагдаж, хяналтад оржээ.
4. Орон нутгийн иргэд, жолооч нарын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;		
1	Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК нь нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй "Тээвэрлэлтийн гэрээ" байгуулах ажлыг хэвшүүлэх, холбогдох стандарт, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, таниулах, мөрдүүлэх ажлыг гүйцэтгэх нэгжийг шинээр зохион байгуулж, шаардлагатай хүн хүч, техник хэрэгслээр хангах;	Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК-иуд нүүрс тээврийн компаниуд, АТҮТ-тэй Гурван талт тээвэрлэлтийн гэрээг байгуулж ажилладаг. Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын мэдээлснээр 2020 оны 2 дугаар улиралд Гашуунсухайт боомтын чиглэлд 4 уурхайгаас 160 аж ахуй нэгжийн 9969 тээврийн хэрэгсэлд С зөвшөөрлийн бичиг авах хүсэлт ирүүлснээс хийгдсэн хяналт, шалгалтыг үндэслэн 154 аж ахуй нэгжийн 6600 тээврийн хэрэгсэлд олгожээ.
2	Тавантолгойн уурхайн компаниуд хөдөлмөр, эрүүл мэнд, болон тээвэрлэлтийн хууль, дүрэм, журмыг зөрчсөн аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулахгүй, байгуулсан гэрээг цуцлах журмыг мөрдөж ажиллах;	АТҮТ нь 2019-2020 онд нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тайланг олон нийтэд нээлттэй цахим хуудаст байршуулжээ. Уг шалгалтад нийт 161 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсаны 25 нь "бага", 67 нь "дунд", 69 нь "их" эрсдэлтэй дүгнэгджээ. Үүнд жолоочийн амрах байр, нийгмийн асуудалд анхаардаг, нийгмийн даатгал төлдөг, татвар төлдөг, засвар үйлчилгээний байртай, ХАБЭА-н болон инженер техникийн ажилтнуудтай байх зэрэг шалгуур хангасан, чадамжтай аж ахуй нэгжүүдэд С зөвшөөрлийн бичгийг хуваарилжээ.
3	ЭМЯ болон Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар нүүрс тээвэрлэлтэд оролцож буй иргэд, бусад хөдөлгөөнт хүн амын дунд нийгмийн халдварт өвчин тархахаас сэргийлэх үзлэг оношилгоо хийх, шаардлагатай үед эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;	ЭМЯ, Эрдэнэс Монгол ХХК, Гашуун Сухайт Авто Зам ХХК хамтран 2020 оны 10-11 дүгээр сард нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт жолооч нарыг хамруулан "Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг" зохион байгуулжээ. Улмаар нүүрс тээврийн жолооч, тухайн бүсэд амьдарч буй иргэдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, зонхилох өвчлөлийн талаар нэгдсэн тайлан гаргахаар ажиллаж байна.

5а	Тээвэрчдийг батапгаат хоол хүнс, тав тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллах, амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой Амралт, авто зогсоолын цогцолборыг Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр дэх улсын хилийн зурваст барих тухай МУ-ын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх;	Амралт, авто зогсоолын “Тайван зогсоол” цогцолборыг Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр дэх улсын хилийн зурваст барьж байгуулж байна. Уг цогцолбор нь 2500 авто зогсоолтой, эмнэлэг, 220 хүний суудалтай кинотеатр, хоолны газар, үсчин, гоо сайхан, халуун усны газруудтай байна. Зогсоолын талбай нь 24 цагийн харуул хамгаалалттай, хяналтын камерийн системтэй байхаар төлөвлөгдсөн байна.
6	Цогтцэций сумын нутаг дэвсгэр дэх 4, 6 дугаар гармын орчимд байрласан аж ахуйн нэгж, үйлчилгээний газар, хувь иргэдийг эмх журам, зохион байгуулалтад оруулах, тээвэр, ложистикийн төвийг байгуулах;	Цогтцэций сумын нутаг дэвсгэр, нүүрс тээврийн замын 4, 6 дугаар гарам орчимд байрлаж байсан 100 гаруй зөвшөөрөлгүй гэр гуанз, үйлчилгээний газар, хувь иргэдийг Таван толгой төмөр зам ХХК-аас хөрөнгө зардлыг гарган нүүлгэн шилжүүлжээ. Эдгээр үйлчилгээ, аж ахуйн нэгжүүд нүүрс тээврийн автозамын 2 дахь км-т бааригдах Тээвэр ложистикийн төвд шилжин ажиллахаар төлөвлөжээ. Гэвч Тээвэр ложистикийн төв 2020 оны 11 дүгээр сарын байдлаар ашиглалтад ороогүй, бүтээн байгуулалтын ажил зогссон байна.
7	Тээвэрчдийг хоршоолол, нийгэмлэгийн зохион байгуулалтад орох, байгаль орчныг бохирдуулахгүй, нийгмийн хэв журам зөрчихгүй байгаа үлгэр жишээч байдлыг сурталчилж, дэмжих;	Нүүрс тээврийн жолооч нар “Баян зам холбоо”, “Тээвэрчдийн зөвлөл”, “Тээвэрчдийн гэргий нарын холбоо”, “Монголын эрчүүдийн нийгэмлэг” зэрэг ТББ-уудад нэгдэн эрх ашгаа хамгаалах аргаа хэмжээ зохион байгуулдаг. Эдгээр ТББ нь тээврийн байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах, нүүрс тээврийн замд гарч буй авто осол, зөрчлийг бууруулах зорилгоор “Хурд 40/50 км/цаг”, “Аюулгүй тээвэр”, “80+ИЛЧИЛБЕ” зэрэг сурталчилгаа мэдээллийг аяныг зохион байгуулдаг.
8	Мэргэжлийн сэтгэлзүйч ажиллуулах, жолооч нартай холбоотой судалгаа, тандалтыг хийх, тэдний эрх ашгийг хамгаалж буй байгууллага, хувь иргэдтэй хамтран ажиллах;	Дээр дурдсан ТББ-ууд нүүрс тээврийн жолооч нарын анхаарал, сэрэмжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах үзлэг шалгалтыг байнга хийх, мэдээлэх тогтолцоог бий болгох зорилгоор тодорхой аян, арга хэмжээг зохион байгуулдаг ч жолооч нарт мэргэжлийн сэтгэлзүйч зөвлөгөө өгсөн, жолооч нартай холбоотой нарийвчилсан судалгаа хийсэн тухай мэдээлэл байхгүй байна.
5. Цагаан-Овоо багийн иргэдийн эрүүл мэнд, тогтвортой амьжиргааг хамгаалах талаар		
1	Эрдэнэс Тавантолгой компани нь Цагаан-Овоо багийн төвийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, үүнд иргэдийн оролцоог хангах;	Эрдэнэс Тавантолгой ХК, Өмнөговь аймаг 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд Цагаан-Овоо багийн иргэдийн газар, эд хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, нүүлгэн шилжүүлэх, уурхайн хотхоноос сумын төв хүртэлх авто замыг барьж байгуулах зэрэг асуудлыг тохирч баталгаажуулжээ. Үүнээс ЭТТ ХК нь тус багийн иргэдийн эд хөрөнгийн үнэлгээг хийж, нүүлгэн шилжүүлэх зардал, эд хөрөнгийн үнэлгээг 100 хувь олгохоор компанийн ТУЗ-ийн шийдвэр гарч, 2020 оны төсөвтөө тусгасан гэж мэдэгдсэн боловч нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ эхлээгүй байна.
2	Нүүлгэн шилжүүлэлтийн гол хариуцагч Эрдэнэс Тавантолгой ХК, Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар байх, эдгээрийн хамт Тавантолгой ХК нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтөд манлайлах үүрэгтэй оролцох;	Тавантолгой ХК нь нүүлгэн шилжүүлэлтийн асуудал хариуцсан нэгж байгуулан ажиллаж байна. Мөн багийн иргэд “Цагаан-Овоо хөдөлгөөн” ТББ байгуулж, төлөөлөл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК, аймаг, сумын ИТХ, ЗДТГ зэрэг бүх талуудын хамтарсан ажлын хэсэг байгуулах болжээ. Аймгийн ИТХ-ын 2019 оны 37 тогтоолоор Цагаан-Овоо багийн төвийг нүүлгэн шилжүүлэх зорилгоор Шинэ суурьшлын бүсийн зураг, төсвийг баталжээ. Энэ дагуу 1600 гаруй өрх болон уурхайн оффисын цогцолборын газрыг шийдвэрлэсэн байна. Гэвч Эрдэнэс тавантолгой ХК болон Тавантолгой ХК нь нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар нэгдсэн байр суурьт хүрээгүй байна.

3	Цагаан-Овоо багийн орчны хяналт, шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлэх;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
4	Цагаан-Овоо багийн иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлыг тооцуулах, шүүхээр нөхөн төлбөр тогтоолгох арга хэмжээ авах;	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний уг зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
6. Цогтцэций сумын хүн амын өсөлттэй холбоотойгоор тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар		
1	Цогтцэций сумын Сум дундын эмнэлгийн статусыг дээшлүүлэх	Тус суманд 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50 ортой Сум дундын эмнэлэг баригдаж, иргэдэд үйлчилж байна. Орон нутгийн удирдлагын зүгээс хүн ам олноор төвлөрсөн бүс нутгийн гарч болох эрсдэл, хүндрэлийг урьдчилан тооцоолж, Сум дундын эмнэлгийн статусыг дээшлүүлэх хүсэлтийг ЭМЯ-нд гаргасан боловч энэ ажил хийгдээгүй байна.
2	Эх барих, эмэгтэйчүүдийн тасгийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадварлаг, туршлагатай эмч нараар хангах	Сум дундын эмнэлгийн Эх барих, эмэгтэйчүүдийн тасгийн хүний нөөцийг 4 ажилтнаар нэмэгдүүлсэн байна. Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлэг, эрүүл мэндийн төв болон уурхайн компаниудад эмч нарыг ажиллуулахаар шаардлага тавих болсноор тухайн бүс нутагт эмч, эрүүл мэндийн ажилтнуудын тоо нэмэгдэж байна.
3	Залуучууд, залуу гэр бүлд чиглэсэн эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Тус сум "Уул уурхай, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл эрчимтэй хөгжсөн загвар сум, хот" болох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд: 30000 хүн ам бүхий дагуул хот болох, уул уурхай, МАА-г хослон хөгжүүлэх, уул уурхайн дагалдах жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, боловсролын чиглэлээр тэргүүлэх сум болох зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна.
4	Цогтцэций суманд сургууль, цэцэрлэгийн шинэ цогцолбор барьж байгуулах	Цогтцэций суманд цэцэрлэгийн насны 1300 хүүхэд байгаа бөгөөд нийт 550 хүүхдийн 3 цэцэрлэг ажилладаг. Одоогоор 2 цэцэрлэг нэмж баригдаж байна. 1080 хүүхдийн багтаамжтай 2 сургуульд одоогоор 2300 хүүхэд сурдаг. Нэмж 960 хүүхдийн багтаамжтай сургууль барьж эхэлжээ. Монголын төмөр замын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулж, одоогоор 100 гаруй оюутан сурч байна.
5	Сумын төвийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах чиглэсэн цогц хөтөлбөр боловсруулж, цагдаагийн байгууллага хяналтаа сайжруулах, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах	Цогтцэций сумын Цагаан-Овоо баг, Таван толгой уурхайг түшиглэсэн шинэ суурьшлын бүс болох Хонгор хотхоны шав тавьж, хотхоны зураг төсөл, холбогдох тооцооллыг хийсэн боловч одоогоор бүтээн байгуулалтын ажил эхлээгүй байна.
6	Цогтцэций сумын төвийн орчныг камержуулах, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, эрсдэл ихтэй цэгүүдийг тодорхойлж, иргэдийн оролцоотой орчныг сайжруулах, хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөс 33 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, сумын төвийн орчныг камержуулах, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах ажлыг зохион байгуулж байна.

7	Нүүрс тээврийн зам дагуух олон гэр, хоолны газар, засвар үйлчилгээний газруудад хамтарсан шалгалт зохион байгуулах, хууль, журамд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэдийг төвлөрсөн тээвэр, логистикийн төвд ажиллуулах	Гашуунсухайт-Тавантолгойн авто зам дагуу 2 дахь км-т Амралт, авто зогсоолын цогцолбор, мөн Ханбогд сумын нутагт баригдаж буй Тайван зогсоол цогцолборыг тус тус байгуулж, ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Зам дагуух бусад үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын тоо улам бүр нэмэгдсэн боловч хяналт шалгалт хийсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.
7. Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг зогсоох талаар		
1	Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах наад захын нөхцөлийг хангах хүртэл Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг зогсоох;	Засгийн газрын 2017 оны 320 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, нүүрсний тээвэрлэлтийг Таван толгой-Цагаан хад, Цагаан хад-Гашуунсухайт чиглэлээр хийлгэх шийдвэр гарсан ба үүнээс хойш уг зохион байгуулалт хэвээр үргэлжилж байна. Улмаар Өмнөговь аймгийн ИТХ-аас тус суурьшлийн бүсэд дахин төлөвлөлт хийж, тоосжилтыг бууруулах, иргэдийн аюулгүй амьдарч, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байгаа мэдээлэл ирүүлсэн болно.
2	Хөдөлмөр, эрүүл ахуйн стандартыг мөрдөөгүй, мөрдөхөөс татгалзсан тээврийн байгууллагууд, нийтийн хоолны газар, засвар үйлчилгээний газрын үйл ажиллагааг зогсоох, холбогдох Зөрчлийн болон холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах;	Цагаанхад суурьшлын бүсэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор тус бүсэд 2017 оноос 30 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй гэрээт цагдаагийн тасаг байгуулжээ. Уг тасаг нь нийтийн хэв журам хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн ЦЕГ-ын даргын шийдвэрээр “Цагаан хад” суурьшлын бүсийн эрүү, хэв журмын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, Цогтцэций сум дахь цагдаагийн хэлтэс, Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн алба хаагчдыг тодорхой хугацаанд хуваарийн дагуу хүч нэмэгдүүлэн ажиллуулдаг байна. Мөн АТҮТ-ийн автотээврийн хэрэгслийн ашиглалтын байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хийсэн энэхүү хяналт шалгалтын тайлангаас бусад үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

--oOo--

